¹⁹ That means “Upholder of Religion, King of (Saint) Knowledge.” Vladimir, Uspensky: The Status of Tibet in the Seventeenth – early Eighteenth Centuries: a Mongolian Perspective. *Rocznik Orientalistyczny* 67, 1 (2014), p. 232.

came into conflict with powerful regent (*desi*) Sangye Gyatso (sde srid Sangs rgyas rgya mtsho, 1653–1705), and in 1705, after a battle, Sangye Gyatso was taken prisoner and later executed. In 1706, acting in accordance with the edict of the Manchu Kangxi emperor, Lhabzang sent Tsanyang Gyatso to Beijing, who, en route to Beijing, passed away near Kukunor Lake.

Lhabzang “found” a “true” incarnation of the Fifth Dalai Lama – Ngawang Yeshe Gyatso (Tib. Ngag dbang ye shes rgya mtsho),²⁰ who, in reality, had been a puppet in the political plans of this Khoshut leader. The new Dalai Lama was not accepted by both the population of Lhasa and many lamas as a true incarnation. The situation remained uncertain until 1717, when, under the pretext of visiting of home by Lhabzang’s son, who was husband of daughter of the Dzungarian leader Tsewang Rabden (Tshe dbang rab brtan, born 1663, r. 1697–1727), the Dzungarian forces marched to Tibet and in November 1717, occupied Lhasa. Lhabzang was killed, and Ngawang Yeshe Gyatso was removed away from Potala. It is possible to assume, that for those Oirat leaders, like Lhabzang and Tsewang Rabden, both Sixth Dalai Lamas had been objects of their politics.

Tsewang Rabden, seems, had the special view on the role of Buddhism and lamas in his policy. For instance, he, accusing the Sixth Dalai Lama Tsangyang Gyatso in the sympathy to Nyingma stream doctrine, tried, for the sake of the “purity” of the Gelug school, to support the Panchen Lama as the “real” Tibetan leader. The Manchu authority accused him in usurpation of his uncle’s (Galdan’s) throne without “permission from other *khans* and the spiritual ranked persons,”²¹ in destruction of temples in Tibet and murder of lamas. One of Tsewang Rabden’s spiritual tutors was Kempothan lama, also known as Lobsang Puntsok, Gomang Laza Lobsang Puntsog and the Dzungarian Noyon Khambo Luwsan Puntsog. That was a noble person, who spent approximately 20 years in Drepung Monastery, and obtained the title of *Ihaaramba*. His teacher was Ngawang Tsondu (Tib. Ngag dbang brtson ‘grus, 1648/9–1722), the famous lama, who founded the line of reincarnates of Jamyang Zhepa (Tib. ‘Jam dbyangs bshad pa), and occupied a prominent place in the history of the Gelug stream, also well-known as tantric master. During the Dzungarian occupation of Lhasa in 1717–1720 Lobsang Puntsog was responsible for the persecution of the Nyingma and Kagyü clerics and conversion of their monasteries to Gelug teaching, thus realizing Tsewang Rabden’s orders.

Lamas at Tsewang Rabden’s court sometimes acted as those magicians, whose might or witchcraft, as was supposed, could give the help to overcome the might of the Manchu armies. For instance, there is the following passage in the Russian archival paper of the first quarter of the 18th century, where one could find the description of the special magic enterprise. The event was noted by the Russian captain Ivan

²⁰ Luciano Petech believed in that it was Lhabzang’s son. Cf. Petech, Luciano: *China and Tibet in the Early XVIIIth Century. History of the Establishment of the Chinese Protectorate in Tibet*. E. J. Brill, Leiden 1972, pp. 17–20.

²¹ Archive of the Foreign Police of the Russian Empire. Fond “The Relationship of Russia with China.” List 62/1, 1723, case 1, 1v. Therefore, it is possible to conclude that, for the Manchu authority, lamas should be not subjects, but objects in the Oirat political system.

Unkovsky, who was sent on December 1721, by the Russian Tsar Peter the Great to the Dzungarian ruler to discuss the border problems of Dzungaria and Russia.

According to Ivan Unkovsky, one holiday evening the lamas of Tsewang Rabden arranged the special ceremony: about 650 meters away from the place of the action (holiday), on the eastern side, “something of a cane and all sorts of trash was erected, it was like a haystack with gunpowder inside. The senior lama came up to this construction and set fire to the gunpowder. The haystack did get fire, and the Kalmyks, in carapaces, thirty men, began to fire from the rifles to the eastern side and all the people, grabbing whatever fell into their hands (stone, stick or piece of soil), with a loud cry did throw it to the eastern side, as if they would march with a victorious war against the Chinese, and Kontaisha [Tsewang Rabden] himself marched on.”²² It is possible to assume that the above mentioned Lobsang Puntsok, the close associate of Tsewang Rabden, had been among those lamas, who arranged the ceremony, which could be a part of the tantric practice, aimed to win over the Chinese.

The Russian Kalmyk lamas could be both subjects and objects of the political activities of their leaders. It depended on the political situation within Kalmyk Khanate. For instance, the famous Shakur lama, being the spiritual leader of the Kalmyks (at the first third of the 18th century), “constantly was in fear, as rivals did know on his influence on the Governor.” For that period the Governor of the Kalmyks was Tseren Donduk (r. 1735–1741) – the principal Kalmyk ruler, in Russian – *namestnik*, who was supported by the Russian authorities and Shakur lama. The Kalmyk leaders, so-called owners, according to Shakur, “are very fickle and frivolous, therefore they can join the side which they believe is stronger, and then, ‘being furious,’ they could attack the *ulus* of the lama, ravage the *ulus* and kill the lama himself – from Donduk Ombo²³ everyone could expect anything.”²⁴ Therefore, Shakur, being the object of the inner Kalmyk policy, depending on the situation, could become a subject of the regional political activities, and verso.

Another illustrative example is the case of Anjjatan lama, who spent over 25 years in Tibetan monasteries (mainly in Drepung) and came back to the Volga, holding a high scholarly degree of *rabjamba* (Tib. *rab 'byams pa*), about in 1712. Before his departure he had had an audience with the Dalai Lama who presented him with gifts – several *thangkas*. Unlike his contemporary Shakur, Anjjatan devoted his life to the spreading of Buddha’s teaching among the Kalmyks, and his disciples became well-known religious figures among those people. Later, some of these disciples along with the incarnation of Anjjatan²⁵ had been among those Kalmyks who driven back to China (Xinjiang) in 1771. The subsequent incarnations of this lama, in accordance

²² Archive of the Foreign Policy of the Russian Empire. List 113/1, 1724, case 1, p. 45.

²³ Donduk Ombo, the rival of Tseren Donduk, was the Kalmyk *khan* from 1737–1741.

²⁴ The National Archive of Kalmyk Republic. Collection 145, list 1, case 199, p. 168.

²⁵ That is very likely, that his name was Louzan Jalchin lama, known also as Louzan Lachin and Lauzin Lanchin, who had played the important role in the exodus of Kalmyks back to China, and who was the seventh (?) incarnation of the famous Anjjatan lama. This issue needs to be studied further.

with his obituary, have played a significant role among Oirats in Xinjiang, supporting the policy of the state power.²⁶

It is interesting to point one more important cleric – Delek lama, who, after destroying of the Dzungarian Khanate by the Qing army in 1758, arrived to the Kalmyks, and became *Shajin lama*.²⁷

Upon his arrival to ruling Kalmyk Donduk Dashi Khan (r. 1741–1761), Delek proclaimed himself “a senior reincarnation,” i.e. a *khutuktu*. He was obviously of an exceptional personality with the outstanding abilities; according to Ubashi Khan (r. 1761–1771), this lama “... upon his arrival and still being unknown to many people, has shown a number of surprising deeds.”²⁸ However, his rule was not long as very soon (about the end of October 1759) his own *shabinars*²⁹ (most likely, given to him by Donduk Dashi) sent a complaint to the *khan*, reporting “on his [*khutuktu*’s] most unlikely behaviour and damage to their *burkhans* inflicted by him and other improper acts, etc. ...”³⁰ Indignant at this behavior of the religious personality, Donduk Dashi took him off from his high position and even put him under arrest. On receiving this news, N. Spitsin, the representative of the Russian authorities to the Kalmyks, thought it was not appropriate for a lama to be under arrest and insisted on his release.

In January 1761, Donduk Dashi died and his son Ubashi succeeded him as *khan* of the Kalmyks. On 28 March 1761 N. Spitsin received a letter from the new *khan* concerning Delek lama: “Now we have some doubts concerning him as it has become known, that not only now but at the time of *huntaiji* he had made wonders, this was reported by Zengors, both by nobles and ordinary people, who had seen and heard about them ... Besides, curious times have come since last year as he by accident makes the ground dry and produces irregular thunderstorms and rainbows and also fire fall ...” Ubashi accused the lama of causing his father’s death and in fact had refused to regard him as the spiritual person: “...it was really strange that *khan* died so suddenly, nobody had had any premonition. It has been revealed to us in our books that the *khan* became the victim of the monk’s magic actions ... Taking into consideration all of this, we do not trust him any longer.”³¹

Ubashi did demand N. Spitsin to “send this lama to some distant place far away from the Kalmyks for his indecent acts. ...”³² Aware of the predicament in which both the secular and religious leaders of the Kalmyks found themselves, N. Spitsin addressed his request to the Imperial Collegium for Foreign Affairs to St. Petersburg. In summer 1761 he received an order to send *khutuktu* Delek lama to the Collegium, accompanied by one of his own people. In autumn of the same year Delek lama was

²⁶ For instance, see: Kitinov, V. U.: Lama Andžatan: inkarnacii učitelja. *Vjestik Rossijskogo univjersitjeta družby narodov. Vsjeobščaja istorija* 2 (2016), pp. 27–35.

²⁷ *Shajin lama* headed the Kalmyk Sangha.

²⁸ The National Archive of Kalmyk Republic. Collection 145, list 1, case 429, p. 30.

²⁹ *Shabinars* – the laymen, who belonged to monasteries and temples.

³⁰ The National Archive of Kalmyk Republic. Collection 145, list 1, case 429, p. 29.

³¹ The National Archive of Kalmyk Republic. Collection 145, list 1, case 429, p. 30.

³² The National Archive of Kalmyk Republic. Collection 36, list 1, case 330, p. 91.

sent to St. Petersburg with his nephew, also a monk. After visiting Moscow en route to St. Petersburg, and then being appointed to settle in southern Russian regions, Delek lama, on the way to his new settlement, fell ill and died in Voronezh-town.³³ Thus, the life of Delek lama is the wonderful illustration of the possible fate of clerics, who did not act in accordance with the wishes of the western Mongolian rulers.

It is well-known that the Oirat lamas had also been the ambassadors to other countries, for instance, to Russian Empire; in this case the ethnicity was an important issue, which meant that the ambassadors had to be the ethnic Kalmyks. For instance, Fedot Alchin, the interpreter of the Russian Ambassadorial Order, testified that “the Kalmyk ambassadors told him that they are the ethnic Kalmyks of the Kontaisha [i.e. of the Dzungar leader] people. Their Kontaisha did not send anyone off the foreigners as [his] ambassadors to the Grand Sovereign [Russian Tsar], except his naturally ethnic people. And earlier Kontaisha sent to the Grand Sovereign the same people.”³⁴

Conclusion

The analysis of these cases allows assuming, that the Oirat clergy had not been simply subordinated to the secular authorities, but also the special factor had had the significant importance – that was the identity issue; only the ethnic Kalmyk and Oirat spiritual persons (lamas) were able to be the subjects of political activity. Therefore,

1. The independent political role of the clergy has not been allowed among Oirats and Kalmyks, although they had been the subjects of the political activity, acting as ambassadors or tantric masters. But if they didn't obey the demands of the authority, they could be imprisoned or anyhow punished. The most important thing for them was the “naturalness” of the clergy, i.e., their ethnic affiliation to the Oirats and Kalmyks.

2. Since the clergy of no-Oirat and no-Kalmyk origin (that means, of the Tibetan or Mongolian lineages) could not have been the subjects of political activity of the Oirats and Kalmyks, they, as a rule, were its objects. Simultaneously, there were the unique leaders, like the Dalai Lama, who could be understood as the subject and object of the political mechanism and activity of the Oirats and Kalmyks; that was the unique case within the political idea of creating of the clerical state with the Tibetan leader as *tutor* and the Oirat ruler as *upholder* of the Faith.

3. The Oirat and Kalmyk spiritual leaders had been able to be the influential political figures when they did get support not only from the highest religious authority (the Dalai Lama), but, above all, had had either hereditary rights (Galdan Khan, Ensa Khutuktu's incarnation) or a higher level of political patronage (the Russian authorities in the case of Shakur lama; the Qing government in the case of Anjjatan lama, after Kalmyk exodus to China in 1771).

³³ The National Archive of Kalmyk Republic. Collection 145, list 1, case 429, p. 34.

³⁴ Russian State Archive of Old Documents. Collection 113 “Zjungarskije (kontajšiny) dela,” list 1, 1640, case 1, p. 156.

References

PRIMARY SOURCES

- Archive of the Foreign Police of the Russian Empire. Fond "Otnošjenija Rossii s Kitajem." List 62/1, 1723, case 1.
- Archive of the Foreign Policy of the Russian Empire. List 113/1, 1724, case 1.
- Russian State Archive of the Old Documents. Collection 113 "Zjungarskije (kontajšiny) dela," list 1, 1640, case 1.
- The National Archive of Kalmyk Republic. Collection 36, list 1, case 330.
- The National Archive of Kalmyk Republic. Collection 145, list 1, case 199.
- The National Archive of Kalmyk Republic. Collection 145, list 1, case 429.
- Ngag dbang blo bzang rgya mtsho: *rGyal dbang lnga pa Ngag dbang blo bzang rgya mtsho 'i rnam thar du ku la 'i gos bzang*. Bod ljongs mi dmangs dpe skrun khang, Lhasa 2012, Vol. 1.

STUDIES

- Bongard-Ljevin, G. M.: *Indija epohi Mau'jev. Izdatjel'stvo Nauka*, Moskva 1973.
- Chuluun, Samplidondov: Several letters regarding Galdan Boshogtu. In: *Oirat People: Cultural Uniformity and Diversification*. Ed. by I. Lkhagvasuren and Yuki Konagaya. *Senri Ethnological Studies* 86 (2014), pp. 61–70.
- Ishihama Yumiko: A Study of the Seals and Titles Conferred by the Dalai Lamas. *Tibetan Studies*. Proceedings of the V Seminar of the International Association for Tibetan Studies, Narita 1989. *Naritan shinshoji*, Narita 1992, Vol. 2, pp. 501–514.
- Il ha caaz. Vjelikoje uložjenije. Pamjatnik mongol'skogo fjeodal'nogo prava XVII v.* Izdatjel'stvo Nauka, Moskva 1981.
- Istorija Kalmykii s drjevnjejših vrjemjen do naših dnjej.* Izdatjel'skij dom «Gerel». Elista 2009, Vol. 1.
- Ho-Chin Yang: *The Annals of Kokonor*. Indiana University Press, Bloomington 1969.
- Kitinov, B. U.: Lama Andžatan: inkarnacii učitelja. *Vjestik Rossijskogo univjer-sitjeta družby narodov. Vsjeobščaja istorija* 2 (2016), pp. 27–35.
- Kitinov, Baatr U.: *The Spread of Buddhism among Western Mongolian Tribes between the 13th and 18th centuries: Tibetan Buddhism in the Politics and Ideology of the Oirat People*. Edwin Mellen Press, Lewiston 2010.
- Lunnyj syjet. Kalmyckije istoriko-litjeraturnyje pamjatniki.* Kalmyckoje kinžnoje izdatjel'stvo, Elista 2003.
- Pagsam-džonsan: *Istorija i hronologija Tibjeta*. Per. S tib. jaz., prjedisl, komment. R. Je. Pubajeva. Izdatjel'stvo Nauka, Moskva 1991.
- Petech, Luciano: *China and Tibet in the early XVIIIth Century: History of the Establishment of Chinese Protectorate in Tibet*. Second, revised edition. (T'oung Pao, Monographic, 1.) E. J. Brill, Leiden 1972.

- Ruegg, David Seyfort: Mchod yon, yon mchod and mchod gnas / yon gnas: on the Historiography and Semantics of a Tibetan Religio–social and Religio–political concept. In: *The History of Tibet*. Ed. by Alex McKay. RoutledgeCurzon, London – New York 2003, Vol. 2, pp. 362–372.
- Sangs rgyas rgya mtsho: *Life of the Fifth Dalai Lama*. Vol. IV. Tr. by Zahiruddin Ahmad. Aditya Prakashan, New Delhi 1999.
- Uspensky, Vladimir: The Status of Tibet in the Seventeenth – early Eighteenth Centuries: a Mongolian Perspective. *Rocznik Orientalistyczny* 67, 1, 2014, pp. 230–237.

ИХ МОНГОЛ УЛСАД ШАШИН ШҮТЛЭГИЙГ ХУУЛЬЧИЛСАН НЬ

Цэрэнбалтавын Минжин

Хууль Сахиулах Их Сургууль, Улаанбаатар

Төв Азид нутаглагчдын шашин шүтлэг харилцан адилгүй боловч тухайн цагийн Монголчуудын ихэнх нь мөнх хөх тэнгэр, уул усныхаа лус савдагт итгэж биширч ирсэн бөө мөргөлтөн байсан юм. Их Монгол улс байгуулагдсаны (1206) дараа гадаад дотоодын худалдаачдын хөл хөдөлгөөн ихсэхийн хэрээр тэдний дагалдан ирэгсэд болон бусад олон шалтгаанаар олон шашны бие төлөөлөгчид ирэх болсноор шашин шүтлэгийн олон төрлийн урсгалууд өөр өөрсдийнхөө номлолоо дэлгэрүүлэх болжээ.

Францисканы гэлэн Вильхельм Рубрук (1220–1293) Хархорумд 1254 оны хавар ирснийхээ дараа олон улсын, өөр хаана ч байхгүй дундад зууны Европын хотууд шиг Парисын Сайнт-Денисын дугантай харьцуулж болохоор, магадгүй түүнээс ч томоохонд тооцогдохоор хоттой танилцжээ. Загалмайтны шашны нэгэн бүлгийн төлөөлөгч байсан Рубрук мэдээж шүтээний барилгыг сонирхжээ. Дэргэд нь христийн–несториан шашны сүм байх ба онцгой анхаарал татсан нэр хүнд бүхий хороололд хоёр лалын сүм, олон үндэстний арван хоёр онгон шүтээний дуган байхтай тэр танилцсан ба энэ нь олон улсын хот гэдгийг гэрчилж хүлээн зөвшөөрөхөд хүргэжээ.¹ Энэхүү тоо баримтаас харахад л тухайн үеийн Их Монгол улсын нийслэлд олон төрлийн шашин зэрэгцэн оршин байсныг илтгэнэ.

Их Монгол улсын зүгээс энэ мэт дэлгэрэх нөхцөлийг ч бүрдүүлж өгсөн ба шашны талаар баримтлах бодлого нь “шашин болгонд хүндэтгэлтэй хандана, үл доромжлоно, ямар ч шашны сүм хийд, тэдний албатуудыг татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх” зэргээр бүхий л таатай боломжийг хангаж өгчээ. Энэхүү үзэл санаа нь “Их засаг”-т тусгалаа олж, хэм хэмжээ тогтоосон хууль болон үйлчилж, хожим Чингис хааныг залгамжлагчдын үед ч хэвээр хадгалагдсан байна.

Энэ үеийн түүхийн гол сурвалж болох Жувейнигийн “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” номонд “Тэдэнд биеэ тушаагаад захирагдсан хүн бүхэн Монголчуудын яаса болон заншил ёсоор амь аврагдан аюул айдасгүй чөлөөтэй амьдрах болно. Түүнээс гадна тэд аливаа мөргөл, аливаа шашныг үл хязгаарлана. Хязгаарлах нь битгий хэл тэд бүх шашныг тэтгэн дэмждэг. Үнэн Аллах өөрийн шашныг ямар ч баялаггүй ард түмнээр дамжуулан бататгах болно”

¹ Erdenebat, U. – Ernst, Pohl: Aus der Mitte der Hauptstadt – Die Ausgrabungen der Universität Bonn im Zentrum von Karakorum. In: *Katalog Dschingis Khan und seine Erben: Das Weltreich der Mongolen*. Ed. By Jutta Frings. Hirmer, Bonn 2005, т. 168–175.

гэсэн Мухаммедын үг түүний баталгаа мөн. Тэд шашин бүрийн хамгийн номтой санваартнуудыг аливаа татвар, алба гувчуурын дарамтаас чөлөөлж, тэдний шашны эд хэрэглэл, өмч хөрөнгийг бүх нийтийн хэрэгцээнд зориулан, мөн тэдний харьяалалд байсан тариачдыг элдэв татвараас чөлөөллөө гэж зарласан. Мөнх хааны захиргааны үед, Чингис хааны удмын хэдэн хунтайж нар, өөрөөр хэлбэл түүний үр хүүхэд, ач гуч нар исламын сайн талыг дэлхийг захирахад ашиглаж байгаа одоо үед тэднийг муу хэлэх хүн ялангуяа Мухаммедын исламуудын дунд л лав байхгүй. Шашны ач тусыг хүртээд сүсэглэн дагах болсон хүмүүс тоо томшгүй олон болжээ”² гэж тэмдэглэсэнээс гадна чухамдаа Чингис хаан болон бусад хаадын шүтлэг бишрэлийн тухайд:

“Чингис хаан ямар ч шашин шүтдэггүй хүн байсан болохоороо аль нэг шашныг ялган гадуурхдаггүй, алиныг нь ч онцлон дэмждэггүй, цөмийг нь адилхан үздэг байлаа. Харин бүх шашны эрдэм номтой, үнэнч шударга санваартнуудыг хүндэтгэдэг, үүнийгээ бурхны хаанчлалд хүргэх баталгаа гэж үздэг байлаа. Түүнчлэн мусульманчуудад ивээлтэй ханддаг шигээ бас загалмайтны болон бусад шашинд ч ивээлтэй ханддаг байв. Түүний хүүхдүүд, ач нар нь ямар шашин шүтэхээ өөрсдөө сонгоно. Жишээ нь тэдний нэг хэсэг нь мусульман шашин шүтлэг болоход нөгөө нэг хэсэг нь христийн шашныг бас шүтдэг болсон. Бас өөр шашин шүтдэг, мөргөлдөө үнэнч хүмүүс ч олон байсан. Тэд хэдийгээр өөр өөр шашинд орсон ч шашнаа улайран өмөөрч хоорондоо хямардаггүй, харин Чингис хааны Яаса хуулийг хэлбэрэлтгүй баримтлан эв эеэ их сахидаг байлаа”³ гэж Исламын шашинт Жувейни их хааны тухай бичжээ.

“Судрын чуулган”-ыг бичсэн Рашид ад-Дин: “Гүюг хааны дэргэд атабэки тушаалтан байсан бөгөөд хүүхэд ахуй цагаас загалмайтны шашны итгэгч Хадаг нь (Гүюг хааны) араншинд нөлөөлсөн нь бий. Түүнээс хойш Чинхай ч энэ үйлсийн хамсаатан болсон байна. Үүнээс болоод Гүюг хаан хэзээ ямагт Христосын шашин санваартны сургаалыг зөвшөөрдөг байв. Энэ тухай сураг чимээ түгсэн учир Шам, Рум, Осууд ба Орос орноос Христос санваартнууд түүний нийслэлийг зорин зүглэх боллоо. Хадаг, Чинхай нар л байсан цагт Лалын шашнаас няцах явдал хэзээ ч дутаж байсангүй. Гүюг хааны захиргааны үед Христос шашны үйлс нь дэгжиж дэвшин дээшилж байхад лалын сүсэгтний нэг нь ч түүнийг эсэргүүцэн дуугарах сачийгүй байлаа.”⁴ Өөр нэгэн баримт: Толуйн хатан Сорхагтани бэхи шашинд хэрхэн хандаж байсан тухайд “Тэр хэдийгээр загалмайтны шашныг шүтдэг байсан боловч лалын (шүтээн) Мухаммед жаягийг амжуулахад дөхөм болохыг маш их хичээдэг бөгөөд лалын шейхүүд имамуудыг өргөл барьцаар цатгаж арвин их хишиг соёрхдог байлаа. Үүний баталгаа нь гэвэл тэрбээр Бухар дахь Медрес (лалын сүм)-ийг бариулахад зориулан мянган мөнгөн зоос соёрхсон бөгөөд түүнийг шейх-ул-ислам

² Ата-Мелик Жувейни: *Чингисхан История Завоевателя Мира*. Перевод с текста Мирзы Мухаммеда Казвини на английский язык Дж. Э. Бойла, с предисловием и библиографией Д. О. Моргана. Перевод текста с английского на русский язык Е. Е. Харитоновой. Москва 2004, т. 13.

³ Жувейни: *Чингисхан*, т. 20.

⁴ Rashīd al-Dīn: *The Successors of Genghis Khan*. Tr. by John Andrew Boyle. New York–London 1971, т. 184.

Сейф ад-дин Бахарзи, түүнийг Аллах ивээх болтугай, энэ сайн үйлсийн хэргийг захирагч, асрагч нь гэж тушаасан ба энэ медрэсе сүм нь вакф байхаас татгалзаж (түүнд) мударрисууд ба түлэбүүдийг оруулсан ба түүнчлэн орчин тойрон ба мужуудад байнга л өглөг илгээдэг байсан мөн лалын сүсэгтэн, гуйлгачин ядуусыг гэжээхэд зориулан эд хөрөнгөө зарцуулсаар байлаа”⁵ гэж бичиж үлдээжээ.

Тэгвэл Католик шашны элч, гэлэн Рубрук Мөнх хааны шашны талаарх үзэл бодлын тухай “Бурхан, хүний гарт урт богино хуруу заяасан шиг хүмүүст бас янз янзын тавилан хайрлажээ”⁶ гэж хэлснийг тэмдэглэжээ.

Италийн Венец хотын худалдаачин Марко Поло (1254–1324), Хубилай хааны шашны тухай үзлийг “Дэлхийд дөрвөн бошигтыг тахин мөргөж байна. Загалмайтнууд бурхнаа Есүс Христ гэнэ, сарацинууд Мухаммед, иудейчүүд, Моисей, онго шүтлэгтнүүд, Согом-баркам. Би бол дөрвүүлийг нь тахин шүтэж байна” хэмээн бичиж үлдээжээ. Энэ бол Чингис хаанаас эхлэн Мөнх хаан, Хубилай хааны шашинд хандах хандлагыг бичиж үлдээсэн хэрэг юм.

Их Монгол улсыг байгуулахад Чингис хааны “Биеийг нь хураахаас сэтгэлийг нь хураагтун, сэтгэлийг нь хурааваас бие нь хаа одох” гэсэн билиг ухааныг төрийн бодлогодоо ялангуяа шашны үзэл номлолоор дамжуулан чадварлаг шийдэж байсан юм. Тухайлбал, “Монголын нууц товчоон”-д өгүүлэгдсэн Хөхөчү бөөг, Чингис хаан, Отчигин ноёноор зөв эс болгосон явдал бол зөвхөн тэр хоёрын маргааны тухайд биш улс төрийн бодлогын чухал ач холбогдолтой хэрэг болно. Мөн Чингис хаантай дэлхийн шашны төлөөлөгчдөөс хамгийн түрүүнд дундад улсын гүн ухаантан Даогын шашны бумба Чань Чуньтай (жинхэнэ нэр нь Цю Чу Цзи, 1148–1220) заллагын бичиг явуулж уулзсан явдал юм.

Харин Их Монгол улсын үед хамгийн анх исламын шашинт ард түмнийг нэгтгэж, дэмжсэн нь 1218 онд Зэв ноён цэргийн нэгтгэл ангитайгаар Хүчүлүгийг дарахаар Хар Хятанд нэвтрэн орсон явдал байв. Хүчүлүг өөрийнхөө бага хатны ятгалгаар тухайн нутгийн хүн ардыг, лалын шашнаас татгалзуулж, бурхны шашинд орохуулахыг эрмэлзэж байжээ. Харин Зэв Хүчүлүгийн нутагт цөмрөн ормогцоо “хүн бүр дуртай шашнаа шүтэж болно. Энгийн номхон иргэдийг огтхон ч хохироохгүй” гэж зар тараав. Үүнийхээ ачаар ч Зэв ноён бүхэл бүтэн улсыг ямар ч хохирол амсалгүй ялалт байгуулж, Их Монгол улсад нэгтгэсэн юм.

Дээр өгүүлснээр Их Монгол улсын нийслэл Хархорум хотод буюу Монголын Их хаадын дэргэд бүх шашны төлөөлөгчид зэрэгцэн оршиж өөр өөрийн шашны давуу талыг ятган ухуулж, Алтан урагийн ноёдууд тэр байтугай зарим их хаадуудыг хүртэл аль нэг шашинд нууцаар орсон гэх мэтээр бичиглэж байв. Харин Их Монгол улсын хаадууд бүх шашинд адил тэгш хандаж, аль нэг шашинд өөрсдөө орохоос зайлсхийдэг байсан бөгөөд шашны төлөөлөгчдийг төрийн үйл ажиллагаандаа татан оролцуулж бичиг захидал дамжуулж байв.

Элчүүдийн авч явсан захиа эдүгээ ч Ром, Парис зэрэг хотуудад хадгалаастай байгаа бол Монгол улсын газар нутгаас өрнийн соёл тэр дундаа шашинтай

⁵ Rashīd al-Dīn: *The Successors of Genghis Khan*, т. 199.

⁶ Рубрук: *Дорно этгээдэд зорчсон минь*. Франц хэлнээс орос хэлэнд орч. Бержерон, орос хэлнээс монгол хэлэнд орч. С. Туяа. Улаанбаатар 1988, т. 205.

холбоотой эд өлгийн олдворууд олдсоор байна. Монгол, Германы хамтарсан археологийн судалгаагаар “Өвөрхангай аймгийн Хархориноос хамгийн үнэтэй бөгөөд олон шашинд холбогдох эд өлгийн зүйлс олсон бол Ховд аймгийн Мөнххайрхан сум, Өмнөговь аймаг, Баянхонгор аймгийн Баянбулаг сум, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутгаас олдсон загалмайн шашинтай холбоотой бичээснээс эхлүүлэн загалмай зүүсэн хүн чулуу”⁷ хүртэл олдсон нь Монголын нутаг дэвсгэрт олон төрлийн шашин цаг үеийн турш зэрэгцэн буюу бие биенээ халан солин оршиж байсныг гэрчилж байна. Харин энэ хандлага Монголын Эзэнт гүрний бүрэлдэхүүн улсын хангуудын үед захирч байгаа нутаг дэвсгэр, ард түмэн, улс төрийн бодлого болон бусад олон шалтгаанаар аажмаар өөрчлөгдөх болов. Юань улсын хувьд бурхны шашныг төрийн шашнаа болгожээ.

Их Монгол улсын эрх баригчдаас бурхны шашныг дэмжин анх нүүр тулан уулзаж, Төвдтэй анхлан харилцах болсон нь Өгөдэй хааны гуравдугаар хүү Годан (1206–1251) бөгөөд Өгөдэй хаан Тангадын Амдугийн хавийн газар нутгийг түүнд эзэмшүүлжээ. Годан эцгийгээ нас барсны дараа дайлаар мордож, Гансуг эзлэж, Төвдийн нутагт нэвтэрч Чамдуу хавийг эзлэв. Төвдийн улс төрийн дотоод байдлыг сайн мэдэж байсан Годан ноён Сажа бандид Гунгаажанцанд⁸ жуух бичиг илгээжээ. Ийнхүү нааштай харилцааны үр дүнд 1244 онд (өөр мэдээгээр 1245 онд) нас сүүдэр жаран тавыг зооглосон Сажа бандид Гунгаажанцан бараа бологсдынхоо хамт монгол ноёны өргөөг зорин холын замд гарахдаа арван настай Пагва, зургаан настай Чагна хоёр ач хүүгээ дагуулан явжээ.

Годан ноён Сажа бандид Гунгаажалцаныг өргөөндөө урин залсан явдал нь Төвдийг Их Монгол улсын хараат улс болгосон чухал үр дагавартай байснаас гадна Годан ноён өөрийн өвчнөөс салж, бурхны шашныг Монголд дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ. “1253 онд Хубилай Сажа бандидыг урин залахаар Годан ноёны өргөөнд элч заржээ. Хубилайд явуулсан хариу захидалдаа Годан ноён Төвдийн багш лам нас барсан хийгээд түүний ач Пагва лам өргөөнд заларч буйг мэдээлжээ.”⁹ Хожим Хубилай хааны урилгаар Пагва лам (1235–1280) Юань гүрний “их багш” болж, “хоёр ёсны онол”-ыг түгээн дэлгэрүүлжээ.

Хэдийгээр Юань гүрний үед олон төрлийн хууль батламжлан гаргаж байсан ч “хоёр ёсны онол” нь төрийн гол бодлогын нэг байсныг үндэслэвэл “Арван буянт номын цагаан түүх” бол голлох үүрэгтэй эрх зүйн эх сурвалж байжээ. Уг хуулийг герман, япон, хятадын эрдэмтэд болон Ш. Нацагдорж, Ш. Бира, С. Жалан-Аажав, Э. Авирмэд, Д. Дашцэдэн, Г. Совд, Г. Баярхүү, Ж. Болдбаатар,

⁷ Эрдэнэбат, У.: Мартагдсан загалмайн тухай тэмдэглэл: Түүхийн хуудас сөхвөл. *Studia Archaeologica* (IV) XXIV, Fasc. 25 (2007), т. 363–398.

⁸ Сажа бандид Гунгаажанцан (1182–1251) нь Сажа хийдийн тэргүүн нь 1219 онд Балба, Энэтхэгт явж, гүн ухааны мэтгэлцээнд оролцож байсан алдарт эрдэмтэн байв. Тэрээр залуу насандаа Каширын алдарт бандид Шакьяшрибхадрагаас (1204–1213) сахил авчээ. Рерих: *Аав хүү Рерих нар ба Монгол*. Ред. Ш. Бира. Улаанбаатар 2008, т. 112.

⁹ Рерих: *Аав хүү Рерих нар*, т. 114.

Д. Лүндээжанцан, И. Дашням, Б. Баярсайхан нар хэл шинжлэл, хууль эрх зүй, түүхийн шинжлэх ухааны үүднээс олон талаас нь шинжлэн судалжээ. Тухайлбал, С. Жалан-Аажав, Б. Баярсайхан нар “Цагаан түүх”-ийг эрх зүйн эх сурвалж болгон судлахаас гадна түүхэн эх сурвалж болохын хувьд нь “Цагаан түүх”-ийн эхийг анх өрнөдөд В. Хейсиг (W. Heissig) 1959 онд хэвлүүлж байсан бол уг эх болон бусад хэд хэдэн хувилбарыг монгол бичгийн латин галигаар хөрвүүлэн буулгаж харьцуулан 1976 онд К. Загастер (C. Sagaster) хэл зүй, утга агуулгын талаас судалгаа хийжээ. Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд байх “Цагаан түүх”-ийн найман янзын эхийг харьцуулан судалгааны бүтээл туурвижээ.

Хэсэг судлаачид “төрийн албадлагаар хамгаалагдсан эрх зүйн дээд хүчин чадал бүхий хууль болохын хувьд нэгдүгээрт: шашин хуврагийн ёсыг илүүтэй зохицуулсан, хоёрдугаарт: хоёр ёсыг тэгш явуулахтай холбогдсон зан үйл, хэм хэмжээг нарийн тодорхойлон зааж өгсөн, гуравдугаарт: хууль зүйн хариуцлага, ял шийтгэлийн хэлбэр, агуулгыг тогтоож өгсөн нь “Цагаан түүх”-ийг төрийн үзэл баримтлалын шинжтэй баримт бичиг гэхээсээ эрх зүйн эх сурвалж болох талаас нь судлах боломжтой гэдгийг харуулж байна”¹⁰ гэж үзжээ.

Их Монгол улсын хаадаас шашны талаар хэм хэмжээ тогтоосон зарлигийн “шашин болгонд хүндэтгэлтэй хандана, үл доромжлоно, ямар ч шашны сүм хийд, тэдний албатуудыг татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх” гэх мэт агуулга бүхий хэм хэмжээг Юань улсын хаад гаргаж байжээ. Энэ нь “Их засаг”-ийн агуулгатай нийцэх агаад Монголын эзэнт гүрний үед ч нэмж баяжигдсаар байсныг илтгэх хэд хэдэн зарлиг¹¹ байна. Үүнд:

1. Харин Хубилай хааны хүү Мангалын (?–1280) 1276 оны нэгэн зарлигт “Мөнх тэнгэрийн хүчинд Хааны сууд Хуан зи Ань-си ван үг маань цэргүүдийн ноёдод, цэрэг ардад, зорчин явах элч нарт дуулгах бичиг. Чингис хааны зарлигт тойд, эрхүүд, сэншинүүд, дашмад сан тамгаас бус аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл өгөн атугай хэмээдэгсэд ажгуу. Эдүгээ бээр бөгөөс урьдын зарлигийн ёсоор сан тамгаас бус аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл өгөн атугай хэмээн Пин-ян фу-д бүхүн Яо мяо, Хоу Ту мяо, Ю Ван мяо-д ахун Жян жэнь рэний орноо Дун жэнь рэний сэншинүүдийг өтөглөж ерөөл өгөн атугай хэмээн барьж явах бичиг өгвэй. Эдний Гуаньд, хийдэд нь элчин бүү буутугай. Улаа шүүс бүү барьтугай. Газар ус юу хээг нь булааж татаж бүү автугай. Эд бас сэншинүүд бичигтэн хэмээж ёс үгүй үйлс бүү үйлдтүгэй. Үйлдвээс үл айх уу? Мөн бичиг маань хулгана жил хаврын тэргүүн сарын хорин зургаанаа Жин-жао фу-д бүхүйд бичвэй.”¹²
2. Хубилай хааны 1277–1289 он үеийн нэгэн зарлигт “Мөнх тэнгэрийн хүчинд Их суу залийн ивээлд Хаан зарлиг маань цэргүүдийн ноёдод, цэ-

¹⁰ Баярсайхан, Б.: *Монгол улсын арван буянт номын цагаан түүх*. Улаанбаатар 2006, т. 27.

¹¹ Баярсайхан, Б.: *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл (1206–1910)* I. Улаанбаатар 2010, т. 68–106.

¹² Баярсайхан, Б.: *Монголын хууль тогтоомжийн ...*, т. 68–69.

рэг ардад, балгадын даргаст, ноёдод, зорчин явах элч нарт дуулгах зарлиг. Чингис ханы ба хааны зарлигт тойд, эрхүүд, сэншинүүд, дашмад аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл өгөн атугай хэмээдэгсэд ажгуу. Эдүгээ бээр бөгөөс урьдын зарлигийн ёсоор аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл өгөн атугай хэмээн Дай-Юань фу-д бүхүн Ши-би-си-д ахун Ан-сэн лу-д барьж явах зарлиг өгвэй. Эдний сүмст, хийдэд нь элчин бүү буутугай. Улаа шүүс бүү барьтугай. Сан тамга бүү өгтүгэй. Газар, ус, цэцэрлэг, тээрэм юу хээг нь булааж татаж бүү автугай. Эд бас тойд зарлигт гэж ёс үгүй үйлс бүү үйлдтүгэй. Үйлдвээс үл айх уу? Мөн зарлиг маань үхэр жил хаврын тэргүүн сарын хорин тавнаа Дайду-д бүхүйд бичвэй.”¹³

3. Анандын (?–1307) 1282 оны нэгэн зарлигт “Мөнх тэнгэрийн хүчинд хааны сууд Ананд чин ван үг маань цэргүүдийн ноёдод, цэрэг ардад, балгадын даргаст, ноёдод, зорчин явах элч нарт, олон иргэнээ дуулгах бичиг. Чингис хааны ба хааны зарлигт тойд, эрхүүд, сэншинүүд, дашмад аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч, ерөөл өгөн атугай хэмээдэгсэд ажгуу. Эдүгээ бээр бөгөөс урьдын зарлигийн ёсоор аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч, ерөөл өгөн атугай хэмээн эд Ан си фу-д бүхүн Шю жэнь гуань, Хуа ян гу, Дун юэ мяо нэрстэн сүмд ахун ти дянь Моу жи тун, Ти лин жан даол жи, Ти жу зань жи жянь, Зао дао цун тэргүүтэн сэншинүүдэд барьж явах зарлиг өгвэй. Эдний гуаньд, хийдэд нь элчин бүү буутугай. Улаа шүүс бүү барьтугай. Цэцэрлэг, тээрэм, дэн буудал, мухлаг, данж юу хээг нь булааж татаж бүү автугай. Эд бас Мао жу тун тэргүүтэн сэншинүүд бичигтэн ал хэмээж өөрийн харьяа үгүй ард шунуулан үгүй үйлс үйлдэн явбаас үл айх уу. Мөн бичиг маань морин жил зуны тэргүүн сарын хорин нэгнээ Кай чэн фу-д бүхүйд бичвэй.”¹⁴
4. Өлзийт хааны (1265–1307) 1301 оны нэгэн зарлигт “Мөнх тэнгэрийн хүчинд Их Суу залийн ивээл хааны зарлиг маань цэргүүдийн ноёдод, цэрэг ардад, балгадын даргаст, ноёдод, зорчин явах элч нарт, дуулгах зарлиг. Чингис ханы ба Өгэдэй хааны ба Сэцэн хааны ба зарлигт тойд, эрхүүд, сэншинүүд аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч, ерөөл өгөн атугай хэмээдэгсэд ажгуу. Эдүгээ бээр бөгөөс урьдын зарлигийн ёсоор аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч, ерөөл өгөн атугай, Цалбад харьяатан Гон жалын орноо Сам дув син ки тэргүүтэн олон тарничдад барьж явах зарлиг өгвэй. Эдний сүмд, хийдэд нь элчин бүү буутугай. Улаа шүүс бүү барьтугай. Сан, тамга бүү өгтүгэй. Сүмд эл харьяатан газар, ус, цэцэрлэг, тээрэм, юу хээг нь булааж татаж бүү автугай. Эд бас тарничид зарлигтан хэмээж ёс үгүй үйлс бүү үйлдтүгэй. Үйлдвээс үл айх уу. Мөн зарлиг маань үхэр жил хаврын дундад сарын хорин тавнаа Дайду-д бүхүйд бичвэй.”¹⁵

¹³ Баярсайхан, Б.: *Монголын хууль тогтоомжийн ...*, т. 70.

¹⁴ Баярсайхан, Б.: *Монголын хууль тогтоомжийн ...*, т. 71.

¹⁵ Баярсайхан, Б.: *Монголын хууль тогтоомжийн ...*, т. 72.

5. Дээрхтэй ижил агуулга бүхий зарлиг 1303 оны Се Үсегийн бичиг, 1305 оны Хан хөвгүүн Хайсангийн зарлиг, 1306 оны Өлзийт хааны зарлиг, 1312–1314 оны Буянт хааны зарлиг, 1323 оны Гэгээн хааны зарлиг, 1324 оны Есөнтөмөр хааны зарлиг, 1335, 1336, 1342, 1343, 1345, 1351 оны Тогоонтөмөр хааны зарлигуудад¹⁶ тусгагджээ.

Дээрх зарлигууд нь Чингис хаанаас эхлэн Их Монгол улсын хаад мөн Хубилай хаанаас уламжлан ирсэн хэм хэмжээ болохыг тодорхой өгүүлсэн бөгөөд зарлигийн агуулга нь:

- “Мөнх тэнгэрийн хүчинд Их суу залийн ивээлд Хаан зарлиг маань чин ван үг маань
- цэргүүдийн ноёдод, цэрэг ардад, балгадын даргаст, ноёдод, зорчин явах элч нарт, дуулгах зарлиг
- Чингис ханы (хааны) ба хааны зарлигт
- Тойд (буддын шашны лам нарыг хэлдэг тойн гэдэг үгийн олон тоо), эрхүүд (христос шашны санваартан нарыг хэлдэг эрхүүн гэдэг үгийн олон тоо), сэншинүүд (бомбын шашин буюу даосизмын санваартан нарыг нэрлэдэг сэншин гэдэг үгийн олон тоо), дашмад (мусалман буюу лалын шашинтан хүнийг нэрлэдэг дашман гэдэг үгийн олон тоо)
- урьдын зарлигийн ёсоор
- аливаа алба гувчуур үл үзэн
- тэнгэрийг залбирч ерөөл өгөх,
- сүм хийдэд нь элчин бүү буух,
- улаа шүүс бүү барих,
- цэцэрлэг, тээрэм, дэн буудал, мухлаг, данж юу хээг нь булааж татаж үл авах,
- аливаа санваартан, шашны зүтгэлтнүүд, бичигтэн хэмээж ёс үгүй үйлс үйлдэж эс болох.

Зарим зарлигт нь:

- хөнгөлөлтөөс чөлөөлөгдөх нэр бүхий лам, санваартангуудын нэрийг цохон тэмдэглэсэн
- морь, үхэр тэжээлгэхгүй байх
- ан ав үл авлах ... зэргийг онцгойлон заасан байна.

Эдгээр зарлигаас харахад Монгол хаад шашны олон урсгалын санваартангуудыг тус бүр өөр өөрөөр нэрлэн зарлиг тунхаг гаргаж байсан нь харагдана. Их Монгол улсын төрийн бодлогоор бүх шашинд адил тэгш хандаж, алба гувчуурын хөнгөлөлт үзүүлж байсан нь Монголчууд байлдан дагуулсан улс орнуудын шашин шүтлэгийг өөрсдийн бөө мөргөлөөс илүүд үзсэндээ биш

¹⁶ Баярсайхан, Б.: *Монголын хууль тогтоомжийн ...*, т. 72–106.

харин Чингис хааны “биеийг нь хураахаас сэтгэлийг нь хураа” гэсэн бодлоготой шууд холбоотой байв. Энэ бодлого Их Монгол улсаас, Монголын Эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудын үед хүчтэй дэлгэрч газар бүрт олон арван ард түмний шашны сүм хийдүүд нийгэм, эдийн засгийн талаар бүрэн биеэ дааж тэдгээрийн санваартнуудын нийгмийн байр суурь хийгээд нэр хүнд нь ихэд дээшилж, улс төрийн хувьд ч тодорхой нөлөө үзүүлж байсан нь Монгол төрийн бодлогын үр дүнд “Их засаг”-аас уламжлалтай эрх зүйн хэм хэмжээ тогтоож байсны нэг илэрхийлэл юм.

Их Монгол улс, Монголын эзэнт гүрний үеийн шашны бодлоготой холбоотой хэм хэмжээнүүдийг “Их засаг”-т хамууруулан ойлгож, олон сурвалжийн мэдээнээс шүүрдэн цуглуулж дараах судлаачид ингэж тодорхойлжээ. Рязановски: “Чингис хааны тогтоосноор:

- Али-бек, Абу-Талев нарын үр удмынхан цөмөөрөө алба гувчуураас чөлөөлөгдөнө. Тэрчлэн Ал-Кораныг уншиж судлагчид, хууль зохиогчид, эмч домч нар, бясалгал даяан хийж, мөргөл залбиралд амьдралдаа зориулсан шинжлэх ухааны хүмүүс, муэдзин нар хийгээд талийгаачийн ясыг баригчдад алба гувчуур бүү ноогдуултугай.
- Аль нэгийг нь илүүтэй үл үзэн бүх шашин шүтлэгийг хүндэлж байхаар тэрээр заасан бөлгөө.
- Аль нэгэн сектийг (шашныг) онцгойлон бишрэхийг хориглох, хүндэтгэлийн нэр зэргийг үл дуудах агаад султан хийгээд өөр хэн нэгэд хандах болбол зүгээр л нэрээр нь хандах.
- Гэмт хэргийн учир алагдах ялаас өр төлөөсөөр амь гарч болох бөгөөд лалын шашинтан хүний төлөөсөнд 10 алтан зоос, Хятад хүний төлөөсөнд нэг илжгээр төлнө.
- Чингис хааны засаг хууль нь худал хэлэх, хулгай хийх, завхайрахыг хориглодог бөгөөд ойр дотныхоо хүмүүсийг өөрийн бие мэт хайрлаж, гомдол доромжлол үл үзүүлэн тэдгээрийг ор тас мартаж ба сайн дураар бууж өгсөн улс орон, хот тосгоныг хайрлан, бурхан тэнгэрийн сүм хийд, тэндэхийн тахилчид, зүтгэлтнүүдийн аливаа татвараас чөлөөлөн хүндэтгэл үзүүлж байх.”¹⁷

Намжил: “Эл зүйлийн шашин суртахууны доторх эрдэм мэдлэгтэй чин сүжигтэй хүмүүсийг эрхэмлэн хүндэтгэмүй. ... Эл шашинд адил тэгш хандмуй.”¹⁸ Сайшаал: “Аливаа шашин суртахууныг хүндэтгэмүй. Гэвч ямар нэгэн шашин ч онц эрхийг эдэлж үл болмой. ... Эл шашны ахмад хэргэмтэн шавь нарыг ангийн алба, гааль гувчуураас онцгойлон хэлтрүүлмүй”¹⁹ хэмээжээ.

Ийнхүү янз бүрийн саналтайгаар “Их засаг” дахь шашны хэм хэмжээг бүрдүүлж байгаа бөгөөд доктор Ц. Энхчимэг Монголын төрөөс явуулж буй

¹⁷ Рязановски, В. А.: *Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, их засаг хууль*. Улаанбаатар 2000, т. 72–73.

¹⁸ Namjil, K.: *Cinggis qaγan-u jasaγ ba bilig*. Qayilayar 1990, т. 131.

¹⁹ Сайшаал, Б.: *Чингис хааны товчоон*. Улаанбаатар 2003, т. 433–434.

шашны бодлогыг нийтэд нь “Эзлэгдсэн орнуудын ард түмнийг оюун санаагаар нь захирч байхын тулд төрөөс бүх шашныг хүлээн зөвшөөрөх бодлогыг явуулж байв. Бодит амьдралд энэхүү бодлогыг хэрэгжүүлэх нь шашин хоорондын зөрчлийг урьдчилан сэргийлж энхийг сахиулахад чиглэж байв²⁰ гэсэн дүгнэлт хийсэнтэй нь санал нэг буйгаа энд тэмдэглэхийн дээр чухам шашны эрдэм номтой мэргэдэд эдийн засгийн хөнгөлөлт үзүүлэн, амьдралын баталгаагаар хангаж, сүм хийдийг нь өргөжин тэлэхэд нь, залгамж үеэ бэлдэх сургууль байгуулахад нь төрөөс тусламж үзүүлэн тэтгэж, тэдний оюун ухааныг уралдуулан бодол санааг нь солилцох нөхцөлийг нь бүрдүүлж, тэднээс улбаалан төрөл бүрийн салбарт нийт ард түмэнд нөлөөлөх хууль цааз, урлаг, соёлын хүрээ ч Их Монгол улс цаашлаад Монголын Юань улсад өргөжин тэлж байсныг дээрх хэдэн зарлигаас харж болохоор байна.

Дүгнэлт

“Их засаг” нь алтан ургийнхны эв нэгдэл, цаашлаад дэлхийн олон шашинт улс үндэстэнг нэгтгэн Их Монгол улсын захиргаанд байлгахад чиглэгдэж байв. Тиймдээ ч Их Монгол улс Монголын Эзэнт гүрэн болон өргөжихөд бүрэлдэхүүн улсуудад нь “Их засаг” нь хууль зүйн дээд хүчин чадалтай үйлчилж байв. Бүрэлдэхүүн улсуудын хаад “Их засаг”-т нийцүүлэн, уламжлан авсан хэм хэмжээ мөн шинээр эрх зүйн хэм хэмжээ тогтоож байсны нэг хэсэг нь ийнхүү шашин, шүтлэгтэй холбоотой хэм хэмжээ байв.

Монголчуудын шашин шүтлэг нь мөнх тэнгэр, бөө мөргөл байсан бөгөөд бурхны шашинт Хар Хятан, несториан шүтлэгтэй Хэрэйд, Найман, Онгууд нарыг захиргаандаа оруулж Их Монгол улсыг байгуулаад, исламын болон загалмайн шашинт улсуудыг байлдан дагуулахдаа тэдний шашин шүтлэгт нь адил тэгш хандаж байв. Гэвч энэ байр суурь нь Монголын Эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудын хувьд аль нэг шашныг төрийн шашин болгон өргөмжлөх, алтан ургийнхнаас аль нэг шашинд илүүтэй найр тавих бодлого хэрэгжих болов.

Энэ нь Юань улсын үед гаргаж байсан шашинтай холбогдолтой эрх зүйн хэм хэмжээ тогтоосон зарлигуудад тусгалаа олсон бөгөөд шашны талаар явуулж байсан төрийн бодлого нь зарим агуулгын хувьд өөрчлөгдсөн ч Чингис хааны “Их засаг”-т бичигдсэн хэм хэмжээ болгон тогтоож өгсөн заалтуудаас уламжлалтай хэмээн үзвэл зохино.

Ном зүй

Erdenebat, U. – Ernst, Pohl: *Aus der Mitte der Hauptstadt – Die Ausgrabungen der Universität Bonn im Zentrum von Karakorum* [Нийслэл хотын төвөөс – Хархорины төв дэх Бонны их сургуулийн малтлага]. In: *Katalog Dschingis Khan*

²⁰ Энхчимэг, Ц.: Шашны талаар их хаадын явуулсан бодлогын асуудалд. *Угсаатан судлал цуврал* XVII (2006), т. 128.

- und seine Erben: Das Weltreich der Mongolen*. Ed. by Jutta Frings. Hirmer, Bonn 2005, т. 168–175.
- Namjil, K.: *Činggis qaγan-u ĵasaγ ba bilig*. Qayilaar 1990.
- Rashīd al-Dīn: *The Successors of Genghis Khan*. Tr. by John Andrew Boyle. New York – London 1971.
- Ата-Мелик Жувейни: *Чингисхан История Завоевателя Мира* (Перевод с текста Мирзы Мухаммеда Казвини на английский язык Дж. Э. Бойла, с предисловием и библиографией Д. О. Моргана. Перевод текста с английского на русский язык Е. Е. Харитоновой). Москва 2004.
- Баярсайхан, Б.: *Монгол улсын арван буянт номын цагаан түүх*. Улаанбаатар 2006.
- Баярсайхан, Б.: *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл* (1206–1910), I. Улаанбаатар 2010.
- Рерих: *Аав хүү Рерих нар ба Монгол*. Ред. Ш. Бира. Улаанбаатар 2008.
- Рубрук: *Дорно этгээдэд зорчсон минь*. Франц хэлнээс орос хэлэнд орч. Бержерон, орос хэлнээс монгол хэлэнд орч. С. Туяа. Улаанбаатар 1988.
- Рязановски, В. А.: *Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, их засаг хууль*. Улаанбаатар 2000.
- Сайшаал, Б.: *Чингис хааны товчоон*. Улаанбаатар 2003.
- Энхчимэг, Ц.: Шашны талаар их хаадын явуулсан бодлогын асуудалд. *Угсаатан судлал* XVII (2006), т. 124–128.
- Эрдэнэбат, У.: Мартагдсан загалмайн тухай тэмдэглэл: Түүхийн хуудас сөхвөл. *Studia Archaeologica* (IV) XXIV, Fasc. 25 (2007), т. 363–398.

МОНГОЛЧУУДЫН ОЮУН САНААНЫ НЭГДЭЛ БА ЗАДРАЛД БУРХНЫ ШАШНЫ ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Яйшийн Шийлэгмаа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Улаанбаатар

Монголын эзэнт гүрний үед (1206–1368) Монгол оронд олон шашин зэрэгцэн оршин байв. Тухайн үед Монголын төр ямар бодлого баримталж байсан бэ? Чингис хаан хийгээд түүний дараах хаадын үед “биеийг нь эзлэе гэвэл сэтгэлийг нь эзлэе, сэтгэлийг нь эзлэвээс бие нь хаа холдох”¹ хэмээн ямарваа ард түмнийг эзлэн захирах хүч болгон аливаа шашинд ижил хандах бодлогыг баримталж байсан нь улс төрийн учир шалтгаантай болно. Монголын их гүрний анхны хаад Хархорумд төвлөрч байхдаа бурхны шашныг зарим талаар тэтгэж байсан мэдээ бий. 1346 онд монгол, хятад хэл дээр зохиосон, Эрдэнэ зуугийн сууринаас олдсон чулууны бичээст дурдсан ёсоор Өгэдэй хаан бурхны шашны нэгэн том сүмийн суурийг тавьж, улмаар 1256 онд Мөнх хаан уг барилгыг барилуулж дуусгажээ.²

Бурхны шашин нь сажавагийн (тө. *sa skya pa*) ёсны хэлбэрээр Төвд нутгаас дэлгэрч 1246 оны эцсээр сажава ёсны тэргүүн Сажа бандида Гунгаажалцан (1182–1251) Хөх нуурт хүрэлцэн ирж, 1247 оны эхээр Чингис хааны ач Годан (1206–1251) лугаа уулзаж, “Тахилын лам, Өглөгийн эзний” барилдлагааг тогтоосон нь Монгол дахь бурхны шашны дунд дэлгэрлийн эхийг тавьжээ.

Улам хүчирхэгжин буй Монголын язгууртны ашиг сонирхолд бөө мөргөлийн шүтлэг нийцэхээ больсон байв. Хубилай хаан эзэлсэн орны ард түмнүүдээ дан ганц хүчээр захирч болохгүйг ухаарч байсан тул тэдний оюун санааг эзэмдэхийн тулд боловсронгуй тогтолцоо бүхий шашин хэрэгтэйг ойлгон төрийн шашны эрэлд морджээ. Тэрээр Ромын Пап лам IV Инносенийд (1195–1254) эрдэм номтой 100 лам явуулахыг хүсч захидал илгээж байсан нь үүний нотолгоо юм. Хубилай хаан (1215–1294), Хятадын иргэншлийг таашаан үздэг байсан хэдий ч Төвдийн бурхны шашныг сонгосноор Монголчуудыг оюун санааны хувьд Хятадын нөлөөнд орохоос сэргийлж чадсан байна.

Бурхны шашин монголыг ард түмний оюун санаанд нөлөөлөөд зогсохгүй, Монгол орны улс төрийн амьдрал, үндэсний хөгжилд ч багагүй нөлөө үзүүлсэн билээ. Тиймээс бурхны шашин Монголчуудын үндэсний онцлог, бие даасан байдлаа хадгалж үлдэхэд нөлөөлөөд зогсохгүй “Цагаан хэрэм”-ний зүгээс ирэх аюулын эсрэг хүчтэй хаалт болсон байна. Монголчууд улс төрийн нэгдэл, тус-

¹ Очирбат, П.: *Тэнгэрийн цаг*. Улаанбаатар 1996, т. 22.

² Лхагвасүрэн, Г.: Монголын бурхны шашин: нийтлэг онцлогийн асуудал. *Mongolica* 15 (36) (2004), т. 93–94.

гаар тогтнолоо үзэл санааны хувьд шашны нэгдлээр илэрхийлж, түүнийг нэгэн тулгуураа болгож байжээ.³

Юань гүрэн мөхөхөд бурхны шашин Монголчуудад нөлөөтэй байж чадаагүйгээс үзэхэд Хубилай хаан шашныг зөвхөн Төвд болон бусад улс, ард түмнүүдийг оюун санааны хувьд нэгтгэх улс төрийн бодлогодоо ашиглаж байсан хэмээн үзэж болохоор байна. Нөгөөтэйгүүр Монголчуудад эзлэгдсэн янз бүрийн үндэстнийг өөрийн эрх мэдэлд нэг шашнаар нэгтгэн захирах хүчирхэг зэвсэг болгон тогтоон барьж байх, бурхны шашны номлол, сургаалыг Монголд нэвтрүүлж оюуны дархлаатай болгох зорилготой байжээ.

Монголчууд бурхны шашныг өргөмжлөн залснаар ном зохиолыг олноор орчуулах болсны зэрэгцээгээр эрдэм номонд нэвтэрсэн их сэтгэгч, гүн ухаантнууд ч төрөн гарчээ. Тэднээс онцлон дурдвал, Чойжи-Одсэр бандид, Энэтхэгийн нэрт гүн ухаантан Шантидева (685–763)-гийн “Бодьсадын явдалд орохуй” (са. *Bodhicaryāvatāra*) хэмээх гүн ухааны алдарт найраглалд 300 гаруй хуудас тайлбар зохион 1312 онд Дайдугийн Цагаан суваргат их сүмд мянган хувь хэвд буулгасан ба мөн алдарт монгол хэл зүй “Зүрхэн толь”-оо туурвисан билээ. Ийнхүү бурхны шашны дунд дэлгэрлийн үеэс Монголын лам мэргэд бие даасан ном, шастир туурвин бүтээх хэмжээнд хүрсэн. 1330 онд “Дөрвөн төрийн арван буянт номын Цагаан түүх” хэмээх төр ёсны алдарт дурсгал бичгийг эмхлэн гаргасан байдаг. Нөгөө талаар сүм хийд лам нар нь ард олны оюуны эрэлт хэрэгцээг хангах үүргийг биелүүлж байв.

Юань улсын эрх баригчид олон үндэстэн, угсаатны ард олны ухамсар сэтгэхүйг жолоодсон олон шашны лам хувраг, сүм хийдийг алба гувчуураас чөлөөлж, шашин бүрт ижил, тэгш хандах бодлого хэрэгжүүлснээр эзэнт улсын дотор үндэстэн ястан, соёл иргэншил хооронд гарч болох элдэв зөрчил, мөргөлдөөнөөс сэргийлж, мөн Монголын ноёрхлын эсрэг тэмцэл гаргуулахгүй байх нөхцөлийг хангаж чадсан ажээ.⁴

Монголын Юань улс мөхсөний (1368 он) дараагаас бурхны шашны нөлөө алдагдан бөөгийн шашин урьдын адил Монголчуудын дунд дахин сэргэсэн билээ. Давааны арын муж хэмээн нэрлэгдэх болсон Монголчуудын уугуул нутагт бөө мөргөлтэй хэвээр байв.

Энэ үед Монголын ихэс дээдэс дор бүрнээ эзэмшил нутагтаа бурхны шашныг дэлгэрүүлэхийг оролдсон шалтгаан нь тасралтгүй дайн дажинд зүдэрсэн ард олны уур хилэнг номхруулах, шашны зүгээс дэмжлэг авах зорилготой байв. Тухайн үед Монголчууд бурхны шашныг хүлээн авсан нь цусаар давалгаалсан их мөрнийг сүүн далай болгон хувиргасан⁵ хэрэг байв. Ийнхүү дотооддоо дээдсийн ноёрхлыг бэхжүүлэх, ард олны эсэргүүцэл тэмцлийг намжаах, алив зөрчил мөргөлдөөнийг эвийн аргаар шийдвэрлэх зэрэг оюун санааны хэрэгцээний улмаас шашин дэлгэрэх зайлшгүй түүхэн шаардлага Монголын нийгэмд бүрдсэн байна.

³ Лувсанцэрэн, Г.: *Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас*. Улаанбаатар 2008, т. 202.

⁴ Ганболд, Ж. ба бусад: *Монголын Юань улс*. Улаанбаатар 2006, т. 128.

⁵ Felipe, Fernandez Armes: *Civilizations: Culture, Ambition, and the Transformation of Nature*. The Free Press, New York 2001, т. 151–152.

XVI зуунд Монголчууд бурхны шашны нөлөөнд нэлээд хүчтэй автаж, лам хуврагын тоо олширч, сүм хийд элбэгшсэн тул энэ бүхнийг оройлон манлайлагч хэрэгтэй болж эхэлсэн юм. Анхдугаар Богд Жавзандамба хутагт болох Өндөр гэгээн Занабазар (1635–1723)-ыг, Монголын ноёдууд, Богдод өргөмжлөх болсон шалтгааны тухайд гэвэл Занабазар Түшээт ханы хүү байсан тул Чингисийн алтан ураг болох бөгөөд Богд гэгээнийг хаанд өргөмжилснөөр Чингисийн алтан урагт төрийн алтан жолоо дахин шилжлээ хэмээн ойлгогдох болсон юм. Ямартай ч бурхны шашныг хүлээн авсан нь Монголчуудын оюун санааны нэгдэлд чухал хувь нэмэр болсон юм.

Дорно зүгт Зүрчидийн Нурхайч (1575–1626)-аар толгойлуулсан Умардын Алтан улс бий болж, Монгол аймгуудын хагарал дээр тоглож эхэлсэн нь Монголчууд улаан, шараар талцаж дайтахад нөлөөлсөн нь дамжиггүй. Цахарын Лигдэн хаан (1592–1634) бүх Монголын нэр төдий хаан болж, Монгол орны гадаад байдал нэн хүндэрсэн энэ үед Далай лам тэргүүтэй шарын шашны төлөөлөгчид шинэхэн хүчирхэг улсад тал засан улмаар 1642 онд Манжийн хааныг Манзуширын хувилгаан хэмээн өргөмжилсөн нь Монголын тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцэлд оюун санааны цохилт өгсөн хэрэг болов. Нөгөөтэйгүүр Монголын зарим ноёдууд харийнхны арга мэхэнд автан тэдний талд зүтгэн идэвхгүй байр суурь баримталж байв.

Ийнхүү Монголчууд тусгаар тогтнолоо алдаж, Манжийн дарангуйлалд орсон XVII зууны сүүлчээс бурхны шашин бүтэц, зохион байгуулалтын хувьд төлөвшин тогтож, Монголчуудын үндсэн шүтлэг болжээ. Манж нар Монголчуудыг эзлэн авах, тэднийг номхон хүлцэнгүй байлгахад бурхны шашныг ямар нэгэн хэмжээгээр ашигласан байна. Нөгөө талаар хүрээ хийдүүд нь соёл, боловсрол, урлаг, мэдлэг ухааны томоохон төв болж байв.

Бурхны шашны дэлгэрэлт ба Манжийн улс төрийн бодлого

Энэ мэт зүүлт, тайлбар, ишлэлийг өгүүлбэрийн дунд жижиг үсгээр шигүү бичих, доогуур зурах (“Алтан хүрдэн мянган хигээст хэмээх бичиг”, 1739), тодоор буюу өөр өнгөөр тэмдэглэх (Түүхийн товч, Цэцэн хан Шолойн 11 хөвгүүний нэрс) зэргээр бусад бичвэрээс ялган цохон тэмдэглэсэн зүйл бий. Үүнээс үзэхэд цохолбор нь номын доторх гол гол зүйлийг онцлон ойлгоход зориулж хийгддэг номзүйн мэдээллийн нэг төрөл гэж үзэж болно.

Монгол судрын 4–100 гаруй мөр шүлэгтэй “төгсгөлийн үг”

Зая бандид Намхайжамц (1599–1662)-ын орчуулсан “Манигамбум”-ын (1712) төгсгөлийн шүлэг зуу гаруй мөр бол “Үлгэрийн далай,” “Алтангэрэл” зэрэг сударт 3–4 мөр шүлэг оржээ. Ийм шүлэг юуны өмнө зохиолын талаарх мэдээллийг агуулахаас гадна судрын их бага, зохиогчийн уран чадварыг харуулсан яруу сайхан үг хэллэгийг давхар илтгэнэ. Утга зохиол судлаачид “төгсгөлийн үг”-ийг “колофон” нэрийн дор тусгайлан авч үзсэн байдаг.

Монгол судрын төгсгөлийн үг, хэвийн мэдээ хоёр холимог нийлмэл шинжтэй юм. Заримдаа төгсгөл үгэнд “хэвийн мэдээ” багтах, “хэвийн мэдээ”-нд багавтар төгсгөлийн үг орсон шинжтэй. “Хэвийн мэдээ” бол орчин үеийн “гаралтын мэдээ” юм. Гэтэл Монгол судрын хэвийн мэдээнд маш өргөн дэлгэр тайлбар, шүлэг, тэмдэглэл орсон нь энгийн бүтэцтэй гаралтын мэдээнээс ялгаатай. Тиймээс “хэвийн мэдээ”-нд бичсэн, орчуулсан номын нэр, хэвлэхэд зориулан барын хэв сийлсэн, үнсэн самбар дээр бичсэн, цаасан дээр буулгасан хүмүүсийн нэрс хийгээд хаана, хэдийд бар сийлсэн, хаана хадгалагдаж байгаа зэрэг мэдээг ялган авч үзэх шаардлагатай.

“Сайн номлол эрдэнийн сан Субашидын тайлбар чандманын түлхүүр хэмээгдэх оршив” зохиолын төгсгөлийн үгэнд: “Сайн номлолын хэвийн бичгийг сайн буянт Цахар хөвөөт цагаан Фунинга сумын Сайн заяат Ойдов хөвүүн бээр хичээн бичив. Сайн өлзий амар жаргал хэв хэзээд дэлгэрэх болтугай” гээд шинээр зохиосон номуудын хэв сийлэхэд олны өргөл цугласнаас үлдсэн мөнгөөр Субашидын тайлбарыг хэвд бүтээв. Энэхүү хэв нь Цахар хөвөөт цагаан хошууны Цагаан уулын сүмд бий гэсэн тэмдэглэл хэвийн мэдээний үндсэн бүтэц юм.

Монгол судрын “хэвийн мэдээ” -г дараах төрөлд ангилан үзэж болно.

1. Цаг хугацааны мэдээлэл:

- а) Махбодын өнгөөр: гал барс жил, усан хулгана жил, модон гахай жил г.м.
- б) Манжийн хаадын он дарааллаар:
 Эээр засагч хааны үе (1644–1662)
 Энх Амгалан хааны үе (1662–1723)
 Найралт төв хааны үе (1723–1736)

⁷⁷ Инжаннаши, В.: *Хөх судар*, т. 51.

Тэнгэрийг тэтгэсэн хааны үе (1736–1796)

Сайшаалт ерөөлт хааны үе (1796–1820)

Төр гэрэлт хааны үе (1821–1850)

Бадруулт төр хааны үе (1850–1908).

ө) Жарны он тооллоор: 12 дугаар равжүн (1723 оноос) г.м.

2. Зохиогчийг монгол, төвд, санскрит нэрээр.

3. Хаана хэвлэснийг барханы нэрээр (Арвай хээрийн барханд хэвлэсэн) эсвэл сүм хийдийн нэрээр (Агийн дацанд хэвлэсэн).

4. Хэвлэлийн хэлбэрийг а) их барын гарчиг, б) дунд барын гарчиг, в) өвөр судрын гарчиг. Хэвийн мэдээнд “Зохиогчийн тэмдэглэл,” “Орчуулагчийн тэмдэглэл” заримдаа холилдон орсон. “Зохиогчийн тэмдэглэл”-д уг зохиолыг хэдийд, хаана, хэн бичсэнийг голлон тодорхойлохоос гадна уншигчдад хандсан үг:

“Алдад унал болсон байвал

Аливаа мэргэдэд наминчилан өчмүй

Ариутган засаж тогтоох бээр

Тусыг бүтээж соёрх ...” гэх мэт зүйл оржээ. Ийм тэмдэглэл голдуу иргэний шинжтэй номд тааралдах ба харин бурхны шашны сударт мөргөлийн үгтэй холилдсон байх нь олонтоо. “Орчуулагчийн тэмдэглэл”-д хэдийд, хаана, хэн орчуулсан, орчуулахад дэмжлэг үзүүлсэн хүний нэр, орчуулах болсон учир шалтгааныг тоочин бичих ба бурханы судар номд бол элдэв ерөөл магтаалын хамт оржээ. Жишээ нь: “Таравчинбо” судрын төгсгөлийн шүлгийг нэрлэж болно.⁸⁸ Тухайлбал:

“Энэ хутагт ихэд тонилгогч зүүдэд дэлгэрсэн судар

Эгүүнээс урьд бүх бус мэргэдийн орчуулагсад

Энэ монгол газраа олон буй бөгөөс – бээр

Эсрэг тэсрэг үг утга нь зохилдох бусын тул

Тэгүүтгэрэлгүй сүсэгт Баясгасан нарт Тидши

Тэмдэгтээ орчуул хэмээн бас бас дургтгасанд

Тэд мэргэдийн орчуулагсдыг буруушааж бурчиж засваас л

Тэрслэхүй найдангүй – бээр үйлдсэн хэмээгдэх бүхийн тул

Тэл хэлт Алтангэрэл увш

Төвдийн олон эх бичгүүдийг тохиолдуулж

Төсөлж мэдсэнийхээ чинээгээр монгол аялгууд

Төгсгөн засаж оршуулбай би ...” хэмээх шүлгээс үзэхэд урьд өмнө орчуулагдсан, энэ удаа эх зохиолтой тулгаж зарим буруу ташаа орчуулсныг залруулан шинэчилсэн зэрэг мэдээллийг авч болохоор байна.

“Тахилын үг,” “мөргөлийн шүлэг” хоёр давхцаж болдог бол аль ч зохиолын төгсгөлийн үгэнд зохиолын он цагийн мэдээ давхцдаггүй учир ном бүтээсэн он цаг, холбогдох эх зохиол, хэд дэх хэвлэл болохыг олж тогтоох боломж бий. Жишээ нь: Монгол Ганжуурын төгсгөлийн үгэнд: “... Лигдэн хааны зарилгаар

⁸⁸ Дамдинсүрэн, Ц.: XVII зууны эхний үеийн орчуулагч Алтангэрэл Увшийн тухай зарим мэдээ. *Studia Mongolica* 5, Fasc. 9 (1966), т. 10.

Гунгаа-Одсэр бандидын хүчинд дулдуйдан орчуулсан” гэсэн бол Монгол Данжуурын төгсгөлийн үгэнд: “II Жанжаа хутагт Ролбийдоржийн (1717–1786) удирдлагаар зохиосон “Мэргэд гарахын орон” толь бичигт түшиглэн орчуулсан” гэжээ. Хааяа нэг газар хэний хүсэлт, дэмжлэгээр, ямар зорилгоор уг номыг бүтээсэн талархлын үг бичсэнийг “Баясалын сайшаал” хэмээн тэмдэглэжээ. Тухайлбал, “Тунгалаг тодорхой мөрнөөс буусан эрдэм төгөлдөр, рашаан үүнийг тогтоон авагчид, тодорхой толь мэт ашид сурагч, багш нөхөд олноор баясан таалан анисан мэт нүдээ нээж анхааран утгыг шинжлэхүй ач тустай” гэснийг “Баясалын сайшаал” гэжээ.⁹⁹



Товч, дэлгэрэнгүй гарчгийн тэмдэгтийн тоо		
Бүлгийн тоо	Товч гарчгийн үсгийн тэмдэгтийн тоо	Дэлгэрэнгүй гарчгийн үсгийн тэмдэгтийн тоо
1-р бүлэг	132	198
2-р бүлэг	56	267
3-р бүлэг	54	317
4-р бүлэг	44	462
5-р бүлэг	46	243
6-р бүлэг	48	336
7-р бүлэг	55	253
8-р бүлэг	56	287
9-р бүлэг	54	574
Дундаж тоо	61	326

Хүснэгт 1–2. Үсгийн тэмдэгтийн эзлэх хувь.

⁹⁹ Төмөрцэрэн, Ж.: Номын соёлын тухай хэдэн үг. *Шинжлэх ухаан амьдрал* 2 (1971), т. 32–36.

Зарим сургаалийн төрлийн номын төгсгөлийн үг нь шашны утга зохиолын адил тахил, мөргөлийн үгээр эхлээгүй ч элдэв ерөөлийн үгтэй хамт орсон нь уламжлалт бичилт гэж үзэхээр юм.

“Зулын өмнө сарын дор
Зуны урт, өвлийн үед
Үзгийг дэвтээж, бэхсээр наадан
Нэгэн ижийг төгсгөв ...”¹⁰

Төвд хэлт монголын утга зохиолын төгсөл үгэнд “элдэв тэмдэглэл” хэмээх хэсэг байна.¹¹ Энэ нь тухайн онцолсон сэдэв зүйлд холбогдох он цаг, хаанаас үзэж болох эх хэрэглэгдэхүүн, лавлах бичгүүдийг голлон нэмэлт болгож оруулсан тэмдэглэл юм. Дээр авч үзсэн “Монгол судрын мэдээллийн нэр, төрөл”-ийн бүтцийг “Хамгийг айлдагч Богд Зонхавын цагид” хэмээх зохиолын жишээн дээр авч үзвэл (*Хүснэгт, график-1-д үз*):

Энд нийт 27 тусгай нэрийн гарчиг орсны хамгийн бага нь 44 буюу 28%, их нь 574 буюу 72% үсгийн тэмдэгтэй. Дунджаар товч нэр нь 61, дэлгэрэнгүй нь 326 үсгийн тэмдэгт байна. Энэ нь дэлгэрэнгүй нь товчоос 5,3 дахин их байгаа нь харагдана. “Монголын нууц товчоо” г.м. богино нэртэй судартай харьцуулбал бараг 30–50 дахин, түүнээс дээш олон тэмдэгтэй байх магадлал өндөр юм. Иймд Монгол судрын нэрийн агуулга, мэдээллийн багтаамжийг сайтар судалж орчин үед цахим мэдээллийн сангийн өгөгдөл программ зохиох, товч дэлгэрэнгүй нэрээр дуудаж хайх зэрэг олон талын практик ач холбогдолтой.

Монгол судрын мэдээллийн бие даасан бүтэц

Монгол судрын гарчгийн бүтцэд томоохон байр эзэлдэг төрөл бол олон сэдэв чиглэлийн бие даасан гарчгийн бүтээл юм. Энэ нь зохиолын хавсралтаар болон бие даасан хэлбэрээр уламжлагджээ. Ийм бүтээлийг ерөнхийд нь ангилж үзвэл:

- Он дараалсан бичгийн гарчиг
- Элдэв лавлахын гарчиг
- Судрын гарчиг.

Он дараалсан бичгийн гарчигт: 1. Овог аймаг, гэрийн үеийн бичгийн гарчиг, 2. Сүм хийд, лам нарын түүхэн нэрийн гарчиг, 3. Хутагт хувилгаадын дүр олсон түүхэн нэрийн гарчиг, 4. Түүх-газарзүйн тэмдэглэлийн нэрийн гарчиг, 5. Шашны түүхт холбогдох нэрийн гарчиг орно.

Элдэв лавлахын гарчигт: 1. Намтар түүхийн нэрийн гарчиг (сүмбүм, тө. *gsung 'bum*), 2. Ном сонссоны (санъяаг, тө. *gsang yig*) ба хүртсэний (жүдрэм, тө. *rgyud rim*) тэмдэглэлийн гарчиг, 3. Элдэв тэмдэглэл, дохионы бичиг, лавлахын гарчиг орно.

¹⁰ Дамдинсүрэн, Ц.: *Монголын уран зохиолын тойм*. III дэвтэр. Улаанбаатар 1968, т. 112.

¹¹ Цээн, Ж.: *Монгол номзүйн онол түүхийн зарим асуудал*. Улаанбаатар 2002.

Судрын гарчигт: 1. Барын гарчиг, 2. Ганжуур, Данжуурын гарчиг, 3. Сүмбүм зохиолын гарчиг зэрэг орно.

Дүгнэлт

Монгол судрын “гарчгийн” мэдээллийн онцлог шинжийн талаар эрдэмтэдтэй санал солилцохоор дараах тэмдэглэлийг хийж байна:

Монгол судрын агуулгад холбогдох “гарчиг” нэртэй бүтээл номынхоо тооноос ч олон байна. “Гарчиг” нэртэй бүтээл Монгол судрын дотор болон хавсралтаар, мөн бие даасан хэлбэрээр, бичмэл ба бараар уламжлагдсан. “Гарчиг” үйлдэгчдийг Монголчууд “Тоо бичиг туурвигчид” гэж нэрлэж байсан нь орчин үеийн номзүйчид хэмээх нэршлээс ялгаатай.

“Гарчиг”-ийн агуулга нь яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол, ганц сэдэвт бүтээлийн аль ч төрөлд орохгүй, харин дэс дараалуулан жагсаасан “Нэрсийн хэлхээс” бүхий өвөрмөц бүтэцтэй. Монголын буддын шашны утга зохиол хөгжсөн (XVII–XIX зуун) тодорхой нийгэм түүхийн нөхцөлд “гарчиг” нэрээр утга зохиолын нэгэн төрөл үүссэн нь зүй тогтолт үзэгдэл юм.

Монгол сударын нэр гарчигт зураг, дүрслэл болон өнгөний, тооны, бэлэгдлийн, уран сайхны шинж бүрэлдсэн. “Гарчиг” нь аман болон бичгийн аргын хосолмол шинжтэй, тухайлбал, “Ном сонссоны тэмдэглэл,” “Ном хүртсэний тэмдэглэл,” “Захиа үг, сургамж үгийн тэмдэглэл,” “Эрхүйеэ, мэдэхүйеэ, олохуйяа хялбар болгосон” гэх мэт монгол нэр томъёогоор тэмдэглэгдсэн. Өмнөх үеийн “толь,” “товчоо,” “нэрс,” “цэс,” “данс,” “бичиг” зэрэг ижил агуулгатай монгол нэр томъёо XVII–XIX зуунд гарчигтай нэгдэж бүхэл тогтолцоот ухаан буй болсон.

Бидэнд уламжлагдсан “гарчиг” нэртэй бүтээлийн шинж бол юуг ч гарчиглах боломжтой нийтлэг нэр тул материаллаг дамжуулагчаас үл хамааран бүхий л баримтыг системчилэхэд тохиромжтой тул номын сан, музей, архив, албан байгууллага, гэрийн баримт г.м. дэлхий нийтээр нийтлэг ашиглах боломжтой. Харин орчин үеийн “номзүй” бол зөвхөн номын мэдээллийг хамруулдаг. Иймд “Утга зохиолын бие даасан төрөл”-ийн хүрээнд авч үзэх, судлах шаардлагатай гэж үзэж байна.

Abstract

Types and Structure of the contents (*Garchig*) information of Mongolian Sacred Texts (Based of Buddhist Literature): Since Buddhism strongly spread into Mongolia from the 17th century, various Sanskrit and Tibetan literary works and terms became adopted and used in Mongolia. Such examples are *sūtra*, *garchig*, *towyog*, and *sanyag*. These terms are used to specify a book’s content which differ both its genres and contents from the modern method of bibliographical references. Therefore, these terms have great significance in the study of Mongolian Buddhism and literature. The terms *towchoo*, *tol’*, *ners*, *tses*, *dans*, and *bürtgel* have gradually changed their

types and integrated into *garchig* which underlines and shapes the information of Mongolian sacred texts and their structures. The *garchig* can be handwritten or woodcutting print. Accordingly, the general structure of *garchig* should be considered as a cover, content, appendix, individual *garchig* of collected works, particular subjects of *garchig*, and chronological and intermingled *garchig* as well. This paper underlines the general characteristics of the *garchig* of Mongolian sacred texts, and distinguishes, whether the *garchig* can be considered as a special genre of literature. Furthermore, the discussion about the documents that include *garchig* used in a common way, should be also studied related to modern bibliography to reveal their similarities and differences.

Ном зүй

- Дамдинсүрэн, Ц.: XVII зууны эхний үеийн орчуулагч Алтангэрэл увшийн тухай зарим мэдээ. *Studia Mongolica* 5, Fasc. 9 (1966).
- Дулам, С.: *Монгол бэлгэдэл зүй*. Дэд дэвтэр. (Өнгөний бэлгэдэл зүй. Зүг чигийн бэлгэдэл зүй). Улаанбаатар 2000.
- Dung dkar Blo bzang 'phrin las: *Dung dkar tshig mdzod chen mo I* [Дунгарын төвд хэлний нэвтэрхий толь, I]. Krung go'i bod rig pa'i dpe skrun khang, Pe cing 2002.
- Монголын нууц товчоо*. Дөрөв дэх удаагийн хэвлэл. Улаанбаатар 1990.
- Содном, Б.: Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв. *Шинжлэх ухаан сэтгүүл* 12–13 (1946), т. 63.
- Төмөрцэрэн, Ж.: Номын соёлын тухай хэдэн үг. *Шинжлэх ухаан амьдрал* 2 (1971), т. 32–36.
- Цэзэн, Ж.: *Монгол номзүйн онол түүхийн зарим асуудал (крилл үсгээр)*. Бемби сан, Улаанбаатар 2002.
- Цэрэнсодном, Д.: *Монголын бурханы шашны уран зохиол*. Улаанбаатар 1998.
- Tserensodnom, D.: Zur Fragen des Titels der mongolischen Epen. In: *Fragen der mongolischen Heldendichtung*. Ed. by Walther Heissig. Bonn 1985. Otto Harrassowitz, Wiesbaden 1987.

МОНГОЛ ХЭЛЭЭР УЛАМЖИЛСАН БУРХНЫ ШАШИН ЭРТЭН ҮЕ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Уухан Жамьян (Hong Jun)

Монгол Улсын Их Сургууль,
Философи, Шашин Судлалын Тэнхим, Улаанбаатар

Өндөр гэгээн Занабазарын Монголжуу бурханы шашинд оруулсан хувь нэмэр

Өндөр гэгээн Занабазар (1635–1723) монголын уламжлалт бурхны шашны төлөө хичээнгүйлэн зүтгэж байв. Түүний хийж буй үйл хэргийг хураангуйлан дурдвал:

Монгол бурхан шүтээн урлан бүтээх талаар хийсэн түүний бүтээлүүд нь монгол үндэстний хэв шинжээрээ онцлогтой байж, Хятад ба Төвдийн бурхны хөрөг дүрээс ялгардаг юм. Өндөр гэгээн Занабазараас монгол нутаг орон, үндэсний зан заншил, монгол нүүдлийн соёл иргэншилдээ тохирсон монгол маягийн хэв загварын бурхны шашныг цогцлоон бий болгохын төлөө тууштай тэмцэж байсан билээ. 1668 оны Галдан бошигт Халх руу халдсан явдал нь Халх Монголыг манжийн харьяанд дагаар оруулсан учраас Монголчууд төрийн эрхээ алдахын сацуу шашны эрхээ ч алдсан юм.

Монгол номын талаар, Энэтхэгийн ланз үсэгтэй ойролцоо бүхий Соёмбо үсгийг зохион бүтээсэн нь, бурхны зарлиг номлолыг монгол хэлэнд нэн оновчтой буулган авах гэсэн оролдлого байсан юм. Дармадалайгийн “Хор чойнжүн”-д “Занабазар гэгээн ‘Самадог’ (тө. *za ma tog*)-ыг монгол хэлэнд орчуулсан ба санскрит үсэгтэй адилхан нэгэн монгол үсгийг шинээр зохиожээ. Ганжуурыг монгол хэлэнд орчуулахыг таалсан боловч цаг төрийн үймээнээс болж эс бүтвэй” хэмээн тэмдэглэжээ.¹ Энэ нь хэдийгээр амжилтанд хүрч чадаагүй боловч, хожмын хүмүүст бурхны номыг өөрийн монгол хэлээрээ урьж унших урам зоргийг өгсөн юм.

Өвөр Монголд дэлгэрсэн монгол уншлагын уламжлалууд

1. Нэйж тойн хутагт Авидын хуучин монгол уншлага

Өвөр Монголын 49 хошуунд бурхны шашныг анх дэлгэрүүлэгч нь Анхдугаар Нэйж тойн хутагт Авид (1557–1653) юм. Хорчин нутагт орших Баян хошуу хийдэд Нэйж тойн шавь нарын хамт “Ламрим ловжин” (тө. *lam rim blo sbyong*) тэргүүтэн олон номыг монгол хэлэнд орчуулж, мөн

¹ Darmadala: *Čayan lingquv-a erikes*. Q. Čoimbel – S. Dorji orčiylulba. Ündüsüten-ü keblel-ün qoriya, Begejing 1996, т. 300.

төвд судраас “Бодь мөрийн зэрэг,” “Хоёр зэргийн хөтөлбөр” тэргүүтэн ба Хангал зэрэг олон номыг монгол хэлэнд орчуулжээ.² Хурлын уншлага, хангал, магтаал зэргийг монгол хэлээр хөрвүүлж, тэдгээрийн ян, дан, хэнгэрэг, цан, цохилт тэргүүтнийг зохион байгуулжээ. Үүнийг хуучин монгол уншлага хэмээдэг.

Тухайн үед Өвөр Монголд шашин дэлгэрүүлж байсан төвд лам Жамбаалин номун хан³ Нэйж тойн богдыг атаархан гүтгэж, заргалдсан учир Манжийн хаан Эеэр засагч (1638–1661) ба V Далай ламаас Нэйж тойныг буруушаан түүний шавь нар болох 60 хүнийг төвд ламд тушаан өгсөн байв.⁴ Үүнээс болж Өвөр Монголд монгол уншлага хязгаарлагдаж, төвд уншлага илүү дэлгэрэх шалтгаан нь болсон билээ.

2. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцангийн шинэ монгол уншлага

Монгол номын шинэ уншлага нь Мэргэн хийдийн гуравдугаар дүрийн гэгээн Лувсандамбийжалцан (1717–1766)-гаас хуучин монгол уншлагыг засан өөрчилж, шинэ хэв маягаар уншиж хурах ёсыг бий болгожээ. Үүнийгээ “шад тэгшилсэн уншлага” гэж нэрлэдэг.

Монгол оронд шарын шашин дэлгэрэхийн хамт лам хувраг олширсноос, хуучин уншлагыг шинэ хэрэгцээ шаардлагад зохицуулах ба сонсоход яруу, цээжлэхэд амар, олон хуврагуудын жигд дуугаар уншихын тусад, гуравдугаар дүрийн Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан, гүүш багш Номундалай нар хамтран хуучин орчуулга ба төвд эхтэй нь тулгаж шинээр орчуулж найруулсан байна. Үүнд уул өмнө нь үргэлжилсэн үгсийн хэлбэртэй байсан уншлагуудыг шүлгийн хэлбэртэй болгон шад зохицуулж орчуулан найруулсан бөгөөд утга санааг төгөлдөр илтгэхийг хичээсэн байна. Тэд бас шинэ хэрэгцээ шаардлагыг хангахын төлөө шинийг эрэлхийлэх замаар номын агуулгыг өргөжүүлэн баяжуулах ажлыг хийж байв. Шинээр найруулсан монгол номд бас ая дан нэмж зохиосон юм. “Дотоод аяар төхөөрөх зүйлийн санаа хэмээх дүрэмлэх бичиг,” “Мэргэн сүмийн хурал уншлагын тэмдэг бичиг” гэх мэтийн монгол шинэ уншлагадаа зохицуулсан зарчим ёс зэргийг хэрэгжүүлжээ.

Германы эрдэмтэн В. Хайссиг (W. Heissig) “Монголын шашин суртахуун” хэмээх номондоо, Монгол орон дахь бурхны шашин нь үзэл санааны талаар ямагт Төвдөд захирагдаж, төвд сургаалд үнэнч байсан болохоор Монголчуудын шашны тухай яривал төвдийн бурхны шашинтай маш адилхан болно. Гэвч Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан аль олон эрэлт

² Darmadala: *Āḡyan lingquv-a erikes*, т. 314.

³ Бас Шивжа гүрийг номун хан гэдэг. Далай лам, Банчин богдын зарлигаар Манж Чин улсын хаантай уулзан бараадаж, зүүн Монголд шашин дэлгэрүүлэхээр Өвөр Монголын хүрээ хошуунд саатаж байв. 1646 онд Эеэр засагч хаанаас засаг тамга соёрхожээ. 1657 онд таалал төгсчээ.

⁴ Mōngke, B.: *Jindamuni erike-yin sudulul*. Öbög mongγol-un soγol-un keblel-ün qoriya, Qayilar 2000, т. 128.

туршилт хийж XVIII зууны үед нэг зүйлийн хэлний утга зохиолыг үүдэн гаргахаар оролдож байв” хэмээн тэмдэглэжээ.⁵

Монгол уншлага дэлгэрсэн газар орнууд

Нэйж тойны үед, анхлан Түшээт хошууны Баян хошуу сүм ба Хөх хотын Бага зуу хоёрт баримталж байгаад хожим нь түүний шавь болон дараа дүрийн хувилгаан нь үргэлжлүүлэн дэлгэрүүлж, Халх, Өвөр Монголын зарим сүм хийд буюу Бээжингийн шар сүм зэрэг хийдүүдэд монгол хэлээр хурдаг байлаа. Жишээлбэл, Монгол улсын Говь мэргэн вангийн хошууны Хоньчийн хийд, Түшээ гүнийн хошууны Билгүүн хийд, Өвөр Монголын Баарин баруун хошууны Төгс бүртгэлд сүм, Ар Хорчин хошууны Зарлигаар хишгийг шүтэгч сүм, Жарууд хошууны Гэгээн сүм зэрэг хийд бурхны номыг монголоор уншиж хурдаг байжээ. Ар, Өвөр Монголд монголоор хурдаг сүм хийд нийт 64 байжээ гэсэн мэдээ бий.⁶

Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны хийд болох Мэргэн сүм нь монголоор хурах явдлыг нэгдүгээр дүрийн гэгээн Дэнү-ва (XVII зуун)-гийн үеэс эхлэн хэрэгжүүлж, дараа нь хоёрдугаар дүрийн Мэргэн гэгээн Данзанжамц (1680–1716) залган хэрэгжүүлсэн юм. Өвөр Монголын Улаанцав чуулганы Урадын баруун гүний хошууны хошуу хийд болох Мэргэн сүм ба тус хошуунд харьяалагдах бусад сүм хийдүүд нь XX зууны дунд үе хүртэл монгол шинэ уншлагаар уншиж хурдаг ёсыг чанд баримталсаар иржээ.

Одоо Өвөр Монголын зургаан чуулганаас монголоор хурал хурж буй хийдүүдийг дурьдвал: Улаанцавын чуулганаас Мэргэн хийд (тө. bsTan dar gling), Гүнийн сүм, Дэвсгийн сүм тэргүүтэн гурав бий. Жирмийн чуулганаас Шар мөрөн сүм, Вангийн сүм хоёр байна. Зуу-Удын чуулганаас Шашин үндсэн сүм (тө. bsTan pa'i 'byung gnas gling), Гэмплийн сүм (тө. bKra shis dge 'phel gling) хэмээх хоёр бий. Зостын чуулганаас Түмэн өлзийт хийд (тө. bKra shis khri ldan gling). Нийт найман хийд байдаг.

Эдгээр монгол уншлагат сүм хийдийн дотроос, хурлын бүх уншлагаа монгол хэлээр уншиж байгаа, мөнхүү миний өөрийн харьяалагддаг хийд болох Зостын чуулганы Түмэн өлзийт хийд юм.

Түмэн өлзийт хийдийн монгол уншлага ба уламжлагдсан байдал

Түмэн өлзийт хийд (тө. bKra shis khri ldan gling) нь Зостын чуулганы Харчин зүүн хошууны дээр үед 360 ламтай, 11 дугантай хийд байсан. Одоо 20-иод ламтай, 11 дугантай хийд мөн. Тус нутаг оронд бурхны шашин анх дэлгэрээд 1600 гаруй жил болжээ.

⁵ Heissig, Walter: *Die Peking'er lamaistischen Blockdrucke in mongolischer Sprache: Materialien zur mongolischen Literaturgeschichte*. Wiesbaden 1954, т. 128.

⁶ Gallu, S.: *Mongyol-iyar delgeregütlügsen burqan šasin-u nom soyol uraliy-un teike*. Öbör mongyol-un arad-un keblel-ün qoriya, Kökeqota 2003, т. 1064.

IV зуун буюу 345 онд Сяньби угсааны Мү рүн Хуан хаан “Луу дүүлсэн бурхны сүм”-ийг үүсгэн байгуулсан юм.⁷ 420 онд Сяньби хувраг Тан Үү Жэ⁸ Энэтхэг орноо зорьж, санскрит хэлний ном судар залан авчирч нэмэлт орчуулга хийв. Эдүгээ Китаны Лио улсын үеийн (907–1125) эртний хуучин 14 суварга байгаа бөгөөд үүний доторх хоёр том суваргад Одсүрэн бурхны шарил болон Бурхан багш Шагжгүвийн ринсэлийг тус тус гол шүтээн болгон залсан байдаг. Энэ түүх бол Монголын бурхны шашны түүрүү үеийн дэлгэрэлтэд хамаарагдах чухал дурсгал болно.

XVI зууны сүүлч XVII зууны эхнээс бурхны шашин машид өргөжин дэлгэрч, XX зууны дунд үе болоход, их бага сүм хийдийн тоо 572 хүрсэн гэдэг. Соёлын хувьсгалын хэлмэгдүүлэлтээр тэдгээр сүм хийдийн тал хувийг нь сүйтгэсэн боловч, эдүгээ бас 360 шахам сүм хийдийн тоо бүртгэл байна.

Энэ нутгаас төрсөн нэрт хүмүүсээс дурдвал: Али-гали үсгийг зохиосон Аюуш гүүш (XVI–XVII зуун), “Хөх судар”-ийн зохиогч Инжиннаши (1837–1892), “Монголын зан аалийн ойлбэр”-г зохиосон Лувсанчойдэн (1873–1928), “Эрдэнэт толь хэмээх шастир”-ын зохиогч Дандаа чинсан Дэмчигдорж (1863–1932), Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэгч Хайсан гүн (1857–1917), анхны монгол сургуулийг үүсгэн байгуулагч Харчин ван Гүнсээноров (1871–1930), хорголжин барыг үүдэн бүтээгч Тэмгээт (1887–1939) нар байна.

Түмэн өлзийт хийдийн монгол уншлагыг анх 2001 оноос эхлүүлсэн юм. Бага уншлагын номуудыг урадын Мэргэн хийдийн их умзад Лувсансэнгэ багш (1930–2003)-аас уламжлан авч, их болоод дунд уншлагын номыг Мэргэн хийдийн бага умзад Мянган-Уул (1975–) багшаас уламжлан авсан билээ.

Өдөр болгоны цогчин хурлын монгол уншлага нь⁹

1. Билиг барамид
2. Итгэл
3. Цайн тахил
4. Дүшдийн лам ёга
5. Богд лам ёга
6. Манзуширын магтаал
7. Шагжамунийн магтаал
8. Аюушийн магтаал
9. Үсниха бизъяагийн магтаал
10. Хонсим бодьсадвын магтаал

⁷ 任红, 里蓉: 《论古代朝阳佛教文化兴盛的原因及历史地位》, 辽宁大学学报(哲学社会科学版) 2009年, 37卷, 第4期. Ren hong – Li rong: Lun gu dai chao yang fo jiao wen hua xing sheng de yuan yi ji li shi dui zhao. Ling ning da xue xue bao (zhe xue she hui ke xue ban) 2009, 37 juan di 4 qi, т. 111.

⁸ 高楠顺次郎、渡边海旭: 《大正藏》, 第50册 No. 2059, 《高僧传卷第三》, 日本, 1934 [Takakusu Junjirō – Watanabe Kaigyoku: *Taishō Tripitaka*]. Vol. 50, No. 2059, Tokyo 1924, т. 38.

⁹ Мэргэн хийдийн Лувсансэнгэ ба Мянган-Уул багшаас уламжилсан нь. Lobsangdambjalcan: *Wcir dar-a mergen diyancī lam-a-yin gegen-ü bum jarliḡ kemegdekü orosiba*. Begejing modon bar 1783.

11. Богд Зонховын магтаал
12. Хоёрдугаар Зонхов Богд ламын залбирал
13. Цагаан шүхэртийн магтаал
14. Түшдийн магтаал
15. Мэргэн гэгээний даншүг
16. Банчин богдын даншүг
17. Цоржийн даншүг
18. Ламын гэгээний даншүг
19. Ламын тахил
20. Цогт зандан
21. Ерөнхий наманчлал
22. Ерөөлийн хаан
23. Майдарын ерөөл
24. Буянт ерөөл
25. Зарьяабадрын ерөөл
26. Сухаваадын ерөөл
27. Ногоон дарь эх
28. Цагаан дарь эх
29. Шашин бадрангуй
30. Өлзий хутгийн шүлэг

Сарын хурлууд

Сар болгоны 29-ээс дараа сарын шинийн нэгэн болтол Ганц баатар, Гомбо, Дамжан чойжал, Лхам, Жамсрангийн хангал уншина.

Жилийн хурлууд

- Цагаан сарын шинийн 1-ээс 15 хүртэл Ерөөлийн хурал хурна. Унших ном нь Таван ерөөл болно.
- Билгийн хоёр сарын 19-нд Арьяабалын магтаал, Өлзий хутаг найман гэгээн.
- Билгийн дөрвөн сарын шинийн 4-нд Ямандагийн ван.
- Дөрвөн сарын шинийн 6-аас 8 хүртэл Маанийн чога.
- Таван сарын шинийн 5-нд Чингисийн сан, Сүлдийн сан, Цагаан эсрүүний сан, Үндсэн сан.
- Зургаан сарын 19-нд Нүннайн чога.
- Долоон сарын 13-аас 15 болтол Таван ерөөл, Таравчинбуу.
- Есөн сарын 22-нд Шагжамунийн магтаал, Майдарын магтаал, Аюушийн магтаал, Хомсим бодьсадвын магтаал, Угаал, Мандал.
- Арван сарын 25-нд Бурхан багшийн магтаал, Богд Зонховын магтаал, Гурван газар, Зулын тахил, Ямандагийн ван.
- Арван хоёр сарын шинийн 8-нд Шагжамунийн магтаал, Нууц цадиг, Рид хувилгааны магтаал.
- Битүүнд Охин тэнгэрийн цэдор өргөнө.

Монголоор хурахын дэс дараалал

Цогчин уншлага нь: Мигзэм, Билиг барамид, Итгэл, Цайн тахил, Лам ёга, Түшдийн лам ёга ба Богд ламын ёгааг өдөр бүр ээлжлэн уншина.

Магтаал: Манзуширын магтаал, Шагжамунийн магтаал, Аюушийн магтаал, Усниха магтаал, Зонховын магтаал, Хоёрдугаар Зонхов богд гэгээний залбирал магтаал, Цагаан шүхэртийн магтаал, Түшдийн магтаалуудыг ээлжлэн уншина.

Даншиг: Мэргэн гэгээний даншиг, Банчин богдын даншиг, Цорж багшийн даншиг, Ламын гэгээний залбирлыг ээлжлэн уншина.

Ламын тахилын чоги: Эхнээс үүсгэхүй, Залахуй, Мөргөл, Тахил, Цогт зан-дан, Наманчлал тэргүүтэн, Мигзэм аль олон уншина.

Залбирал: Үлэмжит залбирал, Адистид гуйхуй, Ламын тахилын ерөөл, Ерөөл (Ерөөлийн хаан, Майдарын ерөөл, Буянт ерөөл, Зарьяабатрын ерөөл, Сухаваадын ерөөлүүдийг ээлжилнэ).

Өлзий оршил: Ногоон Дарь эхийн магтаал буюу Цагаан Дарь эхийн магтаал, Шашин бадрангуй, Өлзий хутгийн шүлэг, Мигзэм.

Монгол номыг унших арван гурван анхаарал¹⁰

1. Шадын (тө. *shad*) чиг дээр заавал зогсох хэрэгтэй.
2. Шадын сүүл тод бөгөөд урт орхицтой байх хэрэгтэй.
3. Шадын эхлэлтийг заавал “О” оруулж ном эхлэгч нэг үг уншсаны дараа-чаар сая бүгдээр эхэлнэ.
4. Ном уншихдаа шад тэгш бөгөөд өмнө, хойно гарах буюу дээр, доор нь оруулж болохгүй салхигүй өдөр далайн ус намжуу урсах адил.
5. Уншлагын дунд хоолойгоо нийлүүлэн ухаа дуу гарган уншина. Чанга сул зандрах буюу дээр доор зандарч уншихыг цээрлэнэ.
6. Аливаа номыг заавал тэр номд тохирсон аялгуугаар тохируулан уншина. Жишээлбэл, энэрэнгүй, уярангуй, догшронгуйгаар зохицуулан уншина.
7. Цохилго нугалаа нь заавал тод байх хэрэгтэй.
8. Үсэгчлэн бичээд үгчлэн уншиж, үгийг заавал тод хэлэх хэрэгтэй. Хэлгий хүмүүн мэт балархай сул хэлж болохгүй.
9. Үгийг заавал тогтсон аялгуунд нь багтаах хэрэгтэй.
10. Дууны өргөлтийн хэсэг болон дарах хэсэгт нь заавал тохируулах хэрэг-тэй.
11. Номын ая аялгуу тодорхой бөгөөд нугалаа уншлагыг эзэмших хэрэгтэй.
12. Номын ян даныг заавал эзэмших хэрэгтэй. Монгол уншлагад арван хоёр ая даан бий.
13. Чагжа хөдөлгөөнийг гүйцэд хийх хэрэгтэй.

¹⁰ Мэргэн хийдийн их умсад Лувсансэнгэ багшийн “Мэргэн хийдийн бага уншага” хэмээх гар бичмэл судраас буулгаж авсан.

Дүгнэлт

Монголчууд, төвд хэл бичгийг хэдэн зуун жил хэрэглэснээрээ төвдийн шашин соёлын хөгжилд том хувь нэмэр оруулжээ. Гэвч монгол лам сэхээтнүүд төвд хэлийг өргөн хэрэглэх болсноор зуун зууны туршид монгол бичгийн хэрэглээний хүрээ хязгаарлагдаж, хөгжлийн ахиц нь зогсонгуйрахад хүрчээ. Тухайн үед монгол лам нар төвд хэлээр ном зохиол туурвидаг байсан учраас өдгөө болоход Монголчууд түүнийг ашиглан хэрэглэх тал дээр хэлний бэрхшээлтэй байгаа бөгөөд монгол бичгээсээ хөндийрөхөд хүргэсэн байна. Бусад үндэстний үг хэл, үсэг бичгийг хэт эрхэмлэн хэрэглэх нь өөрийн үндэстний үг хэл, үсэг бичгийн хөгжин дэлгэрэхэд нөлөөлнө гэдгийг анхаарах хэрэгтэй байна. Монгол уншлага нь Монгол соёлын хөгжилтөд сайн үр нөлөөтэйн дээр Монголын үндэстний шашин буй болохын үндэс суурь мөн билээ.

Ном зүй

- Darmadala: *Āḡān lingqu-a erikes*. Q. Āoimbel – S. Dorji orċiyulba. Ündüsüten-ü keblel-ün qoriya, Begejing 1996.
- Gallu, S.: *Mongḡol-iyar delgerегülүgsen burqan šašin-u nom soyol uraliy-un teüke*. Öbör mongḡol-un arad-un keblel-ün qoriya, Kökeqota 2003.
- Heissig, Walther: *Die Pekinger lamaistischen Blockdrucke in mongolischer Sprache: Materialien zur mongolischen Literaturgeschichte*. Wiesbaden 1954.
- Kičiyeltü: *Mongḡol ungšilya-yin sudur*. Kökeqota 2000.
- Lobsangdambijalčan: *Wċir dar-a mergen diyanċi lam-a-yin gegen-ü bum jarliq kemegdekü orosiba*. Begejing modon bar 1783.
- Möngke, B.: *Āindamuni erike-yin sudulul*. Öbör mongḡol-un soyol-un keblel-ün qoriya, Qayilar 2000.
- 任红, 里蓉: 《论古代朝阳佛教文化兴盛的原因及历史地位》, 辽宁大学学报 (哲学社会科学版) 2009年, 37卷, 第4期, Ren hong – Li rong: Lun gu dai chao yang fo jiao wen hua xing sheng de yuan yi ji li shi dui zhao. Ling ning da xue xue bao (zhe xue she hui ke xue ban) 2009, 37 juan di 4 qi [Рэн хөн –Ли рүн: Эртний түмэд хошууны бурхны шашны дэлгэрэл ба байр суурь]. Лио нин их сургуулийн сэтгүүл, 2009 он 37-р дэвтэр 4-р хугацаа.
- 高楠顺次郎、渡边海旭, 《大正藏》, 第 50 册 No. 2059, 《高僧传卷第三》, 日本, 1934 [Takakusu Junjirō – Watanabe Kaigyoku: *Taishō Tripitaka*. Vol. 50, No. 2059, Tokyo 1924.

МОНГОЛ ТУУЛЬ ДАХЬ БУРХАН ШАШНЫ ДҮРСЛЭЛ

Балчигийн Катунь

Улаанбаатар

Түмэн засагт хаан (1539–1592) анх 1576 оны улаан хулгана жил төвдийн бурхны шашны улаан малгайтны урсгалын их лам, илд зангидагч Гарма багшийг урин авчирч, шавь орж Цахар, Халх түмний дунд бурхны шашныг дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулжээ. Энэ нь санамсаргүй хэрэг биш бөгөөд өмнөх их хаадын төр, шашны харилцааны уламжлалыг харгалзан үзсэний зэрэгцээ тэр үед Төвд оронд бурхны улаан малгайтны урсгал улс төрийн талаар ч, шашин суртахууны хувьд ч хүчирхэг байсныг тооцож үзсэн хэрэг юм. Дараа жил нь 1577 онд Түмэдийн Алтан хаан (1507–1582), Хутугтай Сэцэн хунтайж (1540–1586) нар төвдийн бурхны шашны шар майлгайтны тэргүүн лам Содномжамцыг (1542–1588) ирэхийг урьжээ. Тэгээд Хөх нуурын Цавчаал гэдэг газар сүм байгуулж Алтан хаан, Хутугтай Сэцэн хунтайж нар өөрсдөө манлайлан Өвөр Монголын олон ноёд бурхны шашинд оржээ. Ингээд Алтан хаан Содномжамц ламтанд “Далай лам” хэмээх цол өргөмжилжээ. III Далай лам Содномжамц хариуд нь Алтан хааныг, Хубилай хааны бүх цол гуншинг хэрэглэхийг зөвшөөрчээ. Нэг хоёрхон жилийн дотор болсон эдгээр үйл явдлыг шинжлээд академич Н. Ишжамц “Содномжамцыг Далай ламд өргөмжлөөд түүнтэй багш шавийн барилдлага барьж Түмэд, Ордосыг шарын шашинд оруулсан нь чухамдаа Түмэн засагт хаантай санаа нийлэхгүй, өрсөлдөж зорьсондоо биш болов уу. Монгол хаад ноёд Төвдтэй шашин, төрийн холбоо байгуулахын тулд хамгийн нөлөө бүхий улаан, шар малгайтны аль алиныг талдаа татаж, эцэстээ аль илүү ашигтай гэснээ бүрэн дэмжиж, ашиглах бодлого баримтлан, ажлаа хуваарилаж явуулсан бололтой байдаг. Учир нь Түмэн засагт хааныг улааны шашинд орж байхад нь Алтан хаан, Хутугтай Сэцэн хунтайж нар дургүйцээгүй. Бас Алтан хаан, Хутугтай Сэцэн хунтайж нар шарын шашинд ороход Түмэн засагт хаан эсэргүүцээгүй байна. Түүгээр ч үл барам Түмэн засагт хаан, Автай сайн хан нар цаашдаа Далай ламд урилга заллага ирүүлж, нэн түрүүн Цахар, Халхыг бас шарын шашинд оруулсан байдаг” гэж бичжээ.

Мөн энэ үед Ойрадын Мэргэн Тэвнэ ноён шарын шашинд орж, хүүгээ Төвдийн Лхас хот руу илгээж 1580–1590-ээд онд бурхны ном үзүүлжээ. Хүү нь бурхны номд нэвтэрч Нэйж тойн хэмээн алдаршиж, баруун Монголд шарын шашин дэлгэрүүлсэн байна. Ийнхүү нийт Монголчуудын оюун санаанд шашин багтай үр үндсээ суулгаж улмаар хаан төрийн үзэл суртлын гол хэрэгсэл болон ашиглагдах болсон билээ.¹ Ингээд 1586 онд Халхын Автай сайн хан

¹ Болдбаатар, Ж. – Лүндээжанцан, Д.: *Монгол улсын төр, эрхзүйн түүхэн уламжлал*. Улаанбаатар 1987, т. 195–196.

(1554–1588) Эрдэнэ зуу хийдийг анх байгуулжээ. Түүгээр ч зогсохгүй монгол газар том хүрээ хийд, жижиг хурлын сүмүүд өдий төдийгөөр байгуулагдан бурхны хөрөг зураг, баримал цутгамал үйлдэх, ном барлах ажлыг өрнүүлжээ.

XX зууны эхээр Монгол оронд 600 орчим том хүрээ, 1000 гаруй жижиг дуган, хурлууд байсан бөгөөд тэдгээрт 113000 лам, 160 орчим хутагт хувилгаад байжээ. Ойрадын Баатар хунтайжийн санаачилгаар 1640 онд Халх, Ойрадын ноёдын чуулган хийж Халх, Ойрадын цаазыг баталсан юм. Улмаар Халхын том ноёд хүн ардын оюун санааны нэгдлийг хангахын тулд Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазар (1635–1723)-ыг Халх Монголын шарын шашны тэргүүнд өргөмжлөв. Тэрээр түүхэнд анхдугаар Богд Жавзандамба хутагт буюу Өндөр гэгээн хэмээн алдаршсан билээ.

Монгол туульсын үзэл санаа, уран сайхны эд эсэд, тухайлбал түүний сэдэв, өгүүлэмж, бүтэц зохиомж, дүр дүрслэлийн зүйлд буддын утга зохиолын үзэл санааны болон уран сайхны уламжлал нарийн нягт сүлжилдэн орсон байдаг. Энэ нь Монголд бурхны шашин удаа дараагаар, их бага хэмжээтэй дэлгэрч байсан өнө эртний болон хожуу үеийн тэрхүү түүхэн цаг үе, үйл явцтай холбоотой юм. Ялангуяа монгол ардын баатарлаг туулийн хөгжлийн хожуу үеийн бүтээлүүдэд бурхны шашны аяс хүчтэй шингэж, энэ явцад Энэтхэг, Төвдөөс сурвалжтай уламжлалт бэлгэ тэмдгийн зүйлс ямар нэг өнгөц түрхцийн хэмжээнээс хальж, зарим талаар тухайн баатрын дүрд хүртэл нөлөөлөх болсон байна. Энэ нь монгол туулийн уугуул шинж, Энэтхэг, Төвдийн уран сайхны уламжлал хоёрын нийлэн нэгдэж, монгол туулийн хэлбэр агуулгыг баяжуулахад зохих нөлөө үзүүлснийг гэрчлэх тодорхой баримт юм. Нөгөө талаар монгол аман болон бичгийн зохиолын шүтэлцээ холбоо, янз бүрийн уран сайхны уламжлалын нийлэн нэгдсэн тэр зангилаан дээрээс монгол туульсын өвөрмөцөөр баяжин хөгжсөн тэрхүү онцлогийг илтгэнэ.²

Монгол туулийн баатрын дүрд гарч ирсэн бурхны шашны аяс бүхий түгээмэл зүйлийн нэг бол тухайн баатрыг ер бусын хүчин чадалтай болгож бурхдын биеийг төгсгөн өгүүлэх заншил юм. Энэ нь мөн л хожуу үед тухайлбал, Буддын шашны гэлүгвын ёс Монголчуудын оюун санааны амьдралд ноёлох байдалтай гарч ирэх болсон. XVII зууны үеэс хойш оруулсан шашны наалдац түрхцийн байдалтай хэсэг юм. Ингэж туулийн гол баатрыг бурхдын бие, хүчин төгсгөж өгүүлэх уламжлал “Жангар,” “Бум-Эрдэнэ,” “Даньхүрэл,” “Хангал ташаа хар хээр морьтой Хаан Цэргийн өвгөн,” “Эрт төрсөн Эрэл Мэргэн хаан,” “Хаан Чингэл,” Окины “Хан Харангуй” зэрэг олон туульд байна. Тухайлбал, “Жангар” туульд:

“Ямар зэргийн хүчтэй
Хүн бэ гэж шинжвэл:
Магнай дээр нь
Махгалын хүч тогтсон

² Хүрэлбаатар, Л.: *Монгол тууль дахь буддын аяс*. (Төв Азийн Тууль олон улсын симпозиум их наадам). Улаанбаатар 1998, т. 240–241.

Зулай дээр нь
Зонхавын хүч тогтсон
Орой дээр нь
Очирваанийн хүч тогтсон
Эрээн сайн булчинд нь
Эгц найман мянган шулмын хүч тогтсон.”³

“Хангал ташаа хар хээр морьтой Хаан Цэргийн өвгөн” туульд:

“Орой дээр нь
Очирваанийн бурхан хагацалгүй сахисан
Магнай дээр нь
Махгал бурхан хагацалгүй сахисан
Шанай дээр нь
Шагж бодьсад хагацалгүй сахисан.”⁴

“Хаан Чингэл” туульд:

“Хаан Чингэлийн үснээс
Хамаг бодьсад бүтээд ирэвээ.
Магнай дээр нь
Махгал бурхан бүтээд
Зулай дээр нь
Зонхава бурхан бүтээд
Орой дээр нь Очирваань бурхан бүтээд ...”⁵

“Бум эрдэнэ” туульд:

“Орай дундаан
Очирвааны бурхн төгөсөксн
Зулай дундан
Зунхав бурхн төгөсөксн
Магнаа дундан
Махгал бурхн төгөсөксн
Шанаа дундан
Шагжатүв бурхн төгөсөксн
Хоолой дундан
Хончим бодсад бурхн төгөсөксн
Дал мөрөн хоорандани
Далан барын күчүн төгөсөксн

³ Дүгэрсүрэн, Т.: *Жангар*. Улаанбаатар 1963, 2012, т. 31–32.

⁴ Катуу, Б.: *Дөрвөд ардын тууль*. Улаанбаатар 1996, т. 51.

⁵ Катуу, Б.: *Дөрвөд ардын тууль*, т. 182.

Цээзин биедэни
 Сүмбүр уулаан күчин бүрдүксн
 Бөксөн биендэни
 Баян лусын хаадын
 Күчүн төгөсөксн
 Күмүн эраан
 Күсэли болн төрөксн
 Көтил хангаан
 Даруулган болн төрөксн
 Көкө бүргүдийн
 Шүүрэлгэн болн төрөксн
 Хаан төридайн
 Хамжаан дэмзан болн төрөксн
 Хамук түмэндээн
 Сүлдэ сакуусн болн төрөксн
 Бурхн хааны көвүүн
 Бодисадаан хувилгаан болн төрөксн
 Тэрэ нутгийн эзэн болн төрөксн
 Эрийн сайн балчир гунхан настай
 Бум эрдэни гилай⁶

гэх мэтээр XIV–XV зууны үед Төвдөд бурхны шашны гэлүгвын ёсыг үүсгэсэн Богд Зонхов Лувсандагва (1357–1419) зэрэг түүхэн хүнээс гадна Манзушир хэмээх оюун билгийг арвижуулан соёрхогч бодьсадва, Очирваань хэмээх хүчин чадлыг үүсгэгч бодьсадва, Махгал хэмээх догшин сахиус, Арьяабал буюу Хонсим бодьсадва, Хорин нэгэн Дарь эх, Дээд найман лусын хаад гэх эртний Энэтхэг, Төвдийн буддын домог үлгэрээс үндэстэй бурхан бодьсадва, тэнгэр нар, лусын хаадын нэрийг дурьдаж, туулийн баатрыг тэдгээрийн хүчин чадлаар хүсэмжлэн магтаж байна.

Ийнхүү туулийн баатрыг орой биенээс нь эхлээд дунд, доод биеийг нь төгстөл бурхан бодьсадва, тэнгэр, лусын хаадын эрдэм чадал, ид шид оршсон болгож үзүүлэхдээ мөн л бурхны шашны үзэл санааны чиглэлээр хамгийн урдаар дээд бурхан бодьсадвагаас эхлээд, дунд тэнгэр нар, доор лусын хаадыг хүртэл, туулийн баатрын биеийн дээд, дунд, доод биеийн хувь хэмжээнд нь тохируулан хүчин чадлыг төгсгөн өгүүлжээ.

Энэ нь ч мөн л монголын бөө мөргөлийн уламжлалт үзэл болох дээд, дунд, доод тивийн ойлголтыг хадгалж байх бөгөөд заримдаа тэр нь бурхны шашны амармагийн болон дүрст, дүрсгүй гурван ертөнцийн ойлголттой холилдон нийлсэн байдал ажиглагдана. Туулийн баатрыг ингэж гаднаас нь бурхадын хүчин чадал төгссөн болгож өгүүлэхээс заримдаа бүр баатрын дүрд нь ямар

⁶ Катуну, Б.: *Бум эрдэний хувилбарууд*. II хэсэг. Улаанбаатар 2015, т. 108–109.

нэг бурхад, догшдын шинж байдлыг бурханы шашны уламжлалт ойлголтын дагуу шингээн оруулсан тийм тохиолдол ч байна.⁷

Мөн түүнчлэн Монголд бурхны шашин түгэн дэлгэрэх үеэр шашны суртлыг түгээн дэлгэрүүлэх залгамж хойч үеийг сурган хүмүүжүүлж, боловсруулах гол ордон бол сүм хийд, дацан сургууль байсан учраас түүнийг олон арваар байгуулсан бөгөөд тэдгээрийн гадаад байр байдал, хийц, дотоод хэв шинж, дэг журмыг тодорхой дүрсэлсэн байдаг. Тухайлбал:

“Ой цагаан дуган нь
Оймаан дүүрэн дункайгаад
Замлин гүнчэв
Хүжийн үнэр анкилаад
Арван орны бодисаду адаслагсан сүм”⁸ гэж сүм дуган-ын төрх төлөвийг дүрсэлсэн бол

“Тэр шарын шажныг баригч
Тойн хуврагууд нь
Шар улаан өнгөөр нь илгараад
Сахил санваарыг ариухнаар нь
Шагшвадын үнэр анхилсан
Эш онолын эрдэм бүрдэв
Тоо үзлэгт мэргэжсэн
Тойн сайхан ламын
Өргай дүнхийгээд”⁹ хэмээн бурхны шашны лам хувраг, сахил санваартны гадна хийгээд дотоод үзэл онолыг дүрсэлсэн байдаг.

Ном зүй

- Болдбаатар, Ж. – Лүндээжанцан, Д.: *Монгол улсын төр, эрхзүйн түүхэн уламжлал*. Улаанбаатар 1987.
- Дүгэрсүрэн, Т.: *Жангар*. Улаанбаатар 1963, 2012.
- Катуу, Б.: *Торгууд, Захчин ардын тууль үлгэр*. Ховд 1991.
- Катуу, Б.: *Дөрвөд ардын тууль*. Улаанбаатар 1996.
- Катуу, Б.: *Захчин ардын аман зохиол*. Улаанбаатар 2004.
- Катуу, Б.: *Дөрвөд ардын аман зохиол*. Улаанбаатар 2005.
- Катуу, Б.: *Алдарт туульч М. Парчины туульс*. Улаанбаатар 2006.
- Катуу, Б.: *Баяд ардын аман зохиол*. Улаанбаатар 2011.
- Катуу, Б.: *Монгол урианхайн ардын аман зохиол*. Улаанбаатар 2011.
- Катуу, Б.: *Бум эрдэний хувилбарууд*. II хэсэг. Улаанбаатар 2015.

⁷ Хүрэлбаатар, Л.: *Монгол тууль дахь буддын аяс*, т. 251.

⁸ Катуу, Б.: *Алдарт туульч М. Парчины туульс*. Улаанбаатар 2006, т. 65–66.

⁹ Катуу, Б.: *Алдарт туульч М. Парчины туульс*, т. 67.

Катуу, Б.: *С. Буянгийн туульс*. Улаанбаатар 2015.

Үлгэр тууль ерөөл магтаал. Улаанбаатар 1976.

Хүрэлбаатар, Л.: *Монгол тууль дахь буддын аяс*. (Төв Азийн Тууль олон улсын симпозиум их наадам). Улаанбаатар 1998.

- (4) Գեղեցիկ լիճակով Բ
- (3) Գեղեցիկ լիճակով Բ
- (2) Գեղեցիկ լիճակով Բ
- (1) Գեղեցիկ լիճակով Բ

Սակայն ընդհանուր առմամբ Բ-ի ցանկում և Գ-ի ցանկում օգտագործված բառերը համընկած են:

Սակայն ընդհանուր առմամբ Բ-ի ցանկում և Գ-ի ցանկում օգտագործված բառերը համընկած են:

1. Բառերի և արտահայտությունների համեմատություն

Սակայն ընդհանուր առմամբ Բ-ի ցանկում և Գ-ի ցանկում օգտագործված բառերը համընկած են:

Սակայն ընդհանուր առմամբ Բ-ի ցանկում և Գ-ի ցանկում օգտագործված բառերը համընկած են:

Սակայն ընդհանուր առմամբ Բ-ի ցանկում և Գ-ի ցանկում օգտագործված բառերը համընկած են:

Սակայն ընդհանուր առմամբ Բ-ի ցանկում և Գ-ի ցանկում օգտագործված բառերը համընկած են:

Սակայն ընդհանուր առմամբ Բ-ի ցանկում և Գ-ի ցանկում օգտագործված բառերը համընկած են:



Fig. 1. Čilayun sudur

Бодь мөрийн зэргийн төрөл зүйлүүд

Г. Мягмарсүрэн

Зүүн Хүрээ Дашчойлин Хийд,
Бурханы Шашин Соёл Судлалын Хүрээлэн, Улаанбаатар

Шагжмуни бурхан багшийн зарлиг сургаалийн дотроос хамгийн охь шим сургаал нь билиг барамидын¹ сургаал юм. Үүнийг үе үеийн эрдэмтэн мэргэд олон талаас нь тайлан тайлбарласаар иржээ. Хувь нэгэн бодгалийн оюун ухаан, сэтгэхүйн цар хүрээний чадвар, чадамжаас хамааруулан нийт хүмүүн төрөлхтөнийг бага, дунд, их хэмээн гурав эрэмбэлэн хувааж, доторхи сэдвийн утга агуулгын хувьд маш нарийн дэс дараалалтай, хоорондын уялдаа холбоотойгоор эмхэтгэсэн бүтээл бол “Бодь мөрийн зэрэг” (тө. *Byang chub lam gyi rim pa*) билээ. Зарлиг увдистны ёс² дэлгэрснээс эхлэн “Бодь мөрийн зэрэг” хэмээх нэр томъёо гарчээ. Бодь мөрийн зэргийн номлол судрыг Гаадамбын олон мэргэд зохиожээ. Тухайлбал, Адиша гэгээн бодь мөрийн зэргийн ай савд хамаарах нийт хорь орчим бүтээл туурвисан байна.

Адиша бандид Төвдөд анх заларч ирэх үед Төвдийн Жанчүв-Од (тө. *lha bla ma Byang chub 'od*) тэргүүтэй хүмүүс бурхны сургаалийн утга агуулга бүрэн гүйцэд бүрдсэн, дагаж мөрдөх, авч хэрэглэхэд амар хялбар нэг судар номлож соёрхохыг айлтгасны хариуд “Бодь мөрийн зул” (тө. *Byang chub lam sgron*) нэрт судрыг зохиосон тухай “сайн шавь Жанчив-Од мянган лан алт өргөж, судрын хоёр асуулга, тарнийн гурван асуулга сэлтээр шашныг сэргээн сэлбэхэд хэрэгтэй нэгэн шасдир зохиож соёрх хэмээн айлтгасанд асуусны хариуг үзүүлэхийн хамтаар ‘Бодь мөрийн зул’ судрыг зохиов” хэмээн Адиша гэгээний намтарт³ өгүүлсэн байх бөгөөд судар, тарнийн оньс бүхнийг нэгтгэн, анхааран бясалгахын мөрд жигдрүүлсэн гол ном нь “Бодь мөрийн зул” гэж хожмын мэргэд даяар хүлээн зөвшөөрдөг билээ.

Цаст Төвдийн мэргэдийн оройн чимэг хэмээн алдаршсан Богд Зонхов (1357–1419) XV зууны эхээр судрын ёсны их, дунд, бага гурван зүйл бодь мөрийн зэрэг (тө. *lam rim che 'bring chung gsum*), тарнийн ёсны бодь мөрийн зэрэг (тө. *sngags rim chen mo*), мөн “Мөрийн гурван эрхэм” (тө. *Lam gyi gtso bo rnam gsum*), “Эрдэм бүхний суурь” (тө. *Yon tan gzhir gyur ma*), “Бодь мөрийн зэргийг товч төдий үзүүлэгч” (тө. *Lam gyi rim pa mdo tsam du bstan pa*), “Оюун судлахуй зохист аялгууны дуун чимэг” (тө. *Blo sbyong snyan ngag sgra rgyan*),

¹ Са. *prajñāpāramitā*, тө. *sher phyin, shes rab kyi pha rol tu phyin pa*, анг. *perfection of wisdom*.

² Зарлиг увдистны ёсыг төвдөөр гаадамба гэдэг. Бурхны зарлиг, таалал, номлол нэгийг ч үлдээгүй бүрэн гүйцэд увдис болгон анхааран авах тогтсон таалал болно. Жово Адиша (т. 972/982) гэгээн үндэслэж, Бромдонба Жалбижунай (1004–1064) тэргүүтэн хөгжүүлэн дэлгэрүүлсэн.

³ Shar gdong blo bzang bshad sgrub rgya mtsho: *Shar gdong blo bzang bshad sgrub rgya mtsho 'i gsung 'bum*, po ti gsum pa. mTsho sngon mi rigs dpe skrun khang, 1998, т. 50.

“Эхэн, дунд, эцэст хэрэгтэй буяны ерөөл” (тө. *Thog mtha' bar gsum gyi smon lam*) зэрэг хэд хэдэн бүтээл туурвисан нь өнөө үеийг хүртэл хагас зуун илүү жилийн турш дорно, өрнө зүгийн олон түмэн эрдэмтэн мэргэдийн хараа, сонорыг булааж, зүрх сэтгэлийг татсан, эрдэм шинжилгээ, судалгааны их аяныг үүдийг нээсэн юм. Богд Зонхов лам их, дунд, бага гурван зүйл бодь мөрийн зэрэг судар зохиосон нь “Их бодь мөрийн зэрэг” (тө. *Byang chub lam rim chen mo*), “Дунд бодь мөрийн зэрэг” (тө. *Lam rim 'bring*), “Бага бодь мөрийн зэрэг” (тө. *Lam rim chung ngu*) болно.

“Бага бодь мөрийн зэрэг”-ийг заримдаа “Бодь мөрийн зэргийн хураангуй утга” (тө. *Lam rim sdus don*) гэх юм уу эсвэл “Бодь мөрийн зэргийн эгшиг дуулал” (тө. *Lam rim nyams mgur*) гэж нэрлэх ёс ч бас байна. “Бодь мөрийн гурван эрхэм,” “Эрдэм бүхний суурь,” “Эхэн, дунд, эцсийн буянтай ерөөл” эдгээр судрыг Төвд, Монгол орны бурхны шашны ихэнх хүрээ хийд, лам хуврагууд нийтийн түгээмэл уншлага зэрэгт оруулан уншдаг байна. Богд Зонховын “Бодь мөрийн зэрэг” болвоос Шагжмуни бурхан багшийн айлдсан бодь хутаг буюу гэгээрэхийн хутагт хүрэх арга зам, билиг ухаан бүхнийг хүмүүний оюуныг боловсруулах гурван үе шатаар дамжуулан судалж шинжлэх, нэг мөрд нэгтгэсэн, оюун ухааны өндөр хөгжлийн мөн чанарыг арга, билгийн үүднээс нотлон буулгасан, судар, тарнийн онол, бясалгалын их эрдмийг цогцлоосон оюуны охь шим бүтээлийн нэг юм. Бурхны шашны онол сургаал нь судар, тарни (тө. *mdo sngags*) хэмээх хоёр үндсэн их ай савд хураагдана. Богд Зонхов энэхүү уламжлал ёсоор судрын ба тарнийн ёсны хоёр зүйл их бодь мөрийн зэрэг судар зохиожээ. “Тарнийн бодь мөрийн зэрэг” (тө. *sNgags rim chen mo*) судар нь хэмжээний хувьд “Их бодь мөрийн зэрэг” судартай ойролцоо томоохон хэмжээний бүтээл болно.

Богд Зонховын бодь мөрийн зэргийн эл бүтээлүүдийг үндэслэн төвд, монгол-ын ихэс дээдэс, хутагт хувилгаад, эрдэмтэн мэргэд Шагжмуни бурхан багшаас эхтэй, Нагаржуна, Асанга, Адиша гэгээнээс дамжлагатай, Богд Зонховоос улбаатай бодь мөрийн зэргийн онол сургаал, үзэл номлолыг улам дэлгэрүүлэн хөгжүүлж, эдүгээ энэ цаг үеийг хүртэл нийтдээ 200 хол илүү зохиол бүтээл туурвисан нь “Бодь мөрийн зэргийн ай сав” хэмээн нэрлэж болохуйц⁴ бодь мөрийн номлолын тайлбар зохиолын нэг томоохон салаа салбарыг үүтгэн бий болгосон байна. Манай Монголын төвд хэл дээр зохиол бүтээл туурвиж асан эрдэмтэн мэргэд бараг бүгдээрээ шахам бодь мөрийн зэргийн онол сургаалийн холбоотой зохиол бүтээл туурвисан байдаг.⁵

Ер утга уран зохиолын төрөл зүйлийн талаарх өрнө ба дорны уламжлалт ойлголт бий. Өрнө дахины уламжлалаар уран зохиолын бүтээл туурвилыг зохиомж ба дүрслэх арга, дүрийн систем, байгуулалт, хэмжээ, бүтэц хэлбэрийн тогтвортой давтагдах шинжээр нь үндсэн гурван том хэсэгт хувааж, түүнийгээ “төрөл,” “аймаг” зэргээр нэрлэж заншжээ.⁶ Эрт, эдүгээгийн уран зохиолын зүйлсийг

⁴ Бодь мөрийн зэргийн ай сав хэмээх энэ нэршлийг доктор Д. Ёндон нарын зэрэг эрдэмтэд анхлан өөрсдийн бүтээлдээ хэрэглэжээ.

⁵ Төвд, Монгол хэл дээрх сүмбүм зохиолын гарчиг сэлтээс үүнийг үзэж бэлхнээ мэдэж болно.

⁶ Галбаатар, Д.: *Уран зохиол, онол, түүх, шүүмжлэл, нэвтэрхий толь*. Улаанбаатар 2012, т. 357.

бүхэлд нь уянга, туульс, жүжиг гэж гурван том төрөл болгож ангилах бөгөөд уран зохиолын төрлийг дотор нь зүйл ба зүйл, ангид хуваан тайлбарлах зарчим дэлгэрч, төрөл нь зүйлийг, зүйл нь зүйл ангийг багтаасан ойлголтын цогц систем бүрэлджээ. Жишээ нь, туульсын төрлийг их туульс, роман, тууж, туульс найраглал, өгүүллэг, туурь, үлгэр, домог, хууч яриа, шог яриа ... гэх зэрэг олон зүйлд, уянгын төрлийг их магтаал, ерөөл, уянгын найраглал, шүлэг, дуу, сонет, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав зэргээр, жүжгийн төрлийг эмгэнэлт, хошин, баатарлаг, яриан, аялгуут, шог хошин зэргээр зүйлчилдэг байна.

Цаашлаад туульсын нэг зүйл болох романыг улс төр, туульс, адал явдал, уран зөгнөл, түүхэн, аж байдал, эссе, намтар, гүн ухаан, сэтгэл зүй гэх мэт зүйл анги болгон ангилдаг нь өрнийн буюу Аристотелийн зарчим болно.⁷

Харин дорны уран зохиолын их онолч Дандин “Зохист аялгууны толь” хэмээх алдарт бүтээлдээ уран зохиолыг бүхэлд нь “бие” гэж томъёолоод, уран зохиолын төрөл зүйл, хэлбэр байгуулалтыг ерөнхийд нь “үелэн тасалсан” буюу “шүлэглэсэн” (са. *satyam*, тө. *tshigs bcad*), “үргэлжилсэн” (са. *gadyam*, тө. *tshigs lhug*), “хавсарсан” (са. *misrakam*, тө. *spel ma*) гэж гурав хуваан ангилсан⁸ нь дээр өгүүлсэн өрнийн уран зохиолын төрлийг гурван хэсэгт ангилдаг зарчимтай ерөнхийдөө адилавар гэж хэлж болохоор байна. Гэвч ерөнхийдөө өнгөц хэлбэр, хуваарлалтаараа адилавар харагдаж байгаа боловч доторхи агуулга, зүйл ангийн хувьд эрс ялгаатай нь хэн хүнд ойлгомжтой буй заа.

Бодь мөрийн зэргийн ай савд хамаарах нийт зохиол бүтээлийг тайлбар зохиолын хүрээнд авч үзэж болохоор байгаа бөгөөд төвд хэлт тайлбар (тө. *'grel ba*) зохиол, түүний төрөл зүйлийн талаар гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, холбогдох ном зохиолд хэрхэн тэмдэглэснийг авч үзье.

Академич Д. Цэрэнсодном багш тайлбар зохиолын талаар бичихдээ “шашны гүн ухаан, дотоод үзэл, зан үйл тэргүүтний талаар туурвисан аливаа зохиол бүтээлийн утга чанарыг яруу тодорхой ойлгомжтой болгохын үүднээс тайлбар зохиолын төрөл зүйл буй болжээ” хэмээн тайлбар зохиол үүссэн түүхэн нөхцөл байдлыг тодорхойлоод, “тайлбар зохиол нь дотроо дараахь дөрвөн төрөл айд хуваагдана” гэж тайлбар зохиолын доторхи төрөл зүйлийн талаар

1. Утгын тайлбар (тө. *don 'grel*),
2. Үгийн тайлбар (тө. *tshig 'grel*),
3. Гол тайлбар (тө. *gzhun 'grel*),
4. Бэрхийн тайлбар (тө. *dka' 'grel*) гэж байна⁹ хэмээн өөрийн саналаа дурджээ.

⁷ Галбаатар, Д.: *Уран зохиол ...*, т. 357.

⁸ Дандийн “Зохист аялгууны толь.” *Corpus Scriptorum Mongolorum*. Tomus XVIII. Fasc. I. Улаанбаатар 1972, т. 13–14.

⁹ Цэрэнсодном, Д.: *Монголын бурханы шашны уран зохиол*. Улаанбаатар 1997, т. 274.

Төвдийн эрдэмтэн Дунгар Лувсанпэрэнлэй тайлбар зохиолын төрөл зүйлийг хоёр янзаар авч үзсэн¹⁰ байна. Үүнд: “зургаан тайлбар” (тө. *'grel ba drug*), “гурван зүйл тайлбар” (тө. *'grel ba rigs gsum*) гэсэн хоёр хувилбараар тайлбарлажээ.

“Зургаан тайлбар” нь:

1. Үгийн тайлбар (тө. *tshig 'grel*),
2. Утгын тайлбар (тө. *don 'grel*),
3. Ялгах тайлбар (тө. *'byed 'grel*),
4. Агуу их тайлбар (тө. *rgya cher 'grel*),
5. Бэрхийн тайлбар (тө. *dka' 'grel*),
6. Үлгэр тайлбар (тө. *sgrung 'grel*) гэсэн бол

“Гурван зүйл тайлбар” нь:

1. Үгийн тайлбар (тө. *tshig 'grel*),
2. Утгын тайлбар (тө. *don 'grel*),
3. Сүвэгч буюу зүүлт тайлбар, бэрхийн тайлбар (тө. *mchan 'grel, dka' 'grel*) гэж ялгажээ.

Харь хол нутагт эрдэм номоороо шалгарч, эрхэм хүндлэлийг олсон Монгол мэргэдийн нэг, Энэтхэгийн Гоман хийдийн хамба асан буриад лхаарамба Агваанням (1907–1990) “Таван зүйл тайлбар бий. Утга агуулгыг оньсыг бүрэн үзүүлсэн утгын тайлбар (тө. *don 'grel*), бэрх оньсыг ялгамжаатай номлосон бэрхийн тайлбар (тө. *dka' 'grel*), үр үгийг нягтад үзүүлсэн үгийн тайлбар (тө. *tshig 'grel*), үсэг, утга зэргийг үзүүлсэн хэлний тайлбар (тө. *ngag 'grel*), салбар гишүүн сэлтээр үзүүлсэн ахуй их тайлбар (тө. *rgya cher 'grel*) хэмээх таван тайлбар бий” гэж¹¹ тайлбар зохиолын ангилал болон товч тодорхойлолтыг гарган өгүүлсэн байдаг.

Дээр эш татснаас гадна тайлбар зохиолын төрөл зүйл мөн гэж хэлж болохуйц нэлээд тооны нэр томъёог бид бэлхэнээ хэрэглэсээр байгаа билээ.

Бидний үзэж байгаагаар бурхны шашны уран зохиол нь хэлбэрийн хувьд үргэлжилсэн ба шүлэглэсэн, мөн шүлэглэсэн ба үргэлжилсэн хоёр хэлбэр хавсарсан буюу холимог үндсэн гурван хэв шинж бүхий хэлбэртэй байдаг бол агуулгын хувьд дээрх гурван хэлбэрийн уран зохиол нь олон төрөл зүйлд хуваагдаж болохоор байна. Үүнд: оюун судлахуй (тө. *blo sbyong*), шасдир (тө. *bstan bcos*), сургаал (тө. *bslab bya, bslab tshig*), дуу дуулал (тө. *glu, mgur*), магтаал (тө. *bstod pa*), залбирал (тө. *gsol 'debs*), гэрээс (тө. *kha chems*), захиа (тө. *sprin yig*), зөвшил зөвлөлөгөө (тө. *gros 'debs*), тахил өгүүлэхийн шүлэг (тө. *mchod brjod*), завсар үеийн шүлэг (тө. *bar skabs tshigs bcad*), төгсгөлийн шүлэг (тө. *smras bshad*) болон бусад зан үйлийн яруу найргийг оруулж болохоос гадна үргэлжилсэн зохиолын төрөл зүйлд цадиг (тө. *skyes rabs*), тууж үлгэр (тө. *rtogs*

¹⁰ Dung dkar blo bzang 'phrin las: *Dung dkar tshig mdzod chen mo*. Krung go'i bod rig pa dpe skrun khang 2002, т. 635.

¹¹ Ngag dbang nyi ma: *Chos 'byung lung rigs sgron me*. sGo mang mkhan zur Ngag dbang nyi ma'i gsung 'bum, I, New Delhi 1982, f199b.

brjod), домог (тө. *gtam brgyud*), түүх (тө. *lo rgyud*), намтар (тө. *rnam thar*), үг яриа (тө. *'bel gtam*), бичиг (тө. *yig*), тайлбар (тө. *'grel ba*) гэх зэргийг оруулж болмоор байна.

“Бодь мөрийн зэрэг” анх зохиогдсоноос хойш өнөөг хүртэл эл бүтээлийн холбогдолтой маш олон зохиол бүтээл төвд хэл дээр гарсан юм. Эдгээр бүтээлүүд нь төрөл зүйлийн хувьд маш өргөн хүрээг хамарч байна. Үүнд бодь мөрийн зэргийн “тайлбар” (тө. *'grel ba*), “хөтөлбөр бичиг” (тө. *'khrid yig*), “анхааран авлага” (тө. *mnyam len*), “уншлага” (тө. *kha 'don bya tshul*), “бясалгал” (тө. *shar sgom*), “жишээ үлгэр” (тө. *dpe*), “түүх гарвал” (тө. *lo rgyud dang 'byung khung*), “сонссоны тэмдэглэл” (тө. *thob yig, gsan yig*), “хатуу үгийн тайлбар” (тө. *tshig 'grel*), “түүвэр нэр” (тө. *bdus ming*), “бэрх утгийн тайлал” (тө. *don 'grel*), “сүвэгч тайлбар” (тө. *mchan 'grel*), “эшлэл номлол” (тө. *lung bshad*), “эцсийн шинжлэл” (тө. *mtha 'dpyod*), “шүлэглэл дуулал” (тө. *tshigs bcad*), “сургааль” (тө. *bslab bya*) гэх зэрэг төрөл зүйлүүдэд хуваагдаж болохоор байна. Энд эс дурдсан бусад төрөл зүйл ч бас байж болохыг үгүйсгэх аргагүй. Эдгээр дээр дурдсан төрөл зүйлүүдээс хэдий зарим нь уран зохиолд, зарим нь шашны гүн ухаан, онол сургаал, зарим нь түүх бичлэг зэрэг шинжлэх ухааны олон салбарт хамаарагдах хэдий боловч утга агуулгын хувьд эдгээр бүгд нь далайд цутгах олон гол мөрөн мэт цөм бодь мөрийн зэргийн тайлбар хэмээх нэгэн ай савд хамаарагдах болов уу гэж бид үзэж байна. Дээрхи төрөл зүйл тус бүрийн онцлог шинжийг илтгэн харуулах нэгээс эхлээд нэлээд хэдэн тооны зохиол бүтээлүүд тэр тусмаа бодь мөрийн зэргийн ай савд хамаарах олон зүйл зохиол бүтээлийг ч энд нэрлэж болохоор байна.

Эдгээр төрөл зүйлүүдийн санскрит, төвд, англи, монгол нэр нэрийтгэл ба тэдгээр тайлбар зохиолын онцлог ялгаа, шинж чанар, голлох зохиол бүтээл зэргийг тодорхойлон авч үзье.

Эш (тө. *lung*, анг. *the reading transmissions of religious texts*)

Багш нь шавьдаа аливаа нэгэн судар номыг ямар нэгэн тайлбаргүйгээр эхнээс дуустал үг, үсгийг машинд тодорхой уншиж сонсохыг төвдөөр лүн буюу эш гэнэ. Ямарваа нэг ном судрыг үзэж судлахын өмнө ихэнх тохиолдолд заавал тэр номын эш хүртсэн байх шаардлагатай. Ийм учир ламримын лүн, лүн хүртээх, лүн хүртэх зэрэг нэр томъёо өргөн хэрэглэгдэх болсон байна. Ламримын эш лүн хүртээсэн, хүртсэн тэмдэглэл бие даасан зохиол төдийгүй бусад зохиолын дотор орсон нь их түгээмэл харагддаг.

Тайлбар (са. *ṭīkā*, тө. *'grel pa*, анг. *commentary*)

Ойлгоход бэрх хэцүү үг, утга, агуулга зэргийг тайлбарлан номлохыг хэлнэ. Бодь мөрийн зэргийн тайлбар, Ламримын тайлбар гэх мэт. Тайлбар зохиол нь дотроо нилээд олон төрөл зүйл болж хуваагдана. Бодь мөрийн зэргийн найман их хөтөлбөр тайлбар гэж нэрлэх ёс бий бөгөөд тэдгээр нь Богд Зонховын их, дунд, бага гурван бодь мөрийн зэргийн дээр III Далай лам Содномжамц (1543–1588)-ийн “Бодь мөрийн зэрэг алтан хайлмал” (тө. *Lam rim gser gyi yang zhun*), IV Банчэн богд Лувсанчойжижанцан (1570–1662)-гийн “Бодь мөрийн зэрэг амар мөр” (тө. *Byang chub lam rim bde lam*), V Далай лам Лувсанжамцийн (1617–1682) “Бодь мөрийн зэрэг Манзуширийн аман увдис” (тө. *Byang chub*

lam rim khrid yig 'jam dpal zhal lung), V Банчэн эрдэнэ Лувсан-Ишийн “Бодь мөрийн зэрэг түргэн мөр” (тө. *Lam rim myur lam*), Дагбо Агваандагвын “Дунд бодь мөрийн зэргийн хураангуй утга сайн номлолын шим” (тө. *Lam rim legs gsung nyiing khu*) зэрэг болно. Төвд, Монгол мэргэдийн зохиосон бодь мөрийн зэргийн бэрх хагуу үг, утга, таалал, номлолын дэлгэрэнгүй, хураангуй, тайлбар зэрэг нэн арвин байдаг.

Сүвэгч тайлбар (тө. *mchan 'grel*, англ. *annotated commentary*)

Сүвэгч тайлбарыг заримдаа “гэмдэглэгээт тайлбар,” бас “нарийн тайлбар” гэж нэрлэх тохиолдол ч байна. Сүвэгч тайлбар нь сэдвийн утга агуулга дотроос ойлгоход хэцүү бэрх зарим нэгийг түүж, тусгайд нь тайлбарладаг онцлогтой бөгөөд тайлбарлах гэж байгаа гол зохиолоо бүдүүн үсэг буюу тод өнгөөр, эсвэл том үсгээр бичиж, завсар хооронд нь тайлбараа нарийн үсгээр буюу бүдэг өнгөөр, эсвэл жижиг үсгээр бичдэг заншилтай. Халхын Засаг Энхдэлгэрэнгүй зохиосон “Бодь мөрийн зэргэмжийн анхааран авахын ялгалыг товчлон хураасны үгс, утгыг нарийн үсгээр өчүүхэн үзүүлсэн эрдэнийн хүү сан” гэх¹² зэрэг сүвэгч тайлбар нэлээд бий.

Үгийн тайлбар (тө. *tshig 'grel*, англ. *word by word commentary*)

Тайлбарлах гол зохиолын үг, үсгийн утга агуулга, илэрхийлэх санааг голлон авч, нэг бүрчлэн нарийн нягт буюу дэлгэрэнгүй, хураангуй хэлбэрээр тайлбарлана.

Утгын тайлбар (тө. *don 'grel*, англ. *commentary of meaning*)

Зохиолын илэрхийлэх гэсэн утга агуулгыг голлон тайлбарлана. Утгын тайлбар зохиолын зохиомж нь хэлбэрийн хувьд ерөнхийдөө эхлээд сэдвийн доторхи утгыг хураангуйлан бүлэглэж үзүүлээд, дараа нь ойлгоход хэцүү хэсгийг нарийвчлан өгүүлж, эцэст гарсан утга агуулгыг нэгтгэн номлох хэлбэртэй байдаг байна.

Бэрхийн тайлбар (са. *pañjikā*, тө. *dka' 'grel*, англ. *commentary on difficult points*)

Зохиолын доторхи дав даруйд ойлгоход хэцүү бэрхтэй, хүндэвтэр гэсэн нэр томъёо болон утга агуулга зэргийг түүвэрлэн, тусгайд нь тайлбарладаг шинж чанартай.

Тааллын тайлбар (тө. *dgongs 'grel*, англ. *commentary on the intent*)

Зохиогчийн хэлэх гэсэн санааг улам тодруулж, илрүүлэн гаргах зорилгоор тайлбарлахыг хэлнэ.

Өөрийн тайлбар (тө. *rang 'grel*, англ. *autocommentary*)

Зохиогч өөрөө урьд нь бичсэн, зохиосон зохиолоо хялбаршуулан бичих буюу далд утга, давхар санааг тайлан тайлбарласан байдаг.

Үсэгчлэх тайлбар (тө. *'bru 'grel*, англ. *syllable by syllable commentary*)

Үг, үсэг нэг бүрчлэн машинд нарийн задалж тайлбарлана.

Үндэсний тайлбар (тө. *rtsa 'grel*, англ. *explanation on root text*)

Үндэс (тө. *rtsa ba*) гэдэг нь гол эх сурвалж болсон, цөөвтөр үгээр эсвэл товчлон, хураангуйлж бичсэн эх зохиолыг хэлэх бөгөөд үндэсний тайлбар буюу

¹² Энэхүү судрыг ШУ-ны доктор, зурхайч Л. Тэрбиш багш монгол хэлнээ орчуулан хэвлүүлжээ.

язгуурын тайлбар нь гол эх сурвалж болсон зохиолын тайлбарыг хэлнэ. Адиша гэгээний “Бодь мөрийн зул” (тө. *Byang chub lam sgron*)-ын тухай “Бодь мөрийн зул” болвоос энэхүү номын үндсэн гол удвис мөн” гэж¹³ Богд Зонхов “Бодь мөрийн зэрэг”-ийн эхэнд өгүүлсэн байдаг тул “Бодь мөрийн зул” нь үндсэн гол эх сурвалж, “Бодь мөрийн зэрэг” нь түүний тайлбар гэж бас тодорхойлж болно.

Дэлгэрэнгүй тайлбар (тө. *rgyas 'grel*, англ. *expansive or extensive commentary*)

Тухайн нэг сэдвийг маш өргөн хүрээг хамруулан, их өргөн дэлгэр тайлбарлана.

Тайлбарын тайлбар (тө. *'grel ba'i 'grel ba*, англ. *commentary on commentary*)

Тайлбар зохиолд бүдэг бүрхэг гарсан утга агуулга зэргийг хожим дахин тайлан тайлбарласан зохиол болно. Эртний Энэтхэгийн бандид нарын тайлбар зохиолыг дахин тайлбарласан ийм төрлийн зохиол нэн арвин.

Тайлбар номлол (тө. *'grel bshad*, англ. *detailed commentary*)

Зохиолын бэрх хүчиртэй үг хэллэг, утга агуулга зэргийг тайлбарлах буюу зарим тохиолдолд тайлбарын тайлбарыг хэлнэ.

Тийн номлол (са. *vyākhyā*, тө. *rnam bshad*, англ. *detailed explanation*)

Судар, номын доторхи хэцүү хатуу үг хэллэг, утга агуулгыг тайлбарлана. Ерөнхийдөө тайлбар ба тайлбар номлол зэрэгтэй адилавар болно.

Тийн ялгагч (тө. *rnam dbye*, *rnam 'byed*, англ. *detailed analysis*)

Нэгэн зүйл тайлбар бөгөөд гол ялгаа нь нэгэн бүхэл зүйлийг дотор нь машид нарийн ялгаж, ангилж тайлбарлахыг хэлнэ.

Тийн агуулал (тө. *rnam bzhag*, *rnam gzhas*, англ. *analysis*)

Тийн агуулал буюу тайлбар, шинжлэл нь их, бага ухааны орны ном судрыг маш тодорхой тайлбарлан номлосон зохиол болно.

Номлол буюу тайлбар (са. *bhāṣyam*, тө. *bshad pa*, англ. *explanation*)

Номлол буюу тайлбар нь судар, шасдирын үг, утга, агуулга зэргийг тайлбарлах, номлохыг хэлнэ.

Машид ялгагч (тө. *rab 'byed*, *rab tu 'byed pa*, *rab tu rnam par 'byed pa*, *rab dbye*, англ. *fully able to separate, analyze, treatise, dissertation, accurate analysis*) нь нэгэн их гол утга агуулгыг дотор нь хэсэг бүлэгт хуваан ялгаж, маш тодорхой үзүүлэх гэсэн утгатай.

Нэр, үгсийн тайлбар (тө. *ming tshig 'grel bshad*, англ. *vocabulary*)

Нэр, үгсийн тайлбар номлол нь тухайн нэр, үг зэргийн холбогдох утга санааг тодруулан гаргана. Ажаа ёнзингийн “Их бодь мөрийн зэргээс гарсан дохионы тайлал чухал хэргэтнийг ойр хураасан” (тө. *byang chub lam gyi rim pa chen po las byung ba'i brda bkrol nyer mkho bsdus pa*) зэрэг нэр, үгсийн тайлбар зохиолууд орно.

Утгын хураангуй буюу товчлол (тө. *don bsdus*, *bsdus don*, англ. *summary*)

Утгын хураангуй буюу товчлол нь тухайн зохиолын гол цөм утга агуулгыг товчлон хураангуйлахыг хэлнэ. Биеэ даасан эсвэл аль нэгэн зохиолын хавсарга хэлбэрээр бодь мөрийн зэргийн утгыг хураангуйлсан зохиол олон бий.

¹³ Зонхава Лувсандагва: *Их бодь мөрийн зэрэг*. Төвд хэлнээс орчуулсан доктор Т. Булган. Улаанбаатар 2004, т. 2.

Бэрх оньсын тайлбар (тө. *dka' gnas, dka' gnad*, анг. *commentary on difficult points*)

Онол сургаал, үзэл баримтлалын авсаар ойлгоход бэрх утга сэлтийг тайлан тайлбарлана.

Бэрх оньсыг тодотгогч (тө. *gnad 'gag gsal byed, gsal byed, gnad gsal*, анг. *explanation and elucidation of crucial points and concepts*) нь бэрх утгын тайлбартай адил шууд ойлгоход бэрх утга агуулгыг тайлан тайлбарлана. Цахар гэвшийн “Бодь мөрийн зэргийн дөрвөн эрдмийн тайлбарыг номлосон бэрх утгыг тодотгогч” (тө. *Byang chub lam gyi che ba bzhi'i nram gzhas bshad pa gnad don gsal byed*) нэртэй бодь мөрийн зэргийн дөрвөн онцлог шинжийг маш сайхан тайлбарласан, эш баримтаар сайтар баяжуулсан, үг, утгыг ажиглан шинжлэх ухаанаар задлан шинжилсэн бүтээлийг газар, газрын мэргэд ихэд үнэлж байсан гэдэг.

Номлолын арга (тө. *'chad thabs*, анг. *method of explaining*)

Судар, шасдирын номлолын хоорондын уялдаа холбоог мэдүүлэх, номлоход зохист бодгальд анхааран авахыг дурдан сануулах, ном сонсохын сав бус бодгальд үл үзүүлэхийн тулд далдлан номлох зэрэг арга хэлбэрийг хэлнэ.

Нэмэлт (тө. *zur phyung*, анг. *supplement, appendix*)

Нэмэлт тайлбар нь тухайн гол утга агуулгатай шууд холбоогүй ч үг, нэр, утгын хувьд холбоотой зүйлийг тайлбарлахыг хэлнэ.

Нийт номлол (тө. *spyi bshad*, анг. *survey*)

Судар, шасдирын доторхи утга агуулгын ерөнхийд нь хураан хураангуйлж өгүүлэх буюу ерөнхийлөн тоймлон тайлбарлах.

Ерөнхий утга (тө. *spyi don*, анг. *exegesis of the general meaning*)

Өмнөх нийт номлолтой утга ижил болно.

Товчлол үгс (тө. *sdom tshig*, анг. *summary*)

Товчлол үгс хэмээх нь олон зүйл судар, шасдирын утга агуулга зэргийг хураан хураангуйлж, шүлэглэн үзүүлэхийг хэлнэ.

Хөтөлбөр (тө. *khrid*, анг. *instruction, commentary, explanation*)

Уламжлалт орчуулгаар хөтөлбөр гэдэг нь орчин цагийн хичээлийн хөтөлбөр, тоглолтын хөтөлбөр гэдэг нэр үгний утгаас өөр утгатай. Харин удирдан зааж чиглүүлэх, хөдөлгөх гэсэн утгатай хөтлөх гэсэн үйл үгийн утгаар хэрэглэнэ. Үүнээс хөтөлбөрлөх гэсэн үг гарчээ. Тайлбар (тө. *'grel ba*), номлолтой (тө. *bshad pa*) адил аливаа нэгэн сэдвийг тайлан тайлбарласан байх боловч хөтөлбөр нь шавийн анхааран авах буюу авч хэрэглэх арга замыг түлхүү номлодоогоороо онцлог ялгаатай юм. III Далай лам Содномжамцийн “Бодь мөрийн зэрэг алтан хайлмал,” IV Банчэн богд Лувсанчойжижанцангийн “Бодь мөрийн зэрэг амар мөр,” V Далай лам Лувсанжамцийн “Бодь мөрийн зэрэг Манзушрийн аман удвис,” Лувсанданзанжанцангийн (1639–1703) “Мөрийн зэргийн хөтөлбөр ухааны харанхуйг арилгагч” (тө. *Lam rim gyi khrid blo yi mun sel*) зэрэг хөтөлбөр тайлбар олон байна.

Хөтөлбөр бичиг (тө. *khrid yig*, анг. *instructional manual*)

Дээр өгүүлсэн хөтөлбөртэй адил утгатай бөгөөд утга агуулгыг тусгайлан хөтөлж тайлбарласан судар бичгийг хэлнэ.

Утгын хөтөлбөр (тө. *don khrid*, англ. *instructions on the meaning*)

Утгын тайлбар лугаа нэгэн адил гол зохиолын утга агуулгыг голлон тайлбарлана.

Улаан хөтөлбөр (тө. *dmар khrid*, англ. *practical guidance, direct instruction*)

Тайлбарлан таниулах зүйлээ бодит жишээ, үзүүлэх материал ашиглан, нэгд нэгэнгүй сайтар тайлбарлахыг хэлэх бөгөөд эрт цагт тэжээх буюу анагаах ухаанд мэргэн эмч багш нь өөрийн шавь нартаа амьтны бие цогцосыг задлан, тодорхой зааж үзүүлдэг байсанаас энэ нэр томъёо гарсан гэдэг. Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр дундаас V Банчэн эрдэнэ Лувсан-Иш зохиосон “Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр төгс гэгээрэлд хүргэх түргэн мөр”¹⁴ (тө. *Byang chub lam gyi rim pa'i dmar khrid thams cad mkhyen par bgrod pa'i myur lam*) нь хамгийн алдартай.

Номлолын хөтөлбөр (тө. *bshad khrid*, англ. *explanation and guidance*)

Багшаас шавьд номлож байгаа судар номын үг, утга сэлтийг машинд тодорхой тайлбарлан номлохыг хэлнэ.

Амсуурга хөтөлбөр (тө. *myong khrid*, англ. *guidance through experience*)

Уламжлалт орчуулгаар амсуурга хөтөлбөр гэх, орчин цагийн нэр томъёогоор туршлага хөтөлбөр нь багшаас өөрийн үзэж туулсан туршлага дээр үндэслэн тайлбарлан номлох ба мөн шавь номлол сургаалийг бясалган анхааран авахад тулгарсан асуудал зэрэгт тохирох ерөндөг арга замыг заан сургах зэргийг хэлнэ.

Үзлийн хөтөлбөр (тө. *lta khrid*, англ. *instruction on the view*)

Хоосон чанар, төв үзэл зэрэг тодорхой нэгэн үзэл, онол сургаалийг голлон тайлбарлахыг хэлнэ.

Сэтгэлийн хөтөлбөр (тө. *sems khrid*, англ. *mind-teaching*)

Сэтгэл бодол, оюун санааны тухай тусгайлсан хөтөлбөр тайлбар болно.

Нууц хөтөлбөр (тө. *gsang khrid*, англ. *secret guidance*)

Онцгойлон номлол сонсохын сав төгөлдөр шавь нарт хөтлөн заах нууц увдис сургаал юм.

Оюун судлахуй (тө. *blo sbyong*, англ. *mind training*)

Өөрийн оюун сэтгэлийн доторхи аль хүчтэй буруу үзэл нисваанисын сэтгэл буй бүхий түүнийг онцгойлон номын ёсоор дарж, зөв эерэг үзэл баримтлал олж авах сургаалийг хэлнэ. Үүнд Цахар гэвш Лувсанцүлтэм зохиосон “Оюун судлахуй эрдэнийн эрих” тэргүүтэн олныг дурдаж болохоор байна.

Сургаал (тө. *bslab bya, bslab tshig*, англ. *advice, instruction*)

Бодь мөрийн онолын үүднээс хувь хүний явдал, мөрийг засч залруулах, зөв амьдрах арга ухаан зэргийг заан сургасан зохиолууд орох бөгөөд Цахар гэвш, цанид ловон Шагдар, Агваанданзаньям нарын сургаал олон бий.

Анхааран авлага (тө. *nyams len*, англ. *practice, application*)

Ямарваа нэгэн номлол сургаалийг өөрийн үйл ажлыг голлон эрхэмлэх зүйл болгож хэрэгжүүлэхэд түүнийг хөтлөн заасан гарын авлага болох бүтээлүүд

¹⁴ Тус улаан хөтөлбөрийг гавж С. Гантөмөр лам орчуулан, 2008 онд хэвлүүлжээ. Банчэн эрдэнэ Лувсан-Иш: *Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр төгс гэгээрэлд хүргэх түргэн мөр*. Орчуулсан С. Гантөмөр. Улаанбаатар 2008.

орох бөгөөд үүнд Брагри лам Дамцигдорж “Мөрийн зэрэг тус амгалангийн сайн мөр” (тө. *Lam rim phan bde lam bzang*) хэмээх бодь мөрийн зэргийн утгыг амар хялбар цагаан үг хэллэгээр, шүлэглэсэн ба үргэлжилсэн хэлбэрээр, аман уншлагын арга байдлаар зохиосон бүтээлийг монгол орны хэд хэдэн дацан сургуульд уншлага болгон хэрэглэж ирсэн баримт байдаг.

Уншлага (тө. *kha 'don bya tshul*, анг. *recitation*)

Бодож бясалгах утга агуулгыг үргэлжид санаж дурдахын тухайд аман уншлага болгон дадуулах ёс юм. Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Мөрийн зэргийг амны уншлага болгон үйлдэж авьяас талбих ёс” (тө. *Lam rim ngag don du byas te bag chags jog tshul*), “Мөрийн зэрэг их эрдэнийг хуралд унших ёс” (тө. *Lam rim rin po che tshogs 'don du byed tshul*) зэрэг ба дээр өгүүлсэн Богд Зонховын “Бодь мөрийн хураангуй утга,” “Эрдэм бүхний суурь” гэх мэт олон номыг хурал уншлагад нийтээр уншдаг.

Бясалгал (тө. *shar sgom*, анг. *meditation, visualization*)

Бясалгах бодох зүйлийг сэтгэлдээ ургуулан дүрслэн бодож бясалгах аргачлал бөгөөд Агваанхайдав хамбын “Бодь мөрийн зэргийн амгалант мөрийн увдисыг ургуулан бясалгах ёс” (тө. *Byang chub lam gyi rim pa bde lam gyi man ngag shar sgom bya tshul*), Тойн хамба Лувсандамбийжанцангийн “Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр хамгийг болгоогчийн газар хөтлөгч амгалант мөрийн гурван жил, гурван зүгт анхааран авах эрэмбэ зэргийн данс бичиг их эрдэнийн болор эрх” зохиолд их, дунд, бага гурван төрөлхтний бодь мөрийн зэргийн онолын үүднээс гурван жил, гурван сар бясалгах арга зааврыг үзүүлсэн зэрэг их, бага хэмжээний бясалгалын аргачлал олон бий.

Жишээ үлгэр (тө. *dpe*, анг. *illustration*)

Утга санааг төлөөлүүлэн өөр зүйлсээр дүрслэн тайлбарлан үзүүлсэн зохиол бөгөөд Жура ёнзингийн “Бодь мөрийн зэргийн үүднээс өөрийн сэтгэлийг буяны барилдлагад оруулах увдис эрдэнийн зүрхэн” (тө. *Byang chub lam rim gyi sgo nas rang sems dge sbyor la 'jug pa'i man ngag rin chen snying po*), Эрэн хамба Лувсанцэрэнгийн “Их бодь мөрийн зэргийн тэмдэглэл сэтгэлийн чоныг номхотгох увдис мэргэн арга туст үнэг” (тө. *Lam rim chen mo'i zin bris sems kyi ce sbyang 'thul ba'i mang ngag thabs mkhas wa mo don yod*) нэртэй “үлгэр лам-рим” нь сургаал номлолын утга агуулгыг аман уламжлалт ба бичгийн зохиолын үлгэрээр жишээлэн үзүүлсэн байдаг.

Түүх гарвал (тө. *lo rgyud dang 'byung khung*, анг. *history, annals, chronicle*)

Тухайн зүйлийн анхлан гарсан түүх домог сэлтийг голлон өгүүлсэн байдаг.

Сонссоны тэмдэглэл (тө. *thob yig, gsan yig*, анг. *record of teachings, transmissions*)

Өөрийн багшаас сонссон, заалгасан зүйлсийг мартаггүйн тулд бичсэн тэмдэглэл бөгөөд Их хүрээний Чойжил гавжийн “Мөрийн зэргийн тогтоосны бичиг мартаггүйн магадлалыг сүрээр дарагч лавайн яруу эгшиг” (тө. *Lam rim zin bris brjed nges zil gyis gnon pa'i dung gi sgra snyan*) гэх мэт нэртэй хэмжээний хувьд авсаархан боловч олон эш баримт, түүх домог, номлол сургаал агуулсан зохиол байдаг.

Тэмдэглэл (тө. *zin bris, zin tho*, анг. *record, notes on commentary*)

Сонссоны тэмдэглэлтэй нэгэн адил багшийн хэлж заасныг бичиж тэмдэглэснийг хэлнэ. Гачой лам Лувсандамба аграмбын “Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр хамгийг болгоогчид зорчих амар мөрийн тогтоосны бичиг ханьцашгүй эцэг богд ламын нигуурын рашаан” (тө. *Byang chub lam gyi rim pa'i dmar khrid thams cad mkhyen par bgrod pa'i bde lam gyi zin bris yab rje bla ma'i zhal gyi bdud rtsi*) гэх томоохон бүтээл бий.

Намтар (тө. *rnam thar*, англ. *biography*)

Дээдэс багш, ихэс мэргэдийн цадиг түүх, намтарыг өгүүлсэн байх ба Ёнзон Ишжанцангийн (1713–1793) “Бодь мөрийн зэргийн дамжлагын багш нарын намтар” (тө. *Lam rim bla ma brgyud pa'i rnam thar*), Иштавхай (1901–1972) гэвшийн “Мөрийн зэрэг амар мөрийн багшийн дамжлагын намтар залбирал цагаан сувд эрх” (тө. *Lam rim bde lam gyi bla ma brgyud pa'i rnam thar gsol 'debs mu tig dkar po'i 'phreng ba*) зэрэг байна.

Түүвэр нэр (тө. *btus ming*, англ. *compiled or collected terms*)

Ойлгоход бэрх хатуу үг хэллэг, нэр томъёог түүвэрлэн тайлбарладаг.

Эшлэл (тө. *lung bshad*, англ. *quotation*)

Онол сургаалийг улам баттай итгэмжтэй болгохын тулд өмнөх үеийн судар, шасдир сэлтээс эшлэл татаж, баталгаажуулсан Жалханз хутагт Дамдинбазарын (1874–1923) “Багшийг шүтэх ёсны гол судрын аймгаас хураасан бага бичиг” (тө. *Bla ma bsten tshul gyi gzhung skor las btus pa'i yig chung*) зэргийг дурдаж болно.

Эцсийн шинжлэл (тө. *mtha' dpyod*, англ. *critical analysis*)

Тухайн утга агуулга зэргийг эцэс туйлд нь хүртэл олон талаас задлан шинжилж, цанид гүн ухааны үүднээс эсрэг буруу үзэл баримтлалыг сөхөөн үгүйсгэх төрлийн зохиол юм. Сайн ноён хан аймгийн Лувсандорж гавжийн “Бодь мөрийн зэргийн эцсийн шинжлэл эрхэм зарлигийн далайд орох хөлөг онгоц” (тө. *Byang chub lam gyi rim pa'i mtha' dpyod gsung rab gyi mshor 'jug pa'i gru gzings*) хэмээх бүтээлийг бодь мөрийн зэргийн утга агуулгыг улам гүнзгийрүүлэн задлан шинжилж, ерөнхий үг утгыг гаргаад, тэрхүү утганд сөргүүлэн тавих эсрэг үзэл баримтлалд няцаалт өгч, түүнээ судар, тарнийн эш баримтаар баталжуулсан бурхны шашны гүн ухааны мэтгэлцээний аргаар зохиожээ.

Шүлэглэл (тө. *tshigs bcad*, англ. *poem, verse*)

Гол утга агуулгыг шүлэглэл яруу найруулгын үүднээс толгой холбон, шад мөр тэгшилж, эгшиглэн дуулах хэлбэр бөгөөд Их хүрээний хамба Агваанхайдавын “Бодь мөрийн зэргийн амгалант мөрийн удвисыг ургуулан бясалгах ёс” (тө. *Byang chub lam gyi rim pa bde lam gyi mang ngag shar sgom bya tshul*) зохиолд бодь мөрийн номлолыг шүлэглэн өгүүлсэн байдаг.

Дуулал (тө. *mgur glu*, англ. *spiritual song*)

Сэтгэл хөдөлгөм яруу найруулгаар өөрийн илэрхийлэх хэмээсэн утга санааг өгүүлэх шүлэглэл бөгөөд богд Зонховын “Бодь мөрийн зэргийн эгшиг дуулал,” Марва хэлмэрч, Мил богд нарын бодь мөрийн зэргийн утга санааг агуулсан эгшиг дуулал олон бий.

Магтаал (тө. *bstod pa*, англ. *praise*)

Тухайн сэдвийн онцлог байдал, шинж чанар зэргийг ялгаруулан тодруулж, онцлон магтахын үүднээс туурвисан бүтээл орох бөгөөд Зава ламын “Их нигүүлсэх сэтгэлийн магтаал,” Агваанбалдан цоржийн “Магад гарахын магтаал,” “Хоосон чанарын магтаал,” “Бодь сэтгэлийн магтаал,” Агваанданзаньямын “Мөнх бусын магтаал” зэрэг олныг дурдаж болно.

Залбирал (тө. *gsol 'debs*, англ. *prayer*)

Дээдэс багш, ихэс мэргэдийн эрдэм чадлыг бахархан өгүүлж, магтан дуурсгаж, өөрийн хүсэл өчил зэргийг даатган залбирал болно. Богд Зонховын “Бодь мөрийн зэргийн дамжлагын багш нарын залбирал дээд мөрийн үүдийг нээгч” (тө. *Byang chub lam gyi rim pa'i brgyud pa rnams la gsol ba 'deb pa'i rim pa lam mchog sgo 'byed*)-ээс эхлээд олон тооны залбирал бий.

Гэрээс (тө. *kha chems*, англ. *testament*)

Дотны шавь сэлтэд хандан дотночлон хэлж захих үг яриаг хэлнэ.

Захиа (тө. *spring yig*, англ. *letter*)

Багш шавь, дагалт нөхөд сэлтийн харилцан амар мэнд мэдэхийн ялдамд захиас сургаалийг хамтадгасан захиа бичиг сэлтэд ч бодь мөрийн онол сургаал үлэмжхэн орсон нь харагдана.

Зөвлөлгөө (тө. *gros 'debs*, англ. *advice, counsel*)

Онцгой нөхцөл байдалд тусгайлан хэрэглэх заавар зөвлөмж юм.

Домог (тө. *gtam brgyud*, англ. *legend, tale, story*)

Урьдын гайхамшигт явдал учир, түүх домог зэргийг түлхүү гаргахын ялдамд бурханы шашны онол сургаалаар учир холбогдлыг тайлан үзүүлэх нэгэн бөгөөд хөтөлбөр тайлбар зохиолд шигтгээ болгож домог түүх их ашигласан харагддаг.

Тууж үлгэр (тө. *rtogs brjod*, англ. *story, biography, tales*)

Домогтой адил ихэс дээдэс, эрдэмтэн мэргэдийн намтар түүх, цадиг сэлтийг хэлнэ.

Тахил өгүүлэхийн шүлэг (тө. *mchod brjod*, англ. *invocation, homage*)

Судар, шасдирын эхлэл хэсэгт лам багш, ядам бурханд даатган залбирсан, тухайн судар шасдирын утга агуулгыг товчоолон гарсан шүлэглэл бөгөөд бараг бүхий л ном судрын өмнө орно.

Завсар үеийн шүлэг (тө. *bar skabs tshigs bcad*, англ. *intermediate verse*)

Нэгэн бүлэг, хэсэг утга төгсгөхийн хамтаар утга агуулгыг дүгнэн, яруу найруулгын ёсоор шүлэглэн өгүүлэх арга бөгөөд Лувсандорж гавжийн “Бодь мөрийн эцсийн шинжлэл”-ийн завсар үеийн шүлэглэл нэн онцгой.

Төгсгөлийн шүлэг (тө. *rdzogs tshig, smras bshad*, англ. *terminative conclusion*)

Тухайн судар, шасдирын төгсгөлд өлзий хутаг өгүүлэх, даатган залбирах, эндүү осол цалгайг наманчлах зэргийг агуулсан шүлэглэл бөгөөд ихэнх ном судрын төгсгөлд элбэг тохиолдох бөгөөд Батаа равжамбын “Рашааны үсэрвэр” ламримын төгсгөлийн шүлэг нь утга уран сайхны хувьд тун чамин зүйрлэл адилтгалыг өргөн хэрэглсэн байдаг.¹⁵

¹⁵ Тус төгсгөлийн шүлгийг Л. Хүрэлбаатар (орч.) “Монголын уран зохиолын дээжис”-ийн “Сайн үгсийн сан” I ботьд хэвлүүлсэн байдаг. Хүрэлбаатар, Л.: Монголын уран зохиолын дээжис – 108. Улаанбаатар 2008.

Энэ мэт маш олон төрөл зүйл байна. Дээр эс дурдсан бусад төрөл зүйл ч бас байгааг үгүйсгэх аргагүй. Эдгээр дээр дурдсан төрөл зүйлүүдээс хэдий зарим нь уран зохиолд, зарим нь шашны гүн ухаан, онол сургаал, зарим нь түүх бичлэг зэрэг шинжлэх ухааны олон салбарт хамаарагдах хэдий боловч утга агуулгын хувьд эдгээр бүгд цөм их далайд цутгах олон гол мөрөн мэт бодь мөрийн зэргийн тайлбар хэмээх нэгэн ай савд хамаарагдах болов уу гэж бид үзэж байна. Дээрхи төрөл зүйл тус бүрийн онцлог шинжийг илтгэн харуулах нэгээс эхлээд нэлээд тооны зохиол бүтээлүүд тэр тусмаа бодь мөрийн зэргийн ай савд хамаарах олон зүйл зохиол бүтээлийг нэрлэж болохоор байна.

Abstract

Categories of the Graduated Path of Enlightenment: Je Tsongkhapa wrote his most famous work *Lam rim chen mo*, The Graduated Path of Enlightenment in 1402. Since then has begun the sacred tradition called *Lamrim* tradition. Almost all Tibetan and Mongolian highly educated saints and monk scholars devoted their contribution to this theme creating and inheriting a large number of texts to our generation. We estimate that more than 100 pieces of work belong to the *Lamrim* tradition. Though they all are considered as commentaries to the Path of Enlightenment, according to our latest detailed research, we can divide them into subcategories such as commentary on words, commentary on meaning, autocommentary, annotated commentary, commentary on difficult points, etc. Based on the works written by the Third Gungtang Konchok Tenpai Dronme (Tib. Gung thang dkon mchog bstan pa'i sgron me, 1762–1823) and the Buryad Agwaannyima (1907–1990), ex-abbot of Drepung Gomang Dratsang, and other scientific research work of Academician Ts. Tserensodnom and Dungkar rinpoche (Tib. Dung dkar blo bzang 'phrin las, 1927–1997), we attempt to discuss different types of commentary works revealing them for further studies. The above mentioned eminent monks and scholars mostly dealt with ten sub-categories, but we revealed over 60 sub-categories.

Ном зүй

Банчэн эрдэнэ Лувсан-Иш: *Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр төгс гэгээрэлд хүргэх түргэн мөр*. Орч. С. Гантөмөр. Улаанбаатар 2008.

Bod kyi bstan bcos khag cig gi mtshan byang dri med shel dkar phreng ba [Төвдийн шастирын нэрс хиргүй цагаан болор эрих]. mTsho sngon mi rigs dpe skrun khang, 1985.

Буддын шашин, соёлын тайлбар толь. Буддын соёл. Цуврал II. Нэг, хоёрдугаар дэвтэр. Улаанбаатар 1999.

Бямбаа, Р.: *Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл*. II боть. Улаанбаатар 2004.

- Галбаатар, Д.: *Уран зохиол, Онол, түүх, шүүмжлэл, нэвтэрхий толь*. Улаанбаатар 2012.
- Гомбожав: *Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл*. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал. Улаанбаатар 1959.
- Дандийн “Зохист аялгууны толь.” *Corpus Scriptorum Mongolorum* XVIII. Fasc. I. Улаанбаатар 1972.
- Dung dkar blo bzang ,phrin las [Дунгар Лувсанпэрэнлэй]: *Dung dkar tshig mdzod chen mo*. Krung go’i bod rig pa dpe skrun khang, Pe cing 2002.
- Зонхава Лувсандагва: *Их бодь мөрийн зэрэг*. Төвд хэлнээс орч. Т. Булган. Улаанбаатар 2004.
- Ye shes thabs mkhas: *bKa’rtsom gnang ba’i khal kha’i bla ma rnam kyi mtsan tho bzhug so* [Иштавхай: Зарлиг зохиол туурвисан халх лам нарын нэрс]. Deb ther dang po. dGa’ldan theg chen gling, Ulaanbaatar 1958.
- Khetsun Sangpo: *Biographical Dictionary of Tibet and Tibetan Buddhism. Rgya bod mkhas grub rim byon gyi rnam thar phyogs bsgrigs*. Library of Tibetan Works and Archives. Dharamsala. H.P. 1973–1990.
- Монголын уран зохиолын тойм*. Дэвтэр II. Улаанбаатар 1976.
- Ngag dbang nyi ma: *Chos ,byung lung rigs sgron me* [Агвааням: Номын гарвал эш ухааны зул]. sGo mang mkhan zur ngag dbang nyi ma’i gsung ‘bum, Volume I, New Delhi 1982.
- gSung ,bum dkar chag. *Zhwa ser bstan pa’i sgron me rje tsong kha pa chen pos gtsos skyes chen dam pa rim byong gi gsung ,bum dkar chag phyogs gcig tu bsgrigs pa’i dri med zla shel gtsang ma’i me long* [Шар малгайтны шашны зул Богд Зонхов тэргүүлэн их төрөлхтөн дараалан залрагсдын сүмбүм гарчигийн эмхэтгэл]. Bod ljongs mi dmangs dpe skrun khang, mTsho sngon zi ling 1990.
- Хүрэлбаатар, Л.: *Монголын уран зохиолын дээжис* – 108. Улаанбаатар 2008.
- Cabezón, José Ignacio – Jackson, Roger R. (eds.): *Tibetan Literature: Studies in Genre*. Snow Lion Publications, Ithaca, New York 1996.
- Цэрэнсодном, Д.: *Монголын бурханы шашны уран зохиол*. Улаанбаатар 1997.
- Shar gdong Blo bzang bshad sgrub rgya mtsho: *Shar gdong Blo bzang bshad sgrub rgya mtsho’i gsung ,bum* [Шардон Лувсаншадавжамцын сүмбүм]. Po ti gsum pa, mTsho sngon mi rigs dpe skrun khang, 1998.

СЭРДОГ ГЭГЭЭНИЙ ЗАН ҮЙЛИЙН НЭГЭН ЗОХИОЛЫН УТГА, АГУУЛГА

Нямсүрэнгийн Мөнхцэцэг

Монгол Улсын Их Сургууль, Философи, Шашин Судлалын Тэнхим,
Зүүн Хүрээ Коллеж, Бурхан Шашны Соёл Судлалын Хүрээлэн, Улаанбаатар

XVIII зууны үеийн эрдэмт лам Сэрдог¹ номун хан Лувсанчүлтэмжамц (1845–1915)² бол Хөх нуурын монгол хүн юм. Тэрбээр бага залуу наснаасаа Жүд дацангийн хамбын ширээнд нэг жил, Гүмбэн хийдийн хамбын ширээнд, Чажен Гомбын хийдийн хамбаар тус тус заларч нэр хүнд бүхий хариуцлагатай албыг хашиж байжээ. Мөн буддын мэдлэг ухаанд мэргэшин боловсрохын зэрэгцээ залуу наснаасаа нилээдгүй зохиол бүтээл туурвисан хэдий ч судалгааны эргэлтэнд орсон нь ховор байна.

Түүний зохиолиудаас Сүмдаг,³ Гучит,⁴ Тэмдэгтийн орлогын нэрийн тайлбар, Гайхамшигт оньсон түлхүүр болон “Гүмбэн хийдийн түүх,” “Удиртгал дөрвөн их хөтөлбөр” зэрэг бүтээлүүд нь илүү нийтэд түгэн дэлгэрч хэрэглэгдсээр байна. Тэдгээрээс “Удиртгал дөрвөн хөтөлбөр” буюу “Ондо дэшин ши” (тө. *sNgon 'gro khrid chen bzhi*) хэмээн олноо алдаршсан дөрвөн цогц зохиолын хоёр дахь хөтөлбөр буюу “Доржсэмбэ бурханыг урин бясалгах хөтөлбөр”-ийг⁵ энд онцолж авч үзлээ.

¹ Анх Сэрдог (тө. *ser tog*) цол авсан нь Лхасын Бага зуугийн дуганд алтан ганжир өргөсөн учраас IV Далай ламын нэр хайрласан гэдэг хууч яриа байдаг. Энэхүү VI дүрийн Сэрдог гэгээнийг дээдийн дээд сэрдог гэдэг аж.

² Тэрбээр Домод Жончүгийн хөвөөнөө Арчаа хэмээх газар XIV жарны модон бичин жил буюу 1845 онд мэндэлжээ. Тэрбээр гурван настайдаа Сэрхан Лувсанданзанжамцаас гэнэнгийн санваар авч, таван настайдаа Сэрдог хийд, Гандан допанлинд залагдав. Тэр жилээ Ж. Галсандагвыг шүтэж хэл бичиг, гучит болон чухал хэрэгтэй уншлагуудыг заалгасанаас хойш олон эрдэмт багш нарыг шүтэж ухааны оронд тасралтгүй шамдаж суралцсан байдаг. Тэр цагаас хойш 70 насыг насалтлаа дотоод ухаан хийгээд нийтийн ухааны 192 зохиолоос бүрдсэн арван боть бүтээл туурвин үлдээжээ. 70 насны сүүдэртэйдээ буюу модон бар жил 1915 онд лагшин заларчээ. Сэрдог гэгээний найман дүр тодорсон бөгөөд тэдгээр нь: 1. Агваанпэрэнлэйжамц, 2. Лувсанпэрэнлэйнамжил (1644–1682), 3. Агваандамбийжалцан (1683–1761), 5. Иштүвдэнжамц (Иштүвдэнванчүг) (1786–1839), 6. Лувсанчүлтэмжамц (1845–1915, дээд монгол), 7. Нэр тодорхойгүй (1918–1948, дээд монгол), 8. Лувсаншадүвчойжижалцан (дээд монгол) нар болно.

³ Сүмдаг (тө. *sum rtags*) гэдэг нь төвд хэлний найруулга хийгээд авиа зүйн шастируудын товчилсон нэр.

⁴ Гучит (тө. *sum cu pa*) гэдэг нь төвд хэлний найруулга зүйг дэлгэрэнгүй тайлбарласан зохиол.

⁵ Тө. Blo bzang tshul khriims rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa nyes ltung dri ma 'khud pa'i dag byad man ngag rgyun bzang zhes bya ba bzhugs so*, “Базарсадыг урин бясалгах бясалгалын зэргийг номлосон гэм, уналын хирийг угаан ариусгагч увидасын сайн урсгал хэмээх нэрт оршвой.”

Энэхүү “Удиртгал дөрвөн хөтөлбөр” хэмээхэд “Аврал одуулах бясалгалын хөтөлбөр,”⁶ “Доржсэмбэ бурхныг урин бясалгах хөтөлбөр,” “Мандалын хөтөлбөр,”⁷ “Багшийн егүзэрийн хөтөлбөр”⁸ гэсэн зохиолууд багтаж байна. Эдгээр цогц зохиолуудын агуулга нь бурхны шажинтан хүний энэ насны чухал хэрэг буян хураах арга болсон бумши (тө. *'bum bzhi*) хэмээх зан үйлийг заасан байдаг. Бумши буюу дөрвөн бум хэмээх зан үйлийг бүтээхдээ Монголчуудын хувьд итгэлийг буман удаа одуулж, мөргөлийг буман удаа үйлдэж, Базарсадын (зуун үсэгт) тарнийг буман удаа тоолж, мандалыг буман удаа өргөснөөр буяны чуулганыг хураахаас гадна ой ухаан сайжирч, өөрийн дотоод зөн совин дээшилнэ гэж үздэг.

Харин энэхүү зохиолын тухайд итгэлийг буман удаа одуулж, Базарсадын тарнийг буман удаа тоолж, мандалыг буман удаа өргөж, ламын налжорыг (тө. *rnal 'byor*)⁹ Ганданлхавжаатай (тө. *dga' ldan lha brgya ma*)¹⁰ барилдуулж үйлддэгээрээ бусад зохиолоос ялгаатай ажээ.

Уг бүтээлийн агуулга нь

- Сахихтахуун тангараг хийгээд санваарыг номлох,
- Тангараг санваараа ямар мэт сахихын ёс,
- Сахих ёсноос хэтэрсэн гэм унал гарах ёс,
- Гэмээр халдагдсаныг ариусгаж үйлдэхийн бодит ёс гэсэн дөрвөн хэсэгтэй байна.

Энэхүү зэргэмжүүд нь бясалгал хийх бэлтгэл, мөн бясалгалыг хэрхэн хийх, бясалгал хооронд хийх зан үйлийг тухайлбал хилэнцээ дөрвөн хүчээр ариусгах, буян хэрхэн хураах, хураасан буянаа шамшигдуулахгүй арвитгах аргыг нарийвчлан заажээ.

Сахихтахуун тангараг хийгээд санваарыг номлох нь

“Хэрвээ дээдийн шид бүтээлийг хүсвээс

Чухаг дээд гуравт аврал одуулаад

Таван суртгаалд тийн орш

⁶ Тө. *sKyabs 'gro'i dmigs rim bshad pa bde chen thar pa'i pho brang du 'jug pa'i man ngag rin chen them skas zhes bya ba bzhugs so*, “Аврал одуулах бясалгалын зэргийг номлосон Их амгалан нирвааны ордонд оруулах увидас эрдэнийн шат хэмээх нэрт оршвой.”

⁷ Тө. *Manḍal gyi dmigs rim bshad pa rab 'byams dge tshogs sdud pa'i ngo mtshar yid bzhin lcags kyu zhes bya ba bzhugs so*, “Мандалын бясалгалын зэргийг номлосон хязгаарлашгүй буяны чуулган хураах гайхамшигт чамдан эрдэнийн гох хэмээх оршвой.”

⁸ Тө. *Bla ma'i rnal 'byor gyi dmigs rim bshad pa dngos grub sbrang char 'jo pa'i byin rlobs chu 'dzin dbang po zhes bya ba bzhugs so*, “Багшийн егүзэрийн бясалгалын зэргийг номлосон шид бүтээлийн балын хурыг буулгахын адистид үүлэн эрхэт хэмээх нэрт оршвой.”

⁹ “Ламын егүзэр” буюу “Багшийг бясалгах гурван орон” нь зүрхэн дунд лянхуан дэлбээн дээр мөн оройд болон огторгуйд гэсэн гурван янз бөгөөд энэ үед бурхан болон багшийгаа нэг мөн чанартай хэмээн бясалгахыг хэлдэг байна.

¹⁰ Богд ламд аврал одуулж, Ганданлхавжаагийн үүднээс Багшийн егүзэрийг урин бүтээл хийхийг хэлдэг байна.

Бодийн сэтгэлд эрхэмлэн хичээ¹¹ хэмээсэнчлэн нэн тэргүүнд чухаг дээд гуравт авралыг одуулахын үүднээс, суртгаалын таван суурийг баригч увшийн санваар,¹² арван тэвчигтэхүүнийг тэвчих гэцэл (тө. *dge tshul*)¹³ ба илт болсон аравын үүднээс огоот төгсөгч гэлэнгийн (тө. *dge slong*) санвааруудыг тус бүрт нь авах бөгөөд цаазын 253 сахилуудыг сайтар сахих үүднээс, билэг барамидын хөлгийн мөр дор оюунаа судладаг¹⁴ байна.

Ялангуяа бодь сэтгэлийн увдис дор дадуулах нь батживаас арван билиг чанар төгөлдөр буяны саданг шүтээд, орохын санваарыг зан үйлийн дагуу баримтла гээд түүний (бодь сэтгэлийн санваар) суртгаал болох үндсэн 18 унал¹⁵ хийгээд 46 гэмт үйл¹⁶ тэргүүтний сахихтахуун зэрэг аль тохирох бүхнийг сайтар сахиж хичээгээд, хааяа гэм гарвал даруйд нь өөр өөрийн гол номлолоос заасны дагуу наминчлаваас зохистойг наминчилж, хоривол зохистойг хорьж, адиславал зохистойг нь адислаад, гэм, уналтай нэг хоног ч нөхөрлөхгүй байх ёстойг заажээ.

¹¹ Blo bzang tshul khirms rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa*, т. 3.

¹² Сахиж мөрдөх зүйлс нь амь таслах, өгөөгүйг авах, худал өгүүлэх, ариун бусыг эдлэх, архи уухыг цээрлэнэ. Гэнэн сахил нь дотроо нэгийг сахигч, заримыг сахигч, олонхийг сахигч, дүүрэн гэнэн, ариун гэнэн, итгэлийн гэнэн гэсэн зургаан төрөл байдаг.

¹³ Гэцүл гэдэг нь буяны ёс гэсэн утгатай үг. Гэцүл сахилтан нь 36 зүйлийг сахидаг байна.

¹⁴ “Оюунаа судлах” буюу “ложон” гэдэг нь өөрийн оюун ухааныг шаштир номд заасны дагуу хөгжүүлэх, тухайлбал, Бодь мөрийн зэргийн үүднээс бол бага, дунд, их төрөлхийтний гурван түвшин, “Газар мөрийн хуваарь” зохиолын дагуу бол бодьсэдвын арван газар тэргүүтний зэргэмжээр муу сэтгэлээ хэрхэн ариусгах, оюунаа хэрхэн сайжруулах буюу судлах талаар тодорхой заасан байдаг.

¹⁵ Үндсэн 18 унал нь: Өөрийгөө магтаж бусдыг муулах, Эд номыг үл өгсөн, Наманчилахнаа ч үл сонссон, Их хөлгөнийг тэвчсэн, Чухаг дээдийн эдийг булаах, Номыг тэвчих, Эл шарыг булаах (тойн хуврагаас буулгасан), Завсаргүй тав, Буруу үзэл, Тосгон тэргүүтнийг сүйтгэх, Эс судласанд хоосон чанарыг номлох, Төгс гэгээрлээс буцаах, Ангид тонилгохыг тэвчих, Ширваагааг муулах, Гүн худал өгүүлэх, Дээд гурвын эдийг авах, Муу хууль тогтоох, Бодь сэтгэлийг орхих зэргүүд болно.

¹⁶ Чухаг дээд гурвыг гурван үүдээр тахиагүй, Өөрөө шунахайрах нь хүсэлт сэтгэлээ даган орсон хэмээх, ахмадуудад бишрээлийг эс үйдсэн, Асуусанд үл хариулсан, Зочлохуйг хүлээн аваагүй, Бусдын өглөгийн нөхцөлийг эс бүрдүүлсэн алт тэргүүтнийг эс авсан, Ном хүссэнд номыг эс өгсөн, Шагшаабат цалгайтсаныг хясалд орхисон, Бусдыг сүжиглүүлэхийн тулд үл суралцсан, Нигүүлсэнгүйн цаазыг эс үйлдсэн, Буруу амжиргааг хүлээн авсан, Алгасраад машинд догшрох, Орчлонд зорчихыг хүссэн нисваанист гэмт үйлдэл, Алдар бусыг үл тэвчсэн, Нисваанистай ч үл зассан гэмт үйлдэл, Буяныг судлаачийн дөрвөн номтой харшилсан, Уурласныг үл хайхарсан, Бусдыг хүлцэн наманчилсныг тэвчсэн, Уурлах сэтгэлийг даган орсон, Асрал хүндлээлийг хүсэж нөхөр шуглуулсан, Залуу тэргүүтнийг үл арилгасан, Шуналаар чалчаа үгийг шүтсэн, Самадийн утгыг үл эрсэн, Даяаны түйтгэрийг тэвчиж эс үйлдсэн, Даяаны амтыг эрдэмд үзсэн, Ширваагагын хөлгөнийг тэвчиж үйлдсэн, Өөрийн ёс байсаар атал түүнд үл хичээсэн, Суралцагдахуун бус гадны шишигт хичээсэн, Суралцаж үйлдэхдээ түүндээ баяссан, Их хөлгөнийг тэвчсэн, Өөрийгөө магтаж бусдыг муулсан, Номын тухайд үл олсон, Өөрт ном заасан бодгалд үгэнд нь итгээд утганд нь үл итгэвээс муулах хийгээд үсгэнд итгэсэн гэмт үйлдэл, Хэрэгтэйн нөхөрт үл үйлдсэн, Өвчтний асаргааг үйлдэхийг тэвчсэн, зовлонг арилган эс үйлдсэн, Сэрэмж үгүйд зохистойг эс үзүүлсэн, Үйлдэнд хариу тус үл үзүүлсэн, Бусдын гашуудлыг арилгаж эс үйлдсэн, Эд хүссэнд өглөг үл өгсөн, Шавь нарын тусыг эс үйлдсэн, Бусдын бодолтой зохилдон эс орсон, Эрдмийн сайшаалыг өгүүлж үл үйлдсэн, Шалтгаанд тааруулан эс шийтгэсэн, Рид хувилгаанаар дарах тэргүүтнийг үл үйлдсэн нисваанист гэмт үйлдлүүд эдгээр 46 болно.

Тангараг санваараа ямар мэт сахихын ёс хэмээх энэ хэсэгт “Очир үзүүр”-ээс

“Үдээс өмнө санваарыг авч үйлдэх бөгөөд

Тэр ямагт өдрийн хагас ба завсарт

Бурхан очирт эрдэнэ хийгээд

Лянхуа үйлдэхийн егүзэр алин”¹⁷

гэж номлосон бөгөөд язгуурын таван бурхны ерөнхий ба тус тусын тангаргуудын зориулга, тоог гүйцээгээд үндсэн ба гишүүн гэм гарсан үгүйг сайтар ажиглах бөгөөд ялангуяа унал тусын бүрийн мөн чанар ба үүсэх завсаруудыг нь эндүүрэлгүй мэдээд өдрийн гурван удаа, шөнийн гурван удаагийн зургаан таслалын егүзэрийг тэтгэхийн үүднээс сахиж үйлдэхийн чухал болохыг гаргажээ. Мөн гэм, унал гардаг зүйлүүдийг тодорхойлохдоо үл бишрэх, сэрэмж үгүй байх, нисваанис ихдэх нь зэргүүд болно гээд тэдгээрийг дарах арга нь Доржпүн (тө. *rdo rje phung*) буюу ариун явдалт нөхөрт шүтэх, үргэлж дурьдал мэдэмсэрийг ажиж, буруу зүйлд сэтгэл алгасрахыг тэвчих мөн ямар нисваанисын хувь их байна түүнийг хорьж, ерөндөг болсон аргыг хэрэглэхийг заажээ.

Сахиx ёсноос хэтэрсэн гэм унал гарах ёс

Тус гэтлэх санваар, бодь сэтгэлийн санваарын ялагдал хийгээд үндсэн унал гарах ёсыг мэдэх хэрэгтэй юм. Тарнийн санваараас доройтохын уналд хоёр зүйл байдаг бөгөөд “Доржэмбийн санваар төгөлдөртний унал нь үндсэн ба бүдүүн унал гэж хоёр гардаг”¹⁸ гээд тэр хоёрыг үүсгэхийн шүтээн нь тарнийн санваарыг аваад алдаагүй ба санаа нь тэрхүү мөн чанарт оршигч бөгөөд хоёр онцлог төгссөн байх шаардлагатай аж. Түүний сэтгэлд үндсэн унал бодитой гарахад, үндсэн таван уналаас бусад 13 нугуудын сууринд эхэлж орсноос авахуулаад эцэст нь төгсгөж үйлдэхийг хүртэл “бүхэн ороох”¹⁹ бүрдэх хэрэгтэй багшаа муу үгээр гэмийг өгүүлснээр хүндлэхээ болих буюу багшаа муушаах тэрхүү үйлдээ сэтгэл нь баясах ба тэрхүү үйлийг хийх хүслээсээ буцаагүй, ичгүүр төрөөгүй, гэмд үзэхгүй байх энэ дөрөв, дөрвүүлээ бүрдвээс үндсэн унал нэгэнт гарч тарнийн санваараа алдсан болно.

Тэр нь ч эхлээд багшаа муулах хотол өдүүлбэр²⁰ сэтгэл төрснөөс эхлэн бодит суурь төгсөх мөч хүртэл дөрвүүлээ бүрдэж байх ёстой аж.

Тэр мэт үндсэн унал хийгээд гишүүний бүдүүн унал үүсэх завсрыг мэдэж үйлдээд ёсчилон эс сахиваас гэм маш их бөгөөд “Дэмчогын үндсэн дандар”-аас (тө. *bde mchog rtsa rgyud*)

“Тангарагаа дарсан, муу явдалт

Бярманг хорооход эргэлзээ үгүй за

Хилэнц явдалтай мунхаг чанарт

Мэхлэн урвагч муу чанарт түүнийг

¹⁷ Blo bzang tshul khriims rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa*, т. 5.

¹⁸ Blo bzang tshul khriims rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa*, т. 6.

¹⁹ Бүхэн ороох нь нойр, догшрох, гэмших, атаа, харам, ичгүүргүй, сонжгуургүй найм болой.

²⁰ Хотол өдүүлбэр гэдэг нь (тө. *kun slong*) ямар нэгэн зүйлийг хийх анхны сэдэл санааг хэлдэг бөгөөд энэхүү сэдлээс хамаарч дараа, дараачийн үйл өдөөгдөн гардаг тул бүхэн өдөөх сэтгэл гэдэг ажээ. Дотор нь Угийн бүхэн өдөөх, Цагийн бүхэн өдөөх гэж хоёр хувааж үздэг байна.

Дагинас бээр гэсгээн идсэн ч
Түүнийг би аварч үл үйлдмүй”²¹

хэмээсэн мэт өөрөө ямар мэт авсан санваар хийгээд тангарагаа ихэд эрхэмлэн хайрлаж нүдний цөцгий мэт сахихад шамдан хичээх бөгөөд ялангуяа үндсэн уналаар хэзээ ч халдагдахгүй байх нь их чухал юм. Хэрвээ халдагдваас санваараа алдах тул дахин боомтилох тэргүүтнээр ариусгаж үйлдэх хэрэгтэй гэжээ.

Гэмээр халдагдсанг ариусгаж үйлдэх бодит ёсонд

Таслалын²² бэлтгэлийн зэргэмж, таслалын бодит суурийн зэргэмж, таслалын завсрын зэргэмжийн номлол гэсэн гурван хэсэгтэй байна.

Анхдугаарт: Ерөнхийдөө Доржсэмбэ бурхныг бүтээх олон язгуурын, бүтээлийн арга байдаг боловч өнөө үед огоот алдаршсан нь Сандуй, Дэмчиг, Жигжид тэргүүтний бүтээлийн аргын эхэнд бичсэн байдаг тэрхүү арга юм. Үүний үндсэн гол номлол нь Энэтхэгийн их багш хэмээн алдаршсан Дорждамбын зохиосон “Доржсэмбэ бурхны бүтээлийн арга” хэмээх зохиол юм.

Бэлтгэлийг зэргэмж нь: Өөрийн бүтээл үйлдэх тэрхүү газар орноо сайтар цэвэрлээд үнээнээс гардаг тав²³ ба сайхан үнэрт усаар сүрчиж ариутгадаг байна. Өөрийн олбог суудлаа ёсонд зохилдуулан дэвсэнэ. Өндөр нам нь таарч тохирсон тахилын ширээг байрлуулж, ар талын хэсэгт нь зоригдлын шүтээн Доржсэмбэ бурхны равнайлсан зурмал, цутгамал дүрээс аль нэгийг нь зайлшгүй залах хэрэгтэй ажээ.

1. *Таслалын бэлтгэлийн зэргэмж* гэдэгт эхлээд очирт багшийн өмнө мандал өргөж, соёрхол тавиад тарнийн ёсны санваар авдаг байна. Сахилаа яаж сахих ёс нь өглөө санваар аваад хагас өдөр бясалгах завсарт язгуурын таван бурхны тус тусын тангарагыг тоолж үйлдээд үндсэн ба гишүүн уналаар халдагдсан үгүйг нь сайтар шинжээд ялангуяа тус тусын унал бодитой үүсэх завсарыг нь эндүүрэлгүй мэдэж аваад бясалгах үедээ гурван өдөр, гурван шөнө, зургаан таслалаар бясалгахын үүднээс дадуулахыг заажээ.

2. *Таслалын бодит суурийн зэргэмж* нь Шүтээний хүч, Хашраан гаргахын хүч, Ерөндөг бүхнийг эдлэхийн хүч, Гэмээс дахин буцахын хүч дөрөв юм.

Мөн энэ тухай “Чойжод равсал” хэмээх зохиолд Богд лам
“Дээд мөрийг бүтээхэд билиг чанар төгссөн шүтээнийг
Эс олохыг хүртэл газрын дөхөц үл ирэх тул

²¹ Blo bzang tshul khirms rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa ...*, т. 7.

²² Тодорхой хугацаагаар хэмжин завсартай бясалгал хийхийг хэлэх буюу түн тоолох гэдэг анир чимээгүй, амьсгалыг гадагш цацруулахгүй, гадаад орчноос тасарч, сэтгэлийг дотооддоо жигд барин, гүн бясалгах замаар, тарнийн номын утгыг ургуулж, өөрт шингээх байдлаар үйлддэг байна. Тарни барьсны дараа түн тайлах зан үйлийг гүйцэтгэдэг ёстой ажээ. Энэхүү номны үест бясалгал гурван өдөр, гурван шөнө, зургаан таслалаар бясалгахын үүднээс дадуулахыг гаргасан.

²³ Таван зүйлийн сайхан үнэртэнд улаан үнээний сүү, тараг, тос, баас, шээс эдгээрийг газар унагалгүй авч хольж найруулан ариусгагч бодис болгон хэрэглэдэг байна.

Түүнийг дутаахгүйн уг дор суралц

Гурван үүд хилэнц уналын хирээр бүлхэгдсэн нь

Ялангуяа үйлийн түйтгэрийг судлах нь аньс ихтэй тул

Үргэлжид дөрвөн хүчийг бүрдүүлж шүтэх нь эрхэм”²⁴

хэмээн эрдмээс дээдийн дээд гэсэнд суралцавч үр дүн нь сайжрахгүй байгаа нь эрдмийн суурь болсон шагшаабад ариун бусын гэм бөгөөд хужирхаг газар сайн үр тариа ургадаггүйтэй адил хэмээн жишээлэн үзүүлсэн байна. Мөн бидний бие, хэл, сэтгэлийг л ариусгах тэр дундаа үйлийн түйтгэрийг эдгээр аргаар ариусгадаг ажээ.

Шүтээний хүч (тө. *rtēn gyi stobs*) гэдэг нь: Нүглийг ариусгах муу зүйлийг дарахыг хэлнэ. Шүтээний хүч нь үргэлж сэтгэлтэй холбоотой байна. Учир нь буян, нүгэл гэх ойлголт сэтгэлд л байдаг учраас зохиолд шүтээний хүчийг аврал одуулж, бодийн сэтгэл үүсгэх, Доржсэмбэ бурхныг бясалгах ёс гэсэн хоёр зүйлд хамруулж үзжээ.

Тухайлбал, аврал одуулна гэдэг нь эмээх эсвэл бишрэх гэсэн хүчтэй сэтгэл төрүүлж тэгэхдээ амьтан бүгд зовлонтой тул түүнийг аврах чадал багш, чухаг дээд гуравт байгаа хэмээн итгэмжлэн бодож бясалгаж байгаа сэтгэл юм.

Энэ үест бодь сэтгэл чухал бөгөөд сурвалжаас “Орчлонгоос гэтэлгэж үйлдэх төдий бус, ариусгаж үйлдэхийг олох нь бодь сэтгэл юм”²⁵ хэмээсэн нь бодийн сэтгэл төрснөөр урьд хураасан муу сэтгэлийг ариусгаж чаддаг гэж үздэгтэй холбоотой юм. Жишээлбэл, Доржсэмбэ бурхнаа төсөөлөн бодох нь шүтээний хүч болж өгч байна.

Доржсэмбэ бурхнаа урин бясалгахдаа өөрөө эгэлийн байдлаар оршоод өөрийн тэргүүн дээр Бам (*Bam*) үсгээс цагаан лянхуа гарч түүний дээр их А (*Āh*) үсгээс дүүрэн саран хот мандал гарч дээр нь цагаан өнгийн Хум (*Hūm*) үсэг гарлаа хэмээн санаж тэр аясаа лагшингийн өнгө цагаан Доржсэмбэ бурхан болоод таван өнгийн гэрэл цацарсан, элдэв зүйл чимгээр чимсэн гучин хоёр сайн билгэ тэмдэг, наян лагшин найргаар үзэсгэлэнтэй хээлсэн, баруун мутартаа зүрхэн харалдаа очир барьсан, зүүн мутартаа хонх ташаандаа барьсан, лагшин цэнгэлийн байдалтай оршнооноор дүрслэн боддог байна.

Тийн хашраан гаргахын хүч (тө. *rnam par sun 'byin pa'i stobs*): гэдэг нь урьд үйлдсэн нүгэл хилэнц бүгдэд гэмших сэтгэл юм. Сурвалжаас “Хашраан гаргах хүчийг хилэнц унал тэргүүтэн гэмээс өөрийн сэтгэлийг уудлан гаргахыг хэлнэ”²⁶ гэсэн нь өөрт гурван санваарын хууль цаазаас харшилж байгаа гэм унал ба мөн чанараараа өөрийн дотоод сэтгэлд бодогдож байгаа гэм тэр бүгдийг сэтгэлдээ дурьдаж, сэтгэлийнхээ мухраас уудлан гадагшлуулж, чин сэтгэлээ гэмших явдал юм.

Хилэнцээ хүчтэй хатуугаар наминчлахгүй болвоос ариусахгүй гэдэг бөгөөд айж, гэмшиж наминчлах нь тустай гэжээ. Учир нь гэмшинэ гэдэг нь буруу зүйл хийсэндээ харамсаад тэр хэрээрээ хүчтэй сэтгэл төрүүлснээр энэ алдааг дахин

²⁴ Blo bzang tshul khriṃs rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa* ..., т. 3.

²⁵ Blo bzang tshul khriṃs rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa* ..., т. 10.

²⁶ Blo bzang tshul khriṃs rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa* ..., т. 18.

давтахгүй юмсан гэж хичээх санааг дахин дахин төрүүлэх хэрэгтэй гэсэн хэрэг юм. Хилэнц нүглийг хашраан гаргах хүчээр ариусгах олон янз арга байдаг ч уг зохиолын тухайд гэмшээд дараа нь наминчлах, гэм нүглээ нуухгүйгээр зүүдэндээ шинжлэн наминчлах гэж байдаг хэмээжээ.

*Ерөндөг*²⁷ *бүхнийг эдлэхийн*²⁸ хүч нь (тө. *gnyin po kun tu spyod pa'i stobs*): Доржсэмбэ бурхны тарниа хураангуй эсвэл дэлгэрэнгүй тоолж нүгэл хилэнц ариусах рашаан бууж ариусгах²⁹ бясалгалыг хийж байгаагаар харуулжээ. Сурвалжаас: “Доржсэмбийн тааллыг саран мандалын дээр ‘Хум’ үсэг Игжа (зуун үсэгт, тө. *yig brgya*) хүрээлсэн рашааны усны үргэлжлэл сүү мэт татаад Доржсэмбийн таалалд ороод, өлмийн эрхи хурууны үзүүрээр гаран, өөрийн эсүраны нүх буюу зулайн нүх рүү ороод, бие бүгдэд рашаанаар дүүрлээ хэмээн санаад өөр бусдын тангараг доройтлыг арилгах”³⁰ соёрхол тавиад Доржсэмбэ бурханаас рашаан бууж байгаа хэмээн бодож байгаагаа “рашаан буулгах бодлын зэргэмж” гэдэг байна.

Рашаан бууж судлах бясалгалыг нийтийн ба нийт бусын гэж хоёр хувааж үздэг. Нийтийн бясалгал нь доороос нь хөөх, дээрээс хөөх, цогцлоон хөөх гэж гурав байдаг байна. Нийт бусын бясалгал нь өөрөө ариусангуут рашаан маань нийт амьтан дээр арван зүг рүү цацраад амьтанд тусалж байгаа гэсэн утгатай бөгөөд нарийсгавал дөрвөн үйлсийг³¹ тэтгэн бясалгах, Сав шимийг судлах гэх мэтчилэн олон янз байдаг байна. Энэ хэсгийн гол агуулга нь гурван төрлийн бясалгал хийх ёс байна. Дээр дурьдсан гурван бясалгалаас өөрт тохирохыг сонгож авах буюу эсвэл ээлжилж гурвууланг нь хийсэн ч болох ба гурван бясалгалаа сольж ээлжлэхийн үүднээс базарсад олон уншдаг байна.

Гэмээс жич буцахын хүч (тө. *nyes pa las slar ldob pa'i stobs*) гэдэг нь өмнө үйлдсэн гэм нүглээ дахиж хийхгүй гэж хатуу тангарагласан сэтгэл юм. Өөрөөр хориглон боомтилохын хүч ч гэж нэрлэдэг. Эхлээд гэмээ сайн ухаараад гэмших хэрэгтэй. Хэрвээ гэмшихгүй бол тангарагаа сахих сэтгэл төрөхгүй юм. Иймд дахин буцахын хүчинд номлосон гэмших сэтгэлийг эргэцүүлэн, энэ алдааг хойшид дахин давтахгүй гэж тангараглана. Энэ үед өөрийгөө боомтилох (барих) хэрэгтэй. Энэхүү судрын үест “Доржсэмбэ бурхан маань гэрэл болоод өөрт шингэн хайллаа хэмээн бодож, буян хурааж, адистид оршлоо”³² хэмээн бясалгана.

Тухайн хүн ямар ч аргаар буян хураасан ерөндөгийн дөрвөн хүч буюу энэ дөрвөн хүчийг бүрдүүлэх ёстой байдаг аж. Энэ дөрвөн хүчийг бодол бясалгалаар ч, хураангуйгаар ч хийж иржээ. Ер нь бурхны шашинд нүгэл хилэнцийг ариусгах олон аргууд байдаг. Тухайлбал, сахил санваар сахих ёс, эргэл мөргөл хийх ёс, тахил өргөх, сайн үйлсийг дэмжих түүнд даган баясах,

²⁷ Ерөндөг гэдэг нь дарах гэсэн утгатай. Энэд нүгэл хилэнцийг дарах арга гэдэг утгаар орж байна.

²⁸ Эдлэх гэдэг нь ашиглах гэдэг утгаар орж байна.

²⁹ Судлах (тө. *blos*) гэдэг нь: тарниа уншаад бясалгаж буйгаа хэлж буй хэрэг юм.

³⁰ Blo bzang tshul khriims rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa ...*, т. 19.

³¹ Blo bzang tshul khriims rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa ...*, т. 19.

³² Blo bzang tshul khriims rgya mtsho: *rDor sems sgom bzlas kyi dmigs rim bshad pa ...*, т. 24.

уриалах, сэтгэл үүсгэж бясалгах ёс гэх мэтчилэн эдгээр олон аргууд нь энэхүү дөрвөн хүчинд тулгуурладаг байна.

Таслалын завсарын зэргэмж нь гэдгийг “хэлж ярих, идээний хэмжээг тохируулаад шөнө унталгүй гурван бясалгалыг өөрт оршоож, бясалгал бүтээлээ уншиж үнэрээр хооллогч амьтанд хиншүүн өглөг өгөх, арвис тарний үндсэн тарнийг унших, сац тавих, зургаан язгуурын орны амьтдыг судлах, хилэнц уналыг наминчлах зэрэг аргаа дадуулж, бясалгахад хичээ”³³ гээд тэр мэт өдөр бүр 4 зэргэмжээр таслаад “Базарсад” 101 мянга уншаад уналаа ариусгаад, гишүүн уналын гэмийг ариусгалгүй, Доржсэмбийг сайтар бясалгаад, “Базарсад” ёсчлон хорин нэг уншаад уналыг адистидласнаар арвижихгүй болно гэж үзжээ.

Ер нь гэм нүглээ наминчилснаар сэтгэл ариусах, цаашид буруу зүйл хийхгүй буюу алдаагаа давтахгүй гэж өөрийн хүндлэн биширч, эрхэмлэдэг үнэт зүйлийнхээ өмнө ам тангараг авч байгаа нь ёс суртахуунтай сэтгэл хангалуун, утга учиртай амьдрахад чухал ач холбогдолтой билээ.

Бясалгал бүтээл хийхэд энэхүү “Удиртгал дөрвөн их хөтөлбөр” хэмээх дөрвөн зохиол нь авлага болж өгдөг. Энэхүү зохиолын тухайд Доржсэмбэ бурхантай холбогдож хийдэг ёс, зан үйл байна. Мөн наманчлал буюу дүншигийн 35 бурхны үүднээс хийдэг ёс гэж бас буй. Нийтийн ёсны үүднээс нүгэл хилэнцээ наминчлахад дүншигийг өргөн хэрэглэдэг. Дүншигээр наманчилж чадахгүй уналыг Базарсадын үүднээс наманчилдаг байна.³⁴ Доржсэмбэ бурхны бясалгал нь тарнийн ёсны дээд дөрвөн дандарын ёсонд хамаардаг. Тэгэхээр тарнийн мөрийн үндэс нь үүсгэлийн зэрэг (тө. *bskyed rim*), төгсгөлийн зэрэг (тө. *rdzogs rim*) гэсэн хоёр зэргэмжтэй байдаг.

Abstract

³⁷ Luwsannorow, Samind: *Törin taxilgat Altan Dar'owōnī taxilga, taillaga*. Sod Press, Ulānbātar 2013, pp. 35–38. In his book, the local historian S. Luwsannorow attached a letter, from which I cite here. They noted that Dariganga people have firmly believed in Dar' Mountain as "Father Heaven" (*etseg tenger*) and have respected the site highly for several centuries. Therefore, the Bogd Khaan honoured the mountain as the national level sacred site. It boosted Dariganga patriotism and encouraged them being pro-central government of Mongolia. It was definitely the smart decision of the Bogd Khaan that united all Mongolian ethnic groups under his reign. Therefore, the Bogd Khaan actively supported the worship of Dar' Mountain by his state until its end. Even though native residents have been organising the local offering ritual of Dar' Mountain since 1990 lots of destructive actions are currently happened during the *owoo* ceremony. By the lack of state arrangement on the ceremony, local people cannot manage worshippers to make a praying ritual at the site properly. Thus, pilgrims harmfully damage the ecosystem of the sacred place with their vehicles as well as their unorganised climbing. Additionally, worshippers often drink alcohol and create a lot of garbage at the area. As a consequence, Dar' Mountain is on the stage of the severe damage. Thus, Dariganga people confidently think that restoring state worship of the mountain will potentially inspire its believers to worship and protect their sacred place correctly.

4. Dar' Mountain (Sükhbaatar province)
5. Altan Khökhii Mountain (Khowd province)
6. Suwarga Khairkhan Mountain (Arkhangai province)
7. Suta Khairkhan Mountain (Khowd province)
8. Khan Khökhii Mountain (Uws province)
9. Altai Tawan Bogd Mountain (Bayan-Ölgii province)
10. Gow' Gurwan Saikhan Mountain (Gow'-Altai province)

In his theoretical article, Sneath views that the post-soviet Mongolian state has instituted sacred mountain rites as indispensable elements of contemporary political practice; they have become an administrative duty and an expression of the nation-building project.³⁸ On the one hand, offering the state sacred mountain is a crucial tool for a nation-building project, if we consider the state policy. On the other hand, it will create a big question if we analyse local perception of the national level worshipped site.

Noticeable, honouring new state worshipped sites is a vivid ongoing process in contemporary Mongolia. In the present, some local communities still propose to worship their sacred sites by the state. For example, leaders of Khöwsgöl province suggest the veneration of Dayan Deerkh, the holiest cave of the Darkhad ethnic group, as the state worshipped place. In fact, native residents attempt to strengthen their local community by honouring sacred sites as a part of the local-building project. It is somewhat different from Sneath's conclusion. In short, restoring former sacred mountains of the Bogd Khaan's sovereign Mongolia and establishing new national-level worshipped sites are mainly reasoned from the liberal policy of the state, which accepts the human right of local people. Therefore, the president of the country has agreed on suggestions coming actively from native residents.

Conclusion

In this paper, I determined a perception of the sacred landscape. Firstly, I corrected the use of the expression *owoo*, an essential aspect of sacred sites in Mongolia. The term is widely expressed as altar object or physical construction at a place of worship. In fact, it is only a simple meaning of the term, which can be also translated as cairn. In fact, the Mongols mainly consider *owoo* as a whole sacred mountain. For example, the most revered Dar' Mountain of the Dariganga people is called formally Dar' Owoo, commonly Altan Owoo and informally Owoo. The *owoo* is not only explained as the physical mountain, but it also indicates an invisible agent. In fact, the *owoo* consists of *gadsar* (Earth) a visible entity and *tenger* (Heaven) an invisible entity. According to local perception, *tenger* and *gadsar* are inseparable things this is what the *owoo* represents. Many scholars commonly use the Mongolian term *tenger* of *owoo* by various names, such as lord, deity and spirit. In fact, *tenger* is

³⁸ Sneath, D.: *Nationalizing Civilizational Resources*, p. 465.

the spirit master of the mountain, whereas, Dar' Owoo is considered the mountain itself as a God. All in all, Dar' Owoo is viewed as the centre of the universe in the Dariganga celestial system.

Dar' Mountain was initially worshipped as a memorial *owoo* for Dar' noble, a leader of the region in the pre-Qing period. After establishing the Dariganga Pasture, the Owoo became continuously worshipped as the central sacred mountain of the Pasture unit. Then it became honoured as a state sacred mountain in 1912 based on political reasons. Native residents quickly restored the small scale worship of the mountain in 1990, although the offering ritual of Dar' Owoo was stopped temporary during socialism. Surprisingly, several mountains newly honoured as national level sacred site after the restored state worship of Dar' Owoo in 2004. Sneath views that "Instituted sacred mountain becomes an expression of the nation-building project. On the other hand, the state sacred mountains of specific ethnic groups strengthen identity of local groups. Thus, the state worship also becomes local-building project, if we analyse the local perception of the site. For example, the upper-level ceremony has been critically important for the Dariganga community; so that, they massively celebrated the 100th-year anniversary of the state worship at Dar' Owoo in 2013."



Fig. 1. A historical image of Dar' Owoo. National Archives of Mongolia.



Fig. 2. *Dar' tenger* and *Owoon chuluu* by Bilegsaikhan Tamirjaw.



Fig. 3. *Dar' Mountain* by Bilegsaikhan Tamirjaw.

References

- Baumann, Brian: By the Power of Eternal Heaven: The Meaning of *Tenggeri* to the Government of the Pre-Buddhist Mongols. *Extrême-Orient Extrême-Occident* 35. Presses Universitaires de Vincennes, Paris 2013, pp. 233–284.
- Bawden, Charles R.: Two Mongol Texts Concerning Obo-worship. *Oriens Extremus* 5 (1) Harrassowitz, Wiesbaden 1958, pp. 23–41.
- Bilegsaikhan, T.: *Darigangin tuxen toim*. Mönxīn Üseg Press, Ulānbātar 2015.
- Bira, Shagdar: Mongolian *Tenggerism* and Modern Globalism. *Journal of the Royal Asiatic Society* 14. Cambridge University Press, Cambridge 2004, pp. 3–12.
- Byambadorj, S.: Mongolčūdīn owō taxilgīn jan üil sergej baigā ni. In: *Mongolīn taxilga šütlegt gajar nutag*. Emx. N. Urtnasan – A. Dūrenjargal. Ulānbātar Printing, Ulānbātar 2011, pp. 125–130.
- Halemba, Agnieszka: *The Telengits of Southern Siberia: Landscape, Religion and Knowledge in Motion*. Routledge, London 2006.
- Halemba, Agnieszka: What does it feel like when your religion moves under your feet? Religion, earthquakes and national unity in the Republic of Altai. *Zeitschrift für Ethnologie*. Vol. 133 (2). Dietrich Reimer Verlag, Berlin 2008, pp. 283–299.
- Heissig, Walther: *The Religions of Mongolia*. University of California Press, Berkeley and Los Angeles 1980.
- Ĵamsran, Lxamsüren: *Dariganga süreg xošū*. ŠUA xewlel, Ulānbātar 1994.
- Lindskog, V. Benedikte: Ritual Offerings to *Owoos* Among Nomadic *Halh* Herders of West-central Mongolia. *Études mongoles et sibériennes, centrasiatiques et tibétaines* 47. L'Harmattan, Paris 2016, pp. 1–20.
- Luwsannorow, Samind: *Törin taxilgat Altan Dar'owōnī taxilga, taillaga*. Sod Press, Ulānbātar 2013.
- National Central Archives of Mongolia, M–1. D–1. KhN–1136.
- National Central Archives of Mongolia, A–3. D–1. KhN–226.
- Rachewiltz, Igor de: Heaven, Earth and the Mongols in the Time of Činggis Qan and his Immediate Successors (ca. 1160–1260) – a Preliminary Investigation. In: *A Lifelong Dedication to the China Mission: Essays Presented in Honor of Father Jeroom Heyndrickx, CICM, on the Occasion of His 75th Birthday and the 25th Anniversary of the F. Verbiest Institute K. U. Leuven*. Ed. by Noël Golvers and Sara Lievens. Ferdinand Verbiest Institute, Leuven 2007, pp. 107–144.
- Smyrski, Łukasz: *Między władzą spojrzenia a praktyką. Antropologia krajobrazu [Between the Power and Practice. The Anthropology of Landscape]*. Oficyna Naukowa, Warsaw 2018.
- Sneath, David: Ritual Idioms and Spatial Orders: Comparing the Rites for Mongolian and Tibetan Local Deities. In: *The Mongol-Tibet Interface: Opening new research terrains in Inner Asia*. Ed. by Uradyn Bulag – Diemberger, Hildegard. Brill, Leiden 2007, pp. 135–158.
- Sneath, David: Nationalizing Civilisational Resources: Sacred Mountains and Cosmopolitical Ritual in Mongolia. *Asian Ethnicity* 15 (4). Taylor & Francis Online 2014, pp. 458–472.

Tatár, Magdalena: Two Mongol Texts Concerning the Cult of the Mountains. *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae* 30 (1). Akadémiai Kiadó, Budapest 1976, pp. 1–58.

Urtnasan, Norow – Ayuuš, Dūrenjargal: *Mongolīn taxilgat gaĵar nutag: öw ulamĵlal, üne cene*. Khotula Agentlag Printing, Ulānbātar 2007.

Wallace, Vesna A.: How Vajrapāni Became a Mongol. In: *Buddhism in Mongolian History, Culture, and Society*. Ed. by Vesna A. Wallace. Oxford University Press, New York 2015, pp. 179–202.

ЯМАНДАГА БУРХНЫ ГАЛ МАНДАЛ ҮЙЛДЭХ ЗАН ҮЙЛ

Б. Дарамбазар

“Цогт Цагийн Хүрдэн” Соёлын Төв, Улаанбаатар

Оршил

Ачлалт багш лугаа ялгалгүй Цогт Ямандага бурханаа мөргөмүй.

Монголын бурхны шашны томоохон зан үйлийн нэг нь “жинсрэг цутгах” (тө. *sbyin sreg*) буюу гал мандал үйлдэх ёсон билээ. Гал мандлыг Ямандага, Хэрүга, Сандуй, Наро хажод тэргүүтэн бурхны үүднээс үйлдэх бөгөөд Ямандага бурхны үүднээс үйлдэх ёс түгээмэл байдаг. Ямандага (са. *Yamāntaka*) буюу Жигжид (тө. *Jigs byed*) бурхан болбоос гурван орныг нэгэн агшинд эрхэндээ хурааж муу бүхнийг даран амарлиулж сайн сайхныг дэлгэрүүлэх хүч чадал бүхий ам тангарагтай дандарын ёсны дээд йогийн эрхэм бурхан болой. Гал мандал үйлдэхийн мөнхүү утга нь Ямандага бурханыг урин бясалгаж тахил өргөл үйлдсэнээр хүмүүний хилэнц түйтгэрийг ариусгах, өвчин зовлон, ад зэтгэр, ган зуд тэргүүтнийг амарлиулж нас буян арвиж хамаг амьтан амар амгалан аж төрөхийн шалтгаан нөхцөлийг бүрдүүлдэг бурхны шашны чухал зан үйлийн нэг. Ямандага бурхны гал мандлыг амарлиулах, дэлгэрүүлэх, эрхэнд хураах, хатуу үйл гэсэн дөрвөн үйл (тө. *zhi, rgyas, dbang, drag*)-ийн үүднээс өргөж хамаг амьтны тусыг үйлддэг. Амарлиулах үйл нь хилэнц түйтгэр, өвчин зовлонг амарлиулж үйлдэх, дэлгэрүүлэх үйл нь ном буян, сайн үйлийг дэлгэрүүлэх, эрхэнд хураах үйл нь хамаг амьтныг эрхэндээ хурааж зөв үйлд оруулах, хатуу үйл нь гай барцад, ад зэтгэр, хүмүүн хийгээд хүмүүн бусын хорлолыг буцаах утга агуулгатай.

Ямандага бурханы амарлиулах гал мандлыг өвчин зовлон, ган зуд арилгахын тухайд өргөж болох бөгөөд ялангуяа бясалгал бүтээл хийсний хойно гүйцээлт болгож өргөдөг. Ямандагын авшиг хүртэж нянбыг (нямба, тө. *bsnyen pa*) нь хийсэн лам хүн энэхүү гал мандлыг өргөх бөгөөд авшиг хүртээгүй, нянба бясалгал хийгээгүй лам өргөж болдоггүй.

Жанжаа хутагт Агванлуvsанчойндон (1642–1714)-ы “Болор толь”-ийн тахил өгүүлэлд:

“Хамт төрсөн их амгалангийн тулганд

Угаас ариун мөн чанарын гэгээн гэрлийн галд

Түйтгэрийн сүүт мод түлсэн тахил өглөгөөр

Хоёр хэрэг үлэмж бүтэх аршийн чуулганаа сөгдмүй”¹ хэмээжээ.

¹ ICang skya Ngag dbang blo bzang chos 'don: dPal 'Jigs byed kyi zhi ba 'i sbyin sreg bya tshul gyi cho ga Blo bzang thugs rgyan shel dkar me long zhes bya ba bzhus so. In: ICang skya Ngag dbang blo bzang chos 'don gyi sku 'bum, 'a, т. 1.

Тулга нь хамт төрсөн их амгаланг, гал нь сэтгэлийн мөн чанарыг илэрхийлэх бөгөөд эд зайгаар тахил өргөж, түлснээр хилэнц түйтгэрийг ариусгаж билиг оюуны гэгээн гэрлийг бадраах тухай гал мандал үйлдэхийн товч утгыг ийнхүү өгүүлжээ. Өөрөөр хэлбэл гал мандал нь хүмүүний муу сэтгэлийн хир буртагийг ариусган сэтгэлийн үнэмлэхүй мөн чанар бэлгэ билгийг төрүүлэх зан үйл гэж ойлгож болно.

Бид Жанжаа Агваанчойндоны “Цогт Ямандагын амарлингуй гал мандал үйлдэх ёсны зан үйл сайн оюут тааллын чимэг цагаан болор толь хэмээх оршвой,” Ямандагын егүзэр, Тивийн хувилгаан нэрийг баригч Лувсанлүндэгданзанпэрэнлэйн “Цогт Ямандага ганц баатарын нянбаны үест гүйцээх гал мандал үйлдэх ёс хилэнц уналын харанхуйг сөнөөж шид бүтээлийн цагаан гэрэл гийхийн залуу саран хэмээгч оршвой,” Тойн Цүлтэмийн бичсэн “Цогт Ямандага ганц баатарын нянбаны сүүлд гүйцээх гал мандлыг хэрхэн үйлдэх ёс шид бүтээл бүхэн гарагч хэмээх оршвой” зэрэг эдүгээ лам хуврагуудын чухал гарын авлага болж буй эх сурвалжуудыг ашиглан өгүүллээ бэлдлээ.² Бид энэхүү өгүүллэдээ хамаг дандарсын хаан урилагч аргын үндэсний эрхэм гагц баатар цогт Ямандага бурхны (тө. *'Jigs byed dpa' bo gcig pa*) бясалгал бүтээлд чухал хэрэгтэй гүйцээх амарлингуй гал мандлыг хэрхэн үйлдэх ёсны тухай танилцуулах юм.

Ямандага бурхны амарлингуй гал мандал

Ямандагын гал мандал үйлдэхэд дөрвөн зүйл буй: 1. Гүйцээх гал мандлын хэрэг, 2. Үйлдэх орон, цаг, 3. Үйлдэгч бодгаль, 4. Зан үйлийн зэрэг болой.

1. Гүйцээх гал мандал үйлдэхийн хэрэг.

“Ядам бурханыг баясгаад шид бүтээл хайрлах хийгээд тарни ариун бус, зан үйл илүү дутуу тэргүүтний гэм болон өвчин ад, хилэнц түйтгэрийг амарлиулах тэргүүтний тус эрдэм гарна” хэмээжээ. Ямандага бурханы шадарлах бясалгал үйлдэхэд гарсан гэм алдааг гал мандал өргөж засах, хилэнц түйтгэр, өвчин ад тэргүүтнийг амарлиулахад чухал хэрэгтэй ажээ.

2. Үйлдэх орон, цаг.

Орон нь: Бясалгал үйлдсэн гэр байшингийн зүүн зүгт аль зохистой оронд үйлдэнэ. Цаг нь: Бясалгалаа төгсгөөд хөл хорио тайлахын өмнө үйлдэх, мөн шинийн нэгэн буюу сайн гариг одтой өдрийн үдшийн цагт үйлдвэл зохилтой ажээ.

3. Үйлдэгч бодгаль.

Үйлдэгч бодгаль нь бясалгал бүтээлийг дэлгэр хураангуй алин болох-оор төгсгөсөн бодгаль энэхүү гал мандлын зан үйлийг үйлдэнэ. Бясалгал бүтээл хийгээгүй аваас гүйцээх гал мандал үйлдэж болохгүй. Гүйцээх гал


² bTsun pa Tshul khirms: *dPal 'Jigs byed dpa' bo gcig pa 'i bsnyen pa 'i rjes su kha skang sbyin sreg ji litar bya tshul dngos grub kun 'byung zhes bya ba bzhus so*, т. 1.

мандал үйлдээгүйгээр бусдын гүрэм засалд гал мандал, сор залах, машид оршоолго (равнай) үйлдэж болохгүй гэжээ.

4. Зан үйлийн зэрэгт гурван зүйл байна.

- Тулга бэлдэх
- Зай бэлдэх
- Хэрхэн үйлдэхийн бодит зан үйл.

Газар авч тулга бэлдэх зан үйл. Гал мандал өргөхөд зохилтой зүгт сайн газрыг сонгон газар авах зан үйлийг номын дагуу үйлдэнэ. Тулга нь хамт төрсөн их амгаланг илэрхийлэх бөгөөд гал мандал үйлдэхийн гол суурь болдог.



Зураг 1. Тулга. *mDo sngags bstan pa'i 'byung gnas dpal mnyam med dga' ldan byang rtse thos bsam nor gling grwa tshang gi phyag bzhes bca' gshom gyi rim pa khag dang/ rgyun du nyer mkho' i zhabs rim gyi bca' gshom ji ltar bya tshul gsal byed zla ba 'bum phrag 'char ba' i dri med lha yi rdzing ring zhes bya ba bzhugs do. dGa' ldan byang rtse dpe mdzod khang, 2013.*

Тулга бэлдэх газар нь чулуу, мод, нүүрс, хого сага, хар өнгөтэй бус ариун газар байх ба үрлэн рашаан (дүдээ рилвү, тө. *bdud rtsi ril bu*)-ы дусал буюу адистид дотоод тахил хольсон сайн үнэртнээр ариусгаж өөрийн өмнө тахил балин бэлдээд “Итгэл явуулж бодь сэтгэл үүсгэх” залбирал (тө. *sKyabs 'gro, Sems bskyed*), гурвантаа уншаад нэгэн агшинд өөрийгөө нэг нүүр, хоёр мутартай Ямандага бурханы омогшилд оршуулан “Хрисди” тарниар тахил балин, орон дэлхийг

хоосон чанарын агаарт ариусгах, газар лусын эздэд тахил балин тэргүүтэн өргөх зан үйлийн номыг уншин гал мандал үйлдэх зөвшөөрөл айлтгана. Газар лусын эздэд зөвшөөрөл хайрлалаа хэмээн сүжиглээд тулгаа бэлдэж эхэлнэ.

Тулганы өнгө, хэлбэр, хэмжээ, бүтээх арга зэрэг нь машид нарийн бөгөөд дээрх эх сурвалжуудад ийн дурджээ:

“Тулганы өнгө цагаан, дөрвөлжин хүрээнд эн (өргөн) нь хоёр тохой төдий, өндөр дөрвөн хуруу илүү төдий болгоод түүний голоос эсрүний шугам болон өнцөг шугамыг нар зөв татна. Тулга, мөөр, хөвөө гэсэн дүгрэг гурван зэрэгтэй байна. Тэр нь:

- Тулга нь тигний голоос нэг төө хэмжээтэй дүгрэг,
- Мөөр нь тулганаас дөрвөн хуруу хэмжээтэй дүгрэг,
- Хөвөө (гадна хүрээ) нь мөөрөөс дөрвөн хуруу хэмжээтэй дүгрэг байгуулна.

Тулганы голд дөрвөн хуруу дүгрэг найман дэлбээтэй лянхуа зурна. Лянхуан хүйсэнд найман хуруу очир, өөрийн харсан зүг рүү үзүүрийг нь харуулж зурна. Хөвөөнд очирын эрхэс, ширээний дөрвөн өнцөгт хагас саран очир зурна. Тулга бүхэлдээ, голын очир, лянхуа зэрэг нь цагаан өнгөтэй байна. Мөөрийн очирын эрхэс, саран хагас очирыг үзэсгэлэнтэйгээр үйлд. Ер нь тулгыг тоосон будаг, цэцэг дэлгээд зурах, усан будгаар зурах, шавар тэргүүтнээр урлах зэрэг алинаар ч үйлдэж болох аж. Тулга болон өөрийн завсарт тоосгоор хана өрж галын бүрхүүл (хөшиг) босгон тулгаруу харсан нүүрэн талд цагаан *Вам (Ban)* үсэг бичих хэрэгтэй. Тийнхүү тулгаа номын дагуу бэлдээд үнээнээс гарсан ариусгагч таван бодис болон дотоод тахилын цагаан зандангаар ариусгаж цагаан цэцэг цацаж дэлгэнэ.

Эдийн ялгал

Гал мандлын нэн чухал зүйл нь галд өргөх эд зай болон тахилын эд зай юм. Галд өргөх зүйл нь тус бүрийн эрдэм чадалтай арван гурван зүйлийн ариун нандин эд зай байна. Үүнд:

№	Эд зайны нэр		Эрдэм чадал
	монгол	төвд	
1	Сүүт мод	<i>yam shing</i>	Сүр жавхланг арвижуулна.
2	Шар тос	<i>mar khu</i>	Эд баялгийг дэлгэрүүлнэ.
3	Гүнжид	<i>til</i>	Хилэнц түйтгэрийг ариусгана.
4	Үет цагаан өвс	<i>dur ba</i>	Нас уртасгана.
5	Тутарга	<i>'bras</i>	Буяныг дэлгэрүүлнэ.
6	Таргаар багсарсан арвайн гурил	<i>zho zan</i>	Амгалан жаргаланг төгс болгоно.
7	Өлзийт өвс	<i>ku sha</i>	Бузар, ариун бус тэргүүтнээс сахина.

№	Эд зайны нэр		Эрдэм чадал
	монгол	төвд	
8	Цагаан гич	<i>yungs dkar</i>	Ад тотгорыг дарна.
9	Хуягт арвай (овъёос)	<i>so ba</i>	Эд таваар дэлгэрүүлнэ.
10	Хөх арвай	<i>nas</i>	Үйл бүтэх хүч залиг үүсгэнэ.
11	Буурцаг (вандуй)	<i>sran ma</i>	Харшлах нөхцөлөөр үл чадагдан чанад дарахын хүч чадал дэлгэрнэ.
12	Буудай	<i>gro</i>	Өвчин арилгана.
13	Ялгамжит эд	<i>khyad par can gyi rdzas</i>	Амарлиулж үйлдэх хэрэгтэй үл зохилдохын зүг бүгдийг амарлиулж үйлдэх учир арвижуулах үг, үйл зохиохын зоригдол тэдгээр лүгээ тохируулан үйлдэх буюу нийтэд хилэнц түйтгэр гэм уналыг ариусгах.

Тэдгээрийн шинж чанар болон хэрхэн бэлдэх тухай эх сурвалжид:³

“*Сүүт мод*: Хагарч өгөрсөн, муруй, илжирсэн, хальстай, муухай үнэртэй, өргөс тэргүүтний гэмээс хагацсан шим сайн модны үзүүрээс авна. Урт нь арван хоёр хуруу, бүдүүн нь чигчий хурууны хэмжээтэй чийгтэй байна. Хоёр үзүүрийг сацуу⁴ таслаж хоёр үзүүрт нь зөгийн бал, сүү, тос түрхэнэ. Дотоод тахил хольсон сайн үнэрт усаар ариусгана. Намрын сүүл сар буюу навч шарлаж буй цагт авахгүй, навч нь шинээр ургаж дэлгэрэх цагт авбаас сайн.

Тос: Малын сүү тэргүүтэн цагаан идээний язгуураас гарсан тос байна.

Үет цагаан өвс (дүрва), *өлзийт* (гүша) *өвс* хоёр нь зун цагийн хар ногоон үндэс үзүүр гэмтээгүй байвал сайн бөгөөд үет цагаан өвсийг сүүгээр, өлзийт өвсийг тос сүүгээр түрхэнэ.

Гүнжид нь хар, *тутарга* нь хагараагүй байх ба хагараагүйг түүхэд бэрх байвал хальстай байж болно. *Цагаан гич*, *хуягт арвай*, *буудай* нугууд нь ерөнхий болно. *Буурцаг* нь бөөрөнхий цагаан байна.

Таргаар багсарсан арвайн гурил (*шо-сан*, тө. *zho zan*) нь тос, тараг хоршсон гурилан үрэл юм уу, тутаргыг хуураад таргаар багсарч хийнэ.

Дээд идээ нь тутарга хуурч тарагтай холиод гурван амтатнаар багсарч үйлдэнэ. Таргийн хөрөнгө лугаа үйлдсэн дээд хоёрыг тус тусад нь найруулаад нэгэн саванд бэлдэнэ.

Ялгамжтай эд нь: үрийн тосоор сүрчсэн өлзийт өвс, арвай, хар гүнжид, сүү, хуурсан тутаргыг хуурч тос, мөсөн чихэр хольсон гурилан тутарга, үет цагаан өвс, зандан, бри-янгү (жүрүрийн цэцэг), танчү (арцны мод болон хуш модны давирхай), үнэрт цэцэг, ус нэвтрээгүй хуурсан тутарга нугуудыг зөгийн бал, сүү, тос түрхэнэ. Дотоод тахил хольсон үнэрт усаар ариусгана” хэмээжээ.

³ ICang skya Ngag dbang blo bzang chos ldan: *dPal 'Jigs byed kyi zhi ba 'i sbyin sreg bya tshul gyi cho ga ...*


⁴ Зарим багш нарын уламжлалаар нэг үзүүрийг нь дөрвөлжиж, нөгөө үзүүрийг нь дөрвөн дэлбээтэй цэцэг адил таслахыг зөвлөдөг.

Дөрвөн усны эд нь: арвай, цагаан цэцэг, хэрчсэн өлзийт өвс, хар гүнжид, хуурсан тутарга, цагаан сайн үнэрт, сүү хольсон ус буюу тахил тавигийн долоон эд зай хэмээн алдаршсан ба дотоод тахил холих болой.

Тахилын эдэд цэцэг нь цагаан цэцэг бодитой буюу цагаан будааны язгуур, хуж нь цагаан зандан, гавар тэргүүтэн, зул нь цагаан модон голтой шар тос. Үнэрт ус нь цагаан сайн үнэртийг хольсон ус, амны идээ нь сүүгээр багсарч замбаагаар хийсэн талхлаг (үйрмэг) буюу жимсний язгуур байна. Хос хувцас нь хувцас, цагаан торгоны язгуур хоёр тэнгэрт хоёр хоёр буюу дөрөв байна. Хадаг болно. Созэ нь очир бинлэнгийн навчны үйрмэг найруулсан түүхий тосоор бөөрөнхий хэлбэртэй голд нь хөх адил навчтай балин байна. Балин нь бөөрөнхий тосон балин буюу чимар (талхлаг), жимс байж болно.


Бусад хэрэгсэл: *түлээ* нь сүүт модны төрөлтэй адил хуурай мод буюу тал хээрийн хатсан үхрийн хорхой шавьжгүй аргал байсан ч болно. *Сэвүүр* нь цагаан даавуугаар хийсэн, *цогийг* (*бамбар*) *бадруулагч* нь сүүт адилын хуурай модонд хөвөн юм уу цагаан даавуугаар ороож тосонд дүрнэ. Тулганы хөвөөгөөр хар ногоон гол нь бүдүүн, үзүүр ёроол нь нарийн урт богино өлзийт өвс наймыг таацуулан тулгыг бүрхэнэ.

Цагаан даавуугаар бүтээсэн ширээнд ариусгагч сайн үнэрт ус сэлт бумба, тахил балин, будаа, үснирийн чимэг, цээживч хормогч, эд зай, хөгжим тэргүүтэн аль хэрэгтэй зүйлсийг хотол чуулган бүрдүүлж бэлдэнэ.



Зураг 2. Гал мандалын тахил, зай.

Тэдгээрийг бэлдэх ёс нь: Бүтээгчийн баруун зүгт цагаан даавуугаар бүтээсэн ширээн дээр ертөнцөөс хэтийдсэн тэнгэрт өргөх зүйл сүүт модны үзүүрийг гадагш харуулан өрж бэлдэнэ. Тэгээд дэс дараалан гүнжид, үет цагаан өвс, тутарга, таргаар багсарсан гурил, өлзийт өвс, цагаан гич, хуягт арвай, арвай, буурцаг, буудай, ялгамжит эд зэргийг бэлдэнэ. Ялгамжит эдийг тус тусад нь бэлдээд тус тусад нь өргөвөл болох хэдий ч нэгд холиод өргөвөл хялбар учир тэр мэт үйлд. Эд нугуудыг цагаан сав буюу эсвээс хагарч цуураагүй ариун үзэсгэлэнтэй саванд бэлдэнэ.



Зураг 3. Гал мандалын тахил.

Түүний дотор талд галын тэнгэрт өргөх сүүт модноос эхлээд ялгамжит эд хүртэл бэлдэнэ. Хоёр тэнгэрийн гал мандлын эдийг тус тусад нь бэлдэх сав үгүй болбоос нэгд бэлдсэн ч болно.

Түүний дотор талд ертөнцөөс хэтийдсэн тэнгэрийн чухал эдлэл, хос хувцас (цагаан хадаг), созэ (дамбула) балин, түүний дотор буюу адагт галын тэнгэрийн (тө. *me lha*) чухал эдлэл, созэ, хос хувцас (цагаан хадаг), балин зэргийг бэлдэнэ.

Бүтээгчийн зүүн талд бусдыг өргүүлбэл түүний өмнө дөрвөн усны бодит ширээ буюу үгүй бол ширээний дээр найман дэлбээт лянхуаны дээр зүүн талаас эхэлж эхний саванд ариулах цацал, ам сэрүүцүүлэг, хоёрдугаарт тавиг ус, гуравдугаарт өлмий сэрүүцүүлэгч бэлдэнэ. Тэр гурвын тус тусын өмнө сайн амны идээ нэжгээд нэжгээд ба тэдгээр лугаа ойролцоо ариулах цацал өргөх өлзийт өвс, нэмэх эд хийгээд ус зэргийг бэлдэнэ.

Тос нь бүтээгчийн өмний баруун зүгт тахилчид ойр ширээн дээр бэлдэнэ. Тосох, цутгах шанаг нь баруун өвдөгний ойр ширээ буюу найман дэлбээт лянхуан дээр тавина. Дотоод тахил, ариусгах ус нь зан үйлийн эхэнд ариус-

гагдахуун олноор өмнө тавьсныг гүйцээгээд эд өргөхийн үест баруун, зүүн аль амарт тавина.

Цогийн бадруулаг, сэвүүр, өлзийт өвс, тос утгах шанаг, түлээ тэргүүтэн нь тахилчийн ойр аль зохистойгоор бэлдэж тавина. Тулганы бөөрөнхий шугамын дээр түлээгээ нэг төөнөөс өчүүхэн нам төдийд дугуйлан өрөөд түүний дотор ч түлээгээ босгож тавиад зүүн урд завсарт эхэлж гал асахад хялбар өвс адилаар галын өр засна. Түлээгээ дотоод тахил хольсон цагаан зандангаар ариутгана.

Бурханы дүр хөрөг залах ба үгүй бөгөөс сэтгэлдээ санаад гал мандлын тахилаар илүү дутуу тэргүүтний гэм унал, хилэнц түйтгэр ариусч ядам бурханд шадарлах тэргүүтний тухайд энэ зан үйлийг үйлдэх учир зөвшөөрөл хайрлан соёрхлоо хэмээх санаагаар гал мандлыг үйлдэнэ.

Зан үйлийг бодитой үйлдэх

Шүтээний өмнө ядамын зүг тэтгэгдэхүүн Ямандага нугуудын тахил, цацал (балин), өөрийн өмнө хонх очир, дамар, дотоод тахил, түүний ард өөрийн үүсгэлийн тахил, өөр нэг ширээн дээр урьд явуулах тахил, цацал зэргийг бэлдэнэ. Өөрөө тулга лугаа адил найман дэлбээт цагаан лянхуа зурсан хэтэрхий өндөр бус зөөлөн бөгөөд амгалантай ар нь өчүүхэн өндөр суудалд зүүн зүгт харж завилж сууна. Бүтээлийн нөхөд баруун зүүн аль зохистойд суугаад Итгэл явуулж бодь сэтгэл үүсгээд “Багшийн дамжлага залбирал”-аас эхлээд Өөрийн үүсгэлийг хүртэл дэлгэрэнгүй уншиж бясалгана.

Өргөх ёс нь: тос, үрийн язгуур, ялгамжит эд нугуудыг тосох цутгах шанагаар өргөнө. Үет цагаан өвс, өлзийт өвсийг хоёр хоёроос дээш сүүт мод мэт гараараа өргөнө. Өргөх орон нь: сүүт мод, үет өвс, өлзийт өвс нугуудыг лагшингаас цацарсан гал дотор өргөхийг сана. Тос нь аманд өргөх, гүнжид тэргүүтэн нь гарт өргөхийг зорьж бясалгана.

Газрын эздэд балин өргөж галаа бадрааснаар зан үйлийн уншлага эхэлнэ. Зан үйл нь хоёр хэсэгтэй байна.

1. Ертөнцийн галын тэнгэрт тахил өргөнө. Хамаг амьтанд туслах бодь сэтгэлийн үүднээс галын тэнгэрт сүүт мод тэргүүтэн 13 эд зайг өргөн галын тэнгэрийн тарни, эдийн тарнийг яруу дуугаар уншин “Багш шавь, нөхөр сэлтсийн нирваан хийгээд Бүхнийг айлдагчийг бүтээхэд зэтгэрлэсэн, гурван санваар лугаа харшилсан, амлашгүй нүгэл хилэнц, хамаг өлзий бус, ялангуяа сүр жавхлан хотол чуулахад зэтгэрлэгч, самади тодорхой бус, тарни ариун бус, зан үйл илүү дутуу тэргүүтний хамаг гэмийг амарлиулах болтугай” хэмээн уялга үгийг өгүүлж утгыг бясалгана.
2. Ертөнцөөс хэгийдсэн галын тэнгэрт тахил өргөнө. Тахил болон эд зайг адислан ариусгаж тахил өргөөд галын тэнгэрийг үүсгэх уншлагыг зан үйл (чого)-ийн дагуу уншиж утгыг бясалгана. Түлэх эд өргөх үед Бурханы тарни, эдийн тарни, уялга үг гурвууланг найруулан уншиж арван

гурван эд зай тус бүрийг өргөнө. Эд зай тус бүрийг бүрэн өргөөд тавиг ус, ариулах цацал, өлмий сэрүүцүүлэгч гурвыг өргөнө. Түүний дараа хадаг, созэ балинг зэргийг хотол өргөнө. Дахин сүүт модноос эхлээд бүгдийг дэс дараалан өргөж гүйцээнэ.

Ийн тахил, эд зай тэргүүтнийг өргөж тахисны дараа илүү дутуу унш-саны гэмийг амарлиулах “Зуун үсэгт” тарни, хүлцэл өчил, ачлалын тахил, ерөөл, өлзий оршуулах тэргүүтнийг уншиж зан үйлийн уншлагыг өндөрлөнө.

Ийнхүү Ямандага бурханы гүйцээх амарлингуй гал мандлыг үйлдэж гэм уналыг ариусгах хийгээд ялангуяа нисванисаас үүдэлтэй хилэнц түйтгэрийг галдан шатааж хамт төрсөн их амгаланг төлжүүлэн бэлгэ билгийг төрүүлэх оюун ухааны их хүч энерги орших болой.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэн өгүүлбээс Ямандага бурхны гал мандал нь нууц тарнийн бя-салгал бүтээл үйлдэх хэн нэгэн бээр зайлшгүй өргөх ёстой чухал зан үйлийн нэг мөн. Тиймээс энэ зан үйлийг Багшийн удирдлага дор нарийн нягт суралцаж өргөх зан үйлд мэргэших хэрэгтэй. Энэ нь эхлээд хилэнц нүглээс ангижирч өөрийгөө боловсруулан эрдэм чадал олоход чухал аньстай. Мөн хамаг амьтанд туслахын үүднээс өвчин зовлон, ад зэтгэр, ган зудын аюулыг амарлиулахад энэхүү зан үйлийг үйлдэх нь нэн тустай. Төвчдоо Ямандагын гал мандал нь өөрийгөө боловсруулж, бусдад туслах нэн чухал нууц тарнийн зан үйл болой.

Ном зүй

ICang skya Ngag dbang blo bzang chos ldan: *dPal 'Jigs byed kyi zhi ba'i sbyin sreg bya tshul gyi cho ga Blo bzang thugs rgyan shel dkar me long zhes bya ba bzhus so* [Жанжаа Агваанлуvsанчойндон: Цогт Ямандагын амарлингуй гал мандал үйлдэх ёсны зан үйл сайн оюут тааллын чимэг цагаан болор толь хэмээх оршвой]. Бар судар, Г. Буяндэлгэр ламын хувийн архив. Хэвлэгдсэн газар, огноо тодорхойгүй.

'Jigs byed kyi nral 'byor pa gleng sprul ming 'dzin Blo bzang lung rtog bstan 'dzin 'phrin las: *dPal 'Jigs byed dpa' bo gcig pa'i bsnyen pa'i skabs su kha skang sbyin sreg byed tshul sdig ltung mun sel dngos grub 'od dkar 'byung ba'i gzhon nu zla ba zhes bya ba bzhus so* [Ямандагын егүзэр Тивийн хувилгаан нэрийг баригч Лувсанлүндогданзанпэрэнлэй: “Цогт Ямандага ганц баатарын нянбаны үест гүйцээх гал мандал үйлдэх ёс хилэнц уналын харанхуйг сөнөөж шид бүтээлийн цагаан гэрэл гийхийн залуу саран хэмээгч оршвой”]. Бар судар, Г. Буяндэлгэр ламын хувийн архив. Хэвлэгдсэн газар, огноо тодорхойгүй.

bTsun pa Tshul khirms: *dPal 'Jigs byed dpa'bo gcig pa'i bsnyen pa'i rjes su kha skang sbyin sreg ji ltar bya tshul dngos grub kun 'byung zhes bya ba bzhugs so* [Тойн Цүлтэм: Цогт Ямандага ганц баатарын нянбын сүүлд гүйцээх гал мандлыг хэрхэн үйлдэх ёс шид бүтээл бүхэн гарагч хэмээх оршвой]. Бар судар, Г. Буяндэлгэр ламын хувийн архив. Хэвлэгдсэн газар, огноо тодорхойгүй.

Монгол Данжуур. 44, 45-р боть. Монгол бичгээс хөрвүүлсэн “Цогт Цагийн Хүрдэн” соёлын төв. Улаанбаатар 2012.

Цэрэнсодном, Д.: *Монголын бурханы шашны уран зохиол*. Улаанбаатар 1997.

Уул, ус тахих – Монголчуудын зан үйл

Рэнчингийн Дарьхүү – Дашдоржийн Оюунгэрэл

Монгол Улсын Их Сургууль, Философи, Шашин Судлалын Тэнхим, Улаанбаатар

Энэхүү өгүүлэлдээ бид Монголчууд эртнээс эдүгээ хүртэл байгалиа хайрлан хамгаалж ирсэн уламжлалт зан үйлийн нэг болох уул, ус тахих зан үйлийн уламжлал, шинэчлэлийн асуудлыг судалгааны бүтээлүүдэд үндэслэн авч үзлээ.

Байгаль бол хүний оршихуйн язгуур үндэс, хүний ахуйн үнэт зүйл билээ. Ийм ч учраас байгалиа хайрлан хамгаалах буюу байгалийг хадгалан үлдээх асуудал өнөөдөр дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болсон. “Байгалиа хайрлан хамгаалах гэдгийн гол утга нь юу вэ? гэхээр хүн өөрийн ахуйгаа хамгаалах гэсэн утга байдаг. Хүний ахуйг бий болгогч үндэс бол амьд байгаль. Гэтэл хүмүүс өөрөө өөрийнхөө ахуй орчин руу дайралт хийсээр байна. Энэ бол буруу үйлдэл юм гэдгээ мэдсээр байж шүү дээ. Уг нь хүн байгальтай харилцах ёс суртахуунтай байх ёстой. Тийм байж л хүний амьдрах орчин жинхэнэ утгаараа бүрдэнэ.¹ Энэ асуудлын гол утга санаа нь хүмүүн бид байгаль дэлхийтэйгээ зөв зохистой харьцах, байгалийн нөөц баялгийг ариг гамтай хэрэглэхэд оршино. Уул, ус тахих зан үйл нь Монголчуудын байгальтай зөв зохистой харьцах, ухаалаг хэрэглэх гэсэн байгаль хамгааллын уламжлалт ухаан юм.

Монголчууд байгалийг хэрэглэхээсээ илүү хайрлаж хамгаалах ёс заншлыг эрхэмлэж ирсэн байна. Түүний нэг жишээ нь уул, усаа хайрлан хамгаалах баялаг сайхан уламжлал мөн. Байгалийг хайрлан хамгаалах Монголчуудын ухамсар нь XX зуунд үзэл суртлын байдлаас хавчигдах болсон боловч эдүгээ дахин сэргэж буй нь хүний оршихуйн үндэс болсон уул, усаа төрүүлж өсгөсөн эх лүгээ бишрэн хайрладаг тэрхүү уламжлалт соёл хэзээ ч алга болохгүйн илрэл болсон гэж хэлж болно. Уул, усаа хайрлах, түүний гоо сайхан чанарыг үнэлдэг Монголчуудын уламжлалт ухаан нь гайхамшигтай.

“Монголчуудын уламжлалт соёл, ёс заншил хэдэн мянган жилийн турш байгаль орчинтойгоо зохицон аж төрөх, байгалийн баялгийн зохистой хэрэглээг дэмжих ёс суртахууны зарчмуудыг агуулж байв”² хэмээн М. Золзаяа бичсэн буй. Тийм зарчмын нэг бол байгалийг хайрлан хамгаалах явдал мөн. Бидний өгүүлэлдээ авч үзэж буй уул, ус тахих зан үйл нь энэ зарчимтай шууд холбогдоно.

Монголчууд эрт цагаас байгаль орчноо төрийн хууль, бөөгийн шашин ба бурхны шашны зан үйл, ард нийтийн зан үйлээр хайрлан хамгаалж ирсэн

¹ Дарьхүү, Р. – Насанбат, Б.: Экологийн ёс зүй дэх биотөвт үзлийн онцлог. *Философи, шашин судлал сэтгүүл* 15 (391) (2013), т. 8.

² Золзаяа, М.: *Экологийн ёс зүй – Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй*. Улаанбаатар 2012, т. 364.

түүхтэй. Монгол гүрний их хаадууд байгалийг хайрлан хамгаалах талаар байнга анхаарч ирсэн байдаг. Монголчуудын өвөг дээдсийн оршин нутаглаж байсан голомт нутаг дээр улиран хувирч, мандан мөхөж байсан эртний умардын нүүдэлчин үндэстнүүд уул тахиж байсан тухай түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлджээ. Тухайлбал, “Судар тэмдэглэл, Хүннүгийн намтар”-т “Тавдугаар сард тэнгэрийн их чуулган болж тэдний өвөг дээдэс тэнгэр, газар орон сахиулсныг тахимой” гэж, бас “Зүүн хан улсын бичиг”-т “Хүннүчүүд цагаан сар, таван сар, есөн сард чуулга болж, тахилга хийхдээ морь давхиулж, тэмээ уралдуулдаг” гэж тэмдэглэжээ. “Монголын нууц товчоо”-нд Чингис хаан “Өшөөт дайснаас, Өршөөн аварч, Өнчин бидний, Өмөг болсон, Өндөр дээд, Бурхан халдун чамайг, Өглөө бүр мялааж байя, Өдөр бүр тахиж байя, Үрийн үрд, Үүрд тахиж, Үе тутам, Үргэлж шүтэе ... гэж бүсээ хүзүүндээ эрх мэт өлгөж, малгайгаа гарт сэгэлдэргэлж, гараар өвчүүгээ дарж, наран өөд хандаж, Бурхан халдунд есөнтөө сөгдөж өчин, сацал сацав”³ гэжээ. Энэ нь төрийн их тахилгат Бурхан халдун уулын тахилгын соёл их эзэн Чингис хааны үеэс өнөө хүртэл өвлөгдсөөр уламжлал нь тасраагүй байгааг гэрчилнэ.

Тан улсын түүхэн сударт VIII зуунд Орхон мөрний хөвөөнөө мандаж асан Түрэгийн хаад, бидний “Этүгэн эх” хэмээн сүслэх одоогийн Отгонтэнгэр уулыг тайж, тахиж, рашаан усыг нь эм эмнэлэгт ашиглаж байсан мэдээ сурвалж бий. Тэрчлэн Сүнбэ, Нируны үед уул овоо тахиж байсан ба энэ уламжлал Чингис хааны үед ихэд дэлгэрч, улмаар Манжийн хааны үеийг хүртэл тасралгүйгээр уламжлагдан үйлдэгдсээр байсны жишээ гэвэл XVIII зууны үед Манжийн хаан зарлиг гаргаж, 1778 онд Хан хайрхан уул, 1779 онд Отгонтэнгэр уул, 1818 онд Хан Хэнтий уулыг тус тус тайж тахихаар болгосон байдаг.

Монголчууд эртнээс өнөөг хүртэл уул ус, газар нутгаа тахиж ирсэн бөгөөд уул усны тухайд ихэнх нь гол мөрөн, нуур цөөрмийн эх байдаг. Өөрөөр хэлбэл, ус үйлдвэрлэх эх болсон уул овоодыг ийнхүү тайж тахиж, эрхэмлэн хамгаалж байсан байна. Монгол улсын ерөнхийлөгч асан Нацагийн Багабанди төрийн тэргүүнээр ажиллах хугацаандаа уул тахиx уламжлал заншлаа сэргээж, “Уул овооны тэнгэрийг тайх төрийн ёслол үйлдэх тухай”⁴ зарлиг буулгасан ажээ. Түүнчлэн дараа, дараагийн Ерөнхийлөгчийн үед төрийн тахилгат уул нэмэгдэж, Сутай хайрхан, Хан Хөхий, Их тахилгат хайрхан, Суварга хайрханыг тус тус төрийн тахилгатай болгож, Монголчууд өнөөдөр тахисаар байна. 2012 онд гаргасан Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн зарлигаар⁵ таван жилд нэг удаа тахиж байхаар тогтжээ.

Монголчуудын хувьд уул, усаа тахин шүтэхдээ үйлдэх зан үйл нь анх нүүдлийн аж төрөх ёс болон бөө мөргөлтэй холбоотойгоор үүсч, улмаар бурханы шашны нөлөөг аван хөгжиж ирсэн бөгөөд бидний уламжлалт соёлын нэгэн салшгүй хэсэг болжээ. Энэ талаар Ч. Ган-Өлзий бичихдээ: “Нүүдэлчдийн ре-

³ *Монголын нууц товчоо*. Болор судар хэвлэлийн газар, Улаанбаатар 2015, т. 32.

⁴ Уул овооны тэнгэрийг тайх төрийн ёслол үйлдэх тухай. [http://www.newsmedia.mn/19976\(04.2017\)](http://www.newsmedia.mn/19976(04.2017)).

⁵ Элбэгдоржийн зарлиг. [http://www.elbegdorj.mn/cgi-sys/suspendedpage.cgi?view=arhiv&id=11628\(04.2017\)](http://www.elbegdorj.mn/cgi-sys/suspendedpage.cgi?view=arhiv&id=11628(04.2017)).

лятивизмийн өөр нэг гносеологи үндэс нь мөнхийн сүнсний тухай үзэл санаа, хойд насны амьдралд итгэх, дахин төрөх хувь тавилан гэж үзэх итгэл үнэмшил юм. Энэ бүхэн нь бидний байгальд хандах харилцааг байнга хүмүүнлэг байлгаж, хэрэглэхээсээ илүү хайрлаж хамгаалах оюун санааг бүтээж байжээ”⁶ гэжээ. Ийнхүү Монголчууд эртнээс байгалийг хүндэтгэх, байгальд ээлтэй амьдрах ухаанаар үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлал баялаг түүхтэй.

Уул, усаа тахиж шүтэх монгол ёс заншил нь байгальд ээлтэй амьдрах, байгальдаа хор хөнөөл учруулахгүй, аз жаргалтай амьдрах, байгальтай зохицон амьдрахын зайлшгүйг ухаарсан Монголчуудын хүмүүнлэг үзлийн нэгэн илрэл, хүн байгалийн хоорондын зохист харилцааг дээдэлсэн байгаль төвт үзэл баримтлалын илрэл мөн.

Монголын аль ч нутагт тахилгат уул элбэг байна. Тахилгат уул дараах онцлогтой. Үүнд:

- Тахилгат уул тухайн нутаг орондоо хамгийн сайхан сүрлэг өндөр уул байх нь олонтаа.
- Тахилгат ууланд бишрэл, хүндэтгэлийг төрүүлэхээр сайн сайхныг бэлгэдсэн нэр өргөмжилсөн байдаг.
- Тахилгат уулын төрх байдал нь тахин шүтэж ирсний нөлөөгөөр бусдаас илүү сайн хадгалагдсан байдаг онцлогтой.
 - = Өвөг дээдсээс үе уламжлан тахин шүтэж ирсэн уул, ус байдаг.
 - = Тахилгат уул нь тахилгын судар, домог, ерөөл, магтаалтай.
- Тахилгат уул бүр өвөрмөц зан үйл, ёслол, хорио цээрийн ёс горимтой байдаг.

Нүүдэлчин удамтай Монголчууд ган, зуд зэрэг байгалийн хатуу ширүүн үзэгдлийг даван туулахын тулд уул, усаа аргадан сан тавих, сэржим өргөх, идээ шүүснийхээ дээжээс өргөх зэрэг санаа бодлоо илэрхийлдэг ёс эртний уламжлалтай билээ. Монголчууд тэнгэрийн эзнийг Хурмаст, усны эзнийг лус, уулын эзнийг савдаг хэмээн тахиж иржээ. Үүнийгээ “Уул савдагтай, ус эзэнтэй” хэмээх зүйр үгээр илэрхийлдэг. Зарим нутгийн эзэн савдаг нь их төлөв эмэгтэй савдаг байх тохиолдол элбэг буй. Эзэн савдгийг бүсгүй хүнээр төлөөлүүлэх нь эртний утгаараа эхийн эрхэт ёстой холбоотой боловч өнөө цагийн утгаараа бол эхийн цагаан сэтгэл, гоо сайхан зэргийг онцлон хүндэтгэж байсны илрэл мөн.

Харин зарим уул эзэн савдгийг номч мэргэн хүнээр төлөөлүүлэн өгүүлсэн байдаг нь Монголчууд эрдэм ном, түүний ач ивээлийг хүндэтгэн үздгийн илрэл мөн. Жишээлбэл, Чингэлтэй уулын эзнийг дурдаж болно. Энэхүү уулын эзнийг дүрсэлснийг сийрүүлбэл, их ой цэцэрлэгээр хүрээлүүлсэн гурван давхар орд харшийн дотор Чингэлтэй хайрханы эзэн бие нь индранилийн өнгөтэй, гурван мэлмий төгөлдөр, зүрхэн тус газраа Бурхан багшийн зураглалыг тодруулсан, баруун мутартаа номын боть барьсан, зүүн мутартаа цагаан цэцэг барьсан,

⁶ Ган-Өлзий, Ч.: Нүүдэлчдийн философийн экорелятив шинж чанарын тухай асуудалд. *Эрдмийн ертөнц сэтгүүл* 2011/2, т. 10.

шавь хүүхдийг өвөр дээрээ суулгасан, орой дээрээ номын цагаан хүүхдийн тоорцогтой гэх мэтчилэн дүрсэлсэн байдаг.

Энэ дүрслэлээс харахад, Монголын олон тахилгат уул хайрханы эзэн савдаг нь догшин бурхад байдаг нь Монголд бурхны шашин дэлгэрснээс хойш буй болсон уламжлал юм. Жишээ дурдвал, Отгонтэнгэр уулын эзэн Очирваань гэх мэт олон жишээ буй. Энэ уламжлал эдүгээ ч мөн хэвээр буй болно. Хайрхны түүхийн хуудаснаас сөхвөл, Бурхан багшаас Замбуулинд таван их тэнгэр уул хайрласны хамгийн отгон нь Богд Очирваань хайрхан бөгөөд Отгонтэнгэр уулыг төрийн ёслолын хэмжээнд бөө мөргөл, бурхны шашны ёсоор тайж, тахиж ирсэн түүхтэй. Отгонтэнгэр хайрхан нь 1799 оноос 230 гаруй жил төрийн тахилгатай байсан. Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагтын таалал төгссөн 1924 оноос төрийн тахилга зогсч, гагцхүү бурхны шашны ёсоор тахих зан үйлийг алдаг оног, ил далд үйлдсээр цагийн аясаар саарч, 1930-аад оны үед тахиснаас хойш тахилгын уламжлал тасарчээ. XV жарны цагагчин гахай жил буюу 1911 оны Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын “Зарлигаар тогтоосон Хууль зүйн бичиг”-т “Тайх тахилгах ёслол”-ыг хуульчилж, төр шашныг хослон баригч, VIII Богд Жавзандамба хааны зарлигаар Отгонтэнгэр уулыг төрийн ёсоор жил бүр тайж байх төрийн зарлиг гарсан бол 80-иад жилийн дараа төрийн ёсоор тайж ирсэн уламжлалыг сэргээхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 110 дугаар зарлигаар айлдан соёрхсон билээ. Энэ нь төрт ёсны нэгэн онцлог үйл явдал байлаа.

Монголчууд газраа мал аж ахуйн зориулалтаар ашиглаж түүнээ нутаг хэмээн нэрлэж, тэрхүү нутгаа онгон бэлчээр болгож тахих маягаар хадгалж хамгаалж иржээ. Нутаг усыг бий болгодог уул нуруу, даваа гүвээ, нуур гол усанд ямар нэгэн ид шидийн хүчтэй савдаг бий гэсэн үзэл үүсчээ. Иймээс Монгол хүн өглөө, орой бүр уул, усныхаа лус савдагийг аргадах үүднээс сүүтэй цай, хөөрүүлсэн сүүнийхээ дээжнээс дөрвөн зүг найман зовхист өргөдөг уламжлалтай. Ялангуяа өглөө чанасан сүүтэй цайнаасаа бурхандаа өргөөд, дараа нь уул, усандаа сүсэглэн өргөнө. Энэ нь байгаль дэлхий цаг агаараа сайн сайхан байж, нүүдэлчин бидний амьдралд нэмэр болоосой гэж ам бүл, эд хөрөнгө, мал ахуйгаа даатгадаг боловч нөгөө талаас нь авч үзвэл төрөлх уул, усандаа ихээхэн хүндэтгэлтэй хандаж байгаль дэлхийгээ шүтэн биширч байдгийн шинж гэж үзэж болох юм. Мөн Монголчууд шинэ гэр барих, хүүхдийн даахь үргээх, цагаан сарын шинийн нэгэн болох бусад томоохон баяр цэнгэлийн үед заавал тэнгэр, нутгийн уул, усандаа цай, дээж, айраг, цагаа, архины дээжээ өргөж уул усандаа хүндэтгэл үзүүлдэг ёс заншилтай.

Уул, ус тахих зан үйлийг хийхдээ юуны өмнө тусгайлан зохиосон ном судрыг уншиж, тухайн нутгийн эзэн савдгийг урин залж буй хэмээн сэтгэлдээ итгэн бодож, хүслийн таван эрдэнэ болсон хүж, цэцэг, зул тэргүүтнээр тахил өргөн, түүний сайхан үнэрээр газар орны эздийг баясгадаг. Ийнхүү газарт бууж ирсэн эзэн савдгаа улам баясгахын тулд таван хошуу малаасаа сорчлон сэтэрлэх ёслол үйлддэг. Сэтэрлэх зан үйл нь тухайн малыг тэнгэр газар, уул усныхаа эзэн савдагт өргөж, дархлан онголж буй хэрэг юм. Сэтэрлэх зан үйл нь тухайн малыг бурхан тэнгэр, газар усны эзэн савдагт өргөж, дархлан онголж байгаа

хэрэг юм.⁷ “Сэтэр” (тө. *tshe thar*) гэдэг дархлах гэсэн утгатай төвд үг. Сэтэрлэх нь бурхны шашны зан үйлийн нэр боловч сэтэрлэх зан үйл бөөгийн шашны зан үйлд бас түгээмэл байдаг.

Ус бол амьдрал тэтгэгч ариун зүйлийн нэг хэмээн Монголчууд ихэд эрхэмлэнэ. Рашаан булаг, шандны эхний мод, бутыг авах, гэмтээхийг цээрлэж хадаг яндар зүүн дархлана. Усны эхийг булингартуулахаас болгоомжилно. Булаг, шанд, рашааны тулах эхэнд айл буухыг хориглоно. Сүү цагаан идээтэй шанага, халбагаар булаг, шанд, гол, горхи, худгийн уснаас хутган авдаггүй. Тогтмол усанд биеэ болон хувцасаа угаахыг цээрлэнэ. Гол ус, булаг шандны эхэнд болон ойр орчинд шээх, бохир зүйл хаяхыг цээрлэнэ.

Хүний өөрийнх нь санаа бодол газар дэлхийдээ нөлөөлдгөөс газар дэлхий нь эргээд хүнд нөлөөлдөг гэсэн ойлголт тогтсон байдаг. Уул усыг тахиx гол зорилго нь нэг талаар газар усныхаа лус савдаг эздийг баясгаж, тэднээс нутаг, айл аймаг, гэр бүл, мал сүрэгтээ буян хишиг, аврал гуйж буй хэрэг боловч нөгөө талаар бол энэхүү зан үйл нь газар нутгаа хайрлан хамгаалах болон түүний гоо сайхан чанар, өгөөж хишгийг хүндэтгэн биширсний дээд илэрхийлэл юм. Уул усаа тахиx зан үйл нь хүүхэд залууст байгаль орчинтойгоо ухаалгаар харьцах, унаган төрхөөр нь хадгалах зорилгыг агуулдаг. Энэ нь хүүхэд залууст байгаль хамгаалах ухамсрыг төлөвшүүлэх арга болохоос гадна газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг хадгалах чухал арга болохыг сургадаг.

Монголын тахилгат уул усыг их тахилгатай, бага тахилгатай, байнгын шүтлэгтэй хэмээн хуваадаг. Тахилгын хэмжээгээр нь олон даяар тахиx, өрх гэрээр тахиx зэрэг янз бүрийн хэлбэртэй. Жишээ нь: нийслэл Улаанбаатар хот нь дөрвөн уулын дунд оршдог бөгөөд тэрхүү дөрвөн уулыг нийгмийн анги давхаргын ялгаатай тахиж ирсэн байна. Чингэлтэй хайрханыг номч лам нар, Баянзүрхийг худалдаачид, Сонгино хайрханыг цэргийнхэн, Богд хан уулыг засаг ноёд тахиж ирсэн уламжлалтай.

Уул усны нэг догшин эзэн бол лус юм. Лус нь үүл үүсгэн, хур бороо оруулах сахиус бөгөөд лусын найман аймаг бий гэдэг. Лусыг могой буюу морьтой хүний дүрээр зурж тахиx явдал их байсан. “Уул тахиx ёслол бол чухамдаа уулын эзэн лусыг тахиx ёслол болно” гэж академич Ц. Дамдинсүрэн бичсэн. Бурханы шашны домгоор бол лус нь хүн толгойтой, могой хэлбэрийн биетэй, газар дэлхий, уул усны эзэн, хүмүүн бусын амьтан гэдэг. Навдаг буюу орны эзэн нь орон нутгийн эзэн савдаг, сүлд болсон тэнгэр юм. Хүний толгойн оройн үсэнд ирж оршин хүний амь нас, хишиг буяныг сахин хамгаалдаг гэдэг. Иймд хүний толгойд гар хүрэх, морь, малын толгой руу цохиж нүдэхийг цээрлэн буян хишиг зайлна гэж үзэж иржээ.⁸

Буддын шашны үзлээр бол уул усны эздийг аргадах (тахих) нь уул усны эзэд баясч бороо хур орж, жилийн сайн үрийг бүтээж өгдөг хэмээн үздэг. Хэрэв эс аргадваас хор хөнөөл хүргэдэг гэнэ. Аргадах гэдэг нь тахиx хэмээх утгаас гадна өдөр тутмын үйл хэрэгтээ уул, устайгаа зөв харьцах гэсэн утгыг агуулж байна.

⁷ Сүхбаатар, О.: *Монголын тахилгат уул, усны судар оривой*. Улаанбаатар 2001, т. 10.

⁸ Сүхбаатар, О.: *Монголын тахилгат уул...*, т. 11.

Жишээ нь: хад чулуу, мод бут руу шээж болдоггүй. Хэрвээ зүй бус харьцвал амь насанд аюул учирдаг тухай үлгэр домог, хууч яриа олон байдаг бөгөөд энэ нь хүүхэд залуустаа биеэ зөв авч явах, нутаг усаа хайрлан хамгаалах ухамсрын ийн уламжлан сургадаг.

Уул, овоонд эзэн савдаг бий болгохдоо тухайн газар орны байр байдал, байгалийн тогтоцыг ажин шинжиж ямар шинжтэй буйгаар нь бий болгох тохиол байжээ. Жич: Улаанбаатарын дэргэд орших Сонгинохайрхан уулын сангийн судрыг Их хүрээний нэгэн эрдэмт лам Төвдөөс залагдан ирсэн Лувсанпэрлэй-жамцаас соёрхол эрэн, зохиож өгөөч гэж хүссэн байдаг. Тэрхүү Төвдийн эрдэмт ламтан Сонгино хайрханыг шинжиж үзээд: Их цэргийн ноёны дүртэй уул юм. Тэгэхдээ айхавтар догшин юм байна. Хатуу үйлийг захин хүсэхэд түргэн бүтээх идтэй. Энэ уулын эзэн хөх бух унасан, араа соёо нь зөрсөн, архинд дуртай хөх өвгөн байна гээд уг хайрханы сан сэргимийг зохиожээ.⁹ Үүнээс үзвэл сангийн судрыг зохиогчид нь уул, усыг шинжин, уул, усны эздийг сэтгэлдээ ургуулан уран сайхнаар сэтгэн бүтээж ирсэн уламжлалтай.

Уул, ус тахих зан үйл нь Монголчуудын оршихуйн үндэс болсон байгаль дэлхийгээ хамгаалах, хайрлах, хүрээлэн буй орчноо дархлах ардын уламжлалт арга юм. Энэ арга нь эзэнгүй газар, хад чулуу, ус нутаг байхгүй, бүгд эзэнтэй тул хилэгнүүлж болохгүй, тахиж шүтэж аргадаж байх тухай бурхны шашны зарим зан үйлтэй хоршиж улам өргөн утга агуулгатай болсон байна.

Өнөө үед уул, усаа тайж, тахих үйлийг өргөн цар хүрээтэйгээр үйлдэх болсон нь ихээхэн олзуурхууштай ч гэлээ учир дутагдалтай зүйл ч олон байна. Тухайлахад, төрийн тахилгат Бурхан халдун хайрханы өмнө бие дэх Далай нуурыг тойроод зуны цагт самарчдын оромж дүүрдэг, нутгийн малчдын ярьснаар архидалт, танхайрал, олиггүй бүхэн үүрлэдэг, тахилга хийж байна гээд нийлэг уут, архины шил, шээс, баас болгож баахан бохирдуулаад шилээ харуулдаг тухай сэтгүүлч, судлаачийн бичсэнийг уншиж байв. Тахилгын ёслолын дараа зочдын байрлаж байсан хотхон, овооны орчим, овоо тахилгад зориулан бэсрэг наадам цэнгэл үүсгэсэн талбайгаас ачааны машины 4–5 тэвш хог чөлөөтэй гардаг. Тэрийг хэрхэн зайлуулах хаана далд оруулах гээд бас ч бага биш гэхээр асуудал үүснэ. Шаварт унасан шарын эзэн гэгчээр тэнд үлдсэн нутгийхан л цэвэрлэдэг. Уул нь энэ төр ёсны тайлга тахилга гэдэг чинь хойч үеийнхний байгалиа хайрлан хамгаалах ухамсрыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм гэж боддог.

Гэвч өнөө үед уламжлалт зан үйлийг гажуудуулж буй асуудал их байна. Нэг жишээ хэлэхэд, бөө нар өнөөдөр уул, ус тахих нь их болжээ. Нэг талаасаа зөв боловч нөгөө талаасаа алдаа их харагдах боллоо. Өдрөөс өдөрт бөө нарын тоо толгой өссөөр байгаа нь бидний амьдралд мэдрэгдэх болж, тэдний талаар сайн бас саар мэдээлэл гарах болов. Улаанбаатар хотоос дөрвөн зүг найман зовхист аль руу нь ч гараад явсан чулуугаар босгосон овоо, хадаг уясан мод ихээр харагдана. Сонирхоод ажиглавал бөөгийн л тахилга цайллага өгдөг, өөрсдийх нь тус бүрийнх нь овоо байх юм. Бөө хүн бүр өөрсдийн гэсэн овоотой байх жишээтэй болж хувирлаа. Уул, ус баясгаж байгаа нь сайн хэрэг. Гэтэл яг үнэхээр баяс-

⁹ Сүхбаатар, О.: *Монголын тахилгат уул...*, т. 11.

гаж байна уу гэдэгт эргэлзэж байна. Энд уул, усны тахилгыг жинхэнэ утгаар нь хийх асуудалд анхаарах ёстой. Тахилга хийж байгаа нь энэ гээд л тэр уул, усны эргэн тойронд бөөн бохирдол, хог новшоор дүүрч, сэг зэм болж хувирах нь элбэг байна. Бүгд л шүүс тавьж, идээ засдаг, тэгээд баахан мод овоолж урц шиг болгож байгаад л шатаана. Тэрийгээ тойроод л бөөлнө. Тухайн нэг хайрханыг тахиx зан үйл нь ижил байж болох ч, бүх хайрханыг яг ижил тахиад байгаа нь зөв үү.

Гэтэл хайрхан бүр өөр өөр, савдаг бүр өөр өөр, эзэн бүр өөр өөр, эргэлтийн цэг нь өөр өөр, нүд нь хүртэл өөр өөр байдаг. Ийм байтал бүх хайрханд яг ижил тахилга хийх юм. Бөө хүн тухайн хайрханыг яаж тахиx, аль зүгээс очоод, аль талд нь идээ будаагаа тавих, ямар идээ унд тавих, эзэн нь юу байдаг гэх зэргийг сайн мэддэг байх ёстой. Онгодыг тухайн хайрханы хажууд буулгах уу? үгүй юу? Тухайн хайрханы эзэн нь хүн савдагтай бол улаачид буудаг эсэх, буудаг бол яаж өөрийгөө тоолгож өөр дээрээ буулгаж ундаалж цайлах, хайрханыг тахиж цайлсны учир үр дүнд нь тухайн хайрханы эзэнд хүч өгөх сэвийг нь гаргалцах, удмын тахилга, орхиж явсан савдагыг нь дуудах, тийрэн албин алмаст баригдсан бол зайлуулах, нутаг усны ой савыг нь сэргээх, тухайн бүсэд чатга эзэнтэй нь хавсаж тавих, ямар нэгэн удмын бариаг нь гаргах гэх мэтчилэн олон учир утга бий. Тиймээс дуртай улаач болгон хүссэн хайрхан дээрээ очоод тахилга хийж байгаа нь хэр зохистой вэ? Уламжлалыг гажуудуулсан энэ мэт олон зүйлийг засч залруулах нь чухал байна.

Дүгнэлт

Уул, усаа тахин шүтэх Монголчуудын зан үйл нь мухар сүсгийн зүйл биш, байгалийг танин мэдсэн тэдний их ухааны илрэл мөн. Уул, ус тахиx Монголчуудын уламжлалт зан үйл нь манай улсаас дэлхийн өвд хамаарах ач холбогдол бүхий соёлын биет бус өвийн нэг юм. Монголчуудын байгаль орчноо хайрлан хамгаалах нэг арга ухаан болох уул, ус тахиx зан үйлийг нарийвчлан судалж, энэ уламжлалт зан үйлийг орчин үед хэрхэн шинэчлэх асуудал анхаарал татаж байгаа болно. Учир нь хүмүүний амьдрал байгалиас ихээхэн хамааралтай билээ. Өнөө үед байгаль орчин доройтох болсон нэг шалтгаан бол Монголчуудын хувьд байгаль орчноо хайрлан хамгаалах уламжлалт зан үйл их алдагдсантай холбоотой.

Монголчууд эртнээс уул ус, байгаль дэлхийгээ тахин тайж ирсэн уламжлалтай. Энэхүү зан үйл нь уул, ус, байгаль дэлхийн эзэд (лус, савдаг, навдаг, шивдэг)-ийг хүндэтгэн дээдэлж, од, гараг эрхэсийн орчил хөдөлгөөний сайн тохиол буюу сайн өдөр, цагийг олж, нутгийн ард олон тухайн нутаг орондоо хамгийн ихээр хүндэтгэн дээдэлдэг уул, усандаа идээ, ундааныхаа дээжийг өргөн хүндэтгэл үзүүлж, сүсэглэн залбирч, мөргөл үйлдэх ёслол буюу Монголчуудын байгалийг дээдлэх соёлын цогц илэрхийлэл юм.

Уул, ус тахиx Монголчуудын уламжлалт зан үйл нь байгаль орчныг хамгаалах сэтгэлгээг хувь хүнд төлөвшүүлэх хүмүүжлийн өвөрмөц арга хэрэгсэл

болно. Уул, ус тахих зан үйл бол монгол үндэстний олон мянган жилийн уламжлалт зан заншил, хүн, байгаль амь нэгтэйг өнө эртнээс таньсан саруул ухааны илэрхийлэл билээ. Түүхийн явцад төр, шашны хос ёсны төгөлдөр утгат зан үйл, заншил уламжлал болж тогтжээ.

Өнөө цагт энэ нь хүн төрөлхтний тогтвортой хөгжлийн үндэс болсон ногоон хөгжлийн үзэл баримтлалтай нийцсэн, байгаль хамгааллын төдийгүй үндэстний оюун санаа, үзэл ухамсар, шашин соёл, төр ёсны өргөн дэлгэр агуулгатай болж буйгаараа ач холбогдолтой юм. Түүнчлэн уул, ус тахих Монголчуудын зан үйл нь өвөг дээдсийнхээ мэргэн ухааныг ойлгох, монгол ёс заншлаа мэдэх, төрөлх газар шороо, нутаг усаа хайрлан хамгаалах иргэдийн сэдэл, үйлдлийн эрч хүчийг хөглөн, байгаль орчноо хайрлан хүндэтгэх хамгаалах сэтгэл зүтгэлийг бадрах зэрэг олон талын ач тустай үйл болно.

Abstract

The Mongolian Custom of Veneration of Mountains and Rivers: Nature is the cradle of mankind and the source of human values. Currently, environmental protection and conservation have become the most vital issues in the world. The core of the issue is the proper concern to the mother Earth and the frugal use of natural resources. Rituals in honour of mountains and waters can be considered as the oldest traditional forms of environment conservation. It is commonly practiced among the Mongols for appropriate treatment and maintenance of nature. Bestowing and protecting natural environment are primarily practiced by the Mongols rather than using its resources. This old tradition includes the veneration of the deities living in mountains and waters, and forms a major cultural heritage of the Mongols. Though this cultural heritage and the conscious bestowing of nature encountered ideological oppression in the 20th century, nowadays they have been reawakened. This phenomenon proves the manifestation of the cultural tradition and heritage, according to which people love and respect their land – mountains and waters – the essential origin of their existence and life, as their mothers. The tradition of protecting their lands, favouring their beauty have its unique and amazing features. The paper describes the Mongolian tradition of veneration of mountains and waters, and also its revival as an important part of environmental protection.

Ном зүй

- Ган-Өлзий, Ч.: Нүүдэлчдийн философийн экорелятив шинж чанарын тухай асуудалд. *Эрдмийн ертөнц* сэтгүүл. Улаанбаатар 2011/2.
- Дарьхүү, Р. – Насанбат, Б.: Экологийн ёс зүй дэх биотөвт үзлийн онцлог. *Философи, шашин судлал сэтгүүл* 15 (391). Улаанбаатар 2013, т. 4–12.
- Дашжамц, Д. – Дарьхүү, Р. – Золзаяа, М.: *Монголын ёс зүйн сэтгэлгээний түүх*. Улаанбаатар 2009.

- Золзаяа, М.: *Экологийн ёс зүй – Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй*. Эмх. Д. Тунгалаг. Улаанбаатар 2012, т. 361–379.
- Монголын нууц товчоо*. Болор судар хэвлэлийн газар, Улаанбаатар 2015.
- Мөнхжавхлан, Б. – Дагзмаа, Б.: *Хүрээлэн буй орчны ёс зүйн зарим асуудал – Хэрэглээний ёс зүйн асуудлууд*. Улаанбаатар 2017.
- Сүхбаатар, О.: *Монголын тахилгат уул, усны судар оршвой*. Улаанбаатар 2001.
- Сүхбат, Ш.: *Монголын бөөгийн шашны уул, ус тахих уламжлалт зан үйл*. Улаанбаатар 2012.
- Тэмүүжин, Л. нар (эмх.): *Уламжлалт байгаль хамгаалах арга ухаанаас*. Улаанбаатар 2006.
- Уул овооны тэнгэрийг тайх төрийн ёслол үйлдэх тухай <http://www.newsmedia.mn/19976> (04.2017).
- Элбэгдоржийн зарлиг. <http://www.elbegdorj.mn/cgi-sys/suspendedpage.cgi?view=arhiv&id=11628> (04.2017).

БААТРАА ЯВАГЧ ТАХИЛЫН ХОТ МАНДЛЫН ОНЦЛОГ

Дарханхүү

Монгол Улсын Их Сургууль,
Философи, Шашин Судлалын Тэнхим, Улаанбаатар

“Баатраа явагч судар” (са. *Śūraṅgama sūtra*) нь Их хөлгөний, ялангуяа Чань Буддизмын нэгэн үндсэн гол сурвалж мөн бөгөөд Парамити (Polamiti)¹ хэмээх эртний Энэтхэгийн Буддын гүн ухаантан 705 онд одоогийн Гуанжу дахь (хят. 制止) Жи Жи (хят. 光孝寺) хэмээх сүмд анх удаа санскрит хэлнээс хятад хэлэнд хөрвүүлснээс хойш 1000 гаруй жилийн турш бясалган судалсаар ирсэн юм. Одоо миний бичих гэж байгаа асуудал бол нэгд, тус судрын 7-р бүлэгт өгүүлсэн цөвийн цагт Баатраа явагч тахилын хот мандал (са. *maṇḍala*, хят. 曼荼羅) хэрхэн байгуулах, тахилын мандал байгуулахын дэс дараалал ба тахилын мандлын тогтолцооны бэлгэдлийн тийн ухагчийн номын чанарын тухай, хоёрт, Ханжэүгийн (Хятадын Зэжиан мужийн төв) бурхны шашны чухал дурсгал “Баатраа явагч тахилын мандал”-ын археологийн судлалын тухай авч үзэх болно.

“Баатраа явагч судар”-ыг судалснаар бурхны шашны гүн ухаан, ялангуяа Их хөлгөний гүн ухаан, сэтгэл төдийтний ёс, тухайлан Чань буддизмын сэтгэл төдийтний судалгааг ойлгоход чухал хэрэгтэй. Тэрчлэн энэхүү судраар дамжуулан эртний энэтхэгийн Наландра хийдийн буддын сургалттай танилцахад хэрэгтэй юм. Тэрхүү буддын сургалтанд, Их хөлгөний гүн ухаан болон учир шалтгааны ухааны хөгжилтөд чухал үүрэг гүйцэтгэсэн “Баатраа явагч судар”-ын гол санаа нь сэтгэлийн мөн чанарыг тодруулах явдал мөн. Тиймээс бид энэ судраар дамжуулж сэтгэлийн тухай буддын гүн ухаан түүний мөн чанарыг ойлгох боломжтой болно. Тус бүлэгт хот мандал байгуулах дэс дараалал болон мандлын тогтолцооны бэлгэдлийн утгыг гаргасан байна.

Хот мандал байгуулах алхам, дараалал

1. Шагшаабадаа сахиж Баатраа явагч тарнийг урих нь.

Ялж төгс нөгчсөн бурхнаас Анандад “Номын эцсийн цаг”²-т номын мандалд суух хүмүүс байвал урьд вигчүгийн³ ариун сахил санваарыг сэтгэл хураамжлахыг⁴ асуусны тулд би эдүгээ урьд даяанд⁵ орших хичээнгүйгээр

¹ Эртний дундад энэтхэгийн үед амьдарч байсан гүн ухаантан нэрт орчуулагч. Амьдарч байсан хугацаа нь тодорхойгүй.

² Таван цөвийн цагийг хэлж байна.

³ Са. *bhikṣu*. Гэлэн сахилыг хэлж байна. Монголоор бас “аяга тэхимлэг” гэдэг.

⁴ Сэтгэлээ тогтоон барьж төвлөрүүлэх.

⁵ Са. *dhyāna*. Сэтгэлээ тогтоон барих.

судлах гайхамшигт үүднээс бодьсадвын⁶ явах гэвэл эрхгүй урьд энэ дөрвөн зүйлийн⁷ сахил санваарыг сахих хэрэгтэй. Иймийн тул сааргүй арвис сахил санваартныг сонгож, тэргүүн зэрэг шарманааг⁸ түүний багш болгон шүтэх хэрэгтэй. Шагшаабадыг бүтээсэн хойно ариун шинэ дээл өмсөж, хүж уугиулаад нам тайван сууж нэгэн үзүүрт сэтгэлээр бурхны номлосон арвис тарнийг⁹ 108 удаа урьж дуусгасны хойно орныг засаж номыг мандал байгуулж болно гэж номложээ.

2. Үнэрт шаврыг хөрсөнд сүрчих нь.

Цаст уулын их хүчит цагаан үхрийг эрэн энэ үхэр нь ууланд ургасан нарийн сайхан сайн үнэрт өвсийг идэж гагцхүү цаст уулын ариун усыг уух тул аргал маш нарийн. Түүний аргалыг авч занданд хольж газар сүрчинэ. Хэрвээ цаст уулын үхэр биш бол өмхий бузар тул газар сүрчиж болохгүй. Эсвэл сайн тэгш тал газрын хөрсийг эрж таван тухайн доорх шар шороог аваад зандан (хят. 梅檀), агар (хят. 沉水), сендлэ (хят. 苏合), дүрүшка (хят. 薰陆), гүргэм (хят. 郁金), цагаан гүгү (хят. 白胶), рорда (хят. 青木), банзан хүж өвс (хят. 零陵), үнэрт хүж өвс (хят. 甘松), тахиан хэлт хүж (хят. 鸡舌香) тэргүүтэн арван зүйлийн нарийн талхлаж, болгож шаварт хольж хот мандлын газарт сүрчинэ.

3. Тахилын мандлаа чимэглэх нь.

Эн (эгц) төгрөг диаметр нь нэг алд (арван тохой) зургаан тохой найман өнцөгтэй хот мандал бэлдэж мандлын дунд алт зэс буюу мөнгө модоор хийсэн лянхуа нэгийг тавина. Цэцгийн дотор бадар аягыг тавиад бадар аяганы дотор намрын дунд сарын шүүдрийн усыг хийгээд усны дотор зохисын үзэж олдохуйгаар навчтай цэцгийг хатгаж тавина. Бас найман төгрөг толийг аваад өөр өөрийн орныг бодож тавиад цэцэгтэй бадар аягыг гадуур тавина. Толины гадна 16 лянхуа цэцэг 16 гүйлсийн цэцгүүдийн завсар завсарт сайхан тэгшээр тавина. Гүйлэст¹⁰ гагцхүү агарыг шатааж галын дөлийг бадруулж болохгүй.

4. Тахил өргөх.

Цагаан үнээний сүүг 16 саванд хийгээд сүүг хурууд болгон хийж бас чихэрт тансаг боорцог, сүү, өрөм ба хоргүй сайхан үнэрт эм,¹¹ балт халуун өвсийг шар тос ба балын лянхуа цэцгийн гадуур 16 хувиар цэцгийн гадуур хүрээлж тавиад хамаг бурхан бодьсадва махасадва нарыг тахина. Үдийн цавын цаг, шөнө дөлийн цагт балыг хагас аягыг хийж шар тосыг гурван хувь бэлтгэж мандлын өмнө тусад нэгэн өчүүхэн гүйлс тавьж сайн үнэрт дүрбагаар¹² усыг буцалган угаал өргөж галыг ариун болгон шар тос балыг шатааж бурхан бодьсадва нарт тахил өргөнө.

⁶ Бодьсадвын зам мөрөөр явах.

⁷ Амь тонилох, эс өгснийг авах, буруу хурьцах, чалчаа ярих.

⁸ Дөрвөн үрийн нэг.

⁹ Төвд орчуулгад Цагаан шүхэртийн тарни гэж бичсэн байна.

¹⁰ Сангийн бойпор.

¹¹ Гаа хийсэн нэг зүйлийн цайн төрөл.

¹² Үет цагаан өвс.

5. Бурхны хөрөг шүтэх.

Дөрвөн талын гадна цөм банжид¹³ ба цэцгүүдийг өлгөж мандлын гэрийн дотрын дөрвөн зүгт арван зүгийн түүнчлэн ирсэн бурхан хамаг бодьсадвын хөрөг шүтээнийг зэрэгцүүлж тахина. Дунд Ровозана (хят. 卢舍那佛), Шигэмүни (хят. 卢舍那佛), Майдар (хят. 弥勒佛), Энгуби (хят. 阿閼佛), Авид бурхад (хят. 阿弥陀佛) ба их рид хувилгаант Хонсим бодьсадва (хят. 观世音菩萨) нарын хөрөг шүтээн тахиад бас Очир зүрхэн бодьсадва (хят. 金刚藏菩萨) зүүн баруун этгээдэд Хурмаст (хят. 帝释天主), Эсрүа (хят. 初禅天主), Үжүсэм (хят. 乌瑟摩), Нилэдэндэг (хят. 蓝地迦), Гүдэли (军荼利), Бирингүди (хят. 四大天王), Дөрвөн махранз (хят. 毗俱胝), Винаяака (хят. 频那夜伽)-ыг хаалганы хажуу зүүн баруун талд хос хосоор нь байрлуулна.

6. Шүтээн хөргийг харилцан харгалзуулах нь.

Найман толийг огторгуйн агаараас доош хандуулан өлгөж мандлын дотор тавьсан тольтой эсрэг тэсрэг гэрэл тохиолдож хөрөг шүтээнийг давхцаж ургуулна.

7. Анхны гурван долоон хоногийн даяанд оршихуй.

Анхан долоон өдрийн дотор чин үнэн сэтгэлээр арван зүгийн Түүнчлэн ирсэн бурхан, хамаг бодьсадва, архадын цолыг дуудаж мөргөн мөнхүү зургаан цагт тарнийг урьж хот мандлыг эргэцэж чин үнэн сэтгэлээр номыг хичээнэ. Цаг бүр тасралгүй нэжгээд 108 удаа урина. Дараагийн долоон өдрийн дотор нэгэн үзүүрт сэтгэлээр шамдаж бодьсадвын зорин ерөөх сэтгэл үүсгээд үргэлж тасралгүй болгоно. Зорин ерөөхийн суртахуун миний винайн дотор тодорхойлон гаргажээ. Гурав дахь долоон өдрийн дотор 12 цагт нэгэн үзүүрт сэтгэлээр Баатраа явагч тарнийг урин долоо дахь өдөр хүрээд арван зүгийн түүнчлэн ирсэн бурхан нэгэн цагт илт ажирч, толины гэрлүүд агаараа бурхдад тэргүүнийг элсний хойно даруй номын мандалд даяаныг судалснаар энэ мэт номын эцсийн цагийн хичээн үлдэх улсыг бие сэтгэл гэгээн тунгалаг болсон нь вайдурья адил болгож болно.

8. Зуун өдөрт тэнсэлгүй шидийг олох нь.

Хэрвээ энэ аяга тахимлигийн тахил авсан буяны садан багш ба бас хамт нэгэн чуулганд байх олон аяга тахимлигийн дотор нэгэн гэгээн тунгалаг биш бол энэ зэрэг номын мандал олонх бүтэхгүй. Гурван долоон өдрийн хойно төв шударга сэмээр даяанд суусны хойно хурц язгууртан (хят. 利根之人) болбол сууринаас хагацалгүйгээр суртвадын шид (须陀洹果)-ийг олж болно. Мөнхүү түүний дээр үгүй шидийг олох болно.

¹³ Төвд нэр нь банжид гэдэг. Гурван төрлийн амьтан дүрсээр чимээгүй өлгөмөл цэцгийг банжид хэмээнэ. Гурван зүйлийн амьтны дүрсээр чимснийг дуаз гэнэ. Гурван төрлийн амьтан гэдэг нь эс зохилдох амьтан зохиолдож бүрэлдсэн арслан гарьд хоёр, халиу загас хоёр, матар лавай хоёр зохилдон бүрдсэн өлзийт амьтны зургийг хэлнэ.

“Баатраа явагч судар” дахь хот мандлын тогтолцооны бэлгэдэл

“Баатраа явагч судар” дахь хот мандлын бүтэц тогтолцоо нь тун нарийн бөгөөд энэ нь бурхадын орон дахь тахил өргөл ба хөрөг шүтээн гэсэн хэсгээс бүрдэнэ.

1. “Баатраа явагч судар” дахь хот мандлын байрлалын тийн ухагчийн номын чанар нь.

Цаст уул түүнчлэн ирсний үнэн бодит цогцсын бэлгэдэл. Хүчит цагаан үхэр нь мөн чанарын тийн ариун ердийн төв бэлгэ билгийн бэлгэдэл. Үнэрт өвсийг идэх нь бодь сэтгэлийн ариусгал номын биеийг шагшаавадын хүжээр одон бүтээхийн бэлгэдэл. Ариун усыг уух нь бодь сэтгэлийн ариусгал номын мөн чанарыг тэгш агуулахын бэлгэдэл. Аргал маш нарийн нь бодь сэтгэлийн ариусгал бэлгэ төрөхийн бэлгэдэл. Аргалыг авч занданд холих нь гурван цувралгүй номыг баримтлахын бэлгэдэл. Хэрвээ цаст уулын үхэр биш тул өмхий бузар тул газар сүрчиж болохгүй нь дөрвөн тогтсон тааллыг шүтэн барихын бэлгэдэл. Таван тохойн доорх шар шороог авах нь таван цогцсын шүтэн барилдлагын зангиасыг тайлах бясалгалаар гол болгохын бэлгэдэл. Арван зүйлээ нарийн талхлан шаварт холих нь арван барамидийг шүтэн бясалгахын бэлгэдэл.

2. Хот мандлын чимгийн тийн ухагчийн номын чанар нь.

Энэ нэгэн алд зургаан тохой нь хутагтын найман гишүүнт мөрийн бэлгэдэл. Мандлын төв нь төв үзлийн үнэмлэхүйн үнэний бэлгэдэл. Хийсэн лянхуа нь үнэмлэхүйн үнэн шүтэн барилдлагыг даган дөрвөн хутагт тийн арилсан ном бүтэхийн бэлгэдэл. Цэцгийн дотор бадар аягыг тавих нь хамаг шалтгаан үрийн ялгавар нь түүнчлэн ирсэн зүрхэнд агуулахын бэлгэдэл. Намрын дунд сарын шүүдрийн ус нь түүнчлэн ирсэн зүрхэн шүтэж төв үзлийн дээд самадийг бясалгахын бэлгэдэл. Навчтай цэцэг нь дээд самеди шүтвэл маш дээд билиг төрөхүйн бэлгэдэл. Найман төгрөг толийг авах нь хамаг амьтан зургаан зүйл тийн мэдэхүйн найман чуулган эргэлтээс дөрвийг айлдагч бүтэхийн бэлгэдэл. Цэцэгтэй бадар аягыг гадуур тавих нь билиг оюунд шүтэж ялгуусан цэцэг дэлгэрэхийн бэлгэдэл. Арван зургаан лянхуа цэцэг, арван зургаан гүйлс нь өөрийн үйлдэхүйгээр бусдыг номхотгох хутагтын найман гишүүнт мөрийн бэлгэдэл. Галын дөлийг бадруулж болохгүй нь тийн ухагч билиг үгүй дээд самадийн үйлдэхийн бэлгэдэл.

3. Хот мандлын тахил өргөлийн тийн ухагчийн номын чанар нь.

Тус тус арван зургаан нь хамаг номууд өвөрмөц онцлогтой, тэр бол хутагтын найман гишүүнт мөрийн бэлгэдэл. Бурхан бодьсадыг тахих нь самадигаас илт баясахуй үүсэхийн бэлгэдэл. Шөнө дөлийн цаг нь төв үзлийн мөрийг бясалгахын бэлгэдэл. Балыг хагас аяга нь төв үзлийн тэгш агуулах сэтгэл нь таван нисваанисыг шингэхийн бэлгэдэл. Шар тосыг гурван хувь нь хуран үүдсэн бүхэн мөнх бус, ном бүхэн (би) үгүй, цуварсан бүхэн зовлонтой гэдгийг баримтлан гэтлэхийн бэлгэдэл. Туст нэгэн өчүүхэн гүйлс тавих нь сонсохын үүднээс гүнээ орохуйн бэлгэдэл. Сайн үнэрт дүрба (үетийн цагаан өвс)-гаар усыг буцалгах нь шагшаабадаас самеди, самадигаас бэлгэ нээгдэхүйн бэлгэдэл. Угаал өргөж галын арвин болгон нь няцах сонсохуй, орохуй, түгээхүй, харилцан

учралдан дулдуйдахуйн бэлгэдэл. Шар тос, балыг шатааж нь сонсохуйг өгүүлэн зургаан зангиасыг тайлахын бэлгэдэл. Бурхан бодьсадва нарт тахил өргөх нь гаслангаас нөгчсөн илт болохуй хоёр зүйлийн маш ялгуусаныг хүртэхүйн бэлгэдэл. Үнээний сүү найман зүйл нь хутагтын найман мөчит мөрийн бэлгэдэл.

4. Хот мандлын шүтээн хөргийн тийн ухагчийн номын чанар нь.

Хот мандлын дөрвөн хана нь нэг номын язгуурт дөрвөн түүнчлэн чанарын орон агуулахын бэлгэдэл. Түүнчлэн ирсэн бурхан хамаг бодьсадвын хөрөг шүтээн нь далай мэт явдлыг үзүүлсэн бодь сэтгэл олохуйн бэлгэдэл. Ровазана, Шагжамүни нар нь мөн чанар, төгөлдөр судар тарнийг огоот төгс онохын бэлгэдэл. Хурмаст Эсруа бол нууц хөлгөний ном тэрсүүтийг даран үйлдэхийн илт нөлөөний бэлгэдэл. Найман толийг огторгуйн агаараас доош хандуулан өлгөх нь орохуйн найман мандал эх бэлгийг тольдон төгөлдөржихийн бэлгэдэл. Мандлын дотор тавьсан тольтой эсрэг тэсрэг гэрэл тохиолдох нь сэтгэлийн төрөн түрдэхүй харилцан учралдан дулдуйдахуйн бэлгэдэл. Хөрөг шүтээнийг давхцаж ургуулах нь нэгэн цогц номын язгуур төгс туулахын бэлгэдэл. Буддын номлолд хүний амьдралд зовлон мөн гэж зааж гаргасны хамт зовлонгоос гэтэлгэх арга замыг бас өгүүлсэн байдаг энэ нь “Хутагтын найман гишүүнт мөр” болон түүнийг хураагуйлсан “Гурван суртгаал” буюу шагшаабад, самади, билигт төвлөрөн тусгагдаж байдаг.

Баатраа явагч тахил хот мандал – Археологийн чухал дурсгалт зүйл нь

БНХАУ-ын “Ханжэу хотын Дапүсэ хийдийн соёлын дурсгалт өвийн судалгаа” төслийн судалгааны явцад Дапүсэ хийдийн дотор эртнээс үлдсэн “Найман өнцөгт зураг хээ бүхий тахилын мандлын суурь” байсныг олж илрүүлсэн. Судалгаагаар тухайн тахилын мандал нь Хятадад одоогоор хадгалагдан үлдсэн цорын ганц Сүн гүрний үеийн¹⁴ тахилын мандлын дүрс болон зааг шугамыг гүйцэд хадгалсан эртний Баатраа явагч тахилын мандлын үлдэгдэл болох нь батлагдсан. Хэлбэр болон бүтцийн хувьд Баатраа явагч тахилын хот мандалд заасан хуучин ёс дүрэмтэй нийцэж, Баатраа явагч тахилын хот мандлын эхэн үеийн дүр дүрслэлийг хадгалж, эрт үеийн Баатраа явагч тахилын хот мандлын бодит зүйл болон тэмдэглэсний талаар хоосон орон зайг нөхөж чадсан. Тухайн археологийн олдворыг олж илрүүлсэн засвар хийхээр төлөвлөж байгаа Ханжэу хотын Дапүсэ хийдийн байршлыг тодорхойлох болон төлөвлөх, Шихү нуур нь (дэлхийн өвийн жагсаалт)-д орох агуулгыг баяжуулах гэдэг онцгой ач холбогдолтой.

1. Ханжэу хотын Дапүсэ хийдийн хэрмийг илрүүлсэн нь

Ханжэу хотын Бошэсан уулын өмнө бэлд байрлах чулуун бурхан уулын Дапүсэ хийдийн суурь дотор өнө эртнээс уламжилж үлдсэн “Найман өнцөгт зургийн хээтэй хот мандлын суурь” нь зураг дүрсийн хувьд арга билгийн зураг-

¹⁴ Хятадын түүхэн дэх таван гүрнээс Юань улс хүртэл, 960–1279 хооронд эзэрхэж байжээ.

тай төстэй байж, орон нутгийн оршин суугчид арга билгийн зураг гэж нэрлэдэг. Дапүсэ хийдийн дотор оршин сууж байсан Вин овогт настантай хуучлахаар XX зууны 50-иад оны сүүлчээр тус найман өнцөгт хот мандлын суурин дээр байшинтай байж 2008 оны 5 дугаар сард оршин суугч нь нүүж явсны дараа дээр нь баригдсан байшинг нурааснаас хойш тус найман өгцөгт тахилын мандлын суурь нь хүмүүст танигдаж болсон. Хятадын 1970-иад оны үеийн эртний соёлын өвийг устгаж соёлын хувьсгал буюу 1965 оны 5 дугаар сараас 1976 оны 10 дугаар сарын хооронд явагдсан Хятадын улс төрийн хөдөлгөөний талхагдлаас азаар үлдэж, мөн дээд талд нь байшин барих үед ямар нэгэн гэмтэл учруулаагүйгээс өнөөдрийн найман өнцөгт хот мандлын суурь нь харьцангуй бүрэн бүтэн зураг дүрстэй хадгалагдан үлджээ.

Эртний Дапүсэ хийд нь Шихү нуурын эрэг дээр байрлаж чулуун бурхан уулын урьд бэлд цогцлогдон байгуулагдсан давхарласан бүтэцтэй. Урд шатаар дээш өгсөхөд харагдах үзэмж нь гойд сайхан байна. Уулын оргил хэсэгт байрлах барилга байгууламж нь хуучин Майдар бурхны хашааны үлдэгдэл зүүн талд том чулуун бурхны хашаатай. Хойд Сүн улсын сүүлчийн үед урласан том чулуун бурхны хөшөөнөөс зөвхөн гол хэсгийн хадан чулуу нь үлдсэн. Тухайн хоёр байгууламж нь бүгд Дапүсэ хийдийн үлдэгдэл мөн. Майдар бурхны хашааны хамгийн хойд хэсэгт хойноос урагшаа харсан том дугантай байж XX зууны 50-иад оны үед эвдэрчээ. Хуучин том дуганы тавцангийн өмнөх чулуун шатны доор хэсэгт хоосон орон зайтай байж тухайн хоосон талбайн урагш хойш 8.7 м, зүүн баруун тийш 9.15 м байж найман өнцөгт хот мандлын суурь нь хоосон талбайгаас баруун урагш чиглэлд байрлана. Найман өнцөгт тахилын мандлын суурь нь найман талтай зургийн гол хэсэгт дугуй цагирагтай байж найман талтай тойрсон цагиргаар хүрээлэгдэж найман хэсэг дэвүүр хэлбэртэй дүрс бүрэлдсэн. Найман өнцөгт хот мандлын суурийн хамгийн том диаметр ташуу өнцөг хоорондын зай нь 215 см хамгийн бага диаметр нь 209 см найман өнцөгт хоорондын дугуй цагиргийн диаметр нь 76 см дугуй цагиргийн гадна холболтын найман ширхэг дэвүүр хэлбэртэй зураг дүрсийн жижиг нь 28 см, том нь 76 см, хажуу урт нь 72 см байна. Зураг дүрсийн хувьд арга билгийн зурагтай төстэй байж гэвч арга билгийн зураг байхгүй мөн ямар нэгэн тайлбар байхгүй. Дугуй цагиргийн ирмэгийг дагуулж, тоосгоор дэвүүр маягийн дүрс үүсгэн шаллаж, дугуй цагиргийн голын хэсэг нь бага зэрэг хотойлттой дугуй хэлбэртэй байна. Тоосгоны хэмжээ нь голдуу гурван төрөл. Зөвхөн нуруу талын хэмжээг хэмжих боломжтой байж 4x24 см, 3.5x22 см-ын хоёр төрлийн тоосгоор голлож зургийн гол шугамыг бүрэлдүүлнэ. 2.5x12 см-ын нимгэн жижиг тоосгоор шугамын дотор талын хоосон орон зайг бөглөсөн. Мөн харьцангуй зузаан тоосго болон хэлтэрхий чулуугаар шугамын дотор талын хоосон орон зайг бөглөжээ.

Найман өнцөгт хот мандлын суурьтай нийлж байгаа зүүн талын гадаргууг цементэлж, баруун талын хэсэг нь хүнсний ногооны талбай болон хаягдлаар дүүрч хуучин хэлбэр нь алдагдаж ямар хэв шинжтэйг нь ажиглах боломжгүй болжээ. Гэвч урд хойд хоёр захын шалнаас тодорхой олж харагдах нь тоосго дэвсэж, найман өнцөгт хот мандлын суурь нь бага зэргийн товойлттой харагдана. Найман өнцөгт хот мандлын суурийн ташуу өнцгийн хүрээнд хоёр ширхэг

нь урагш хойш болон зүүн баруун чиглэлтэй байна. Урагш хойш чиглэлийн хоёр үзүүрийн гадна талд шулуун шугам үүсгэсэн тоосгон шал байж тоосгоны үзүүр хэсэг нь Т хэлбэр үүсгэсэн хөндлөн тоосгон шал байна. Хоёр үзүүрийн тоосгоны шугамын урт нь тус бүр 140 см байна. Голын хэсэгт жигд өрсөн тоосгыг шугам доторх орон зайд байна. Үүнээс төсөөлөхөд найман өнцөгт тахилын мандлын суурийн гадна хүрээний намхан тоосгон шалны зураг дүрс нь тэгш дөрвөлжин хэлбэр үүсгэсэн магадлалтай. Найман өнцөгт хот мандлын суурийг одоо харахад 工 хэлбэрийн тоосгон шалтай дүрс бүхий талбайн гол хэсэгт бага зэрэг үрэгдэж магадгүй хуучин 田 үсгийн хэлбэртэй байсан байх магадлалтай. Хоёр үзүүрийн тоосгон шугамын урт нь тус бүр 140 см байж дээр нь гол хэсгийн найман өнцөгт хот мандлын суурийн диаметр нь 215 см-г нэмэхэд тухайн зураг дүрсийн урагш хойш чиглэлийн урт нь 495 см байж ойролцоогоор бараг 5 м байна. Гадна хүрээний тоосго нь найман өнцөгт хот мандлын суурийг шахаж мөн хоёр тоосгоны хэмжээ чанар нь төстэй болохоор нэг цаг хугацаанд хийж гүйцэтгэсэн байх гэж таамаглаж болно. Эл гарсан хэсгийн тоосгон шалнаас харахад тоосго нь ямар нэгэн чимэглэл үсэг байхгүй хавтгай тоосго бөгөөд нягтаршил өндөртэй боловч он жилийн нүдэн баримжаагаар төсөөлөж болохгүй.

2. Найман өнцөгт хот мандлын суурь нь Баатраа явагч тахилын хот мандалтай холбоотой байх талын судалгаа.

Найман өнцөгт хот мандлын суурь нь бурхны шашны зан үйлийн тахилын хот мандлын онцлогийг хадгалсан найман өнцөгт хот мандлын суурь нь нийт талбайд ил тод харагдах зүйл эсвэл тухайн талбайн төв хэсэгт байж нэг төрлийн чухал ач холбогдолтой барилга болох нь илт харагдана. Мөн тус барилга нь Дапүсэ хийдийн үлдэгдэл соёлын дурсгал байж шашны өнгө аястай харагдаж байна. Түүхэн тэмдэглэлийг үндэслэхэд тухайн талбай нь таван гүрний¹⁵ үед холбоотой бурхны шашны сүм хийдийн газар түүх хөгжлийн хувьд маш тодорхой байж ерөөс тасалдаж байгаагүй. Анхан шатны таамаглалаар бурхны шашны сүм хийд дэх бурхны шашны зан үйлийн тахилын мандлын байгууламж гэж үзэж болно. Мөн тухайн хэлбэр дүрсийн онцлогоос найман өнцөгт хот мандлын суурь мөн болохыг баталж байна.

Найман өнцөгт хот мандлын суурь Баатраа явагч тахилын хот мандлын стандарт хэмжээтэй нийцэж байна. Бурхны шашны стандарт тахилын мандалаас харахад Баатраа явагч тахилын хот мандал нь “Баатраа явагч судар”-т тогтолцоо ба хэлбэр заасан тахилын хот мандлын дүрэмтэй нийцэж байх ёстой. “Баатраа явагч судар” нь Тан улсын үед орчуулсан “Түүнчлэн ирэгсдийн нууцыг бүтээхүй утга, илт олохуйн шалтгаан хамаг бодьсатва нарын далай мэт явдал үзүүлсэн бурхны үсний Баатраа явагч их хөлгөн судар” Чань буддизмын хамгийн чухал гол сурвалжийн нэг болно. Тус судрын 7-р бүлэгт Ялж төгс нөгчсөнөөс Анандад номлосон Баатраа явагч тахилын хот мандлыг аргаас иш татвал Баатраа явагч тахилын хот мандлын стандарт нь дугуй хэлбэртэй, найман өнцөгт хот мандлын суурьт тооцогдоно. Найман өнцөгт хот мандлын суурь

¹⁵ Хятадын түүхэн дэх 907–960-ийн хоорондох цаг үе.

нь Баатраа явагч тахилын хот мандлын гол онцлог болон таних тэмдэг болохыг илэрхийлсэн байна. Баатраа явагч тахилын хот мандал нь найман өнцөгт хэлбэртэйгээр “Баатраа явагч судар”-ын үзэл санаа болон онцгой утгыг илэрхийлж дахин бас холбогдол бүхий буддын зан үйл илтгэжээ.

Хойд Сүн гүрний үе дэх нэрт Хуушан (хят. 戒环, амьдарч байсан хугацаа тодорхойгүй) бээр “Тахилын мандал гаслангаас нөгчсөн үнэхээр өгүүлсэн бодгаль мөн. Хутагтын найман гишүүнт мөрөөр бүхэл цогц илтгэнэ” гэж тайлбарласан байдаг. Хутагтын найман гишүүнт мөр бол хутагтын дөрвөн үнэний сургаал доторх мөрийн үнэний агуулга болно. Нисваанисыг түртгэх найман зүйлийн зөв арга гэсэн утгатай. Бодитойгоор хэлбэл үнэн онол (эрмэлзэл), үнэн үг, үнэн үйлс, үнэн амьдрал, үнэн хичээл (чармайлт), үнэн дуртгал, үнэн самади (бясалгал) зэрэг болно. Энэ хэдийгээр Баатраа явагч зөвхөн Баатраа явагч тахилын хот мандлын найман өнцгийн хэлбэрт хийсэн тайлбар боловч бурхны шашны хутагтын найман гишүүнт мөрийн утга санаа агуулсан байдаг. Тахилын мандлын найман өнцөгтөд тулгуурласан болохоор найман өнцөгт хот мандлын суудлын суурь нь Баатраа явагч төрлийн тахилын хот мандлын бусад төрлийн тахилын мандлаас ялгарах мандлын хамгийн том онцлог мөн.

3. Ханжэу хотын түүхэн дэх эртний баатраа явагч хийд

Өмнөд Сүн гүрний¹⁶ “Сианчүнлэнанвэ”(хят. 咸淳临安志)-ын хэвлэлд өмнөд Сүн улсын эртний “Шихү нуур”-ын газрын зургийн тэмдэглэлээс шинжвэл том чулуун бурхны хойд хэсгийн баруун талд Баатраа явагч хийд байрлаж өмнөд гүрэн улсын үйс хадгалагдан үлдсэн бусад Шихү нуурын газрын зургаас харахад бүгд ижилхэн байрлал дээр Баатраа явагч хийдийн байрлалыг тэмдэглэж өнөөдрийн том чулуун бурхны үлдэгдлийн хажууд байгаа Майдар бурхны хашаан дахь найман өнцөгт тахилын мандлын суурийн байршилтай давхцаж байна.

Орчин үеийн илрүүлснээр өмнө сүн гүрний бар зураг (хят. 西湖繁盛全景图)¹⁷-аас батлагдах нь том чулуун бурхан болон баруун талын хойд хэсэгт байрлах Баатраа явагч хийдийн байршлыг нарийн тодорхой зураглаж гаргасан байна. Өнөөдрийн найман өнцөгт тахилын мандлын суурийн байршил нь Сүн гүрний үед Баатраа явагч хийдийн хүрээнд байрлаж байгаа нь батлагдсан. Археологийн судалгаагаар “Баатраа явагч судар”-ын 7-р бүлэгт байгаа тахилын хот мандлыг байгуулах тогтолцоотой нийцсэн найман өнцөгт тахилын хот мандлын суурийг олж илрүүлсэн нь бодит үнэн болон судрын тэмдэглэлтэй нийцэж байгааг харгуулж мөн Баатраа явагч тахилын мандлын үлдэгдэл зүйлийн нэг болохыг баталж байна. Найман өнцөгт тахилын хот мандлын суурь нь Баатраа явагч тахилын хот мандал мөн гэсэн дүгнэлт гаргах түүхэн баримт болсон. Тухайн газарт Баатраа явагч хийд нь өмнөд Сүн гүрний эртний Шихү нуурын зураг (хят. 西湖图) дээрх бүтэн нэр нь Шисан Жиан Лоу Лэнг Ян Си (хят. 十三间楼楞严寺) харин өмнөд Сүн гүрнээс хойш түүхэн ном сударт

¹⁶ Хятадын түүхэн дэх хойд сүн гүрэн мөхсөний дараа Жоу геүгийн байгуулсан гүрэн. 1127–1279 хооронд эзэрхэж байжээ.

¹⁷ Арван зургаан метр урт Сүн гүрний үеийн Шихү нуурын зураг.

Шисан Жиан Лоу (хят. 十三间楼) гэж нэрлэдэг. Сүн гүрний нэрийг 1065 онд Шиан Яан Юан (相严院) болгон солив.

4. Баатраа явагч тахилын хот мандалын Сүн гүрний үед байгуулагдсан судалгаа.

Найман өнцөгт хот мандлын суурь нь Баатраа явагч тахилын хот мандлын харьцангуй эхэн үеийн хэлбэр мөн. Археологийн судлалын ангиллын аргачлалаар Баатраа явагч тахилын хот мандлын загварын төрлөөр тухайн Баатраа явагч тахилын хот мандлын он цагийн тодорхойлно. Юань гүрний үеийн нэрт хушаан (хят. 惟则大师)¹⁸ өөрийн (хят. 楞严经圆通疏) гэх бүтээлдээ тайлбар хийсэн нь: Чаншуй (хят. 长水)-ын хэлэхээр “Мандлын хувьд заавал хөрсийг цэвэрлэсэн байх хэрэгтэй” Ву Сингийн хэлээр (吴兴) “Мандал босгоход эхлээд хөрсийг цэвэрлэж дараа нь шар шороог малтан арван зүйлийн эмт ургамлыг нарийн талх болгож шаварт хольж сүрчин хот мандлыг байгуулна.” Ву Сингийн хэлэхээр хөрсийг овоолж мандлыг байгуулна.

Харин Венлингийн хувьд тухайн маргаанд оролцохгүйгээр Баатраа явагч тахилын хот мандлын найман өнцөг болон эн (эгц) төгрөг диаметр нь нэг алд (арван тохой) зургаан тохой хэмжээг тодотгосон байна. Эдгээр нь хойд Сүн гүрний үеийн эрдэмтэн нэрт хушаан нарын Баатраа явагч тахилын хот мандлыг байгуулах арга болон мандлын хэлбэр тогтолцооны талаар өөр өөр үзэл бодолтой байсныг илэрхийлж байна. Тухайн маргааны талаар орчин үеийн бурхны шашны нийгэмлэгийн анхны тэргүүлэгч Юанен хушаан (хят. 圆瑛大师)¹⁹ тайлбарлахдаа: “Эрт хөрсийг битүүлсэн нөхцөлт мандлыг байгуулж хөрсийг цэвэрлэнэ гэдэг нь орчин тойрныг цэвэрлэх”-ийг ярьж байна. Хөрс битүүлнэ гэдэг нь хөрс овоолохыг ярьж байна. Юанен хушаангийн үзэхээр Чяншугийн хэлсэн хөрс цэвэрлэх гэдэг нь тухайн талбайг цэвэрлэсэнээр мандал болгон ашиглаж болно. Энэхүү хэв маяг нь хамгийн анхны Баатраа явагч тахилын хот мандлын хэлбэр мөн. Хөгжлийн нэг шинж тэмдэг нь Эүсэнгийн заавал хөрсийг овоолох мандлын хэлбэр мөн. Шар шороо болон арван зүйлийн эмт ургамлыг хольж талбай дээр сүрчин найман өнцөгт хот мандлын суурийг бэлтгэнэ. Энэ бол анхны Баатраа явагч тахилын хот мандлын загвар болно.

5. Бусад хоёр Баатраа явагч тахилын хот мандлын хэв загвар.

Дээрх хоёр төрлийн Баатраа явагч тахилын хот мандлын хэв загвараас гадна Мин гүрний үеийн Гоу мин се (хят. 高明寺) хийдийн байгуулсан Баатраа явагч тахилын хот мандлын хэв загвар болон Манжийн үеийн Бээжин хотын Тан же се (хят. 潭柘寺) хийдийн Баатраа явагч тахилын хот мандлын хэв загварыг олж илрүүлсэн байна. Мин гүрний Гоу мин се (хят. 高明寺) хийдийн Баатраа явагч тахилын хот мандлыг нэрт хушаан Чуан ден Дэ ше (хят. 传灯大师) 1615 онд байгуулжээ. Бээжин дэх 1700 гаруй жилийн түүхтэй Тан же се (хят. 潭柘寺) хийдийн Баатраа явагч хот мандал нь Найралт төв (хят. 雍正, 1677–1735)-ийн гурван он эхэлж байгуулав. Урт удаан жил сэлбэж зассангүйгээс болж хууч-

¹⁸ Юань гүрний үе, 1280–1350 хооронд амьдарч байсан нэрт хушаан. Хят. 师妹别天如集, 录高僧摘要 зэрэг алдарт бүтээлтэй.

¹⁹ Хятадын орчин үеийн бурхны шашны нийгэмлэгийн тэргүүлэгч нэрт хушаан. 1878–1953 хооронд амьдарч байжээ.

ран эвдэрч 1971 онд албадлагаар нуран ганц хуучин суурь л үлдсэн байдаг. 2013 оны 5 дугаар сард олон байгууллагын тусламжаар дахин хуучин суурин дээр нь сэргээн барьсан байдаг. Энэ тахилын хот мандал нь давхар саравчтай задгай хэлбэрийн модон бүтэцтэй найман талтай тойрог дуган модон материалын бүтэцтэй барилга болно. Энэ барилгын хэлбэр нь маш өвөрмөц онцлогтой түүний доор талд найман өнцөгт цагаан гантгич чулуун суурин дээр байрласан байдаг. Гадуур нь цагаан гантгийн чулуун хашлагаар хүрээлэн диаметр нь 47 тохой яндрын суурин дээр нь найман талт том дуган дөрвөн талт тус бүр хаалгатай бусад дөрвөн талаар цэцгийн салбартай модон цонхтой, хот мандлын өндөр нь 49 тохой дуган нь дээврийн диаметр нь 47 тохой болно. Гол хаалган дээр нь Манжийн хаан Энх Амгалан (1711–1799)-гийн гарын бичээстэй пайз өлгөж байдаг. Эртнээс Хятадын бурхны шашинд зөвхөн гурван эртний Баатраа явагч тахилын хот мандал байгаа гэсэн уламжлалтай байдаг. Одоо энэ уламжлал нь археологийн судалгаагаар батлагдсан байна.

Дүгнэлт

Баатраа явагч тахилын хот мандал нь бурхны шашны бясалгал болон уламжлалын хувьд чухал ач холбогдолтой. Баатраа явагч тахилын хот мандлыг олж илрүүлсэн нь бурхны шашны дурсгалын хувьд маш ховор олдвор төдийгүй сонгодог бясалгалын онцлогтой болохыг илэрхийлж байгаа юм. Ханжэу хотын чухал дурсгалт зүйл Баатраа явагч тахилын хот мандлын тухай судалгаа нь эдүгээгийн бурхны шашны судлалд чухал хувь нэмэр болох учиртай. Баатраа явагч тахилын хот мандлын эх үүсвэрийг хайх хэрэгтэй байгаа бөгөөд энэ нь бурхны бясалгалын түүхийн судлалд ач холбогдлоо өгөх нь дамжиггүй. Түүхэн олдвороос энгийн хэлбэрийн мандал байгуулах хэв загвар болон аргачлалыг танилцуулж, жижиг сүм хийд болон багахан ёслолын талбайд ч гэсэн хялбар-аар үйлдэх боломжтой болох нь харагдаж байна. Лянхуа цэцгийн өргөлийн таваг нь бурхны шашны онцлогийг илтгэж, шүүдрийн дусал цуглуулах зэрэг зан үйл нь олон сүсэгтний оролцоог нэмэгдүүлж, ёслолын чиг хандлагатай болоход нөлөөлөх ба мандлын бодитой номын чанар болон тахил үйлдэхийн үүргийн талаар шинэ мэлдээлэл өгч, тэгш талбай дээр тодорхой хэмжээтэй найман өнцөгт зураг дүрстэй, тодорхой харьцаагаар багасгасан тахилын ширээ хийж зан үйл үйлдэх боломжтойг нээж өгч байна.

Ном зүй

Дарханхүү: *Баатраа явагч их хөлгөн судар*. Удам соёл хэвлэлийн газар, Улаанбаатар 2015.

Ĵamiyantübden – Ĵoriytu: *Merged yarqu-yin oron*. Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, Begejing 2002.

- Ўоригу: *Kitad töbed mongyol qariçayuluγsan burqan šasin-u toli*. Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, Begejing 2003.
- Qü šiübei pen – Ĵamiyanqaimčig – Elbegasang: *Töbed mongyol kitad qabsurayan burqan šasin-u qandun toli*. Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, Begejing 2000.
- Küčigen: *Budda-yin šasin kiged Budda-yin gün uqayan*. Öbör mongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a, Kökeqota 2010.
- “南怀瑾南怀瑾选集第八卷” 复旦大学出版社2003年7月。 *Nan huai jin <nan huai jin xuan ji> fu dan da xue chu ban she, 2003 nian* [Нан хуай жин: Нан хуай жиний сонгомол зохиол наймдугаар боть.] Fudan University 2003.
- 释见明 “图解楞严经” 百花洲文艺出版社2009年4月。 *Shi jian ming <tu jie leng yan jing>* [Ши жиэн мин, Баатраа явагч судрын зурагт тайлбар]. Bai hua zhou wen yi chu ban she, 2009.
- 圆瑛法师 “楞严经讲义” 华东师范大学出版社数据核字2014 第022488号。 *Yuan ying fa shi <leng yan jing jiang yi >* [Юүэн еин па ши: Баатраа явагч судрын тайлал]. Hua dong shi fan da xue chu ban she, 2014 niandi 022488 hao.

МОНГОЛЧУУДЫН ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛ ДЭХ ГАЗАР СОНГОХ ТУХАЙД

Энхбаярын Жигмэддорж – Гаравсүрэнгийн Идэрмаа
Монгол Улсын Их Сургууль, Түүхийн Тэнхим, Улаанбаатар

Оршил

Монголчуудын өдөр тутмын амьдрал ахуй, соёл, уламжлалд газрыг шинжин сонгож аливаа зан үйлийг үйлдэх явдал чухал нөлөөтэй байсаар байна. Үүний нэг нь талийгаачийг нутаглуулах газрыг сонгох явдал билээ. Монголын түүхийн сурвалж бичиг болон аман мэдээнээс үзвэл газар сонгох ёсыг “газар үзэх,” “газар шинжих,” “газар гуйх” гэх мэтээр нэрлэж, бичиж иржээ.¹

Өнөө үед Монголчуудын оршуулгын зан үйл дэх газар сонгох уламжлал ба Улаанбаатар хот зэрэг хүн ам төвлөрсөн томоохон суурин дахь газрын асуудлыг хэрхэн зүй зохистойгоор шийдвэрлэх вэ? гэдэг асуудал судлаачдын анхаарлыг татаж байна. Энэ илтгэлд Монголчуудын оршуулгын зан үйл дэх газар сонгож ирсэн уламжлал, Улаанбаатар хот дахь оршуулгын газруудын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар бага боловч өгүүлэхийг зорив. Газар сонгож ирсэн уламжлалын тухайд “Монголын археологийн хээрийн шинжилгээний тайлан,” “Монголын археологийн өв” болон энэ чиглэлээр гарсан бусад ном, бүтээлийг ашигласан бөгөөд өнөө үеийн оршуулгын газруудын хувьд “Улаанбаатар Буян” ХХК-иас хийсэн зарим судалгааны үр дүнг тусгасан болно.

Монголчуудын оршуулгын газрыг сонгож ирсэн уламжлал

Монголын түүхийн сурвалж бичиг болон археологийн эх хэрэглэгдэхүүнээс үзэхэд нас барсан хүнийг хүндэтгэн оршуулах, шарил үүрд орших газрыг сонгох явдал эрт үеэс уламжлалтай аж. Монгол улсын нутаг дахь булш оршуулгын дурсгалын хамгийн эртнийх нь неолитийн үе буюу НТӨ 4000 орчим жилд холбогдож байгаа бөгөөд энэ үеэс нас барсан хүнээ оршуулж, хүндэтгэх болон гашуудах зан үйлийг гүйцэтгэж байжээ.² Монголчуудын оршуулгын зан үйл,

¹ Qurčabileg: *Mongyolčuud-un orsiyulya-yin soyol*. Öbör Mongyol-un soyol-un keblel-ün qoqiya, Kökeqota 2003, т. 76; *Газрын шинжийн монгол судар*. Монгол, англи хэлнээ орчуулсан Б. Няммягмар. Улаанбаатар 2012, т. 35; Отгонбаатар, Б.: *Монголчуудын оршуулгын зан үйл (XX зуун)*. Улаанбаатар 2009, т. 46.

² *Монголын эртний булш, оршуулга*. (Монголын археологийн өв. Боть III.) Улаанбаатар 2016, т. 13.

хэлбэр түүхэн цаг үеүүдэд хувьсан өөрчлөгдөж ирсэн бөгөөд эрт, дундад үеийн Монголчуудын хувьд булж оршуулах заншил түгээмэл байсныг археологи болон бичгийн сурвалжийн мэдээнээс харж болно.

Хүннү нар нүүдэлчдийн түүхнээ хамгийн гүн, сүрлэг оршуулгыг үйлдсэн ард түмэн юм. Эртний Египетчүүд нас эцэслэсэн хаадын булш болох пирамидыг газрын хөрсөн дээр байгуулдаг байсан бол Хүннү нар газрын хөрсөн доор 20 гаруй метр гүнтэй пирамид мэт хэлбэртэй гүн нүх бүхий бунханта оршуулгыг бүтээдэг байсан билээ.³ Өнөөгийн судалгааны түвшинд Монгол болон ОХУ-ын Буриад, Тува улсын нутагт Хүннүгийн язгууртны 12 оршуулгын газарт 2160 орчим булш байгааг (нэг оршуулгын газарт дунджаар 10–500 орчим булш, малтан судалсан 27) бүртгэсэн бол цагариг хэлбэрийн чулуун дараас бүхий жирийн жижиг булш Монгол улсын 300 гаруй газраас илэрсэн бөгөөд эдгээрт байгаа булшны тоо 10 мянга хол давна⁴ (нэг оршуулгын газарт дунджаар 100 орчим булш). Харин малтлага судалгаа хийсэн булшны тоо 400 орчим болжээ.

Хүннү болон Монголчуудын оршуулгын зан үйлд ижил төстэй зүйл олон байгаагийн (тухайлбал, оршуулгын байгууламжийн зохион байгуулалт, дагалдуулах төрөл зүйлийг сонгох, байршуулах заншил, хүнээ тавьсан байдал гэх мэт) нэг нь газар сонгох явдал юм. Хүннүгийн язгууртны болон жирийн булшийг судалсан эрдэмтэд оршуулгын газрын байрлал зүйн талаар өөрсдийн санал, дүгнэлт хийсэн байна. Тухайлбал, З. Батсайхан “Хүннү булшуудын ихэнх нь уулт хээр ба ойт хээрийн бүсэд орших бөгөөд тал хээрийн бүсэд тохиолдохгүй байна”⁵ гэсэн бол Ц. Төрбат Хүннүгийн оршуулгын газрын байрлал зүйг нэгтгэн харахад доорхи 5 үндсэн шинж ажиглагдаж байгааг дурьджээ. Үүнд:

1. Өнөөг хүртэл хүн, амьтан нутаглаж буй (ялангуяа өвөлжөө бүхий) үржил шимтэй баялаг бэлчээр бүхий газар,
2. Том жижиг гол, мөрний сав хөндийд,
3. Ихэвчлэн өндөрлөг газарт (уул толгойн бэл, тэнэгэр ар газарт),
4. Ойр орчимд нь хад асгатай уул бүхий газарт,
5. Элсэрхэг буюу шаварлаг хурдастай газарт байх юм гэжээ.⁶

Монгол улсын нутагт малтсан Хүннүгийн язгууртны булш ихэвчлэн модтой уул, толгодын бэл, тэнэгэр ар газар харин жирийн жижиг булш уул, толгодын өвөр хэсэг, тэгш газарт байх ажээ.

³ *Балгасын тал дахь Гол мод-2-ын Хүннүгийн язгууртны булшны судалгаа*. Улаанбаатар 2015, т. 7.

⁴ *Монголын эртний булш, оршуулга*, т. 142, 166.

⁵ Батсайхан, З.: *Хүннү (археологи, угсаатны зүй, түүх)*. Улаанбаатар 2002, т. 27.

⁶ Төрбат, Ц.: *Хүннүгийн жирийн иргэдийн булш*. Улаанбаатар 2004, т. 22.

“Монголын археологийн хээрийн шинжилгээний тайлан,” “Монголын археологийн өв” болон бусад судалгааны⁷ үр дүнгээс харахад, Монгол нутаг дахь эрт, дундад үеийн нүүдэлчид нас барсан хүнийг нутаглуулахдаа:

- Монголын баруун бүс нутагт ихэвчлэн голын хөндий, тэгш тал, уулын ам,
- Хойд болон төвийн бүс нутагт уулын энгэр бэл газар,
- Говь ба Алтайн уулсаар буй булшнууд уулын ам, энгэр, бэл, нуурын өмнөд эрэг

зэрэг газарт оршуулсан байдал ажиглагдаж байна. Эндээс харахад, эрт дундад үеийн Монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйл, нас барсан хүнийг нутаглуулах газрыг сонгох явдал нь оршуулж буй хүний нийгэмд эзлэх байр суурь, цол хэргэм, хөрөнгө чинээний байдал болон булшинд хэрэглэх мод, чулуу зэргийн олодог гэх мэт олон зүйлээс шалтгаалж байжээ.

Хүннүгийн үед нас барсан хүний тухай судлаачид “Хүннүгийн үед оршуулах газрыг овгийн ахлагч буюу бөө зааж тогтоодог байжээ. Хүннүчүүд овгийн нэгдсэн оршуулгын газартай байх нь түгээмэл тул оршуулгын газрын дотор чухам хаана булшийг байрлуулахыг шийднэ. Ойр төрлийн хүмүүсийг нэг дор ойрхон оршуулахыг эрмэлздэг байсан бололтой”⁸ хэмээн бичжээ. Уг зан үйлийн ул мөр эдүгээ ч зарим талаар уламжлагдан ирсэн бөгөөд орчин үеийн Монголчуудын оршуулгын ёсонд бурхны шашны лам хувраг нар талийгаачийг нутаглуулах зүг, газрыг заан тогтоох явдал түгээмэл буй.

Монголчууд талийгаачийг уулын оройд нутаглуулж ирсэн явдал нь бөө мөргөлийн угшилтай хэмээн зарим судлаачид үздэг. Тухайлбал, уулын оройд оршуулах ёсон нь бас ил тод бөө мөргөлийн угшилтай оршуулгын ёсон байгаа юм. Бөө нарын үзэхээр нэгд, уул хайрхны толгой, тэнгэрт ойр байгаа тул тэнд нөгчсөн хүнийг тавибал тэнгэрт халихад амар бөгөөд тэнгэр лүгээ харилцахдаа дөхөм хоёрт, уул хайрхны толгой этүгэн эхээс хэтийдэж гарсан болохоор тэндээс хойч үе, ураг садан, харьяат иргэнээ сайн муу явж байхыг бараалж, цаг тухайд нь дэмжин туслаж байхад амар гэдэг байжээ.⁹

Хүннүгийн язгууртны булш оршуулгын газрын байршлыг ажиглахад эртний нүүдэлчид нар мандан гарч буй зүүн зүгийг “урд зүг” хэмээн үзэж аливаа зан үйлийг үйлдэж байжээ. Хүннүгийн томоохон оршуулгын газар болон суурин газар хоёрын хооронд холбоо байж болох тал байгаа бөгөөд 200-аас дээш булштай оршуулгын газрын ойролцоо суурин газар орших зүй тогтол гэмээр зүйл ажиглагдаж байна.¹⁰ Тухайлбал, Ноён уул-Бороогийн суурин, Иволгын суурин-Иволгын оршуулгын газар, Тамирын уулан хошуу (Бурхан толгой)-Хэрмэн талын зэрэгцээ гурван хэрэм зэрэг газрыг дурдаж болно. Энэ бол талийгаачийг

⁷ Батсайхан, З.: *Хүннү (археологи, угсаатны зүй, түүх)*; Төрбат, Ц.: *Хүннүгийн жирийн иргэдийн булш*; *Талын морьтон дайчдын өв соёл: VIII–XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн*. Улаанбаатар 2014; *Балгасын тал дахь Гол мод-2-ын Хүннүгийн язгууртны булшны судалгаа*. Улаанбаатар 2015; *Монголын эртний булш, орицуулга* г.м.

⁸ Төрбат, Ц.: *Хүннүгийн жирийн иргэдийн булш*, т. 14.

⁹ Qurçabileg: *Mongolciud-un orşiyulγa-yin soyol*, т. 77.

¹⁰ Батсайхан, З.: *Хүннү (археологи, угсаатны зүй, түүх)*, т. 27.

нутаглуулах газрыг сонгох явдал нь нийгмийн хүчин зүйл, аж ахуйн бодит нөхцөл байдалтай холбоотой байсныг илтгэнэ.

Өнөөгийн судалгааны түвшинд дундад үеийн Монголчуудын оршуулгын дурсгалыг язгууртны бунхант оршуулга, чулуун ба шороон овоолгот булш (жирийн иргэдийн булш), хадны ба агуйн оршуулга, гэсэн үндсэн гурван төрөлд хувааж байна. Монголчууд язгуур угсаа бүхий ноёд, баатар сайн дайчин эрсийг хүндэтгэн дээдэлж, тэдний шарилыг уул, хад болон агуйд оршуулдаг байжээ. Энэ талаар “Монголын нууц товчоон,” Рашид ад-Дины “Судрын чуулган” зэрэг сурвалж бичиг болон археологийн хэрэглэгдэхүүнээс тодруулж болох юм.

Эрт цагаас XII зууныг хүртэл овог аймгийн тэргүүлэгчдийг нэгэн газарт оршуулж түүнийгээ “Ихсийн газар” гэж нэрлэдэг байсан бөгөөд энэ нь нийтийн оршуулгын газартай шинж чанар адил¹¹ хэмээн судлаачид үздэг. “Монголын нууц товчоон”-д¹² тэмдэглэснээр Бурхан халдун уулан дахь “Ихсийн газар”-ыг тахидаг байсан бөгөөд тэрхүү тахилгын идээ ундааг хүртэх эрх язгууртан болон тэдний хатан нарт байжээ. Судлаачдын үзэж байгаагаар МНТ-ны “Ихсийн газар”-ын тахилга бол ямар нэг лус савдаг, газар усны эзэн, өвөг дээдсийн сүнс, сүлдэд бус Бөртэ чино тэргүүтэй Монголчуудын дээд өвөг Бурхан халдун ууланд ирж голомтоо бадраасан газар буюу Ихэс дээдсийн газарт өргөж буй зан үйл юм.¹³ Дундад үеийн Монголчуудын төсөөллөөр үхэгсдийн орон нь газар эхэд буюу тодорхой хэлбэл овгийн шүтлэгт ууланд байдаг тул уулын нар тусдаг эвэр энгэрт оршуулах явдал түгээмэл¹⁴ байжээ. МНТ-ны 164-р зүйлд Хэрэйдийн Ван ханы өгүүлсэн хэсгээс тухайн цагт Монголчууд язгууртан хүнийг нас барсны дараа өндөр ууланд нутаглуулж байсныг харж болох мэт. Тухайлбал:

“... *basa ong-qan ügüleriin ... bi ber edö'e ötölba namayi ötölfü ündüte-garu'asu qa'ucitba bi qa'ucitcu qaldut-ta qaru'usa qamuq ulus ken medegü ...*”¹⁵ гэх зэргээр өгүүлжээ.

“Судрын чуулган”¹⁶-ы мэдээгээр Сорхогтани бэхи хатан болон хан хөвгүүдийг Сэлэнгэ мөрний Бүри өндөр хэмээх уул, Өгөдэй хааныг хоёр өдөрчийн зайтай газар орших Мөнх цастай өндөр ууланд тус тус оршуулсан ажээ. Хадны болон агуйн оршуулга нь газрын хөрсөн дор булшны нүх ухаж үхэгсдийн шарилыг булшлах бус харин байгалийн бэлэн агуй хонгил, хадны хөмөг ашиглан шороо чулуугаар далдалж нөгчигсдийн шарилыг оршоодог. Байрлалын хувьд ихэвчлэн уулын дунд болон орой хэсгийн холын бараа сайн үзэгдэх дэвсэг дээрхи

¹¹ Пэрлээ, Х.: *Эртний монголчуудын үхээсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд*. Улаанбаатар 1956, т. 5.

¹² Rachewiltz, Igor de: *Index To The Secret History of the Mongols*. Indiana University, Bloomington 1972, т. 27.

¹³ Өлзийбаяр, С.: “Ихсийн газар”-ын утга учир хийгээд Биндэр овооны тахилгын асуудалд. *Historia Mongolarum XV. Fasc. 5. №474 (36) (2016)*, т. 33.

¹⁴ Мэнэс, Г.: Символика солнца в системе погребельного обряда монгольских племен. *Археологических памятники средневековая в Бурятии и Монголии*. Новосибирск 1992, т. 20.

¹⁵ Rachewiltz, Igor de: *Index To The Secret History of the Mongols*, т. 76 үзнэ үү.

¹⁶ Рашид Ад-дин: *Судрын чуулган*. Орос хэлнээс орчуулсан Ц. Сүрэнхорлоо. Боть II. Улаанбаатар 2002, т. 44, 228.

хадны хөмөг, агуйд тохиолдоно.¹⁷ Хад, агуйн оршуулгад талийгаачийг нутаглуулах газрыг сонгосон байдал нь нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэл, байгаль дэлхийтэй харьцах арга ухаан, талийгаачид хүндэтгэл үзүүлэх гүн гүнзгий утга, зан үйлийн улбаа тодорч байна.

Монгол улсын нутагт малтсан дундад үеийн булш оршуулгын судалгааны үр дүнгээс харахад XII–XIII зууны Монголчууд нас барсан хүнийг уулын наран энгэр ээвэр газарт оршуулахыг эрхэмлэн үзэж байжээ. Тодруулбал, дундад үед хамаарах газар зүйн байрлал, газар сонгосон байдал зэргийг тодорхойлсон 140 булшийг оршин буй байршлаар нь ангилан авч үзэхэд 56.4% буюу 80 гаруй булш нь уул, толгодод оршин байна.¹⁸ Үүнд, уулын энгэр газарт 56.96%, оройн хэсэгт 6.32 %, бэл хормойд 20.25%, бусад 16.45% байгаа ажээ. Энэ бол Монголчууд талийгаачийг оршуулах газрыг сонгохдоо өдрийн турш нэр тусах энгэр ээвэр газрыг эрхэмд үзэж байсны илрэл юм. Монгол нутаг дахь эрт, дундад үеийн булш, оршуулгын газрын байршлыг ажиглахад сүүдэр газар, уулын онь, хөтөл, өнчин ганц мод, булаг шанд ба их хөлийн зам харгуй бүхий газар оршуулахыг цээрлэдэг байжээ.

Монголд бурхны шашин хүчтэй дэлгэрэхийн хамт нийтээр ил задгай оршуулдаг заншлыг дэлгэрүүлсэн ба XVI–XVII зууны үеэс ноёд, дээд лам нарыг чандарлан, чандрыг бумбанд хийж дээр нь суварга барин оршуулах, хүүрийг хатааж сүм бунхан барин хадгалах болсноор “Бумбат,” “Бунхант,” “Шарилт” гэдэг газар зүйн нэр гарсан байна.¹⁹ Монгол дахь бурхны шашны дэлгэрэлттэй уялдан оршуулгын газрыг сонгох явдалд лам хувраг нар голлох үүрэгтэй болж, “Газрын шинжийн судар” хэмээх судар номыг ашиглах болжээ.

“Газрын шинжийн монгол судар”-т “Хүүр тавих газрыг шинжих нь” гэсэн хэсэг байх бөгөөд түүнд:

“Хаан адил уул байвал хүний арван гурван үе хүртэл сайн, хатан адил уул байвал хүний долоон үе хүртэл сайн, эм түшмэл адил бол хүний таван үе хүртэл сайн, ... хурц дов сондуултай уул нь эр уул гэх ба эр газар тавьбал хүн ам өсөх, өөрийн суудлыг оловч хэт нь батгүй. Олон хонхор хотгортой чийглэг уулыг эм уул гэх ба ийм газарт хүн болон төгс эдлэл арвидаж болох ч алдсаа өлзийгүй. Гол мөрөн ба нурсан шороо холилдсон уулыг мани уул гэх ба орхих ёстой газар мөн”²⁰ гэх мэтээр өгүүлсэн байдаг.

Бурхны шашны судар номонд “Шарил оршуулахуйн ёсонд эр хүний шарилыг өшгөлж түрүүлдэж байх газар дор баригдахуй. Эм хүний шарилыг хормойгоо бүтээн дэлдэж суухуй дор адил газарт оршуулахуй”²¹ хэмээн эрэгтэй хүнийг уулын оройд, эмэгтэй хүнийг уулын бүсэлхийд оршуулах тухай заасан нь Монголчуудын эрт, дундад үеийн оршуулгын зан үйлийн улбаа бололтой. Монгол

¹⁷ *Талын морьтон дайчдын өв соёл: VII–XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн*. Улаанбаатар 2014, т. 79–80.

¹⁸ Энхсайхан, Д.: Монголчуудын оршуулгын газар сонгох ёс. *Нүүдэлчдийн өв судлал XI*. Fasc. 18. Улаанбаатар 2011, т. 225.

¹⁹ Пэрлээ, Х.: *Эртний монголчуудын үхэгсдээ*, т. 3.

²⁰ *Газрын шинжийн монгол судар*, т. 35–39.

²¹ Qurčabileg: *Mongolčiud-un orşiyulγa-yin soyol*, т. 76.

улсын Үндэсний Төв Архивын баримтанд тэмдэглэсэнээр XVIII–XX зууны эхэн үеийн Монголчуудын хувьд ноёд, язгууртныг далд оршуулах (булж оршуулах) явдал хадгалагдсаар байсан бөгөөд “Ноёдын шарил оршуулсан газар”-ыг²² хамгаалах үүрэг бүхий өрх, ард сууж байв. Бурхны шашны лам хутагт, хувилгааны тухайд шарилыг чандарлан суварга бүтээхийн зэрэгцээ занданшуулан сүм дуганд залж байсан²³ ажээ. Харин эгэл жирийн ардыг гол төлөв ил тавих ба энэ үйлийг хариуцах хүнийг ясчин буюу яс баригч²⁴ хэмээн нэрлэж байв.

И. Майский “Орчин үеийн Монгол” бүтээлдээ тухайн цагийн Монголчуудын оршуулгын зан үйл, газрын тухай өөрийн ажигласан сонин содон зүйлийг бичсэн нь:

“Автономит Монголд нас барсан хүний оршуулга маш өвөрмөц байдалтай. Энэ бол эхлээд харахад европчуудад дээд зэргийн гайхаш төрүүлэх нэг монгол заншил юм. Гэхдээ Буддын сүсэглэлээр нас барсан хүний цогцсыг газарт булах ёсгүй, харин шувуу араатны идэш болгох учиртай. Ийм учраас Монголчууд нас барсан хүнээ булшинд хадгалдаггүй харин хээр талд ил орхиж араатан амьтан, агаар салхиар үрэн таран хийлгэдэг ... Хүнгүй шахам газар хөдөөлүүлдэг болохоор талийгаачийг нутаглуулах энэ хэлбэрт ямар нэгэн онцгой, эвгүйрэх зүйл байхгүй. Томхон хот, сүм хийдийн газарт бол арай нарийн, жишээ нь 30.000 орчим хүн байнга суудаг Өргөөд (Их хүрээ) талийгаач харьцангуй олон тоотой учраас тэнд оршуулгад зориулсан тусгай булш буй болсон байна. Энэ булш гэдэг нь хотоос холгүй орших үхсэн хүнийг ил тавьдаг ерийн уулын энгэр бэлийг хэлнэ. ... Өргөөгийн хутагт болон алдар нэртэй том лам нарын шарилыг занданшуулан олны мөргөлийн сүм дуганд байрлуулна.”²⁵ хэмээн эрт, дундад үеийн Монголчуудын оршуулгын зан үйл дахь талийгаачийг нутаглуулахдаа уулын энгэр эвээр газрыг сонгох явдал хэвээр хадгалагдсаар байсныг тэмдэглэжээ.

Өнөөг хүртэл малтан шинжилсэн булш оршуулгын дурсгал болон сурвалж бичгийн мэдээ нь Монголчууд талийгаачийн шарил, үүрд орших газрыг дур зоргоороо сонгож байгаагүйг харуулж байна.

²² Ноёдын шарил оршуулсан газрыг хамгаалж байсан ардуудын өрх, малын тоо бүртгэлийн данс. МУУТА. ФТ-101. Д-2. Хн-4 гэх мэт.

²³ Нас барсан хутагт цорж, хамба нарын шарилыг бумбанд хийх ба мөнгө гаргуулах тухай нугалбар бичиг. МУУТА. ФМ-171. Д-1. Хн-72; Богдын шарилыг суваргалан хойт дүрийг тодруулах тухай тогтоол. МУУТА. ФТ-179. Д-1. Хн-233 гэх мэт.

²⁴ Тухайлбал, Хүрээнд хэн болох нь тодорхойгүй үхсэн хүмүүсийг ясчингаар зайлуулсан тухай. МУУТА. ФМ-179. Д-1. Хн-975; Хүрээний ойр тойроны 15-ний газар шалган байцааж, хүрээний газар нас барсан хүний ясыг ясчингаар зайлуулах зэрэг асуудлаар харилцсан нугалбар бичиг. МУУТА. ФМ-33. Д-1. Хн-1770 зэргийг дурьдаж болно.

²⁵ Майский, И.: *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*. Орос хэлнээс орчуулсан Ц. Отхон. Улаанбаатар 2001, т. 72.

Орчин цагийн Монголчуудын оршуулга дахь газрын тухай асуудал

Орчин үеийн Монголчуудын оршуулгын зан үйлд бурхны шашны зэрэгцээ бөө мөргөл, христос, лалын шашнуудын нөлөө нэвтрэхийн хамт булж оршуулах, чандарлах, ил тавих зэрэг хэлбэрүүд зэрэгцэн оршиж байгаа бол дэлхий нийтэд далд оршуулга болон чандарлан оршоох хоёр үндсэн хэлбэр зонхилж байна. Монголчууд хот суурин газар олноор амьдрах болсноор нийгэм, эдийн засаг, оюун санааны амьдрал, зан заншилд зарим өөрчлөлт гарч, шийдвэрлэх асуудал бий болж байгаагийн нэг нь оршуулгын газрын тухай асуудал юм. Уг асуудлыг Улаанбаатар хотын оршуулгын газруудын жишээгээр авч үзье.

Эдүгээ Монгол улсын нийслэл Улаанбаатар хот 147 мянган га газар нутагтай бөгөөд үүнээс 18 мянган га газрыг хүн байнга оршин суудаг орон сууцны хороолол, байшин барилга, гэр хороолол эзэлж байна. Улаанбаатар хот дахь оршуулгын газрууд нь байршлын хувьд их төлөв хотын зүүн хойт, хойт, баруун хойт талын уулын энгэрт буй бөгөөд сүүлийн 60 орчим жилийн хугацаанд бий болжээ. Энэ нь хотын хүн ам жилээс жилд өсөн нэмэгдэж, европ маягийн оршуулга (цемент, төмөр хайс, хашаа, овор ихтэй хөшөө, чулуу тавих г.м.) олширсон зэрэг шалтгаанаас улбаатай юм. Нийслэл хотын хэмжээнд буй оршуулгын газруудын талбайд 250 мянган орон сууц (7, 9 давхар) барьж болох²⁶ тооцоо гарсан байдаг.

Монгол Улсын Бүртгэл, Статистикийн Газрын мэдээгээр Улаанбаатар хотын хэмжээнд 1957–2015 оны хооронд 264.516 нас баралт бүртгэгдсэн байдаг. Улаанбаатар хотод нэг жилд дунджаар 6500–7500 хүн нас барж байгаагийн 50 орчим хувийг газарт оршуулж байна. Нэг шарилыг газарт оршуулахад ойролцоогоор 15–20 м.кв талбай зарцуулдаг бөгөөд үүнээс 238.516 хүнийг газарт далд оршуулсан гэж үзвэл 4.770.320м² буюу 477 га газар далд оршуулгад зарцуулагдсан тооцоо гарна. Өнөөдрийн байдлаар нэг хүнд олгож байгаа газрыг 15–20 м.кв гэж үзвэл арван жилийн дараа гэхэд Улаанбаатар хотын 1300 орчим га газар зөвхөн оршуулгын үйл ажиллагаанд зарцуулагдана гэсэн үг. Энэ байдлаар оршуулгын газрын талбай хүрээгээ тэлж, түүнийг дагасан олон асуудал тулгарах нөхцөл үүсээд байгаа юм. Тухайлбал, оршуулгын газрын дэргэд айлууд олноор буух, ухвар мөчид зарим хүмүүс оршуулгыг ухах, хулгай хийх зэрэг нийгэмд хор уршиг бүхий үйлдлүүд гарах болов.

Улаанбаатар хотын дотор 120 га газрыг эзлэх Далан давхарын (Самбалхүндэв) оршуулгын газрыг авч үзэхэд, оршуулгын газрын эрүүл ахуйн бүсийг 300 метрээс доошгүй зайд байхаар тогтоосон журам зөрчигдсөн, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, хөшөө, чулуу нь нэр хаяггүй, хэн болох нь мэдэгдэхгүй булш хэдэн зууд хүрсэнээс гадна олон жилийн турш хуримдлагдсан хур хог, хаягдал бий болсон байдалтай байна. Одоогийн байдлаар Далан давхарын оршуулгын газарт эзэнтэй, хөшөөтэй 111.475, эзэнгүй (нэр хаяг эвдэрсэн)

²⁶ Бат, Ч.: *Нийслэлийн оршуулгын өнөөгийн байдал*. “Экологи ба буяны зан үйл” хэмээх эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Улаанбаатар хот, 2008 оны 10 дугаар сарын 27.

71.350, эвдэрсэн 47.600, хөрсөөр хучигдсан 2.250 шарил байна. Мөн оршуулгын газрыг харгалзах, бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хяналт тавих үүрэгтэй цорын ганц харуул байгаа нь оршуулгын газрыг тойрсон гэмт хэрэг, хулгай дээрэм ихсэхэд хүргэж байна. Тухайлбал, булш бунхан тонон эвдэж сүйтгэх, барилгын хог хаягдал хаях г.м.

Улаанбаатар хотын хэмжээнд 1957–2015 он хүртэл хийгдсэн далд оршуулга 265.000 гэж үзвэл 18894 м³ буюу 52000 тонн чулууг оршуулгын үйл ажиллагаанд ашигласан дүн гарна. Энэ нь Улаанбаатар хотын урд байрлах “Зайсан толгой”-гоос гурав дахин том хэмжээтэй болно гэсэн үг юм. Оршуулгын нэг хайрцаг хийхэд 2 метрийн урттай 12 ширхэг банз ордог бөгөөд Нийслэлийн хэмжээнд 1957–2015 он хүртэл хийгдсэн далд оршуулга 265.000 гэж үзвэл 529.032 ширхэг гуалин мод зарцуулагдсан дүн гарч байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын хэмжээнд оршуулгын зан үйл үйлдэх газрын байршил, талбайн хэмжээг тогтоосон бөгөөд хамгаалалтын бүсийг батлагдсан хил хязгаараас эргэн тойронд 300 метрт тогтоосон байдаг.

Хүснэгт 1. Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрт буй оршуулгын газрууд.
“Улаанбаатар Буян” ХХК-ны судалгааны материал. Улаанбаатар 2016.

Албан ёсны зөвшөөрөлтэй оршуулгын газар					
№	Газрын нэр	Талбай (га)	Байршил	Оршуулгын хэлбэр	Тайлбар
	Нарангийн энгэр	297.3	СХД, 26-р хороо	Далд оршуулга	“Улаанбаатар буян” ХХК хариуцдаг
	Далан давхар (Самбалхүндэв)	120.2	ЧД, 12-р хороо	Далд оршуулга	Нөөцгүй болсон тул 1987 оны АДХГЗ-ны 72 тоот тогтоолоор хаасан
	Цагаан даваа	51.2	БЗД, 22-р хороо	Далд оршуулга	Нөөцгүй болсон тул 1987 оны АДХГЗ-ны 72 тоот тогтоолоор хаасан
	Өлзийт дахь Мааньтийн оршуулга	52.6	ХУД, 14-р хороо	Далд оршуулга	
	Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн	50.2	СХД, 21-р хороо	Далд оршуулга	“Улаанбаатар буян” ХХК хариуцдаг
	Диваажингийн цэцэрлэгт хүрээлэн	40	Төв аймгийн Эрдэнэ сум	Далд оршуулга	“Улаанбаатар буян” ХХК хариуцдаг
	Мянган лант	30.6	БЗД, 20-р хороо	Далд оршуулга	
	Буяны төв цогцолбор (баруун)	17.3	СХД, 32-р хороо,	Чандарлан оршуулах	“Улаанбаатар буян” ХХК хариуцдаг

Албан ёсны зөвшөөрөлтэй оршуулгын газар					
№	Газрын нэр	Талбай (га)	Байршил	Оршуулгын хэлбэр	Тайлбар
	Японы оршуулгын газар	15.2		Далд оршуулга	Хаагдсан
	Оросын оршуулгын газар	9	БЗД, 5-р хороо	Далд оршуулга	Хаагдсан
	Алтан өлгий	6.2	БЗД, 22-р хороо	Далд оршуулга	“Улаанбаатар буян” ХХК хариуцдаг
	Нисэхийн оршуулгын газар	3.7	ХУД, 16-р хороо	Далд оршуулга	Нөөцгүй болсон тул 1987 оны АДХГЗ-ны 72 тоот тогтоолоор хаасан
	Исламын шашинтны оршуулгын газар	2.3	СХД, 26-р хороо	Далд оршуулга	
	Буяны төв цогцолбор (зүүн)	2	БЗД, 20-р хороо	Чандарлан оршуулах	“Улаанбаатар буян” ХХК хариуцдаг
Албаны ёсны бус, зөвшөөрөлгүй газрууд					
	Баянчандмань	–	Төв аймаг, Баянчандмань	Далд оршуулга	
	Шүлэг уулын энгэр	–	СХД, 21-р хороо	Далд оршуулга	
	Жирмийн цагаан нуур (Баянцогт)	–	Төв аймаг, Баянцогт сум	Далд оршуулга	
	Партизаны оршуулгын газар	–	Төв аймаг, Батсүмбэр	Далд оршуулга	
	Гачуурт, Шар хоолойн оршуулга	–	БЗД, 20-р хороо	Далд оршуулга	
	Гродокын оршуулга, казакуудын оршуулга	–	Налайх дүүрэг	Далд оршуулга	
	Баян уулын энгэр дэх Налайхын оршуулгын газар	–	Төв аймаг, Эрдэнэ сум	Далд оршуулга	
Бүгд		1000 орчим га газар Далд оршуулга: 19, чандарлах оршуулга: 2			

Хүснэгтэд тэмдэглэсэн эдгээр оршуулгын газрууд нь кадарстрын зураглал хийгдээгүй бөгөөд энэ нь төлөвлөлтгүй, эмх замбраагүй байдлаар талийгаачдыг нутаглуулах, газар тэлэлтийг даамжуурах нөхцөл болж байна. Уг асуудлын бодлогын түвшинд шийдвэрлэхийн тулд эрх зүйн орчныг бүрдүүлэх буюу “Оршуулгын тухай” хуультай болох асуудал яригдах юм. 2016 оны байдлаар Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй бүгд 20 гаруй оршуулгын газар нийт 1000 гаруй га газрыг хамарч, тэдгээрийн хаяа түшин 25000 орчим айл өрх амьдарч байна гэсэн тооцоо гарчээ.

Олон улсын оршуулгын холбооны (ICCFА) албан ёсны цахим хуудсанд бичсэнээр Австрали, АНУ, БНХАУ, ХБНГУ тэргүүтэй дэлхийн 70 гаруй улс оршуулгын хуультай ажээ.²⁷ Харин Монгол улсын хувьд өнөөг хүртэл оршуулгын тухай хууль батлагдан гараагүй байна. Иймд ойрын хугацаанд УИХ болон холбогдох байнгын хороогоор уг хуулийн төслийг оруулан хэлэлцүүлж батлуулах зайлшгүй шаардлага бий болж байна.

2015 онд Улаанбаатар хотын 9 дүүргийн 1000 хүнийг хамруулсан олон нийтийн санал асуулгын дүнгээс үзэхэд “Монголчуудын оршуулгын аль төрлийг дэмждэг бэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын хамгийн олон буюу 53.9% нь чандарлах зан үйлийг дэмжжээ. Үүнд, газарт оршуулахыг дэмжсэн 40.0%, чандарлах 53.9%, бунхлах 1.3%, ил тавих 3.6%, хариулаагүй 0.2% байна.²⁸

Олон улсын хэмжээнд далд оршуулах, ил тавих, чандарлан оршуулах зэрэг хэлбэрийн байгаль орчин, хөрс, газрын хэвлий, ус, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгааг хийсэн байдаг. Үүнд:

Хүснэгт 2. Оршуулгын хэлбэрүүдийн байгаль орчин, хүн амд үзүүлэх нөлөөлөл.

Байгаль орчинд үзүүлэх нөлөө (агаарт)		
Далд оршуулах (Булж оршуулах)	Ил тавих	Чандарлах
3–5 жилд зөөлөн эд, 40–50 жил түүнээс дээш хугацаанд хатуу эд задардаг. Энэ явцад агаарт 20 шахам төрлийн хорт хий тухайлбал, цууны хүчил, шоргоолжны хүчил, аммиак, хүхрийн хүчил, нүүрч хүчилийн дутуу исэл г.м. Үүгээр дамжин агаарын бохирдол үүснэ.	Байгальд тавьснаар нохой, шувуу зэрэг араатан амьтан идэж устгадаг учир онцын хор нөлөө бага.	Шаталтын явцад аммиак, азотын хий, метан зэрэг агаар гарах боловч шүүлтүүрийн нарийн системтэй учир агаарын бохирдол үүсгэхгүй.

²⁷ The International Cemetery, Cremation and Funeral Association, <https://www.iccfa.com>.

²⁸ Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын 9 дүүргийн ард иргэдээс санамсаргүй түүврийн аргаар авсан “Судалгааны асуулга”-ын тайлан, 2015 оны 4 дүгээр сар.

Байгаль орчинд үзүүлэх нөлөө (хөрс, газрын хэвлийд)		
Далд оршуулах (Булж оршуулах)	Ил тавих	Чандарлах
Олон жил агаарын дутмагшилтай орчинд байсан учир өвчний нянгуудаар хөрс, газрын хэвлийг бохирдуулна. Тухайлбал, Боомын савханцар нь 30, сүрьеэгийн савханцар 30–40 жил, тарваган тахал 40 жил болон түүнээс хугацаагаар өвчлөл үүсгэх боломжоо хадгалдаг байна.	Задралын элементүүдийн үлдэц бага зэрэг бий боловч онцгой бохирдол үүсгэхгүй.	Ямарч нян, бактери 1000 хэмийн халууныг тэсвэрлэхгүй учир хөрс, газрын хэвлийд сөрөг нөлөөгүй.
Хүн амын эрүүл мэндэд үзүүлэл нөлөө		
Хөрсөн доор олон жил хадгалагдаж, агаар, хөрсийг бохирдуулж хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.	Хот, суурин газартай ойр тавьсан тохиолдолд өвчин тараах аюултай.	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй.

Хүснэгтэд үзүүлсэн байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл Монголчуудын оршуулгын зан үйлд давамгайлж ирсэн далд оршуулах хэлбэр хүн ам төвлөрсөн хот, сууринд тохиромжгүй бөгөөд газар эдэлбэрт сөргөөр нөлөөлж буй харагдана.

Судалгаагаар янз бүрийн халдварт болон халдварт бус өвчнөөр нас барсан хүмүүсийг газарт оршуулсан тохиолдолд өвчний халдвар 60–70 жил ус, хөрс, агаарт хадгалагдаж, дахин өвчлөлийг шинээр үүсгэх магадлалтай байдаг ажээ. Энэ нөхцөлд дэлхийн ихэнх орнууд оршуулгын тухай хуулиараа зохицуулан чандарлан оршуулж халдвар тарах нөхцөлийг зогсоодог байна. Эдгээр судалгаанаас харахад далд оршуулга нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө их бөгөөд цөлжилт үүсгэх, гол мөрөн татрах, хөрсний бохирдол бий болгох, байгаль экологийн тэнцвэрийг алдагдуулах нэг нөхцөл болдог ажээ.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн ам хурдацтай өсөн нэмэгдэхийн хирээр далд оршуулгын газрууд хотын захын хороололтой хаяа нийлж, хүн амын амьдрах орчин, хотын өнгө үзэмжинд сөргөөр нөлөөлөх болжээ. Иймд оршуулгын тухай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, байгаль, орчин, экологи, хотын өнгө үзэмж, дэд бүтцэд сөргөөр нөлөөлөх аливаа үзэгдлийг зүй зохистойгоор зохицуулах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд хамтран ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Дэлхий дахинд авч үзвэл оршуулгын чандарлах хэлбэр жил бүр өсөлттэй байгаа бөгөөд чандарлах нь далд оршуулгатай харьцуулахад зардал багатай, улс орны дэд бүтэц, тэр дундаа оршуулгын газрыг эмх цэгтэй, зохион байгуулалт бүхий болгох давуу талтай, хөрсний бохирдлын асуудлыг шийдвэрлэх, газар ашиглалтын асуудлыг зүй зохистой болгоход тодорхой ач холбогдолтой зэрэг болно.

Монгол улсын хувьд 2004 онд Улаанбаатар хотод чандрын үйлчилгээ үзүүлдэг анхны буяны сүм байгуулагдаж, олон улсын чиг хандлагад нийцсэн шинэ дэвшилтэд технологи нэвтрэх эхлэл болсон юм. Чандарлах хэлбэр нь хот орчмын байгаль, экологийн байдлыг хэвээр хадгалах, агаарын бохирдлыг бууруулах, оршин суугчид эрүүл, айдасгүй амьдрах, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, оршуулгын газар эмх замбраагүй өргөжин тэлэх явдлыг хязгаарлах зэрэг нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй юм. Улаанбаатар хотын хэмжээнд авч үзвэл, сүүлийн 7 жилийн хугацаанд нэг жилд дунджаар 6000 гаруй хүн нас барсан байх бөгөөд үүнээс “Улаанбаатар Буян” ХХК 2012 онд хамгийн олон буюу 3021 хүнд чандарлах үйлчилгээ үзүүлсэн бол 2016 онд энэ тоо 1554 болж буурчээ.

Орчин үед оршуулгын газруудыг хэрхэн төлөвлөх тухайд хот суурин газарт чандарлах хэлбэрийг сонгох нь зүйтэй гэсэн хандлага давамгайлж буй хэдий ч бодит байдал дээр хэрэгжих явдал харьцангуй бага байна. Үүнд, сүүлийн жилүүдийн Монголын эдийн засгийн үзүүлэлтийн бууралт болон шашин шүтлэгийн байдал нөлөөлж байгаа бололтой.

Дүгнэлт

Монгол нутаг дахь эрт, дундад үеийн булш, оршуулгын газрын байршлыг ажиглахад сүүдэр газар, уулын онь, хөтөл, өнчин ганц мод, булаг шанд ба их хөлийн зам харгүй бүхий газар оршуулахыг цээрлэдэг байжээ. Монгол нутагт байгаа булш оршуулгын дурсгалын ихэнх нь уул толгодод орших ба уулын нар туссан энгэр, ээвэр газарт шарилыг байрлуулсан байна. Энэ нь Монголчууд уул, толгодын оргилыг нар ивээсэн мөнх тэнгэрийн ариун газар хэмээн үзэж ирсэнтэй холбоотой бололтой.

Монголчуудын оршуулгын зан үйл дэх газар сонгох явдал нь нүүдэлчдийн шүтлэг бишрэл, нийгэм, оюун санааны амьдралтай нягт уялдаатай байна. Газар сонгох ёс түүхийн урт удаан хугацааны туршид уламжлагдан өвлөгдөхийн сацуу агуулга, хэлбэрийн хувьд зарим талаар хувьсан өөрчлөгдөж иржээ. Тухайлбал,

- Монголд бурхны шашин дэлгэрсэнтэй холбоотой оршуулгын зан үйлд зарим өөрчлөлт орсон бөгөөд оршуулгын газрыг сонгох явдалд лам нар голлох үүрэгтэй болж, “Газар шинжих судар” зэргийг ашиглах болжээ.
- Газрыг зүй зохистой сонгох нь нас барсан хүнд хүндэтгэлтэй хандах, хойд насны буян заяаг тэгшлэх, үлдэж буй үр хүүхэд олон түмэн амар жимэр аж төрөх гүн гүнзгий утга илэрхийлж байна.

1990-ээд оноос хойш Монгол улсын нийслэл Улаанбаатар хот зэрэг хүн ам төвлөрсөн томоохон суурин газарт амьдарч байгаа хүмүүсийн оршуулгын зан үйлд тулгамдаж буй асуудлын нэг нь оршуулгын газрыг хэрхэн зүй зохистой шийдвэрлэх юм. Эдүгээ Улаанбаатар хот дахь оршуулгын газрын талбай хүрээгээ тэлж, түүнийг дагасан олон асуудал үүсч байна.

Дэлхий дахинд авч үзвэл оршуулгын хэлбэрийн хувьд чандарлах явдал харьцангуй өсөлттэй байгаа юм. Чандарлах хэлбэр нь хот орчмын байгаль, экологийн байдлыг хэвээр хадгалах, агаарын бохирдлыг бууруулах, оршин суугчид эрүүл, айдасгүй амьдрах, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, оршуулгын газар эмх замбраагүй өргөжин тэлэх явдлыг хязгаарлах зэрэг нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй. Иймд оршуулгын зан үйлийг уламжлал болон дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагатай уялдуулах нь зүйтэй байна.

Монголчуудын оршуулгын зан үйл дэх газар сонгох явдал нь шүтлэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, байгаль дэлхийтэй харьцах арга ухаан, аж ахуйн өвөрмөц байдлыг илтгэсэн соёлын нэг ажээ.

Abstract

Land Selection for Mongolian Funeral Rites: Accessing landscapes and conducting religious ceremonies have been integral parts of Mongolian daily life. One of such customs is funerary custom. Selection of a burial ground is a sign of Mongolian religious belief, world view, relation with nature, and also is a part of funerary customs with unique indication of Mongolian livelihoods. In this article we aimed to briefly describe the current state and problems of cemeteries in Ulaanbaatar as well as historic tradition of Mongolian burial ground choosing. For the tradition of burial ground choosing, we have used the volumes of *Reports of Field Archaeology in Mongolia* and *Mongolian Archaeological Heritage* as well as other relevant books and articles. Besides, we included some survey results on “Ulaanbaatar Buyan” Co. Ltd.

Ном зүй

ЭХ СУРВАЛЖ

Rachewiltz, Igor de: *Index To The Secret History of the Mongols*. Indiana University, Bloomington 1972.

Рашид Ад-дин: *Судрын чуулган*. Орос хэлнээс орчуулсан Ц. Сүрэнхорлоо. Боть II. Улаанбаатар 2002.

МУУТА. М–9. Д–3. Хн–357. нугалбар–2.

МУУТА. М–65. Д–2. Хн–95. нугалбар–1.

МУУТА. М–31. Д–2. Хн–1277.

МУУТА. М–86. Д–1. Хн–234.

МУУТА. М–87. Д–1. Хн–188.

МУУТА. Т–9. Д–1. Хн–2041.

МУУТА. М–85. Д–2. Хн–652. нугалбар–5.

МУУТА. Ф–1. Д–1. Хн–285

МУУТА. Х–1. Д–1. Хн–289. т. 168–169.

СУДЛАГААНЫ МАТЕРИАЛ

- Балгасын тал дахь Гол мод-2-ын Хүннүгийн язгууртны булшны судалгаа.* Улаанбаатар 2015.
- Батсайхан З.: *Хүннү (археологи, угсаатны зүй, түүх).* Улаанбаатар 2002.
- Газрын шинжийн монгол судар.* Монгол, англи хэлнээ орчуулсан Б. Няммягмар. Улаанбаатар 2012.
- Майский, И.: *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр).* Улаанбаатар 2001.
- Монголын археологийн хээрийн шинжилгээний тайлан.* I–VIII боть. Улаанбаатар 2014.
- Монголын эртний булш, оршуулга* (Монголын археологийн өв. Боть III.) Улаанбаатар 2016.
- Мэнэс, Г.: *Символика солнца в системе погребельного обряда монгольских племен. Археологических памятники средневековая в Бурятии и Монголии.* Новосибирск 1992.
- Отгонбаатар, Б.: *Монголчуудын оршуулгын зан үйл (XX зуун).* Улаанбаатар 2009.
- Өлзийбаяр, С.: “Ихсийн газар”-ын утга учир хийгээд Биндэр овооны тахилгын асуудалд. *Historia Mongolarum* XV. Fasc. 5. 474 (36) (2016), т. 29–37.
- Qurčabileg: *Mongyolčuud-un orsiyulγa-yin soyol.* Öbör Mongyol-un soyol-un keblel-ün qoγiya, Kөkeqota 2003.
- Пэрлээ, Х.: *Эртний Монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд.* Улаанбаатар 1956.
- Талын морьтон дайчдын өв соёл: VII–XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн.* Улаанбаатар 2014.
- Төрбат, Ц.: *Хүннүгийн жирийн иргэдийн булш.* Улаанбаатар 2004.
- Энхсайхан, Д.: *Монголчуудын оршуулгын газар сонгох ёс. Нүүдэлчдийн өв судлал* XI. Fasc. 18 (2011), т. 221–227.

ЗҮҮН ХҮРЭЭ ДАШЧОЙЛИН ХИЙДИЙН ЦАМЫН ХӨГЖИЛ

Батмөнхийн Мөнгөнчимэг

Бернийн Их Сургууль, Берн

Дашчойлин хийдийг хуучин Зүүн хүрээний¹ суурин дээр сэргээн байгуулаад 25 жил болж байна. Тус хийд Хүрээ цамыг 2002 оноос сэргээсэн бөгөөд тухайн онд цөөн хэдэн лам нар Солонгос, Германд цамаа гаргажээ. 2003² оноос тус хийд Хүрээ цамыг олон баг өмсгөлтөй, жил бүр тогтмол гаргадаг болсон.

Монгол цамын хөгжил, сэргэлт, уналтын түүхийг Монголын төдийгүй гадаадын үе, үеийн эрдэмтэн судлаачид сонирхон судалсаар ирсэн. Хүрээ цамыг 1811 оноос 1937 он хүртэл, нийт 127³ удаа харайсан гэх боловч эл хугацаанд цам хэрхэн хувьсан өөрчлөгдөж, хөгжсөн тухай тодорхой мэдээлэл бидэнд хараахан олдоогүй байна.⁴ Энэхүү өгүүлэлд эрдэмтэн В. Хайссиг (W. Heissig), Б. Ренчин, Л. Хүрэлбаатар нарын монгол цамын тухай бүтээл дээр суурилан нэгдүгээрт, монгол цамын түүхэн үүслийг тодруулан, уламжлалт дэг жаяг нь өнөөгийн Дашчойлин хийдийн цамын үндэс нь болж буй хоёрдугаарт, Зүүн хүрээ Дашчойлин хийдийн 2009 он, 2016 оны Хүрээ цамд хийсэн судлаачийн ажиглалт, харьцуулалт, ярилцлага, дүрст бичлэг, судалгаагаар цамын дүр, бэлгэдэл, агуулга, хувьсал өөрчлөлтийг харуулахыг хичээлээ.

Цамыг XVIII зууны эхэн үеэс Төвдөөс Монголд нэвтэрсэн хэмээн эрдэмтэд санал нэгтэй байдаг⁵ бөгөөд цам Монголд дэлгэрэхдээ Монголчуудын өвөрмөц

¹ Дэлгэржаргал, П. – Нямдорж, С. – Батдорж, С. – Лхагвабаяр, В. (эмх.): *Их хүрээний гучин аймаг. Баримт бичгийн эмхэтгэл (1651–1938 он)*. Мөнхийн үсэг ХХК, Улаанбаатар 2015, т. 3, 5.

² Kollmar-Paulenz, Karénina – Mungunchimeg, Batmunkh: *Der mongolische Maskentanz (Tsam) in Vergangenheit und Gegenwart. De Gruyter ASIA* 69 (2015, 3, т. 625–683. Мөн миний бие 2003 онд тус хийдийн цамын дүрс бичлэг хийсэн. Бичлэг нь одоо Венийн Үндэсний Их Сургуулийн номын санд дипломын ажлын хавсралтанд байна. Мөн Ц. Мөнх-Эрдэнэ ламын бичсэн Зүүн хүрээ Дашчойлин хийдэд дэглэн гаргаж буй Хүрээ цамын товч тайлбартаа хоёр хуудсанд 2003 оноос Цам тус хийдэд гарах болсон гэсэн тайлбартай санал нэг бас баримтанд тулгуурлан санал болгоход тус хийд цамыг 2003 оноос хийддээ гаргасан болно. Бас өөр нэгэн баримт бол 2003 онд тус хийдийн лам Г. Уламбаяр Эрлэг номун хаанд, түүнтэй, тэрээр хийсэн ярилцлагт тэр манай хийдийн анхны цам гэдгийг баттай хэлж байсан. Дашчойлин хийдийн их гэсгүй Ц. Алтанхүүгийн 2007 оны “Дэлхийд гайхагдсан Монгол Цам” ярилцлагтаа 2002 оноос цам тус хийдэд гарсан тухай дурдсан. 2008 оны 7 сарын 11-нд Зүүн хүрээ Дашчойлин хийд Хүрээ цам тайлбартаа Хүрээ цамыг тус хийд 2002 оноос хойш нийт 6 удаа гаргасан гэж мэдээлсэн.

³ Кимүра Аяако: *Монголын хүрээ цамыг бусад орны цамтай харьцуулан судалсан нь*. Улаанбаатар 1997, т. 12.

⁴ Кимүра Аяако: *Монголын хүрээ цамыг ...*, т. 12.

⁵ Хүрэлбаатар, Л.: *Судар шастирын билиг*. Улаанбаатар 2002, т. 300; Баасансүрэн, Х.: *Энх тунх эрдэнэ зуу*. Улаанбаатар 2011, т. 82; Vareja-Starzyńska, Agata: *Description of the Erdene Zuu Monastery Life (Including Cam Ritual). Based on Notes from the Kotwicz Expedition*. Polish Academy of Arts and Sciences, Warsaw 2012, т. 152; Lang, Maria-Katharina – Bauer, Stefan (eds.): *The Mongo-*

онцлогийг шингээн дэлгэрснийг Агваанлуvsанхайдав (1779–1838) хамба номон хан 1836 онд цамын тухай бичсэн судардаа өгүүлсэн. Эрдэмтэн Л. Хүрэлбаатар, К. Аяако нар энэ тухай сурвалжлан өгүүлжээ.⁶ Үүний зэрэгцээ XVIII зуунаас өмнө Монголчуудын дунд чам харайж байсан тухай гадаад, дотоодын эх сурвалжуудад дурдсан байна.⁷ Үүнээс өгүүлэхэд:

1. Халхын Зая Бандид С. Лувсанпэрэнлэй (1642–1715)⁸ нь төвдийн V Далай ламаас “Зая гэгээн”⁹ хэмээх цол алдрыг 1678 онд хүртэж, чам сурсан талаар эрдэмтэн Л. Хүрэлбаатар “Огторгуйн цагаан гарди” номын нэгдүгээр ботийн “Ухааны таван орны ялгуусан бандид” гарчигтай зохиолдоо Зая бандид цамын бүжгийг сурсан тухай “Алмай зугаа наадмын дур сэтгэлээр адил үгүй нян зүйл цамын бүжгийг сурав”¹⁰ гэжээ. Мөн Г. Жамц “Нэн тод Гэрэлт Зая Бандида” номондоо “1657 онд, Зая гэгээн 16 насандаа Эрдэнэ зуу хийдэд Өндөр гэгээнд бараалхан ном хүртээд цамын бүжгийн ёс дэгийг сурсан”¹¹ тухай өгүүлжээ.
2. Төвдийн V Далай лам Агваанлуvsанжамц (1617–1682)¹² “Их цогт пүрэвийн цамын тэмдэглэл бичиг – Бурхны цэнгэх бүжиг”¹³ хэмээх цамын онолын номоо бичсэн. Түүний намтарт, 1636 онд хэсэг Монголчууд цамын бүжгийг үзэж суралцсан тухай тэмдэглэжээ.¹⁴

lian Collections Retracing Hans Leder. Austrian Academy of Sciences Press, Vienna 2013, т. 84–94; Позднеев, А. М.: *Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии с отношениями с его последнего народа*. Санкт-Петербург 1887; Шастина, Н. П.: *Цам журнал* Хозяйство Монголий № 26. Улаанбаатар 1928; Кимүра Аяако: *Монголын хүрээ цамыг ...*, Гангаа, Д.: *Хүрээ цам*. Улаанбаатар 2003; Majer, Zsuzsa – Teleki, Krisztina: *Reviving the Cam Dance Tradition in Mongolia*. Traditional Mongolian Culture II. Budapest 2014.

- 6 Хүрэлбаатар, Л.: *Монгол Цам*. Монгол соёл, урлаг судлал I–II. Улаанбаатар 1999; Кимүра Аяако: *Монголын хүрээ цамыг ...*, т. 1.
- 7 Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 627.
- 8 Жамц, Г.: *Нэн тод гэрэлт Зая Бандида*. Улаанбаатар 2017, т. 21.
- 9 Хүрэлбаатар, Л.: *Огторгуйн цагаан гарди*. Улаанбаатар 1996, т. 43. “Зая бандид” гэдэг нь Ялгуусан бандид гэсэн үг бөгөөд (я үсгийн ард а үсгийг бичээгүй байна) цаашлаад Зая гэдэг нь ялгуусан буюу гоц хэтэрхий ялгарсан цолгорсон, “бандид” гэдэг нь таван ухааны эрдэмтэн гэсэн үг хэмээн тайлбарлажээ. Majer, Zsuzsa – Teleki, Krisztina: *History of Zaya Gegeenii Khüree, the Monastery of the Khalkha Zaya Pandita*. Ulaanbaatar 2013, т. 16; Bareja-Starzyńska, Agata: *Description of the Erdene Zuu Monastery Life (Including Čam Ritual). Based on Notes from the Kotwicz Expedition*. Polish Academy of Arts and Sciences, Warsaw 2012.
- 10 Хүрэлбаатар, Л.: *Огторгуйн цагаан гарди*, т. 50; Баатарбилэг, Ё.: *Архангай аймаг*. Улаанбаатар 2007, т. 68.
- 11 Жамц, Г.: *Нэн тод гэрэлт Зая Бандида*, т. 23.
- 12 Werner, S. Forman – Rintschen, Bjamba: *Lamaistische Tanzmasken (Der Erlik-Tsam in der Mongolei)*. Koehler & Amelang, Leipzig 1967, т. 62. “Der große V. Dalai Lama Ngag-dbang blo-bzang” хэмээн V Далай ламын нэрийг бичсэн байна. Харин Л. Хүрэлбаатар болон Karénina Kollmar-Paulenz эрдэмтэн хоёрын бичсэн зөвхөн нэг (*mtso*) (*mtsho*) *h* үсэг Хүрэлбаатар багшийн V Далай тэмдэглэлд дутсан бусад бүх үг үсгийн зөрөөгүй болно Ngag-dbang blo-bzang rgya mtso? (*mtsho*?); Sagaster, Klaus: *Der mongolische Buddhismus Geschichte*. In: *Dschingis Khan und seine Erben*. Ed. by Jutta Frings. Hirmer, München 2006, pp. 342–347.
- 13 Хүрэлбаатар, Л.: *Судар шастирын билиг*. Улаанбаатар 2002, т. 300.
- 14 Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 629.

3. Эрдэмтэн Б. Ренчин герман хэлээр хэвлүүлсэн, *Lamaistische Tanzmasken* бүтээлдээ “Монгол цам” нь XVI зуунд үүссэн, Монгол цамын баг болон хувцас загварыг V Далай ламаас сурсан хэмээжээ.¹⁵
4. Германы монголч эрдэмтэн В. Хайссиг *Die Mongolen* бүтээлдээ цамын багт бүжиг Монголд XVI–XVII зуунд үүсч хөгжсөн¹⁶ хэмээжээ.

V Далай лам Агваанлуvsанжамц Монголчуудыг цамтай холбож дурдсан нь зүй ёсоор анхаарал татаж байна. Өнөөгийн байдлаар монгол цамын тухай эх сурвалж, хэрэглэгдэхүүн, бид эрэлхийлж байгаа.¹⁷ Монгол цамын үүслийг Д. Гангаа монголын анхны цам Ойрадын зүүн гарын улсад 1723 онд гарсан гэж бичжээ.¹⁸ В. Хайссиг монгол цамын тухай олны мэдэх Урадын Мэргэн гэгээн-тэй холбоотойгоор Мэргэн гэгээн хийддээ цамын бүжгийн нэгэн гарын авлагыг 1750 онд бичсэн тухай тус бүр дурджээ.¹⁹ Сүүлийн бүтээл нь III Мэргэн гэгээн Лувсандамбийжалцангийн²⁰ “Мэргэн хийдийн Монгол цамын тухай бүтээл” (1750) хэмээх гар бичмэл юм. Энэ гар бичмэлийн модон бар нь “Алмаз эрих”²¹ нэртэй, тус хийдийн цамын тухай судар болно. Үүний нэг хувь Швейцар улсын эрдэмтэн Karénina Kollmar-Paulenz-ийн хувийн номын санд байна.²² Өөр нэг хувийг, эрдэмтэн Р. Отгонбаатар “Монгол модон барын архивын эх гарчиг”²³ хэмээх Япон улсад 1998 онд хэвлүүлсэн судалгаандаа: “*Mergen süm-e-yin cham-un üy-e jerge-yi kerkijü bayiçayaqu temdeg biçig almas er(i)ke kemekiü*” эхтэй нь галиглан хэвлүүлжээ. Энэ зохиол бол гуравдугаар дүрийн Мэргэн гэгээний “Алмаз эрих” хэмээх цамын тухай бүтээл юм.

Одоогоор “Алмаз эрих” цамын судар нь XVIII зууны монгол цамын баттай эх сурвалж болж байна. Эл эх сурвалж, Л. Хүрэлбаатарын анх цамыг Эрдэнэ зуу хийдэд, 1786 онд хэрхэн дэглэсэн тухай²⁴ Аристотелийн он цагаар шалгах онолоор²⁵ авч үзэхэд Монголчуудын дунд Эрдэнэ зуу хийдэд цам дэлгэрэхээс 36 жилийн өмнө анх 1750 онд Урадын III Мэргэн гэгээн “Алмаз эрих” судартаа өөрийн хийдийн цамын тухай өгүүлсэн юм. Иймд 1750 онд Л. Лувсандамбийжалцан²⁶ цамын тухай монгол хэлээр бичсэн нь цамын түүх, хөгжил судалдаг эрдэмтэн судлаачдад чухал баримт, өв болж байна. Үүний дараа Эрдэнэ зууд

¹⁵ Werner, S. F. – Rintschen, B.: *Lamaistische Tanzmasken*, т. 61.

¹⁶ Heissig, Walther: *Die Mongolen. Ein Volk sucht seine Geschichte*. Econ Verlag, Düsseldorf 1979, т. 270.

¹⁷ Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 632.

¹⁸ Гангаа, Д.: *Хүрээ цам*, т. 18.

¹⁹ Heissig, W.: *Die Mongolen ...*, т. 241.

²⁰ Heissig, Walther: *Geschichte der mongolischen Literatur*. Otto Harrassowitz, Wiesbaden 1994.

²¹ ”Алмаз эрдэнийн эрих” хэмээх III Мэргэн гэгээний модон бар бичмэлийг Karénina Kollmar-Paulenz нь 2015 онд бичсэн бидний Цамын судалгаанд, *Rosenkranz aus Diamanten* хэмээн номын нэрийг Герман хэлрүү нь хөврүүлсэн билээ.

²² Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 625.

²³ Отгонбаатар, Р.: *Монгол модон барын номын эх гарчиг*. Токио 1998, т. 75–103.

²⁴ Хүрэлбаатар, Л.: *Судар шастурын билиг*. Улаанбаатар 2002, т. 299.

²⁵ Aristoteles: *Rhetorik*. (Reclam Universal-Bibliothek) Stuttgart 1999, т. 19.

²⁶ Отгонбаатар, Р.: *Монгол модон барын номын эх гарчиг*, т. 101. *Qorin qoyaduγar-tur; Mergen süm-e-yin 'cham-un üy-e jerge-yi kerkijü bayi*.

цам 1786 онд харайсны хожим хойно 1836 онд хамба номон хан буюу Хүрээний 12-р их хамба Агваанхайдав (1779–1838) Эрлэг номон ханы цам буюу Жахар цамын “Дансранжамцын гарчам” хэмээх номоо²⁷ бичжээ. Хүрээ цам ХХ зууны эхэн үе хүртэл өргөн дэлгэрч, цам харайхыг олон улсын эрдэмтэд ирж үзсэн тухай ЗХУ улсын эрдэмтэн А. М. Позднеев (1851–1920),²⁸ Н. Шастина (1898–1980)²⁹ нар судалгаандаа тэмдэглэжээ. Мөн Австрийн Ханз Ледер (1843–1921)³⁰ “Эрдэнэ зуугийн цам”, “Хүрээ цам”-ыг үзээд, нутгийн уран дархнаар цамын бурхдыг модоор сийлбэрлүүлж, Европ тивд авчирсан нь өнөөгийн олон улсын угсаатны зүйн музейд хадгалж байна.³¹

Зүүн хүрээ Дашчойлин хийдийн цамын бэлтгэл

Эрдэмтэн Б. Ренчин, В. Форман нарын 1967 онд Лайпциг хотноо хэвлүүлсэн, цамын тухай номонд “Хүрээ цам”-ын хурлын бэлтгэл ажил 1937 он хүртэл сар гаруйн өмнөөс эхлэдэг³² гэжээ. Үүнийг өнөөдөр Дашчойлин хийд мөн адил мөрдөх ба Хүрээ цамын бэлтгэлийг зуны эхэн сарын сүүлчээр эхлээд, зуны сүүл сарын 9-нд гадаалдаг. Улмаар олон жил завсарласны эцэст тус хийд хүрээ цамыг долоон жил бэлдэж, 2003 онд сэргээн харайсан байдаг.³³ Эл хугацааны бэлтгэл ажилд лам хувраг, ард иргэд ач тус нэмэртэй байсны дунд тус хийдийн ахмад лам Д. Дашдорж асан залуудаа Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хутагт ламын хийдэд шавилан, цамд харайж байсан туршлагатай тул³⁴ чухал үүргийг гүйцэтгэжээ. Бэлтгэл ажлын он жилүүдэд тэрбээр цамын хувцас хэрэглэлийг загвар хийцийг гаргах, хийдийн оёдолчин Б. Эвшинсүрэнгээр цамын

²⁷ Ngag dbang mkhas grub: *bsTsan bsrung rgya mtsho 'i gar 'chams gsal byed dam Idan snying gi me long zhes bya ba bzhungs so*. 1836. (Дансранжамцын гарчам номны товчлол Ү. Дашням 1980 он); Хүрэлбаатар, Л.: *Судар шастирын билиг*.

²⁸ Pozdneyev, Aleksei Matveevich: *Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia*. Ed. by John Richard Krueger. The Mongolia Society, Bloomington 1978.

²⁹ Шастина, Нина Павловна: *Цам журнал* Хозяйство Монголий № 26. Улаанбаатар 1928; Шастина, Нина Павловна: *Религиозная мистерия “Цам” в монастыре Дзун –хуре. Журнал Современная Монголия № 3*. Улаанбаатар 1935.

³⁰ Үүнийг Австри улсын Ханз Ледер судлаач Lang, Maria-Katharina – Bauer, Stefan (eds.): *The Mongolian Collections Retracing Hans Leder*. Austrian Academy of Sciences Press, Vienna 2013 хэмээх бүтээлээс мэдэж болно. Энэ модон сийлбэрүүд бол манай Монголын урчуудын гар урлалын нэгэн чухал бүтээлээс гадна цамын дахин сэргэлтэнд туслах түүхийн нэгэн баримт юм.

³¹ Teleki, Krisztina: *The Khüree-Tsam and its Relation with the Tsam Figures of the Leder Collections*. In: *The Mongolian Collections Retracing Hans Leder*. Ed by Maria-Katharina Lang and Stefan Bauer. Austrian Academy of Sciences Press, Vienna 2013, т. 76–83; Lang, M. – Bauer, S. (eds.): *The Mongolian Collections Retracing Hans Leder*.

³² Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 643.

³³ Дашчойлин хийдийн их гэсгүй Ц. Алтанхүүгийн 2007 оны “Дэлхийд гайхагдсан Монгол Цам” ярилцлага. 2009 оны 8 дугаар сарын 12-нд Д. Дашдорж гуайтай хийсэн ярилцлага бас лам Ц. Алтанхүүгийн 2007 оны “Дэлхийд гайхагдсан Монгол Цам” ярилцлага хоорондоо тохирч байна.

³⁴ 2009 оны 8 дугаар сарын 12-ын ярилцлагат оёдолчин Б. Эвшинсүрэн хамт байсан болно. 2008 оны 7 сарын 11-нд Зүүн хүрээ Дашчойлин хийд Хүрээ цам тайлбартаа 50 гаруй цам гарна гэж тэмдэглэсэн байна. Мөн Ц. Алтанхүү лам бас 2007 оны сонини ярилцлагтаа 50 гаруй цам гарч байгааг дурдсан байна.

хувцас чимэглэлийг урлуулах ажлыг тэрээр гардан хийжээ.²⁹ Унгарын монголч эрдэмтэн Майер Жужа, Телеки Кристина нар тус хийдийн цамыг бас судалсан бөгөөд тэд 2004 онд 40 лам, 2005 онд 53 лам цамд харайсан гэж тэмдэглэжээ.³⁵ Мөн 2007–2008 онд тус хийд 50 гаруй цамын баг бүтээж, 2009 онд 60 гаруй болж нэмэгджээ. 2016 онд есөн цамын багийг шинээр нэмсэн бөгөөд нийт 83 цамын багтай болсон. Мөн тус хийдийн цамын бэлтгэлд “хээрийн цам,” “гоё дэг” гэж лам нарын нэрлэсэн бэлтгэл хоёр цамыг дурдах нь зүйтэй.³⁶ Эдгээрийг 2009 оны хээрийн судалгаагаар баримтжуулан тэмдэглэж, тус судалгааны хэрэглэгдэхүүн болгосон.

Дотор цам

Цамын судалгаанд онцлон тэмдэглэх ёстой гол хэсэг бол дотор цам юм. Төвд, монгол эх сурвалжид дотор, гадаад цамын тухай, V Далай лам Бүжиг “*gar chams*”-г гарын дэгийг эрхэмлэснийг бүжиг, хөлийн байдлыг эрхэмлэснийг ая байдал, Эрдэнэ зуу хийдийн цамын номонд 1786 “бүжиг цам алинд ч биеийн ая байдал голлохоос гадна цамыг гадаад, дотоод нууцын бүжгээс ангид авч үзэж үл болох” тухай бичжээ.³⁷ Эдгээр тодорхойлолт нь хамба номон хан Агваанхайдавын 1836 онд бичсэн номонд харин ч илүү нарийвчлан “Бурхны хийх бүжиг, хүний харайх цам хоёрт харшлах зүйл ер үгүй хэмээн өгүүлжээ.”³⁸ Цамд гарч байгаа лам бүр бурхан сахиусны өмнөөс гарч буй учир, дотоод гадаад бэлтгэлийг сайн бүрдүүлж бясалгалыг хийж хамаг амьтныг муу үйлээс аврах, хэрэгтэйг хамба номон хан Агваанхайдав онцолжээ. Мөн эрдэмтэн Л. Хүрэлбаатар бүжиг цам хийгээд шашны тахил, бясалгалын зан үйл хоёрын холбоог цам гэж тайлбарласан.³⁹ Эдгээр тодорхойлолтоор Дашчойлин хийдийн дотор цамыг авч үзвэл, тус хийдийн дотор цам хойд дугандаа гардаг. Дотор цамын эхний өдөр Аргамба⁴⁰ ганцаар цамын өмсгөлтөйгөө дуган дотор бүжиглэхдээ гарын хөдөлгөөнөөр бурхадыг урин цамнах, шашны багаж зэвсгээр дохин бүжиглэдэг. Тэрээр зүүн, баруун хөлийн өлмий өсгийгөө ээлжлэн дэвслэх, хатгалах хөлийн хөдөлгөөнөөр шашны дайсан тотгорыг дарах цам харайдаг. Цамчин нь эргэх хөдөлгөөнөөр гартаа барьсан пүрэв, сэрээгээр ээлжлэн лянга эвдэх, хатгах, нум сумаар шашны дайсныг харвах зэрэг дөрвөн зүгийн муу муухайг номхотгох, бурхны шашны нууц тарнийн зан үйлийг гүйцээдэг. Түүнийг цамнах үед хийдийн хамба болон бусад лам нар хурал хурж, уншлага айлдахдаа хэнгэрэг, цан, дун, бишгүүр зэрэг хөгжмийн дуу гаргадаг. Дараагийн

³⁵ Majer, Zsuzsa – Teleki, Krisztina: *Reviving the Cam Dance Tradition in Mongolia*. (Traditional Mongolian Culture II.) Budapest 2014.

³⁶ Энэ тухай дэлгэрэнгүй судалгааг Mungunchimeg, Batmunkh: *Mongolischer Tsam-Tanz Geschichte, Entwicklung und Gegenwart*. Dissertation. Universität Wien 2010, т. 62–63; Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 655 үзнэ үү.

³⁷ Хүрэлбаатар, Л.: *Судар шастурын билэг*, т. 300.

³⁸ Ngag dbang mkhas grub: *bsTsan bsrung rgya mtsho 'i gar 'chams ...*, т. 3а5–b1.

³⁹ Хүрэлбаатар, Л.: *Монгол цам*, т. 76.

⁴⁰ Forman, Werner – Rintschen, Bjamba: *Lamaistische Tanzmasken*, т. 97. үзнэ үү.

өдөр Сэржимба, сүүлийн өдөр Цамын ноён Чамбон⁴¹ нар ганц ганцаар өмнөх хөдөлгөөн үндсэндээ адил цамнан лянга эвддэг.⁴² Харин тэдний гартаа барих шашны хэрэглэл өөр өөр байна.⁴³ Дашчойлин хийдийн дотор цамын гарын үндсэн авлага бол Агваанлуvsанхайдав хамба номон ханы “Шашны сахиусны далайн бүжиг цамыг гийгүүлэгч тангаргатны зүрхний толь” гэж тус хийдийн 2009 оны цамын Чамбон буюу цамын ноёнд гарсан Ц. Алтанхуяг лам, 2016 оны цамыг удирдсан Ц. Мөнх-Эрдэнэ лам нар өгүүлж байсан. Үүнийг лам дугандаа ганцаар цам харайдаг онцлогтой, дотоод нууц тарнийн бүжиг гэдэг утгаар дотор цам хэмээн нэрлэсэн байна.

Гадаа цам

Дашчойлин хийдийн Гадаа цам билгийн тооллын зуны сүүл сарын 8-ний өдрийн хурлыг шөнөжин хурж өглөө нь 9-нд хийдийн хурал гадаалаад өдөр нь хашаанд бүх цамчин, цамын баг чимэглэл хувцас цамд мөргөхөөр цугласан сүсэгтэн олны өмнө жинхэнэ цам гардаг. Энэ бол гадаа цам юм.

Гадаа цамын өмнө хийдийн хашааны хог шороог цэвэрлэж, хойд дуганы өмнөх зассан талбайд, тус хийдийн зураач лам цагаан шохойгоор долоон давхар тэгийг зурж, тойргийн гадуур дөрвөлжин хүрээ⁴⁴ татна. Ингэснээр цам харайх энэ талбай мандал болон хувирдаг гэж Д. Гангаа бичсэн бол энэ долоон тэгийн утгыг эрдэмтэн Б. Ренчин асан дээр дурдсан номонд тодорхой тайлбарласан.⁴⁵ Японы эрдэмтэн К. Аяако хуучин хүрээ цамын тэгийг мөн адил зурдаг тухай тэмдэглэснээс үзвэл Дашчойлин хийдийн тэгийг зурах арга бол цамын уламжлалт дэг юм.

Гадаа цам гарах дуганы хаалганы харалдаа бадамлянхуа цэцгийг ариун бүхнийг илтгэн 2009 онд зурсан бол 2016 онд дөрвөн очир зурсан нь их сүр хүчийг илтгэж байв. Хойд дуганы баруун, зүүн хоёр талд нэг нэг цэнхэр асар барьж, зүүн талын асарт тус хийдийн хамба, цорж, цогчин унзад болон цанчин, хэнгэрэгчин, бүрээчин нар, баруун талын асарт гадны зочид суудаг шийдэл тус онуудад адил хэвээр байсан. 2009 онд, Цагаан Дарь эх болон Манал бурхны хөргийг хийдийн хашаанд хойш харуулан дэлгэсэн байсан⁴⁶ бол 2016 онд, Цагаан Дарь эх, Очирваань бурхны хөргийг гол дуганы өөдөөс харуулан дэлгэсэн байлаа.⁴⁷ Мөргөлчдийн суудлыг 2009 оноос нэгэн жигд цэнхэр өнгөтэй,

⁴¹ Forman, W. – Rintschen, B.: *Lamaistische Tanzmasken*, т. 96. үзнэ үү.

⁴² Mungunchimeg, Batmunkh: *Mongolischer Tsam-Tanz ...*, т. 62–63; Majer, Zsuzsa: A cam tánc hagyományának felélesztése Mongóliában. *Kerékyomok*, 2008, т. 54; Nebesky-Wojkowitz, René De: *Tibetan Religious Dances*. Ed. by Christoph von Furer-Haimendorf. Paljor Publications, Delhi 2001, т. 108.

⁴³ Үүний талаар дэлгэрэнгүй мэдээллийг Mungunchimeg, Batmunkh: *Mongolischer Tsam-Tanz ...*, т. 62–63; Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 655.

⁴⁴ Кимүра Аяако: *Монголын хүрээ цамыг ...*, т. 20.

⁴⁵ Forman, W. – Rintschen, B.: *Lamaistische Tanzmasken*, т. 105. үзнэ үү.

⁴⁶ Mungunchimeg, B.: *Mongolischer Tsam-Tanz ...*, т. 66. үзнэ үү.

⁴⁷ Б. Мөнгөнчимэг, 2016 онд хийсэн веддио архиваас үзнэ үү.

2016 онд театрын мэт дээшээ ахисан шийдлээр илүү тухтай болгож байв. 2016 онд цамын бурхад гарч ирэх дуганы хаалганы өмнө шар хөшиг татаж, дуганы баруун, зүүн асар 2009 оны шийдэлтэй адил хэвээр байлаа.⁴⁸ Цамын тэгийн голын тойрогт нь шар өнгийн сүүдрэвч байрлуулдаг уламжлалт дэгтэй.⁴⁹ Хийдийн хашаанд дуганы гадаа цамын бэлтгэлийн үед дуган дотор лам нар цамд харайх өмсгөл зүйлт чимэг багаа өмсөн бэлдэнэ.

Гадаа цамын үед зүүн талын цэнхэр асарт суудлаа эзэлсэн цамын хөгжимчид хамгийн эхлээд цан цохиж, харанга, хэнгэрэг дэлдэн, бүрээ бишгүүр татдаг. 2009, 2016 онд дуганаас хоёр Хохимой буюу Дүртэддагба гаран, дуганы урд цамын тойргийн хойно урт улаан модоор газар дохин цамнаад, нилээн хугацааны дараа хамгийн гадна талын 7 дахь тэг татсан замаар цамнасан. Тэдний хувцас цагаан өнгөтэй цээживч, өмд дээр улаан судалтай арга ясыг загварласан, үүрэг нь шашны мөр замыг ариусгах бас цамын чойжингуудын цамнахад үхээрийн хаалгыг онгойлгох гэсэн утгатай, харайх дэвслэх хөдөлгөөнтэй. 2009, 2016 онд хоёр Хохимой цамнаж дуусаад, цам гарч байгаа дуганы хаалганы шар хөшигний хоёр талд байрлуулсан арслангийн баримлын хажууд харуул мэт улаан модоо барин, цам дуустал зогсож байсан.

Энэ хоёрын дараа 15-н зүг хамгаалагч буюу тугчин хүүхдүүд нар зөв талаас, өөр өөр өнгийн туг барин, цамын тэгийн гадуур дөрвөлжин хүрээний тодорхой зайнд эгнэн, барьсан туг далбаагаа газар хатган зогсоно. Зүг хамгаалагч нар цам болох талбайд муу юм оруулахгүй байх үүрэгтэй. 2009 онд, зүг хамгаалагчдад энгийн, лам биш хүүхдүүд бол 2016 онд голдуу лам хүүхдүүд туг барьж байв. Эдгээрийн дараа Жажар, Сор хоёрыг дуганаас гаргаж цамын голын тойрогт байрлуулдаг. Жажар бол төмөр балгас буюу Дамжанчойжалын орон хэмээн судлаачид үздэг. Эдгээрийг цамын үед салхи бороо болон цаг агаарын тааламжгүй нөхцөлөөс хамгаалахын тулд хажууд нь нэг лам сууж зохих судрыг уншдаг. 2009 онд Шава, Махи хоёр цамыг харайсны дараа сор жахарыг гаргаж байсан. Энэ нь цамын дэгийг нэг загварт бариж хашиж болохгүй онолд суурилсан юм. Сор жахартай хамт хоёр баатар гартаа урт мод барьсан хар хэрээнээс сорыг хамгаалахаар гарч ирж сорын хоёр талд зогсдог. Хар хэрээ, хоёр баатарт энгийн хүн гардаг ба цамд ирсэн мөргөлчдийг зугацуулах үүрэгтэй.

Шава Махи хоёр цамыг буцаж ороход, Хашин хаан хүүхдүүдээ дагуулан гарч ирдэг. Хашин хаан 2009 онд зургаан хүүхэдтэй, 2016 онд таван хүүхэдтэй гарсан. Хашин хаан урт том эрих хүзүүндээ зүүж шар хүрэмтэй гартаа хадагтай, том даалин уутандаа чихэр дүүргэсэн байдаг. Түүний хүүхдүүд том толгойтой, шар, бор өнгийн багтай, тэд дуганаас гарч, баруун талын асрын доор цамнахгүй, шууд сандал дээр суудаг. Хашин хаан догшин Чойжингуудыг цамнахаар гарч ирэхэд хадагтай угтаж, үдэж оруулах үүрэгтэй, өөрийнхөө том уутнаас мөргөлчид дунд чихэр хүртээдэг.

Дараагийн цам нь 2009 онд Гонгор, Намсрай хоёр цамнахаар гарч ирсэн. Намсрай таван шөвх үзүүртэй хохимойгүй, бүлтгэр нүдтэй багтай, зүүн гар-

⁴⁸ Mungunchimeg, B.: *Mongolischer Tsam-Tanz ...*, т. 70. үзнэ үү.

⁴⁹ Kollmar-Paulenz, K. – Mungunchimeg, B.: *Der mongolische Maskentanz ...*, т. 667.

таа эрдэнээр бөөлжигч хулгана, баруун гартаа шүхэртэй, гал шаргал өнгөтөй хувцастай, Гонгор улаан үстэй, том цагаан багын арлуу урт даавуун унжлагтай цагаан өнгийн хувцастай, нэг гартаа зэндмэнэ эрдэнийн бумба, нөгөөдөө чандманьтай. Энэ хоёр ард олонд эд баялаг түгээх үүрэгтэй.

Энэ хоёр цам 2016 онд 2009 онтой адилхан шийдэлтэй боловч дэс дараалал өөр цамнасан. 2016 онд шинээр олон цам нэмэгдэж гарсан нь агуулага болон дараалалыг их өөрчилсөн байсан. Үүнийг нарийвчлан авч үзвэл 2016 онд Хашин хаанаас өмнө улаан үстэй, хөх улаан хувцастай хоёр цам гарч ойролцоогоор 6 минут хамт цамнаад, ороход дахин хоёр цам улаан үстэй нэг нь цагаан шаргал, нөгөөх нь улаан багтай бас л ойролцоогоор 6 минут цамнана. Энэ хоёртой хамт нэг арслан гарч ирж цамын гадна талбайг тойрон цам харайхгүй толгойгоо дохин явах нь шашныг шүтэн дохиж байгааг илтгэнэ. Үүний дараагийн хоёр цам нэг нь эвэртэй нөгөө нь таван хохимойтой, хар хөх өнгийн багтай бас л ойролцоогоор 6 минут цамнаад буцаад ордог. Эдгээр цам нь Эрлэг номон хааны элч нар юм. Энэ хоёр цамын дараа Шава Махи хоёр цамнадаг. Тэр хоёрын дараа хоёр Азар цамнаад буцаад ороход, Цагаан өвгөн гарч ирж цамнаад хүмүүст хишгээ хүртээдэг. Цагаан өвгөний дараа дөрвөн цам бүгд таван хохимойтой гурван хар хөх нэг нь улаан багтай эдгээр нь ойролцоогоор 6 минут цамнаад тэд дараагийн гарч ирэх Чадраабалыг хүлээдэг тэрээр хар хөх багтай гавал барьсан. Эдгээр нь Чадраабалын нөхөд сэлт Гомбо буюу Махгалын тушаал биелүүлэгч тэд мөргөлчин олонд удахгүй Гомбо бурхан залрахыг мэдүүлж хамт цамнаад ордог.

Эдгээрийг буцаж ороход Гомбо гарч ирдэг. Эл бурхан хар бараан догшин багтай бас хүмүүний энэ явах нас ба зуурдын зовлонгоос хамгаалах амьтныг өрөвдөх нинжин сэтгэлд тусалж байх тангарагтай тэрээр ганцаар цамнаад ордог. Түүнийг ороход сая л Намсрай болон Гонгор гарч цамнана. Энэ хоёртой зөрөөд, улаан сахиус Жамсрангийн хоёр нөхөд Рэгвийлхамо, Лайхансродга нар бөгөөд нэг хохь бүхий титэмээр баг нь чимэгдсэн догшин дүртэй туг болон гавал гартаа барьсан тэднийг харайж дуусахад хөгжим сүртэй болон улаан сахиус буюу Жамсран бурхан заларч, цамнахад өмнөх хоёр цам нь хажууд нь хүлээн зогсдог. Жамсран сав ертөнц дайн дажинг дарах, дайны цэргийн сахиус. Жамсран бусад цамтай адил үсэрч харайх, эргэж тойрох хөдөлгөөнтэй, дахин давтаад байгаа мэт боловч хөдөлгөөн бүр шашны гүн утга, агуулгатай. Жамсран сахиусны дараа цамын ноён цамнаад түүний 20 шанаг уламжлал ёсоор хамт цам харайсан. Хөгжим жигд дуугарч, хэсэг хугацаа өнгөрсний дараа Замунди буюу Эрлэг номун хааны юм нь орой дээрээ очир чимэгтэй 5 хохимойтой хөх багтай, баруун гартаа гурван салаат сэрээтэй, зүүн гартаа гавалтай, түүний хормогч нь зааны яс мэт цагаан өнгийн гоёлтой тэрээр ганцаар нилээн удаан цамнадаг.

2016 онд Эрлэг номун хаан эврээ шар хөшигний завсраар хэд хэдэн удаа цухуйлган, олны анхаарлыг өөртөө татаж, цамын тайлбарлагч лам түүний залрах гэж буйг олонд зарлаж байв. Тэгээд Эрлэг номун хаан заларч тэргүүндээ таван хохимойгоор чимсэн том эвэртэй бухын толгойт хар хөх багтай, баруун гартаа жижиг хүн толгойтой, хүн дүртэй шор, зүүн гартаа урт цалам барин,

чагжаа хийж хэсэг хугацаанд удаан цамнаад, Замундитэй хамтаар үргэлжлүүлэн цамын тойргийн хойно цамнаж байсан бол сүүлдээ хамгийн гадна тойрогт энэ хоёр үргэлжлүүлэн тойрон цамнахад бусад цамууд дуганаас цувран нэгэн тойрог болж цамнасан. Энэ нь цамын онолд заасан хөдөлгөөн дэгийг нэг загварт барилгүй илүү баяжуулсан сонирхолтой шийдэл байсан.

2009 онд нилээн өөр байсаныг энд авч үзье. 2009 онд Жамсран цам харайгаад Охин тэнгэр буюу Балданлхам бөгөөд энэ нь толгойдоо тогосны өдөн гоёлтой таван хохимой чимэгтэй хар хөх багтай энэ ертөнцийн амьтан бүгдийг энэ яваа насанд нь бүхэл аюул өвчин зовлонгоос аврах тангарагтай гэдэг тэрээр ганцаар цамнаж дуусаад дараагийн цам Гомбыг хүлээдэг. Энэ нь Махгал буюу Гомбо гарч ирээд Балданлхам сахиусны баруун гар талд цамнадаг энэ хоёр хамтдаа буцан ороход, хоёр Азар гарч ирдэг. Энэ хоёр Азар толгойдоо энэтхэг маягийн улаан шаргал хоёр өнгийн багтай, ээмэг нь урт өтгөн, хууз сахалтай, гартаа шидэт мод барьсан тэдний бүжиг харьцангуй удаан. Эдгээр Азрууд цамнаж дуусаад, дугандаа орохгүй, Цагаан өвгөнийг гарч ирэхэд тосдог. Цагаан өвгөн хүмүүст урт нас, өлзий хишиг оршоох бэлгэдэлтэй. Тэрээр цан хөгжмийн аяанд хэдэнтэй найган бүжээд, арвай будаа баруун гараараа өргөн цацаад, тойргийн зүүн талд зассан хивсэнд дээр хажуулдан хэвтэх хүртэл хоёр Азар түүний ойрхон байдаг. Түүнийг хивсэн дээр хажуулдан унтахад, Хашин хааны нэг хүүхэд түүний чихэнд ойр цан цохин сэрээдэг. Цагаан өвгөн цочин сэрж, түүний дээлийн хормойноос татан өвөр дээрээ авч, өөрийн том ноосон малгайг толгойд нь углаж, түүнийг дагуулан, Хашин хаанд очиж, тэврэн золгодог. Тэгээд Цагаан өвгөн Хашин хааны хүүхдүүдийн толгойг адислаад хоёр Азарыг сугадан, нар буруу цамын тойргийн гадуур явж, дуганаас богцтой чихэр гарган мөргөлчид болон хүүхдүүдэд тараах ба энэ зуурт цам хэсэг завсарладаг.

Үүний дараа хөгжим сүртэй дуугарч, цамын ноён буюу Чамбон гарч ирэх ба цамын хоймор дуганы шар хөшигний өмнө, цамын тойргийн хойд хэсэгт цамнадаг. Тэрээр малгайн орой дээр таван хохимойн чимэглэлтэй хар малгайтай бөгөөд түүний нүүр баггүй харин хамрын үзүүр хоёр хацарт хар хөөгөөр мэнгэ мэтээр түрхсэн байдаг нэг гартаа гавлын яс мэт аяга түүн дотор нь улаан өнгийн зүрхтэй нөгөө гартаа урт очиртой энэ хоёрт таван өнгийн хадаг зүүлттэй. Тэрбээр уран нум сумаар харвах, эргэлдэн хөлөөр хатгах, гараар даллах, дэвэх мэтээр удаан хөдөлгөөнөөр цамнаж, баруун тал руу цамын гадна тойрогт харайхад, дуганаас бусад 20 шанаг нар түүнийг даган шанаг буюу 7-р тойрогт цамнацгаана. Нийт цамын ноёнттой, 21 болон чамбон, аргамба, сэржимба гурав нь таван хохимой чимэгтэй хар малгайтай бусад шанагууд нэг л хохимойтой хар малгайтай шанагууд цамнах ба эдгээр нь Ямандага бурхны нөхөд сэлт гэдэг хөдөлгөөн ижил хувцас нь өнгөөрөө л өөр Эдгээрийн цам хамгийн гадна талын эрдэмтэн Б. Ренчингийн тэмдэглэсэн шанаг тэгт харайдаг. 21 шанагийн цам их удаан бөгөөд цамнаж дуусаад дор бүрээ сандал дээр суун хэсэг амарч дараагийн цамыг хүлээнэ.

Хөгжим жигд дуугарч, хэсэг хугацаа өнгөрсний дараа орой дээрээ очир чимэгтэй Замунди буюу Эрлэг номун хааны юм нь 5 хохимойтой хөх багтай бас баруун гартаа гурван салаат сэрээтэй, зүүн гартаа гавалтай, түүний хормогч

нь зааны яс мэт цагаан өнгийн гоёлтой тэрээр ганцаар нилээн удаан цамнадаг. Энэ үед түүнд Хашин хаан хадаг барин золгоод хадгаа түүний энгэрт зүүдэг тэрээр цамнасаар л бас Цагаан өвгөн, Азрууд мөргөлчдийн өмнүүр чихэр тараан тойрон явна. Энэ 2009 оны цамын төгсгөлд Эрлэг номун хаан заларч хэсэг хугацаанд удаан цамнахад Хашин хаан хадаг барин ирж түүнд мөргөдөг. Эрлэг номун хааны үүрэг нь хүмүүний хийсэн үйлийн үрийг үнэн зөвийг ялгах, хорлох муу сэтгэлийг дарах бөгөөд төгсгөлд нь Замундитай хамт цамнаж дуусаад баруун асарын өмнө маягтай, тэр хоёр зогсон өмнө нь харайсан 21 Шанаг суудлаас босон өөр бүх өмнө нь гарсан цамууд дахин бүгдээр цамнана.

Ингээд цамын ноён дахин шашны нарийн ёслол үйлдэн цамнахдаа баруун гартаа том зэсэн цөгцтэй сэржим барин хөдөлгөөнөө өмнөхтэй адил хийхэд зүүн асраас Цорж Унзад лам нар хөгжмийн аяанд тохируулан аяаг эгшиглүүлэн, хөлийн хөдөлгөөний тоог төвд хэлээр даган давтан дуулах мэт түрдэг. Түүний хөлийн хөдөлгөөн дайсны орныг өчүүхэн дэвслэх дөрвөн зүгийн муу муухайг дарах бадамлянхуан эргэлтийг хийгээд сэржмээ өргөхөд туслах лам ирж цөгцийг аваад тэр хооронд дахин бусад шанагтай нэгэн жигд хөдөлгөөн хийгээд дуусахад дахин нөгөө туслах лам цөгцийг авч ирж цамын ноёнд өгөөд тэрээр дахин ганцаар цамнана. Энэ хооронд нөгөө Эрлэг номун хаан болон Замунди нар сандал дээр суун амардаг. Харин цамын ноён үргэлжлүүлэн ганцаар цамнаад нөгөө цөгцтэй сэржимийг өргөдөг дахин цамнахад шанагууд дагалдан цамнадаг. Тэд зүүн хөлийн өлмий өсгий дээр эргэлдэн харайна. Үүний дараа цамын ноён дахин цөгцтэй хөдөлгөөнийг гурваас найман удаа давтан хийдэг бөгөөд энэ дээр дурдсан эрдэмтэн Л. Хүрэлбаатарын цамын онолын номонд тодорхойлогдсон байдаг.⁵⁰ Энэ цамын ноён буюу Чамбон ойролцоогоор нэг цаг гаруй гоцлон олон төрлийн цамын хэрэглэлтэй цамнахад, түүний 20 шанаг дахилтанд хамт харайлт 2009 онд хийсэн бол 2016 онд 21 шанагууд суугаад бусад цамууд нь төгсгөлдөө удаан цамнасан.

Үүний дараа хийдийн хашааны гадаа бүх цамчид, мөргөлчид бэлдсэн талбайд сор залж ирэхийг хүлээнэ. Ингээд хэдэн лам нар сорыг залж, сорын араас жахарыг 2009 онд жандагууд нь өргөн дамжилж ирсэн бол, 2016 онд лам нар өөрснөө хийдийн хашаанаас өргөж гал руу хийн шатаасан. Ингэхэд хамгийн эхэнд тус хийдийн Цорж лам, Хамба лам нар хамт явж, хөгжимчин лам нар дагалдсан. Цорж лам тарнийн хатуу ёсны уншлага уншин Жахарыг толгой дээгүүрээ гурав эргүүлээд галд хаядаг. Сүсэгтэн олон үүнтэй зэрэгцэн цаасан дээр хүслээ бичсэн зүйлээ гал руу хийн шатааж, гадаа цам өндөрлөдөг.

Дашчойлин хийдийн 2009 он, 2016 оны хоёр цамын хувцас, утга бэлгэдэл, засал арга зэргийг харьцуулахад нийтлэг, өвөрмөц ялгаатай зүйлс олон байна. Эндээс үзэхэд тус хийд цамын хөдөлгөөн, засал дэгийг нэг хэв загварт баригдахгүй, цаг үеийн онцлог, хөгжил дэлгэрлийг цамын онолтой нийцүүлэн бэлгэдэж, цам харайлгаж байна. Мөн 2016 оны цам Улсын баяр наадамтай давхцахад цамыг үзэх мөргөлчдийн тоо нэмэгдэгдэж, нас залуужсан, 2009 онтой харьцуулахад олон улсын зочид цамыг олноор үздэг болсон байв.

⁵⁰ Хүрэлбаатар, Л.: *Судар шастирын билиг*, т. 309.

Баруун талын зассан цэнхэр асарт Канад, АНУ, Энэтхэгийн элчин сайдын яамдаас ирсэн дипломат төлөөлөгчид 2016 онд ирсэн бөгөөд тус яамныхан хийдийн цамд тогтмол ирдэг хэмээн Ц. Мөнх-Эрдэнэ лам өгүүлсэн.⁵¹ Цамыг сонирхох, даган баясах сүсэгтэн хүмүүсийн тоо нэмэгдэж байна. Хүрээ цамыг 2016 онд дэглэхдээ, цамыг монгол, англиар тайлбарлаж, цам эхлэхийн өмнө цамд гардаг бурхадын тухай давтамжтайгаар англиар тайлбарлаж Монголчууд, гадаадын иргэд, жуулчид цамыг ойлгоход дөхөмтөй болгож байв. Бас 2016 онд дөрвөн уулын эздийг шинээр гаргасан ба дөрвөн уулын эзэд цам харайхгүй зүгээр л тус тусын уулынхаа харалдаа зогсдог. Энэ нь нийслэлчүүдэд хотын онцлог уламжлалыг таниулан өгч байна.

Дүгнэлт

Бясалгал хийсэн лам нарын оюуны ертөнцийн оньсон түлхүүрийн ачаар улс орон, ард түмний сайн сайхны төлөө ядам бурхдыг энэ ертөнцөд урин залж, хүмүүст урт насыг бэлгэдэн, бурхдын баг, гар хөлийн хөдөлгөөнөөр муу үйлийг дарах шашны нууц тарнийн ёс бол цам хэмээн эрдэмтэн Б. Ренчин, Л. Хүрэлбаатар, В. Хайссиг, түүний багш Р. Блейхштейнер, Японы Кимура Аяако нар ижил төстэй дүгнэлтийг өгсөн байдаг. Б. Ренчингийн Хүрээ цамын судалгаан дээр тулгуурлан эрдэмтэн Л. Хүрэлбаатарын “Эрдэнэ зуу цамын судалгаа” Д. Гангаа “Хүрээ цам” мөн Япон улсын эрдэмтэн Кимура Аяакогийн “Монгол цамыг бусад орны цамтай харьцуулсан судалгаа” болон, Унгарын монголч эрдэмтэд Майер Жужа, Телеки Кристина нарын монгол цамын бүтээлүүд, Польшийн монголч эрдэмтэн Агата Барея-Старжинска, хамба лам Х. Баасансүрэнгийн “Энх тунх Эрдэнэ зуу” зэрэг бүтээлүүд цаашдын судлагдахуун арвин байна.

Монгол улс ардчилсан нийгэмд шилжсэний дараа, 2003 оноос Зүүн хүрээ Дашчойлин хийд Хүрээ цамыг сэргээх, олон түмэнд зориулан нийтийн төлөө хийж буй засал гүрэм юм. Тус хийдийн удирдлага, лам нарын уйгагүй хөдөлмөрийн үр дүнд бидний мартаж дөхсөн соёл, бурхны ёс заншил, цамын бүжиг сэргэн, бидний болон дараа дараагийн үеийхэн уламжлалт тахил шүтээн сахиусаа танин мэдэж, Хүрээ цам хэмээх соёлын өвийг XXI зуунд таниулж байна.

Abstract

Mongolian *Tsam* Dance with Special Focus on the Historical Development of the Masked Ritual Dance and the *Khüree Tsam* Dance in Dsüün Khüree Dashchoilin Monastery: Since the early 2000s the Mongolian Buddhist masked ritual dance called *Tsam* in Mongolian language has been re-introducing into the Mongolian religious field. This paper examines the Mongolian masked dance in its historical and con-

⁵¹ 2016 оны 8 дугаар сард Ц. Мөнх-Эрдэнэ ламтай хийсэн ярилцлага.

temporary aspects, with a special focus on the *Khüree tsam* in the Dsüün Khüree Dashchoilin Monastery situated in Ulaanbaatar. The article provides an overview of the Mongolian origin and historical development of the masked ritual dance. Furthermore, it is also an ethnographic study of the *Tsam* performance in Dashchoilin Monastery providing a comparative study of its dances of 2009 and 2016 and its development during this period.

Ном зүй

ЭХ СУРВАЛЖ

Ngag dbang mkhas grub: *bsTsan bsrung rgya mtsho'i gar 'chams gsal byed dam Idan snying gi me long zhes bya ba bzhugs so* [Агваанхайдав: Шашны сахиусны далайн бүжиг цамыг гийгүүлж тангаргатны зүрхний толь]. 1836, гар бичмэл. Б. Дарамбазар ламын хувийн архив.

СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ

- Aristoteles: *Rhetorik*. (Reclam Universal-Bibliothek) Stuttgart 1999.
- Баасансүрэн, Х.: *Энх тунх эрдэнэ зуу*. Улаанбаатар 2011.
- Баатарбилэг, Ё.: *Архангай аймаг*. Улаанбаатар 2007.
- Bareja-Starzyńska, Agata: *Description of the Erdene Zuu Monastery Life (Including Čam Ritual). Based on Notes from the Kotwicz Expedition*. Polish Academy of Arts and Sciences, Warsaw 2012.
- Bareja-Starzyńska, Agata: The Reincarnation Lineage of Zaya Gegeen. In: *History, Architecture and Restoration of Zaya Gegeenii Khüree Monastery in Mongolia*. Ed. by Isabelle Charleux. Monaco 2016.
- Bleichsteiner, Robert: *Die Gelbe Kirche*. Verlag Josef Belf, Wien 1937.
- Werner, S. Forman – Rintschen, Bjamba: *Lamaistische Tanzmasken (Der Erlik-Tsam in der Mongolei)*. Koehler & Amelang, Leipzig 1967.
- Гангаа, Д.: *Хүрээ цам*. Улаанбаатар 2003.
- Дэлгэржаргал, П. – Нямдорж, С. – Батдорж, С. – Лхагвабаяр, В. (эмх.): *Их хүрээний гучин аймаг. Баримт бичгийн эмхэтгэл (1651–1938 он)*. Мөнхийн үсэг ХХК, Улаанбаатар 2015.
- Жамц, Г.: *Нэн тод гэрэлт Зая Бандида*. Улаанбаатар 2017.
- Кимүра Аяако: *Монголын хүрээ цамыг бусад орны цамтай харьцуулан судалсан нь*. Түүхийн ухааны докторын зэрэг горилж бичсэн ганц сэдэвт зохиол. Улаанбаатар 1997.
2. Налжирмаагийн мөн чанараар явах нь: Пад хэмээгээд өөрөө Налжирмаагийн мөн чанарт төрөөд, оройдоо лам гурван эрдэнийг үүл мэт бүрхүүлээд, зүүндээ дагинасын чуулган нугуудыг шуугиулаад, хойд талдаа номыг тэтгэгч сахиусын чуулганаар хүрээлүүлээд, замын зүүн талаар дарсанчлан агаар-

аар одох. Хоосон чанарын билгүүний мэлмийгээр үзээд зам зуурын тэнгэр чөтгөрийг өөртөө хураан, бүгдийг бодийн мөрд байгуулан одох болой.

Жодын лүн, ван

Ер нь жодын номын тайлбарыг эрх аваад ёсчлон бүтээгээгүй хүнд номлож болохгүй. Нууц тарнийн тарний дээд удвис номлол зөвхөн чихнээс чихэнд дамждаг ёстой байсан нарийн номлол юм.

Өнөө цагт хүмүүс “Жод лүйжин”-гийн номыг их сонин содон гээд сонирхоод байна. Тийм болохоор зөв ойлголттой байж учрыг нь сайн мэдэж байгаад үзэж судлан сонирхоод зогсохгүй өөрсдийн муу сэтгэлийн хорлол болон дөрвөн их шуламаа дарахын төлөө зөвөөр, сайн бүтээгээсэй гэсэндээ “Жод лүйжин”-гийн зан үйлийн тухай өөрийхөө сонссоноо товчхон тайлбарлахад “Жод лүйжин”-гийн номын эрх (ван) нь нийтийн Огторгуйн үүд нээх болон нийт бусын Огторгуйн үүд нээх гэсэн хоёр төрөлд хуваагддаг. Нийтийн ванг авсан байхад бүх ёсны “Лүйжин”-гийн номыг уншиж, сонсож, судлаж, бүтээж, бясалгаж болно. Үүнд: Гэлүгва, Нимава, Гаржүдва, Сажав мөн Жононба, гэхдээ өөр өөрсдийнхөө дамжлагын багш, лам нарынхаа өөрсдийнх нь дамжуулж ирсэн ном номлолоор унших ном нь өөр өөр байж болно.

“Жод лүйжин”-гийн эрхийг авсан төдийгөөр сурна гэхэд бэрх юм. Ханд Хажидаас дамжуулсан ая дан (эгшиг дуулал) болон хонх дамрын цохилтын дэг жаяг учир утга их чухал байдаг. Тэдгээр нь ямар утга учиртай, яагаад гадагшаа дотогшоо цохих, хэрхэн тасалдаг гээд олон ёс, зан үйл бий.

Ван аваагүй хүмүүст нарийн зүйлийг ярих боломжгүй. Ялангуяа нийт бусын ван аваагүй үед “Ханд нинжүд” (тө. *mKha' 'gro snyan brgyud*) буюу Мажиг рин-бочэгийн багшийн егүзэр болох “Нирвааны гүнзгий зам” буюу “Шива ламсав” (тө. *Zhi ba lam zab*)⁵ гэх номыг үзэж болохгүй, дагаж дуурайн ая данг нь ч сурч болохгүй гэж үздэг. Энэ ном бол “Гүрү ёго” Ламын налжор (тө. *bla ma'i rnal 'byor*), хандын гүн гүнзгий бясалгалын дээд удвис юм.

Ерөнхий зүйл ярихад “Жод лүйжин” гэдэг нь мунхагийн харанхуйг тасалж, хоосон чанарыг илт оноосон билгүүнээр энэ биеийг тэнгэр, чөтгөр алийг нь ч ялгалгүй өглөгт өгөх ёсон юм. Энэ үйлдэл нь бурхны сургаалын хоёр чуулган (буяны чуулган, билгүүний чуулган)-ыг хослуулан хураах гайхамшигтай бясалгалын нууц дээд удвис. Тийм болохоор бид эхлээд бодь сэтгэл, хоосон чанарын тухай номлолыг үзэж, судлах хэрэгтэй. Бурханы гүн ухааны таван ботиос ядаж хоёр ботийг нь завал сонсож судалсан байх хэрэгтэй. Үүнд, Парчин (тө. *phar phyin*) буюу “Чандад хүрэхүй судар” Ум (тө. *dbu ma*) буюу “Төв үзлийн номлол” (энэ хоёрыг хувь хүн өөрийнхөө чадлын хэрээр судалж үзэж сонсох хэрэгтэй). Ийм нарийн нууц удвисыг бид сонирхох нь зүйн хэрэг. Гэхдээ өөртөө тус хэргийг нь авахыг хүсвэл ёсчлон бүтээх нь гол юм. Өөрт болон бусдад энэ номны

⁵ Тө. *Ma cig mkha' 'gro snyan brgyud zab ma rgyun gyi rnal 'byor bder bkod pa zhes bza ba bzhugs so.*

ач тусыг хүргэхийн тухайд зан үйл, дэг жаяг, анхааран авлагыг хувь хүн өөрийн чадлаар зөв зохистой хийж бүтээх хэрэгтэй.

Миний зайвий Лам IX Богдын тухайд олон шавь нартаа “Жод лүйжин”-гийн ванг харамгүй хайрласан. Багш маань нас өндөр болсон ч “Ханд Нинжүд”-ийн эрхийг бараг тасрах гээд байсан болохоор олон шавь нараа ялгалгүйгээр зааж үлдээсэн. Энэ нь ч бас хэргийн тухайд байсан юм. Бид нар нь ван (тө. *dbang*) буюу эрх авснаар номоо үзэх боломжтой гэж болгоосон. Миний хувьд ламынхаа дэргэд арван жил тасралтгүй хамт байсан. Цаг ямагт ном айлдах, ван хайрлах болгонд нь дахин дахин сонсож дахин дахин авсан хувьтай хүн билээ. Мөн өөрийнхөө хэмжээнд чойрын гурван богийг Энэтхэгийн Дарамсалагийн “Цанид” (тө. *mtshan nyid*) сургуульд Цадма (тө. *tshad ma*) буюу Шалгадаг ухаан, Парчин буюу Билиг барамид, Умава буюу Төв үзлийн ухаан зэрэг номуудыг арван жилийн хугацаанд сонсож судалсан. Ийм сайхан хувь тохиолоор судрын, тарнийн номыг олонтаа сонсон хөтлүүлээд тэр дундаас “Жод лүйжин”-гийн номлолыг IX Богдоос дэлгэр сайхан хөтлүүлж авсан хувьтай нэгэн билээ. Одоогоор аль чадлаараа л бодож, бясалгаж, уншиж байгаа хэдий ч тийм амар бүтэхгүй их хичээл зүтгэл буян шаардах нь ойлгомжтой юм.

Жүдийн дамжлага нь

Ингээд дамжлагыг тодорхой тайлбарлавал:

Бурхан багш *སྟོན་པ་སངས་རྒྱས་*, Жэвзүн Жамъяан *ཇི་བཙུན་འཇམ་དབྱངས་*,
Арьяа-дэва *ལྷ་ཏུ་དེ་བ་*, Падамба *པ་གཅིག་དམ་པ་*. Энэ нь эцгийн дамжлага *པ་རྒྱུད་*
ཐབས་ཀྱི་བརྒྱུད་པའི་སླ་མ་.

Юүм чинбо *ཡམ་ཆེན་ཤེར་སྲིན་*, Жэвзүндулма *ཇི་བཙུན་སྟོན་པ་*,
Сухасиди *སུ་ལ་སི་རྩི་*, Мажиглавдонма *མ་གཅིག་ལབ་སྟོན་མ་*. Энэ нь эхийн дамжлага
མ་རྒྱུད་ཤེས་རབ་བརྒྱུད་པའི་སླ་མ་.

Энэ нь холын дамжлага болой.

Бурхан багш *སྟོན་པ་སངས་རྒྱས་*, Жэвзүн Жамба *ཇི་བཙུན་བྲམས་པ་*, Пагба Тогмэд
འཕགས་པ་ཐོགས་མེད་, Ловон Игнен *དབྱིག་གཉེན་སོགས་*. Энэ нь бурхны хөвгүүдийн
дамжлага *སྲས་རྒྱུད་རྩང་འཕྲུག་བརྒྱུད་པའི་སླ་མ་*.

Хамгийн гол нь болох ойрын дамжлага нь:

Доржчан *རྡོ་རྗེ་འཆང་*, Жэвзүн Жамъяан *ཇི་བཙུན་འཇམ་དབྱངས་*, Бавудорж *དབའ་འཕོ་*
རྡོ་རྗེ་, Богд лам Лувсандагва *སྟོན་བཟང་གྲགས་པ་* тэргүүтэй ойрын дамжлагын багш
нар *ཉེ་བརྒྱུད་བྱིན་རྒྱལ་བ་བརྒྱུད་པའི་སླ་མ་*)

Жамбалжамц *འཇམ་དཔལ་རྒྱ་མཚོ་*, Васачойжин *བ་སོ་ཚོས་རྒྱན་*,

- 3. 'མན་ངག་ཟབ་མོ་བདུད་ཀྱི་གཅོད་ལུལ་སྐྱོན་ཐོག་གཅིག་མའི་གཞུང་རྗེ་སློན་ལམ་མཐའ་ཡས་རྒྱ་མཚོས་མཛད་པ་བཞུགས་སོ།

Лам Ханд Дагинастаа мөргөмүй. Бурханы зарлиг номлол билгүүний чинадад хүрэхийн таалал, Лам бүтээлийг олсон нугуудын амны увдис, гүнзгий увдис шулмын таслах орон хувь төгөлдөр нугуудын номхотгох үйлтэнгүүдийн орон догшин ширүүн газар нэг суурин дээр анхааран авахын дараалал багтаагүй нь үгүй дор хураангуйлан хураахын ёсоор өгүүлэн үйлдэх болой. 1. Сэтгэл итгэмжлэхийн орон ариуны тухайд дамжлагын товч түүхийг өгүүлэх хийгээд, 2. Дамжлага түүнээс гарах увдисыг бодитой өгүүлэх болой.

- 4. 'བར་པ་གྲུ་ཚང་གི་གཅོད་ཁིད་སྐལ་ལྷན་འབྲུག་དོགས་ཞེས་བྱ་བ་ཐུན་མོང་མིན་པ་གྲུབ་མཐའ་གཞན་ལ་གསང་བ་མན་ངག་གི་སློང་བཞུགས་སོ།

Энэ гүнзгий “жод”-ын увдисыг анхааран авлага хийхийн ёсонд хоёр: Увдис бодитойд мөн хоёр: 1. Урьд одуулах дараалал, 2. Бодит суурийн дараалал. Анханд нь мөн дөрөв: 1. Шашинд орохын үүд аврал одуулахын тайлбар, 2. Их хөлгөнд орохын үүд, бодь сэтгэл төрүүлэх (үүсгэх)-ийн тайлбар, 3. Хоёр чуулганыг хурааж үйлдэх ламын егүзэрийн тайлбар. 4. Хоёр түйтгэрийг арилгаж үйлдэх “А” үсгийн рашааны угаалгын тайлбар. Маш тодорхой тайлбарласан байгаа.

- 5. 'སློབ་དཔོན་འཇམ་དབལ་བཤེས་གཉེན་གྱི་མཛད་པའི་གཅོད་ཁིད་སྐལ་ལྷན་འབྲུག་དོགས་རྒྱུང་བ་བཞུགས་སོ།

Энэ тайлбарт жод анхааран авах орон, цаг, тэр газрын аймшигт амьтадыг яаж хураах тухай маш тодорхой байна. “Жод”-ын тайлбар болгон хэдий тайлбарлах ном нь адил нэг ном боловч лам бүрийн өөрийнх нь үндсэнд буусан боловсрол бүхэн аль нэгэн бясалгалаараа адилгүй болохоор тус тусдаа онцлогтойгоор тайлбарласан байгаа. Би энд номын утгыг тодорхой бичиж тайлбарлаж чадахгүй нэгэн өчүүхэн шавь, мөн тэр болгон бичиж тоочиж болохгүй, ном болгоны нэрний дараа жод сонирхож буй болон анхааран авлага болгодог хэн бүхэн эдгээр тайлбар номыг уншиж судалж үзээрэй гэсэндээ ерөнхий зүйлийг давтахгүйгээр товчхон бичлээ. “Жод”-ын тайлбар маш олон, энд номных нь нэрсийг бичээд л орхих санаатай. Эдгээр тайлбар номнууд зөвхөн Гэлүгвын “Жод”-ын л тайлбар номнууд юм.

- 6. 'གཅོད་གདམས་ངག་སྤུལ་བྱུང་གསེར་གྱི་ཕྱིང་བ་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།
- 7. 'རྒྱལ་བ་དགེ་འདུན་རྒྱ་མཚོའི་གསུང་འབྲུམ་ལས་གཅོད་བརྟུང་འདེབས་སོགས་བཞུགས་སོ།
- 8. 'གཅོད་ཀྱི་རྩ་ཚིག་མདོར་བརྟུས་པ་བཞུགས་སོ།
- 9. 'གཅོད་ཀྱི་གདམས་བཤམ་འདོད་ཀྱི་དེད་དཔོན་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།

Энэ номын лүнг IX Богд Жамбалнамдолчойжижанцан Ламаасаа хүртсэн. Энд хүртсэн лүн, номнуудаа тухайлан бичлээ. Учир нь аливаа нэгэн номын

лүн (эшлэл), ван (эрх), тид (тайлбар хөтөлбөр)-ийг дамжлага тасраагүйгээр авч байвал тухайн номыг үзэх, судлах болон анхааран авлага хийхэд адистид жинлав нь буудаг гайхамшигтай.

10. **ཐབས་ཤེས་བྱང་འབྲེལ་གྱི་རྣམ་འབྱོར་ཟབ་མོ་གཅོད་མན་ངག་དང་ནམ་མཁའ་སྐོ་འབྲེད་གྱི་
དབང་བཤད་ཟིན་ཐོར་བཀོད་པ་བཅས་བཞུགས་སོ།**
 11. **གཅོད་གྱི་གདམས་པ་གདན་ཐོག་གཅིག་ཏུ་རིལ་ནས་ཉམས་སུ་ལེན་ཚུལ་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།**
 12. **རྗེ་བཙུན་མཁའ་སྐྱོད་དབང་མོ་ལ་བརྟེན་པའི་གཅོད་ཚོགས་མཁའ་སྐྱོད་གྲུབ་པའི་དགའ་
སྟོན་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།**
- хайрласан.
13. **གཅོད་གཞུང་ཐར་འདོད་དེ་དཔོན་མའི་ཚིག་དོན་གསལ་ཚིག་དོན་གསལ་བར་སྟོན་པའི་ཉམས་
ལེན་གསལ་བའི་སྟོན་མེ་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།**

Энэ ном Жалба-Инсава буюу Банчин-Чойжижанцангийн айлдвар юм.

Хавсралт

Гадаад дотоодын зургаан ад, эцэг эх энэ найм нь язгуурын найман итгэл мөн тул найман зочид үүгээр голлон гурван орны хамаг амьтад орчлон нийтийн зовлон ялангуяа гурван муу заяатны зовлон өвөрмөц дор ч амьтан тус тусын нарийхан зовлон алинаар энэлсэн ба бас ч зовлон ч даяараас гэтэлгэн дээргүй бодь хутагт байгуулахын тулд би бурхны хутгийг олж үйлдсүгэй, түүний тулд би махамудрагийн зод шулмыг тасалдаг орныг бясалгаж үйлдэх бөгөөд биеийн тахил өглөгийн зэрэгт орж үйлдэе хэмээн санаж өөр ямагтын тусын хир үсний үзүүрийн төдий ч үл үйлдэн бусдын тусын ямагтын оюун нийт бус нэгэн шуудаар эс төрөх хүртэл оюун судлах бөгөөд дахин дахин сэтгэлийг үүсгэтүгэй. Тэр мэтийн оюун эс төрөхийг хүртэл сэтгэл үүсгэлтийг дахин дахин бясалгаж үйлдэх ба тэндээс сэтгэлийн үүсгэлэн хатуу нэгэн лавтай шууд төрөх лүгээ бодь сэтгэлийн санааг үл замхруулахын агаарт бүх гэгээн сансрын бүднэр бүгдээрийг өөрийн өмнө хурааснаас тэдгээрийг орчлонгийн зовлонгоос аврахын тулд үнэнхүү тэнгэр чухаг дээд гуравт итгэл явуулсугай хэмээхээр сүслэхийн сэтгэл үүсгэтүгэй. Тэр ч үнэхээр туулсан бурхан бээр үнэнхүү утганы туйлын авралын орон мөний тул тэр мэтийн үнэнхүү чухаг дээд гуравт итгэл явуулваас орчлонгийн зовлон даяараас магадгаяа аварч чадмой.

Түүнд итгэл явуулахын ялгаварт ч бүднэр догшин хүн бус тэргүүтэн амьтдыг өөрийн өмнө хураан үнэнхүү чухаг дээд гуравт итгэл явуулсугай хэмээн санаж анхан Пад хэмээн гурвантаа өгүүлж чөмөг бүрээг гурвантаа ширжигнүүлэн үлээж тэнгэр чөтгөр найман аймаг тэргүүтэн бүднэрийг өөрийн өмнө хураасугай.

Ганлингийн тухай

Тэр ч 16 нас хүрсэнээс дээш ба 60 наснаас доош, өөрийн идэршил өөртөө буусан, булай үйлдэгсэдийн чөмөг, хорхойтсон чөмөг, үр тасрагсдын чөмөг, яргачин хийгээд турж үхсэний чөмөг тэдгээр нь бэлгэ муу тул хадгалж үл болно. Бус бас толгойгүй чөмөг, хагархай, хулганы яртаны чөмөг, мөн ганлингийн толгой үгүйдэж, төмөр зэс мод эвэр тэдгээрийг ганлингийн толгойд залгаж үлээх нь доройтмол ганлин мөн бөгөөд муу эд зохисгүй тул хадгалж болохгүй. Ялангуяа хар сарлагийн эвэр дайсныг оруулж дарагч муу сав ба болшгүй муу эд тул тэдгээр эдийг чөмгөнд залгаж үлээвээс тэр ганлингийн дууг сонсогсод бүгд буруу дуунд ухаж бүгдээр буруудаж одно. Тэдгээр эдүүдийг залгасан тэр ганлингийн дууг чихээр сонссон бүхэн сэтгэл нь үл амарч, хорлолын сэтгэл төрүүлэх хийгээд ер тэр дуу сонсогдохуйд газар орон бүгдэд өлзий бус болох ба элдэв нүгэлт ёр гарах тул эвэр тэргүүтэн тэдгээр эдийг залгасан ганлин түүнийг нэгээхэн агшинд ч хадгалж бүү үйлдсүгэй. Хүний чөмгөн бүрээ энэ нь дуудах эд мөн авч хадгалах зохисгүй ганлин тэдгээр нь цааш хаагч үйлдэх эд, элдэв гэмиг үүсгэгч зохисгүй эд мөн тул тэдгээрийн бэлгэ чанарыг сайтар мэдээд шинжлэхэд нэн их чухал хэрэгтэй. Тэр ч хадгалах зохисгүй тэдгээрүүд үгүй агаад эрдэм бүгд төгссөн ганлинг эрэх хэрэгтэй.

Тангараг эс доройтсон шагшаабад лугаа төгссөн тойны чөмөг, мөн ард боловч сүсэг төгөлдөр номд сүжигтэй хилэнцийн зүгээс машинд цээрлэх бөгөөд буянг болохуйцаар бүтээгч, бодьсадвын язгуурт тэр мэтийн чөмөг, тэдгээр алинд ч 16 нас хүрснээс 60 нас өнгөрөхийг хүртэлх, ялангуяа нас идэр бөгөөд оюун ухаан мэдэл бүгд доройтолгүй үхсэний баруун чөмөг нь баатарыг дуудагч эд мөн. Зүүн нь дагинасыг дуудагч эд мөний тул хүүр түүний доор эс удсан ба дээр алин буй агсан түүнийг огтолж үйлдсүгэй. Тэр ч бүтэн хүүрээс огтолж бүү үйлдсүгэй. Шувуу нохой тэргүүтэн хөндөж үйлдсэнээс огтолсугай.

Чөмөг тэдгээр нь эгэл хүн бусыг дуудагч эд мөн.

Ганлин тэр нь анхдугаар дуун гарахад бодлого тэр мэт үйлдсүгэй – ая бүгдээр сонсогтун хэмээсэн дуу нарийхан эрчимтэй сонсголонтой түүний гурван оронд илэрхий сонсогдохоор сана. Түүний гурван орны аль бүхий амьтад өөр өөрийн явдал үйлд ямарч зай чөлөөгүй авч тэр үйлсийн залгамжаагаа таслаад бүгд эгц шударга сонсож энд ирэхийг дурлаж сэтгэл үймэлцэн төрөхөд санатугай.

Ганлинг хоёрдугаар үлээхэд – ая бүгд энд хурахтун хэмээх дуу сонсогдоход сана. Түүнд үймэлдэж босон харайснаас тус тусын зүг зүгээс шуугилдан пижигнэлдсээр ирдгийг сана.

Ганлинг гуравдугаар үлээсэнд дээд доод зүг зовхис бүхнээс шууд хуралд-санаас үл үлгэрлэвээс нэгэн их хуримд хүн бүр цугларсанчлан өөрийн өмнө цуглараад газар дэлхийн гурван хувийн хоёрны хэртэй багсаралдан дүүрч болсонд сана. Тэндээс тэдгээр бүгдээс өөр дор сүслэн биширч ихэд сүслэж буйд санаад Пад хэмээн гурвантаа өгүүлтүгэй.

Падийн бодлого ч ганлин лугаа адил болой. Тэр мэт цугларсан зочдуудыг орчлонгийн зовлонгоос аварч үйлдэхийн тулд чухаг дээд гуравт итгэл явуулах

хэрэгтэй бөгөөд тэр ч өмнө огторгуйд авралын орон чухаг дээд гурвыг үүсгэж бодлогын оронд энэ мэт тодотгож үйлдэх хэрэгтэй.

ДӨРВӨН ТӨРЛИЙН ШУЛАМ

Шулам хэмээгч нь: их дүрстэй бөгөөд алинаар үзэвч их аймшигтай, жийрхэм бодитой бүтсэн нь үгүй билээ. Товчилвоос шулам хэмээх нь тонилох мөрийн тотгор болсон алимад түүнийг хэлнэ. Тийм бөгөөд хайртай энэлэх дотно нэгэн ч бодийг бүтээхийн шулам болох болой. Ялангуяа шуламд би дор баригч гайхлаас их нь үгүй тул гайхал үүнийг эс таслах хүртэл шулам бүгд түүнд уурсах бөгөөд тиймийн тул би дор баригч шулмыг таслах арганд мэргэжиж үйлдэх хичээнгүйг чангатгахын үүднээс хичээхийн дашрамд би дор баригчаас төрсөн гурван шулмыг таслах хэрэгтэй.

Шулам дор дөрөв буй. Түүнийг нэрлэвээс: торогч шулам, торохгүй шулам, дурлан баясагч шулам, дээрэнгүйлэгч шулам нь би дор баригч дөрвөн шулам болой.

Торогч шулам нь: нүдээр дүрс үзэх цагт сайхан дүрстэйд тачааж, муухайд уурлах сэтгэл төрж, түүнчлэн чих, хамар, бие, хэл хийгээд тэдгээр эрхтний оронд үзэгдэгч дуун, үнэр, амт, хүртэхүй нүгүүдийн сайханд нь тачаал төрөн муухайд нь уурлах сэтгэл төрснийг тачаангуй урин хоёрт баригч шулам гэнэ. Тэр нь эрхтний оронд илт байгаанд нь тачаах уригнах тул илэрхий эрхтэнд торсоноор нөхцөл үйлдэж бусад амьтанд хорлоод түүгээр орчлонд хүлэгдэхийн уг болдог тул шулам хэмээх ба илэрхий байгаа сайн муу хоёрт тордог тул торогч шулам гэнэ.

Торохгүй шулам нь: эрхтний оронд эс үзэгдэвч өөрийн сэтгэлд сайн муугийн атгаг алинч төрөх тул түүнд шүтэж чөтгөр хэмээхийн аймшигт үзэгдлийг баримталж жийрхэх ба тэнгэр хэмээхийн баясгалангийн үзэгдлийг баримталснаар, амар уужим тайван баяр баясал төрүүлэх бөлгөө. Тэр мэт сайн муу хоёрын хоёр атгагийг сэтгэлдээ бариснаар нөхцөл түүгээр сэтгэл нисваанист болох бөгөөд нисваанис түүнд илэрхий торолтгүй бодитойгоор орноо бүтээгүй боловч нүглийн элдэв зүйлд барилдуулан хорлолыг магадаар үйлдэж чадах тул түүнийг шулам хэмээдэг тэр ч бодитой бүтсэн нь үгүй илэрхий торохгүй тул түүнийг торохгүй шулам гэнэ.

Дурлан баясагч шулам нь: өөрийн сэтгэл алинд тачаах түүнээ баясан дурласанаас сэтгэл зоригшил ихэд төрөхийг хэлнэ. Түүний уг нь ертөнцийн өргөл хүндлэл хотол чуулган олон нөхөд цуглах, ядам бурханы нүүр үзэх, адистэдийн чадлаар ад зэтгэрийг номхотгох, өвчин зовлон бэрхшээлийг амирлуулах, ялгамжаатай бясалгалын байдал төрөх, хурц зөн билэг зүүд ургах, бие, хэл, сэтгэл гурав амгалан хийгээд чадал бадрах, тэнгэр, чөтгөр, хүн гурав өөрийн эрхгүй хурах, эд агуурс төгс эдлэлийг өргөн хүндлэл өргөмжлөл хэмжээлшгүй болох, рид хувилгаан элдэв ид шидийг үзүүлэн чадах, тэдгээрт өөрөө ихэд баясан дурлаж, өөрөө ихэд дээрэнгүйлж их омог төрүүлэх нь тонилсон бодийг олохын зэтгэр болдог тул тэдгээрт баясах дурлах шулам гэнэ.

ЛУВСАНБАНЗАР БАГШИЙН ТОВЧ НАМТАР

Д. Лхагвасүрэн

Өтвөш Лоранд нэрэмжит Их Сургууль,
Монгол ба Төв Ази Судлалын Тэнхим, Будапешт

*Эхлээд дээд багшийг шүтэн, зарлигчлан бүтээж
Завсарт нь хатуужлыг эдлэн, анхааран авч
Эцэст нь ялгалтгүй дамжлага заншлыг барьсан
Адилтгаишгүй багшийн өлмийд бишрэнгүйгээр мөргөө.*

Энэтхэг, Төвдийн мэргэдийн Жодын¹ гүн нарийн увидасын суурь багтай тавигдсан үе бол XVIII зууны эхэн үе гэж үзэж болох юм. Учир нь тухайн үеэс Монголын олон дээдэс лам нар жодын увидас, дамжлагыг хүртэж, улмаар нямба (шадарлах) бүтээл хийж эхэлсэн байдаг. Энэ цаг үеэс Монголд жодын хоёр гол дамжлага дэлгэрсэн нь Жагар ламын хийгээд Ноён хутагтын гэсэн хоёр үндсэн дамжлагууд юм. Үүний Жагар ламын дамжлагыг Молом (тө. sMon lam) хэмээх лам Монголд дэлгэрүүлсэн байдаг. Молом лам бээр Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууны Тэгшийн хонхор² гэдэг газар нутагладаг байжээ. Молом лам бээр гүн нарийн увидасыг залахын тухайтад дээдийн багшийг эрэлхийлж сэтгэл зоригдон бэрх хатуужлыг эдлэн явж, хутагт Энэтхэгийн оронд зорчсон бөгөөд улмаар Утайн таван үзүүрт ууланд даяанд залран суусан их лам Жэр Чойжамцаас энэ гүн нарийн увидасыг залж иржээ. Ийм учраас Жагар Молом лам гэж нэрийдэх болсон бөгөөд Монгол орноо жодын ховор нарийн увидас дэлгэрэхэд асар их ач тусыг үйлдэж домог³ болсон ч түүний талаар тоймтой судалгаа одоо хүртэл хийгдээгүй байна.

¹ Жод (тө. *god*) хэмээх нь билгийн чиндад хүрэхүйн номлолоор сансарын зовлонгоос гарахын увидас юм.

² Тэгшийн хонхор хэмээх газар нь одоогийн Дундговь аймгийн Дэрэн сумын нутагт байх нэгэн газрын нэр.

³ Молом ламын домог. Молом хэмээх Хүрээний ядруухан лам Ханд бурхантай уулзах минь гэж санаад алс нутагт Энэтхэгийн орныг зорин явсан байна. Хатуу бэрхийг туулан нэгэн ойн дундуур явж байтал морин шоргоолжны үүрэн дээр яваад орчихсон аж. Амиа аврахын тулд морин шоргоолжны эсрэг тэмцэж байгаад ухаан алдан унаж гэнэ. Нэг сэрээд харсан чинь нүдний нь өмнө ногоон дээлтэй үзэсгэлэнтэй нэгэн эмэгтэй зогсож байжээ. Тэр эмэгтэй бодитой Ханд бурхан байсан бөгөөд Молом ламд “Та цаг нь болоогүй байхад намайг зорин яваад амиа алдахад хүрлээ, та одоо нутагтаа буцаж очоод Жодын ёсыг дэлгэрүүл, таныг нутагтаа хүрэхийн үед нэг юм өгнө” хэмээн хэлээд яван оджээ. Молом лам нутгийн зүг буцаж яваад Хүрээнд төхөн ирээд түр амс зуураа нойрсож орхиж гэнэ. Гэв гэнэт өвөр дээр нь нэг юм унахад, цочиж сэрээд харсан ганлин (тө. *rkang gling*) байсан байна. Тэрхүү ганлинг Ханд бурхан өөрөө хайрласан гэх бөгөөд Молом лам ч Жагар Молом лам хэмээн алдаршиж жодын увидасыг нийтэд түгээн дэлгэрүүлсэн байна. Энэхүү домгийг миний багш (Х. Банзар) шавь нартаа олон удаа ярьж өгч байсан бөгөөд би хувьдаа олон удаа сонсож билээ.

Энэхүү дамжлагаас салаалсан олон дамжлага байдаг. Үүний нэг дамжлага нь Жагар Молом ламаас Намжил зочид дамжуулсан увидас бөгөөд лам бээр Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууны Ихийн хонхор⁴ гэдэг газар нутагладаг байжээ. Түүнээс Ишдоо зоч лам авсан бөгөөд мөн Шавийн хошуунд харьяалагдах одоогийн Төв аймгийн Баянцагаан сумын нутагт амьдарч байжээ. Ишдоо ламаас Пунцаг зочид дамжуулсан байна. Ламтан бээр Цэцэн хан аймаг буюу одоогийн Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Чандган тал орчмын салбар уулаар нутаглаж байгаад, тэндээсээ баруун зүгт нүүдэллэн явсаар одоогийн Дунговь аймгийн Дэрэн сумын нутаг Цахиуртын хонхорт ирж суурьшсан байна.

Тэр цагаас Пунцаг зоч нь олон шавь нарын багш болж тэднийгээ жинхэнэ сайн зоч болгохын тухайд биечлэн сайтар зааж сургаж байжээ. Пунцаг зоч нь гурван гол шавьтай байсан бөгөөд тэдний нэг нь нутгийн ард олон Дам гэж хүндэтгэн нэрлэдэг Дашням зоч, Удаах шавь нь бухан Гончиг зоч гэж байжээ. Гончиг зоч нь 1960, 1970-аад оны үед Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Амгалан орчмоор нутаглаж байсан ба түүний тусыг хүртэхээр олон газрын хүмүүс цуглаж байдаг айл байлаа. Пунцаг зочийн бас нэгэн эрхэм шавь нь миний багш Лувсанбанзар (хэргийн тухайд алдрыг өгүүлэхэд) бөлгөө. Багш маань Пунцаг зочоос энэхүү увидасыг авч нямба бүтээлийг нь гүйцээж, шавь бидэнд уламжлан үлдээсэн үнэхээр бишрэм зарлигийн ачтан мөнөөс мөн билээ.

Монголын ард түмний туулж өнгөрүүлсэн олон зуун жилийн түүхэн хөгжлийн явцад бүтээж байгуулсан шашин соёлын өв сан яндашгүй арвин баялаг билээ. Түүнд өчүүхэн хувь нэмрээ оруулсан эрдэм мэдлэг төгс, улс үндэстнийнхээ ирээдүй хувь заяаны төлөө санаа тавьдаг, үнэнч зүтгэлтэй, өөдрөг үзэлтэй, авьяас билэг нэгэн бол миний багш Хандын Банзар (1904–2008) юм.

1914 онд Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуу, одоогийн Дундговь аймгийн Дэрэн сумын VII багийн нутаг Цант халтар хэмээх газар малчин ард Долзодын Хандын дөрөв дэх хүү болон мэндэлсэн. Бага насандаа бусдын адил аав ээжийн гар дээр хүмүүжиж байгаад, 5–6 насандаа өөрийн том ахын дэмжлэгтэйгээр Дэлгэрийн чойрын хийдэд⁵ шавилан сууж бурхны номын анхны Га, Ха-г үзэн төвөггүйхэн уншиж бичиж сурчээ. Буяны зам мөр нээгдэн улмаар зодын номыг машид хүсэмжлэн, таалалд барин зоч болохоор зориг шулуудаж Баянцагаан сумын Бэлийн хийдэд шавилан суусан юм. Зоч лам болоход Лувсанжав багшаараа Хангал магтаал болон хурлын бүх уншлага номыг, Пунцаг зоч багшаасаа Хандын цэжү судар,⁶ Дагинасын чихний чимэг увидаслал зэрэг номын авшиг, зан үйлийг хоцроолгүй гүйцээн, ном ёсны дагуу

⁴ Ихийн хонхор. Одоогийн Дундговь аймгийн Дэрэн сумын нутаг.

⁵ Дэлгэрийн чойрын хийд (тө. Chos dbyings 'od gsal gling). Олноо өргөгдсөний долоодугаар (1918) онд Зава Дамдин хэмээх алдаршсан Лувсандаян гавж одоогийн Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг Дэлгэр уулын энгэрт энэхүү хийдийг байгуулжээ.

⁶ Ханд цэжү (тө. *mKha' 'gro tshes bcu*). Сар бүрийн шиний 10 болон хуучны 25-ыг Ханд болон Ловон бурханы буулттай өдөр хэмээдэг. Энэ өдрүүдэд хурдаг хурал номын нэр.

хүртгэж, Дугар багш нь өөрийн гараар хавчиг үүрэг бэлтгэн өгч зоч лам болох ерөөл тавин урьдын номын барилдлагаар шавьдаа ихийг бүтээх ерөөлийг айлдсан гэдэг.

Ингээд 17 насандаа Намхай-Гожэдын ван (тө. *Nam mkha 'sgo spyod*) авшгийг хүртэн, тангараг дамцагийг доройтуулалгүй шимийг нь авч өөрийн бие, эх болсон амьтны тусад зориулан ертөнцийн явдлыг огоорон орхиж, хатуужлийг үйлдэж өвөл нутгийнхаа Цантын уулын хадан агуйд Тойног бурханы бясалгал нямбанд гурван жил суугаад хавар цас ханзрангуут Хэрмийн шанд, Мухарын шанд, Наран хөгцтийн нутаг болох Нарангийн гурван овоо болон үхээрийн газар чүмэг жарзыг гурван жил гүйцээж агуу багш нарын сургаал номлолыг дамжлага суртал ялгалгүй ихэд чармайн суралцаж Тойног, Таван ханд бурхдын бүтээл нямбыг хоцроолгүй хийж гүйцээжээ.

Амгалан бүгд багшийн адистэд байгаа тул ачийг хариулан багш нартаа сүсэглэн, ялангуяа нууц тарнийн очирт хөлгөний мөр бүгдэд гагцхүү багш чухал учраас багшийн егүзэрийг бясалгаж тангараг цаазыг ягштал баримтлан төдийгөөс өдийг хүртэл дээдлэн ирсэн юм. Ингэж ирэхдээ багш нарын сургаал номлолыг үргэлжлүүлэн дамжлагыг үл таслан Дундговь аймгийн Дэ-рэн, Дэлгэрцогт сум мөн Төв аймгийн Баянбараат, Батцагаан сумын нутгаар амьдран өөрийн өчүүхэн мэдлэг оюунаа ертөнцийн амьтны тусад ерөөл агуу ихээр тавьж түүнчлэн өөрийн ба хүмүүний эцэг эх болон ойр төрлийнхний тухайд буян үйлдэх хийгээд талийгаачдын хойтын буяныг үйлдэвч эс зориулваас буян очихгүй бөгөөд харин зориулваас ямар мэт зориулсан тэр хэмжээгээр буян хүргэхийн тухайтад, өглөг буяны төгс бодийг уг шалтгаан мөн чанар, шид бүтээлийг дээд багш нарынхаа айлдвар зарлигийн дагуу сэтгэл, эрдэм чадлаа зориулж явсан эгэл нэгэн буянтан юм.

1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлтийн цаг үед монгол орны хүн амын оюуны хэрэгцээг хэдэн мянган жил тэтгэж ирсэн Буддизм, дорно дахины шинжлэх ухааны салбарт ард түмний бүтээсэн соёл, боловсролын өв, зан заншлыг нухчин дарсан билээ. Хэлмэгдүүлэлтэнд ойролцоогоор 10000 гаруй хувраг, эрдэмтэн мэргэд өртөж байсан нь монголчуудын хамгийн оюунлаг давхрага, сэхээтний цөм байсан юм. Энэ хэлмэгдэгсдийн дотор түүний том ах Сүхээ гэр орноороо хэлмэгдэн үгүй болжээ. Гэвч хэлмэгдүүлэлт эхэлснээр бурханы шашны үзэл санаа номлолыг дамжлага болгон үлдээх боломжгүй болсон учир хар болж гадаад дүрдээ эгэл хүмүүний ёсийг үзүүлж байсан боловч дотоод сэтгэлдээ зодын гүн увидас, багшийнхаа айлдсан дамжлагыг үргэлж өөрийн таалалд болгоон доройтуулалгүй авч ирсэн байдаг.

1939 онд буюу эх орны дайны үеэр эр цэргийн албанд тагагдан таван жил цэргийн албыг хаагаад 1944 онд өөрийн төрсөн эгч Нямсүрэнгээ даган “Аж үйлдвэрийн комбинат”-д орж оёдолчин, эсгүүрчин, эд шалгагч, цехийн мастер, үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, нярав, нягтлан бодох зэрэг ажлуудыг хийж ажилчин ангийн эгнээнд хөл нийлүүлэн эх орныхоо бүтээн байгуулалтанд өөрийн сэтгэл зүрхээ зориулан үр бүтээлтэйгээр тасралтгүй 36 гаруй жил ажиллаж байгаад гавьяаныхаа амралтанд гарсан буянтай буурал бөлгөө. Угийн хөдөлмөрч хүн тул 1975 оноос үйлдвэрийн район буюу одоогийн Хан-Уул

дүүргийн өндөр настны зөвлөлийн дарга, мастер зэрэг ажил үүргийг алжаал зүдэрлээс үл шантран хийж байсан.

Монгол оронд ардчилалын салхи сэвэлзэж эхэлсэн 1980-аад оны сүүлч үеэс оюун бодлын дунд Наран хөгцтийн өвгөн багшынхаа номын аньсыг бүрэн үл гүйцээн бурхан болсныг сэтгэлдээ санасаар, өөрийн оюун бодлоо буяны садангийн айлдвар зарлигт чиглүүлж, ариун тангаргийн үүднээс дамжлага төгөлдөр багш дээдэстэй таалал нийцүүлж, эх болсон амьтан бүгдийг орчлонгийн зовлонгоос ангижрахад туслах үйлсэд сэтгэл шулуудан орж, 1989 оны 12-р сарын 22-ны өдөр буюу шороон могой жилийн өвлийн эхэн сарын билэгт сайн өдөр зулын 25-нд анх Баянгол дүүрэгт Тарвалин нэртэй зодын хурал нээсэн билээ.

Наяад жил европ хэв маягаар амьдарсан ч, уламжлал, дорно дахины сэтгэлгээ, түүний дотор бурханы шашны гүн ухааны сэтгэлгээний өв уламжлалыг эн тэргүүнд дээдэлж, сүм хийдийг сэргээсэндээ бурханы шашны жинхэнэ дэг жаягаараа хөгжихөд бага ч болов тус нэмэр болох тухайтад их хувь завшаан хэмээн ихэд бахархдаг байсан юм.



Зураг 1. Лувсанбанзар багш (1914–2008). Зургийг Ё. Ганзориг авсан.

Лувсанбанзар багшийн байгуулсан тус хийдэд 1990 онд Энэтхэг улсаас манай улсад суух элчин сайд Бакула Ринбүчи багш саатан морилж Намдолдэчэнлин (тө. rNam 'grol bde chen gling) хэмээх нэр хайрласан билээ. Тэр цагаас өнөөг

хүртэл дэвжин дэлгэрч номын шавь нар хийгээд сүсэгтэн олон түмний хөл тасралгүй, ертөнцийн хүмүүний амар амгалангийн төлөө бүхий л амь амьдралаа зориулсан багшийн минь үйл хэрэг үргэлжилсээр байна. Х.Банзарын нөр их хөдөлмөрийг төр засаг, түмэн олон тухай бүр үнэлж дүгнэж ирсэн юм. Багш маань 2008 оны намрын адаг сарын шинийн 8-нд дүрс лагшингаа хурааж, ёсыг үзүүлж, Үржинхандын оронд заларсан билээ.



Зураг 2. Лувсанбанзар багшийн оршоосон алтан суварга. Зургийг Д. Лхагвасүрэн авсан.

Алин зүгт орших чиггүй бэрх газрыг
Эшийг баригч Молом багш минь адисла
Наран хөгцөтийн аглаг оронд
Лувсанбанзар багш минь адисла
Хагацашгүй зүрхний орд харшид
Язгуурын багш минь адислан зохио.

Лувсанбанзар багшийн өлмий бататгахын зарлиг
Сайн оюут хоёрдугаар ялгуусны эрхэм зарлиг хийгээд
Ялангуяа **таван сахиа** судар тэргүүтнээр
Амьтны зовлонг хоцроолгүй амирлуулагчийн
Өлмийн лянхуаг зуун галавт батад оршоон соёрхо
Авралт итгэлт таны гайхамшигтай бодийн сэтгэл сайтар боловсорсны хүчээр
Арилсан дээд орон алив амьтан тэргүүтэн
Ялгамжаат үржинхандын оронд залархын цагт
Би хийгээд нөхдийн анхан дор дагуулан барих болтугай.

Намдолдэчэнлин хийд

Хоёр мянга гаруй жилийн тэртээгээс монгол туургатны дунд бурханы шашин анх дэлгэрэхдээ Улааны ёс ба хуучин ёсны урсгал түгэн дэлгэрсэн түүхтэй. Түүхийн олон зуун жилийг Монголчууд туулан өнгөрүүлэхдээ шашны гол номлолуудыг хооронд нь харшилдуулахгүй баримталсаар ирсэн. Цагийн урсгалд хөгжил бадрал, буурал доройтлыг үзэж ирсэн бурханы шашин нь ардчилал, шинэчлэлийн он жилүүдэд Монгол орноо дахин сэргэн, сүм дуганаа нээж сүсэгтэн олондоо үйлчилж, үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах сайхан боломж бүрдсэн юм.

Энэ таатай үед бидний багш Х.Банзарын санаачлагаар тус хийд нь XVII жарны шороон могой жилийн өвлийн эхэн сарын зулын 25 буюу 1989 оны 12-р сарын 22-ны өдөр Тарвалин нэртэйгээр (одоогийн Гэмтэл согог судалын үндэсний төв эмнэлгийн баруун урд) хамгийн анх сэргээгдсэн жодын хурал юм.

1990 оны зургаадугаар сард одоогийн Монголын “Зурхайчдийн холбоо”-ны тэргүүн Пүрэвсүрэн нь тусдаа биеэ даан буян номын үйл ажиллагааг явуулах болсон байна. Намдолдэчэнлин хийд нь Монгол улс дахь төр, сүм хийдийн хоорондын харилцаа нь төр нь шашинаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчмыг баримтлан одоо хүртэл үйл ажиллагааг явуулж байгаа билээ. БНМАУ-ын Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын тэргүүлэгчдийн 1991 оны долоодугаар сарын 22-ны 32 тоот тогтоолоор Жагармоломын нэрэмжит Намдолдэчэнлин хийд хэмээн Монгол улсын хууль зүйн дагуу албан ёсны зөвшөөрөгдсөн бурханы шашны байгууллага болсон юм. 1991 онд тус хийд нь Сонгино хайрхан дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэр болох Баянхошуунд шилжин суурьсан билээ. Намдолдэчэнлин хийдийн зорилго нь түүх соёлоо өвлөх, оюун ухааны гэгээрэл, сэтгэлийн ариуслыг эрхэм болгож, энэрэл нигүүсэл, эв зохицлыг бэлгэ тэмдэг болсон шашны үзэл сургаалыг түмэн олон ялангуяа залуу үеийг хүмүүжүүлэхэд чиглэдэг байна.

Тус хийдийн үйл ажиллагаа нь голлон буяны үйлсийг эрхлэх бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд буяны сан байгуулах, буяны өргөл хандив өргөх, бүрдүүлэх, гадаад дотоодын буяны ажиллагаанд оролцох, зовлон бэрхшээл зүдгүүр тохиолдсон нөхцөлд хувь хүн, хамт олон, бүс нутагт тусламж хүргэх, тусламжийн хөдөлгөөн өрнүүлэх зэрэг ажиллагаа явуулахаас гадна сүсэгтэн олонд бурханы шашины үзэл сургаалыг таниулан дэлгэрүүлэх мөн лам хувраг, олон шавь нарын шашны болон хууль, эрх зүйн мэдлэг, ерөнхий боловсролыг дээшлүүлэх, сургалтыг дүүргийнхээ боловсрол төвтэй хамтран зохион байгуулдаг. Мөн сүсэгтэн олны шашин номын эрэлт хэрэгцээг хангахын тулд шашны зан үйл, хурал номын үйл ажиллагааг дэг жаягын дагуу чанд баримтлан явуулдаг.

XX зууны төгсгөлд Монгол хүний нийгмийн сэтгэлгээ, амьдрах орчин, хэв маягт ихээхэн өөрчлөлт гарсан нь сүм хийдүүдийн үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлж байгаа юм. Монгол орны эдийн засгийн хямралтай, улс орны байдал хүнд байгаагийн улмаас санхүү нөөцийг бүрдүүлэх боломж хомс болж ирлээ. Гэвч тус хийд нь өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг ба 40–50 лам, ажиллагсдын

бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын хурал номын үйл ажиллагааг тогтмол явуулж байна. Хурлын онцлог нь Ловон Бадамжунай бурханы айлдвар номлол, нарийн нууц увидасын жод лүйжин, гүрэм номыг хурдаг.

Гол шүтээн: Ловон Бадамжунай, сахиус нь Зангад, Янсан ядам, Дүртэддагва, Ханд, Тойног, Гомбо, Жамсран тэргүүтэн болно.

Хурал номын үйл ажиллагаа нь өдөр тутам цогчин хурал хурахаас гадна сар бүрийн шинийн 10-нд Ловон чоги, 15-нд Ханд цэйжү, Янсан ядам, 25-нд Ханд цэйжү, Зангад сахиус, 29-нд Ханд цэйжү, Дүртэддагва, Жамсран сахиус хурахаас гадна өдөр бүр цогчин хурал, Лүйжин хурдаг байна.

Баянхошууны хийд гэж нийтэд алдаршсан энэ хийдээс маш олон тооны зоч лам нар төрөн гарсан юм. Учир нь энэ хийдээс 1990 оноос хойш анхлан жарз, нямба бүтээлийг хийж эхэлсэн бөгөөд жил бүр тасралтгүй лам нараа уртын жарзанд гаргаж байна. Үүнээс гадна энэ хийдээс ойролцоогоор 10 орчим хийд өрх тусгаарлан байгуулагдсан байна.



Зураг 3. Намдолдэчэнлин хийдийн гол дуган. Зургийг Ё. Ганзориг авсан.

Ном зүй

IX Богд Жавзандамба: *Лүйжин*. (жодын айлдвар болон бусад тайлбар хөтөлбөр). Улаанбаатар 2018.

Лувсанчойжиням: *Болорын толь*. Эрхэлсэн Д. Бүрнээ, Д. Энхтөр. Монгол улсын их сургууль, Улаанбаатар 2006.

Оюунбилэг, Б.: *Намдолдэчэнлин хийдийн түүхэн товчоон*. Стра принт ххк 2009.

Оюунбилэг, Б.: *Дорж ловон Лувсанбанзар*. Улаанбаатар 2019.

МАЙДАР ЭРГЭХ ЗАН ҮЙЛ

Ц. Отгонбаяр

МБШТөв Гандантэгчэнлин хийд, Улаанбаатар

Г. Жалсрайжамц

Өтвөш Лоранд нэрэмжит Их Сургууль,
Монгол ба Төв Ази Судлалын Тэнхим, Будапешт

Майдар бурхан нь Гандан (тө. *dga' ldan*) хэмээх тэнгэрийн оронд Бурхан багшийг орлож үлдсэн учир түүнийг Бурхныг орлооч, Үл ялагдагч, Майдар¹ хэмээн нэрлэх бөгөөд сайн цагийн мянган бурханы тавдугаар бурхан болж Замбулинд залрах учиртай гэж бурхны шашны их хөлгөний ёсонд үздэг. Майдар бурхны тэргүүн дээр залран буй суварга нь түүний багш Бурхан Буддаг бэлгэддэг мөн ирээдүйд Бурхны номыг дэлгэрүүлэхийн бэлгэдэл болгож номын хүрдээр мутрын тэмдэг хийж, удахгүй Замбуулинд залрахын бэлгэдэл болгож хагас суугаа байдлаар дүрсэлдэг билээ.

Үүний учир бурхны шашинтай орнууд ирээдүй цагийн тус амгалангийн бэлгэдэл болсон Майдар бурхныг бүтээж ирээдүйд түүний шашинтай учрахын ерөөл тавьж сайн сайхан бүхнээ даатган дээдлэн шүтэж ирсэн уламжлалтай.

Майдар эргэх уламжлал

Монгол газар анхлан Эрдэнэ зуу хийдэд Майдар эргэх зан үйлийг үйлдэж байсан бөгөөд Өндөр гэгээн Занабазар алтан унжлагат (сэрчэн) хэмээх гал тахиа жил Эрдэнэ зуу хийдэд зүүн дөрвөн аймгийн чуулганд уригдан залагдаж Ерөөл, Майдар эргэх тэргүүтэн буян номыг үйлдсэн байна.² Үүнээс хойш Монгол оронд Майдар эргэх зан үйл ихэд дэлгэрч мөн Майдарын дацангууд олноор байгуулагдсан байна.

Жишээлбэл, Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошууны Шаддүв-чойнхорлин хийд Майдар дацантай, Жанчивлингийн хүрээ, Түшээт хан аймгийн Сэцэн вангийн хошуу, Сэцэн хан аймгийн Мэргэн гүн Цэрэнвандуй-бавуудоржийн хошуу, Далай чойнхор вангийн хошуу, Засагт хан аймгийн Сэцэн бэйлийн хошуу, Засагт хан аймгийн Цогтой бэйсийн хошуу, Далай гүнгийн хошуу, Дэжээлингийн хүрээ, Хошуу хийд тус тус Майдар дацантай байжээ. Монголын сүм хийдүүдийн түүхээс үзэхэд Майдар эргэдэггүй хүрээ хийд ба-

¹ Майдар хэмээх үг нь эртний Энэтхэгийн санскрит хэлний Мадри (Maitreya) хэмээх үгнээс гаралтай монголчилбол “асрах,” “хайрлах” гэсэн утгатай үг аж. Булган, Т.: Их хүрээний Майдар дацангийн уламжлалт ёсон. In: *Майдарын эрин. Нийгмийн хөгжлийн чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын эмхэтгэл*. Эмх. М. Батаа. Улаанбаатар 2013, т. 48.

² Сонинбаяр, Ш.: *Монголын соёл, түүхэнд өндөр гэгээний оруулсан үүтгэл*. PhD диссертац, Монгол Улсын ШУА-ийн Түүхийн Хүрээлэн. Улаанбаатар 1999, т. 100.

раг байхгүй байна.³ Учир нь XVI зуунаас эхлээд Монгол оронд Богд Зонховын номын ёс буюу гэлүгвын урсгал Монгол орон даяар түгэн дэлгэрсэнтэй холбоотойгоор Майдар эргэх зан үйл нь нэн их дэлгэрсэн байна.

Харин Их хүрээнд Майдар дацан болон Майдар бурхныг V Богд Жавзандамба хутагтын үед Зүүн хүрээнд их Майдар шүтээнийг бүтээн залж Майдар эргэх ёслолыг өргөн дэлгэр болгосон байдаг. Энэ тухай Их хүрээний хамба номун хан Агваанхайдав (1779–1839)-ийн 1833 оны харагчин могой жилийн өвлийн эхэн сарын шинийн 15-нд бичиж төгсгөсөн “Их хүрээнд бүтээсэн Майдар бурхны гарчиг тунгалаг царайг тодотгогч чандмань толь хэмээх оршвой”⁴ хэмээх зохиолд тодорхой өгүүлсэн байна.

Уг Майдар дацан нь шүтээн мөргөлийн дацан байсан бөгөөд шашин соёлын зан үйл, хурал номын үйлийг түлхүү эрхэлдэг ба жил бүрийн Майдар эргэх зан үйлийг голлон гүйцэтгэдэг байжээ. Гэвч XX зууны 20–30 онуудын цаг төрийн өөрчлөлтөөр шашин номын үйл ажиллагааг хааж, сүм дугануудыг нураан газар дээр нь шинэ барилга байшингууд барьснаар 1943 онд Майдар бурхны дуганыг хамт үгүй болгосон билээ.⁵

Майдар эргэх зан үйл

Доорхи нь МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Майдар эргэх ёслолыг танилцууля. Эл ёслолд хоёр долоо орчим хоногийн өмнөөс бэлдэж эхэлнэ. Дөрвөн дугуйтай тэргэнд Майдар шүтээнээ залан хийд тойрон гороо хийхэд бэлэн болгоно. Шүтээний өндөр нь газраас найман тохойгоос багагүй байх ёстой. Тэргийг дөрвөн өнгийн будгаар будна. Үүний дугуйг улаанаар, хайс, шалыг шар, хөх, улаан, ногоон өнгийг хослуулан буддаг.

Тэрэгний хайсны шонгуудад долоон эрдэнэ, найман тахил, бадан зэргийг зурж, дөрвөн буланд нь таван өнгийн чимэгтэй жалцан тавьж тэрэгний голд тэргийг бараг бүрэхүйц том, өндөр иштэй шүхэр байрлуулдаг. Зарим хийдэд Майдар шүтээнээ дамнуурга дээр ч залж эргэдэг уламжлал байсан байна. Харин тэрэгтэй тохиолдолд тэргэнд мод, цаасаар шууж хийсэн ногоон өнгийн морь, зааныг хөллөдөг байжээ. Морь, зааны нуруунд чандмань эрдэнийн дүрсийг зална. Майдар эргэх өглөө, өдрийн тогтмол хурлаа өглөө эртлэн хурж эрт өндөрлөдөг. Үүний дараа хийдийн хамба ламтан 2, 3 ширээт ламын хамт Майдар бурхны алтадсан хөргийг дуганаас гаргаж, бусад шавь лам нар мяндаг тушаалын эрэмбээр Майдарын таван аймаг номыг авчирч бурхны өмнө зална. Дараалах лам нар хүж, арц асаан сангийн бойпор, цэцэг, долоон эрдэнэ,

³ Амгалан, Н.: Их хүрээний Майдар дацангийн уламжлалт ёсон. Ип: *Майдарын эрин. Нийгмийн хөгжлийн чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын эмхэтгэл*. Эмх. М. Батаа. Улаанбаатар 2013, т. 98.

⁴ Амгалан, Н.: Их хүрээний Майдар дацангийн уламжлалт ёсон. Ип: *Майдарын эрин. Нийгмийн хөгжлийн чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын эмхэтгэл*. Эмх. М. Батаа. Улаанбаатар 2013, т. 92.

⁵ *Майдар эргэх ёс*. <https://www.ikon.mn/n/q5b>. (04.2017).

өлзийт найман тахил, таван хүсэл зэргийг тэргэнд залсан Майдар бурхны өмнө өргөнө. Үүгээр Майдар эргэх ёслол эхэлнэ. Ёслолын тэргүүнд бүчиж хүрээлсэн сүсэгтнүүдийг замаас зайлуулах үүрэгтэй, барын хуйлсан арьс барьсан хоёр лам явна. Тэр нь бэлгэдлийн чанартай хамгаалагч болон тэдгээрийн араас тавь орчим ташуур барьсан зохицуулагч явж Майдар эргэх ёслолын дэг жаягийг хангадаг байна.

Эл бүгдийн удаа ногоон морь хөллөсөн Майдар бурхны тэрэг явдаг. Хорь орчим лам морины цулбуур, тэргэнд уясан татлага оосрыг мөрөндөө эгэлдэргэлэн тэргийг чирнэ. Тэрэгний араас хоёр үхэр бүрээч, удаа нь хийдийн лам нар орж явна. Бусад лам нар жагсаалын дагуу дараах байдлаар хоёр талд нь явна. Үүнд эхний эгнээний баруун, зүүн талд хуралд үйлчилдэг лам нар дуганд тахилын ширээн дээр байдаг хурлын хэрэглэгдэхүүнийг гартаа барьж явна. Хоёр дахь эгнээнд гэлэнгүүд явах бөгөөд хүн бүр ёслол өндөрлөтөл хонх цохиж явдаг. Гуравдугаар эгнээнд сэлнэн, дөрөвдүгээр эгнээнд дуударма, тавт цан, зургаад бишгүүр, ганлин, бүрээ, долоод үхэр бүрээ, наймд хэнгэрэг дэлдсэн лам нар жагсан явна. Хэнгэргийн жижгийг нь нэг, томыг нь хоёр лам (гуравдахь нь дохиураар түүнийг дэлдэнэ) тус тус барьдаг. Есдүгээр эгнээг чимгийн гэж нэрлэж болно. Эл эгнээнд долоон эрдэнэ, өлзийт найман тахил, хүслийн таван эрдэнэ зэрэг бэлгэдлийн зүйлийг Майдар шүтээндээ зориулан модоор хийж, өндөр ишэнд хадан өргөж явна. Мөн эдгээрээс гадна ялгуусны тэмдэг, бад тэргүүтнийг тусгай дамнуурга дээр залан лам нар Майдар бурхны тэрэгний хоёр талаар авч явна. Аравдугаар эгнээнд бадан, шүхэр барьсан лам нар жагсдаг. Тэдний дамнуурганы өмнө бишгүүртэй хоёр, бүрээтэй мөн хоёр, сангийн бойпор барьсан нэг лам тус тус явна.

Хутагт хувилгаадтай энгийн лам нар зэрэгцэн алхах ёсгүй. Дамнуурганы араас бүрээ барьсан хоёр лам, хутагтуудын ойр дотны хүмүүс дагалдаж явдаг. Гол сүмийн үүднээс хөдлөсөн цуваа хийдийн их хаалгаар гарч зогсоно. Майдар бурхан залсан тэргээ нар зөв эргүүлэн, гол дуганаа харуулан зогсоодог байна. Эл зан үйл Майдар бурханд мандал өргөхөөс эхэлж Бурхан багшийн үйлсийг тэтгэн баясгагч Майдар бурхныг ариун сургаалаа хайрлан соёрхож эл ёслолд оролцогч нийт хүнд үеийн үед хүндлэн тахиж явах өршөөл нигүүлслийг гуйн наманчилдаг байна.

Үүний дараа Майдар бурхан залсан тэргээ баруун тийш нар зөв эргүүлэн хөгжмийн зөөлөн эгшиглэн хийдээ тойрч хөдөлнө. Хөдөлгөөн нь удаан дэг жаяг ёсоор зааны явдал шиг байна. Хийдийн хойд хаалганы дэргэд цуваа зогсож лам нар хангай дэлхийн эзэнд балин өргөн ном уншдаг. Үүний дараа лам нар тэргээ тэнд нь орхиод түр амрахаар гэр гэртээ явдаг байна. Дараа нь гурван цагийн орчим лам нар тэргэн дээрээ цуглаж, Майдар бурхныхаа өмнө сууцгаан угаал, өлзий хутаг зэрэг бурхны хутгыг олгож, Сухавадийн оронд төрөл арилжихыг хүсэн, аз жаргал, ариун ёсны ерөөлийг хурдаг.

Хурал өндөрлөхөд тэргийг дахин хөдөлгөж, хийдийн зүүн хаалганы дэргэд ирж шүтээнээ өмнө зүг хандуулан энд Майдарын таван аймаг номыг хурдаг. Хурахдаа лам бүрт номын хоёроос гурван хуудсыг хуваан өгч уншуулдаг байна. Майдарын цуваа тэндээс хөдөлж хийдийн гол хаалгаар орж гол сүмийн



Зураг 1–2. Майдар эргэх ёслол. МБШТөв Гандантэгчэнлин хийд, 2010 он. МБШДС-ийн номын сангийн фото архив.

хаалганы дэргэд зогсоно. Энд Майдарын ерөөлийг хурж үүгээр Майдар эргэх ёслол өндөрлөнө. Бурхныг тэрэгнээс залж гол сүмдээ залах ба ёслолын бусад хэрэглэгдэхүүнийг байр байранд нь тавина.

Ном зүй

- Амгалан, Н.: Их хүрээний Майдар дацангийн уламжлалт ёсон. In: *Майдарын эрин. Нийгмийн хөгжлийн чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын эмхэтгэл*. Эмх. М. Батаа. Улаанбаатар 2013, т. 94–101.
- Булган, Т.: *Буддын философийн дэвтэр*. Улаанбаатар 2010.
- Булган, Т.: Их хүрээний Майдар дацангийн уламжлалт ёсон. In: *Майдарын эрин. Нийгмийн хөгжлийн чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын эмхэтгэл*. Эмх. М. Батаа. Улаанбаатар 2013, т. 48–49.
- Сонинбаяр, Ш.: *Монголын соёл, түүхэнд Өндөр гэгээний оруулсан үүтгэл*. PhD диссертац, Монгол улсын ШУА-ийн Түүхийн Хүрээлэн. Улаанбаатар 1999. *Майдар эргэх ёс*. <https://www.ikon.mn/n/q5b>. (04.2017).

ШАШИН ТӨРИЙГ ХОСЛОН БАРИГЧ, НАРАН ГЭРЭЛТ ТҮМЭН НАСТ ЭЗЭН ХААН VIII БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН ДЭЛГЭМЭЛ ШҮТЭЭН ЗУРАГ

Болдын Шүр

Өтвөш Лоранд нэрэмжит Их Сургууль,
Монгол ба Төв Ази Судлалын Тэнхим, Будапешт

С. Гансүхийн (хамт)

“Мөнхийн урлаг” Эртний Өвийн Галерей, Улаанбаатар

Оршил – Бурхан шашны түүх, соёлд холбогдох эд өлгийн зүйлс

Аливаа орны эд өлгийн зүйлс нь тухайн улс орны туулж ирсэн түүхэн цаг хугацааны баримт, нотолгоо болдгоороо үнэ цэнэтэй юм. Эцэг өвгөдөөс уламжлагдан ирсэн биет өвийг өөрийн хүсэл сонирхолд хөтлөгдөн, цуглуулах явцдаа тэдгээрийн түүх, гарал үүсэл, урлаг соёлын онцлог талаас нь ажиглалт судалгааг хийхийн зэрэгцээ эрдэмтэн судлаач, сонирхогчдын судалгааны эх хэрэглэгдэхүүн болгосоор ирсэн. Бидний цуглуулгын дийлэнх хэсгийг бурхны шашинтай холбоотой биет өвүүд эзэлдэг. Иймээс энэ өгүүллэлд энэхүү эд өлгийн зүйлсээс төлөөлүүлэн нэгэн бүтээлийг сонгон тайлбарлахыг зорилоо.

Шүтээн зургууд

Энэхүү өгүүллийг эхлэхийн өмнө бурхны шүтээн зургийн талаарх товч ойлголтыг хүргэе. Бурхны шүтээн зургийн уламжлал анхдугаар Богд Жавзандамба хутагт, Өндөр гэгээн Занабазарын үеэс (1635–1723) эхтэй ба дорно дахины бурхан дүрслэлийн сонгодог харьцааг анх боловсруулсан эртний Энэтхэг, Төвдийн урлахуй ухааны онолыг баримталж ирсэн хэдий ч монгол соёлын өвөрмөц онцлог, арга ухаан шингэсэн өвөрмөц онцлогтой урлаг болон хөгжсөн юм. Монгол зургийн уламжлал хүрлийн үеэс эхтэйг, эдүгээ үед хадгалагдаж ирсэн соёлын өвөөс харж болно. Шүтээн зургийг бурхны шашны онолд суралцаж сэтгэл оюун нь ариусан, бурхан бүтээх “тиг”-д¹ суралцсан урлаач бүтээдгийн учир нь хийсвэр, далд гүн ухаанд төвлөрдөгт оршиж буйн хэрэг юм.

Монгол шүтээн зургийг даавуу, цаас болон торгон дээр байгалийн шороон будаг, алт, мөнгөөр урладаг. Монгол шүтээн зураг нь гүн ухааны утга агуулгатай бүтээгддэг нь урлаач бүтээж буй явцдаа гүн бясалгалд орж, оюун ухааны дээд цэгт хүрэн урладагт оршино. Монгол урлаачийн бүтээл нь монгол хүний соёлын

¹ “Тиг” гэдэг нь хүний биений бүтэц судлал, математик, геометрийн аргачлалаар гаргаж ирсэн төгс хэв дүрсийн харьцааг хэлнэ.

хэв маяг, хээ дүрслэл, өнгөний бэлгэдэл зэргээрээ бусад орны бүтээлүүдээс эрс ялгардаг.

Тус өгүүлэлдээ “Мөнхийн урлаг” галерейн сан хөмрөгт хадгалагдаж буй VIII Богд гэгээний шүтээн танка зургийн зарим нэгэн тайлбарыг хүргэхээр зорив.



Зураг 1. Анхдугаар Богд, Өндөр гэгээн Занабазар.
“Мөнхийн Урлаг” Эртний Өвийн Галерей

Өгүүлэн буй VIII Богд Жавзандамба хутагт (1870–1924) буюу Богд хааны шүтээн зураг нь бодит хүний хөргийг гэрэл сүүдрийн ялгарлаар хэлбэржүүлэн фото зураг мэт амьдлаг, бодит (реалист) арга барилаар гурван орон зайн дүрслэлийн эзлэхүүнтэй, нэгэн тэгш хэмд өнгийн дан ба давхар дагнаасаар өгөгдсөн орон зайд, олон үйл хөдлөлийг багтаан, бурхан бүтээх шашны тиг, шүтээн урлалын уламжлалыг баримтлан зурснаараа онцлог. Эл өгүүлэлд өгүүлж буй шүтээн зурагтай бүтээсэн арга барил, зохиомжийн хувьд ижил төстэй зураг эдүгээ Богд хааны музейд хадгалагдаж буй юм. Богд хааны ордон музейд хадгалагдаж буй VIII Богд, Дондогдулам хатны шүтээн зураг (Зураг 2.) нь орчин үеийн дүрслэх урлагийг үндэслэгч, соён гэгээрүүлэгч, их зураач Балдуугийн Шаравын² бүтээл юм. Монголын сүүлчийн хаан VIII Богд

² Балдуугийн Шарав (1869–1939) нь Их хүрээнд 22 насандаа ирж өөрийн авьяас чадвараараа тодорч ордны зураач болсон түүхтэй. Аливаа уран бүтээлч өөрийн тогтсон арга барил, давтагдашгүй онцлог хэв маягтай байдаг. Б. Шарав уламжлалт арга барилд хүлэгдэлгүй шинэлэг зүйлийг туршин туурвиж байсан нь бүтээлүүдэд нь тод илрэнэ. Түүний бүтээлүүдээс дурдвал: “Монголын нэг өдөр,” Өглөө кинон дээр гардаг “Ленин,” “Үрс гарч буй,” “Богд хааны өвлийн орд,” “Гүүний үрс гаргах баяр.”

Жавзандамба хутагт, Дондогдулам хатны хөргийг бүтээлгэх эрх эгэлгүй нэгэн урлаачид оногдсон байх нь гарцаагүй юм. Өнөөгийн бидэнд цаг хугацааны уртыг туулан хадгалагдан, уламжлагдаж үлдсэн эдгээр хаан хатны хөрөг хийгээд шүтээн зураг нь хосгүй үнэт өв болохыг илтгэхийн тухайд:

- Монголын сүүлчийн хаан, хатны бодит хөрөг зураг
- Монголын дүрслэх урлагийн гайхамшгийг илтгэх хосгүй бүтээл
- Он цагийн хувьд түүхэн үнэ цэнэтэй
- Монгол хүний оюуны болоод эдийн соёлыг илтгэх баримтат өв
- Богд эзэн хаанаа бурханчлан сүсэглэн шүтэж байсны илрэл.



Зураг 2. Наймдугаар Богд Жавзандамба хутагт, Улсын эх дагина Дондогдулам. Богд Хааны Ордон Музей.

VIII Богд хааны шүтээн зургийг судалгааны хүрээнд холбогдох тайлбар

Энэхүү шүтээн зурганд VIII Богд Жавзандамба хутагтыг номын хувцастай, баруун мутартаа эрх унжуулан барьж зүүн мутраа өвдөг дээрээ аван ном бясалган амгалан тайван дүрээр сэнтийдээ залран буй байдалтай дүрсэлсэн нь хааны оюун ухаан, дотоод хүч чадлыг уг бүтээлээрээ урлаач илэрхийлэхийг зорьсон гэлтэй.

Богд хааны өлмийн баруун доор хэсэгт Эрлэг номун хаан буюу Дамдинчойжоо бурхны хувилсан дүр залран буйгаар дүрсэлсэн байна. Баруун мутартаа очирьг бэлгэдсэн, бэрээ өргөж зүүн мутартаа гавал аяга (тодов) барин цээжний харалдаа авчран дүрэлзэж буй галын өмнө хөх өнгийн өмсгөлтэй бүтээжээ. Тэргүүнээ таван хохимой толгойн титэм, биедээ хүний толгойн болон ясан зүүлт зүүж хөл дороо нүгэлт хүмүүсийг бяц гишгэж буйгаар дүрсэлжээ.

Богд хааны өмнөх битүү сийлбэртэй номын ширээнээ арга билгийн төлөөлөл болох хонх очир, бурхдыг урин дууддаг хүний гавлаар хийсэн дамар, мөнгөн бумба, рашааны гүц байгаа бол зүүн талд нь гавал тодов, эрдэнийн алтан

бумбыг тус бүр дүрслэн зурсан байна. Мөн Богд хааны баруун талд шүрэн толгойтой цагаан хаш хөөрөг аяганы нь хамт дүрсэлжээ. Аягыг тусгай суурин дээр зориулалтын таглаагаар тагласан байдалтай дүрсэлсэн байгаа нь тухайн үед дээдэс язгууртны аяганы хэрэглээний хэв маягыг харуулсан үнэт баримт юм. Аяганы хэрэглээний соёл, хэв маяг нь тухайн хүний зэрэг, зиндааг илэрхийлдэг байж. Ер нь Монголчууд аягаа дээшээ харсан сав хэмээн эрхэмлэн дээдэлж, идээнийхээ дээжийг хийн өөдөө дээшээ өргөдөг ахуйн баялаг уламжлалыг урлаач уг бүтээлдээ дүрслэн үлдээжээ.

Уг шүтээний тэргүүн дээд хэсэгт хүслийн таван эрдэнэ: дүрс, дуу, үнэр, амтлах, хүрэлцэх зэргийг түгээгч охин тэнгэр дагинасыг дагалдуулан зурсан байна. Богд хааны номын багш Ёнзон хамбыг³ баруун талын тэргүүн дээр хэсэгт нь залжээ. Мөн Богд хааны баруун талд баринтагласан судрууд бий. Богд гэгээн найман мянга гаруй санскрит, хятад, төвд, монгол номын арвин баялаг сантай байсан гэдэг. Тэрээр номын сангаа баяжуулахаар Сайн ноён хан аймгийн Чин сүжигт номун хан Цэдэнбалжир (1894–1921) гэж төвд хэлэнд нэвтэрхий, хятад хэлтэй номын хүнийг урин авчирч, түүгээр ном сурвалжлуулж олуулсан гэдэг. Зүүн дор хэсэгт эв эеийн бэлгэдэл эвтэй дөрвөн амьтан болон амьтан ба ургамлын ертөнцийг сахин хамгаалагч Цагаан өвгөнийг зүүн мутартаа эрих барьсан байдалтай дүрсэлжээ. Цагаан өвгөн буюу Цэрэндүг нь урт нас, аз жаргал, энх амгалан оршин тогтдог хэмээн бэлгэддэг.

Бүтээлийн зүүн дээд хэсэгт Мигжид Жанрайсэг⁴ бурхныг дүрсэлсэн нь VIII Богд Жавзандамба хутагтын мэлмий, бие нь чилээрхэхэд Жанрайсэг бурхныг бүтээн залж байсан түүхтэй холбоотой гэж үзэж болох юм. Мигжид Жанрайсэг баруун мутартаа рашааны гүц, зүүн мутартаа алтан толь барьсан байна. Мөн Балдуугийн Шарав энэхүү шүтээн зургандаа мандан дэвжихийг цэцэгсээр, угалзарсан үүлэн хээгээр монголчуудын тэнгэр шүтлэгийг илэрхийлж буй гэлтэй.

Дүгнэлт

Өвөг дээдсээс өвлөгдөн ирсэн соёлын биет өвийн судалгааг хийх нь тухайн өвийн соёлын болоод түүхэн ач холбогдлыг тогтооход тустай. Бидний судалгааны эх хэрэглэгдэхүүн болох Монголын сүүлчийн хааны хөрөг зураг буюу шүтээн зураг нь Б.Шаравын бүтээл юм. Өгүүлэн буй Богд хааны шүтээн зургийн зурсан арга барил, зохиомжийг ажиглахад хааны дүр төрхийг тухайн үеийн шинэлэг хэв маяг болох хөрөг зургийн (реалист) арга барилаар бүтээсэн байдаг. Зурагт Богд хааны эдэлж хэргэлдэг эд зүйлс, эрхэмлэн дээдэлдэг шүтээн зэргийн цогцлоон дүрсэлсэн нь Б. Шаравын хаантай ойр дотны болоод бурхны

³ Цэдэн овогтой Лувсанхаймчиг, Богд Жавзандамба хутагтын номын мэргэн багш (ёнзон) Их хүрээний хамба номун ханы алба хашиж байжээ.

⁴ Мигжид Жанрайсэгийн 80 тохой дүрийг, VIII Богд Жавзандамба хутагтын мэлмийг анагаах зорилгоор XIX зууны эцэст Их хүрээнд гуулиар бүтээжээ. Улмаар уг бүтээл Монголчуудын бэлгэдэл болж байгаад коммунистууд засгийн эрхэнд гарсны дараа түүнийг буулган ЗСБНХУ-д аваачсанаар ул мөргүй алга болсон юм.

шашны өргөн мэдлэгтэй байсныг илтгэж буй юм. Богд хааны уг танка зургийг бүтээсэн байдлыг ерөнхийд нь харахад урлаач хааны дүр төрх, итгэл үнэмшил, эрхэмлэн дээдэлдэг бүхий л зүйлийг баримтлан, маш уран нарийн бүтээсэн нь урлахуй ухааны өргөн мэдлэгтэй уран бүтээлч байсныг харуулж байгаа юм.

Ном зүй

- Амгалан, М.: *Баруун Монголчуудын эдийн соёлын дурсгалт зүйлс*. Улаанбаатар 2000.
- Батчулуун, Л.: *Марзан Шаравын туурвилзүй*. Улаанбаатар 2009.
- Гансүх, С.: *Нүүдэлч Монголын сод бүтээлүүдийн дээжээс*. Улаанбаатар 2015.
- Даваасүрэн, Д. – Сүхбат, Г. (ред.): *Монголын соёл, урлаг судлал I*. Мөрөөдлийн гурвалжин хэвлэлийн газар, Улаанбаатар 2015.
- Дамдинсүрэн, Д.: *Их хүрээний нэрт урчууд*. Ред. Цүлтэм, Н. Монгол пресс, Улаанбаатар 1995.
- Дулам, С.: *Монгол бэлгэдэл зүй III. Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*. Улаанбаатар 2011.
- Кочешков, Н. В.: *Народное искусство монголов*. Москва 1971.
- Meinert, Carmen (ed.): *Buddha in the Yurt: Buddhist Art from Mongolia* [Гэрт заларсан бурхад, Монголын бурхны шашны урлаг]. 2 vols. Hirmer, Munich 2011.
- Өндөр гэгээн Занабазар, Монголын Богд нарын ном бүтээл*. Монгол бичиг төв, Найдан эмнэлэг, Богд хааны ордон музей, Улаанбаатар 2015.
- Сонгино, Ч.: *Монгол эмэгтэйн уран үйл*. Улаанбаатар 1989.
- Богд гэгээний багшийг цаазалсан түүх*. <http://www.budda.mn/news/673.html> (04.2017)